

Улсын бүртгэлийн дугаар ...  
Аравтын бүрэн гэрээний  
ангиллын код ...

Нууцын зэрэглэл А  
Төсөл гүйцэтгэх дугаар  
ШуСс-2019/68

## **ГЕОПОЛИТИК СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН**

# **“МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН САЛБАРТ УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА”**

Суурь судалгааны төслийн тайлан  
2019-2021

Төслийн удирдагч

Д.Мягмар. Монгол Улсын шинжлэх ухааны  
гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны  
доктор, профессор, хошууч генерал.  
Геополитик судлалын хүрээлэнгийн  
захирал.

Захиалагч байгууллага

Боловсрол шинжлэх ухааны яам

Улаанбаатар хот  
2022 он

## ГЕОПОЛИТИК СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# “МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН САЛБАРТ УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА”

Суурь судалгааны төслийн тайлан  
2019-2021

Төслийн удирдагч	Д.Мягмар, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал, Геополитик судлалын хүрээлэнгийн захирал.
Захиалагч байгууллага	БСШУЯ-ны Шинжлэх ухааны яам
Санхүүжүүлэгч байгууллага	Шинжлэх ухаан технологийн сан
Гүйцэтгэгч байгууллага	Геополитик судлалын хүрээлэн. Улаанбаатар-14210. Энх тайвны гудамж 7а. ГХЯ-ны байр. Өрөө 31. Утас 93138353. И-мэйл: <a href="mailto:igsmongolia@gmail.com">igsmongolia@gmail.com</a>

Улаанбаатар хот  
2022 он

## ГАРЧИГ

<b>УДИРТГАЛ</b> .....	<b>5</b>
Реферат. Түлхүүр үг .....	8
Гүйцэтгэгчдийн нэрсийн жагсаалт .....	10
Нэр томьёо, товчилсон үгийн жагсаалт .....	11
<b>Нэгдүгээр бүлэг. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧИН: СУДАЛГАА, ДҮГНЭЛТ</b> .....	<b>12</b>
<b>1.1. Аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт</b> .....	<b>15</b>
1.1.1. Ерөнхий хандлага .....	15
1.1.2. Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын өөрчлөлт .....	18
1.1.3. Бүс нутгийн аюулгүй байдалд тулгарч буй зарим эрсдэл .....	20
1.1.4. Олон улсын аюулгүй байдлын цаашдын төлөв .....	23
<b>1.2. Аюулгүй байдлын дотоод орчны өөрчлөлт</b> .....	<b>30</b>
1.2.1. Аюулгүй байдлын дотоод орчны өөрчлөлтийн өнөөгийн байдал, ерөнхий хандлага .....	30
1.2.2. Үндэсний үнэт зүйлсийн тухай ойлголтын өөрчлөлт .....	32
1.2.3. Үндэсний ашиг сонирхлын тухай ойлголтын шинэчлэл .....	36
<b>Хоёрдугаар бүлэг. ЭРСДЭЛ СУДЛАЛЫН ҮНДЭС, ХЯМРАЛ, СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО</b> .....	<b>40</b>
<b>2.1. Хямралын тухай ойлголт, хямрал стратегийн эрсдэлийн угтвар нөхцөл болох тухайд</b> .....	<b>40</b>
2.1.1. Хямралын тухай тодорхойлолт, үндсэн ойлголт .....	40
2.1.2. Хямралын орчин үеийн хандлага .....	45
2.1.3. Хямрал үүсэх учир шалтгаан, үр дагавар, тэдгээрийн уялдаа холбоо .....	54
<b>2.2. Хямрал ба стратегийн эрсдэл</b> .....	<b>60</b>
<b>2.3. Эрсдэл судлалын тухай ойлголтын үндэс, стратегийн эрсдэл</b> .....	<b>68</b>
2.3.1. Учирч болзошгүй эрсдэлийн тухай ойлголт, онол, эрх зүйн үндэс .....	68
2.3.2. Стратегийн эрсдэлийн мөн чанар.....	82
2.3.4. Эрсдэлийн шинжилгээний хандлага.....	85

<b>Гуравдугаар бүлэг. УЧИРЧ БОЛЗОШГҮЙ СТРАТЕГИЙН ЭРСДЭЛИЙН ТААМАГЛАЛ .....</b>	<b>88</b>
<b>3.1. Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэл.....</b>	<b>88</b>
3.1.1. Улс төрийн салбарт учирч болох эрсдэлийн тухай ойлголт .....	88
3.1.2. Улс төрийн салбарт эрсдэл үүсгэж болзошгүй дотоод хүчин зүйлс.....	94
3.1.3. Улс төрийн салбарт эрсдэл үүсгэж болзошгүй гадаад хүчин зүйлс ....	101
3.1.4. Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал.....	115
3.1.5. Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал .....	120
<b>3.2. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэл.....</b>	<b>132</b>
3.2.1. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн тухай ойлголт...	132
3.2.2. Эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт .....	142
3.2.3. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал .....	148
3.2.4. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл .....	157
<b>3.3. Нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэл .....</b>	<b>162</b>
3.3.1. Нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн тухай ойлголт.....	162
3.3.2. Нийгмийн салбарт эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйлс.....	169
3.3.3. Нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал .....	174
<b>Дөрөвдүгээр бүлэг. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС.....</b>	<b>176</b>
<b>4.1. Улс орны хөгжлийг удирдахад эрсдэлийг тооцох арга зүйн үндэс ..</b>	<b>176</b>
<b>4.2. Эрсдэлийн үзүүлэлтэд тулгуурлан төрийн удирдлагыг хэрэгжүүлэх асуудал .....</b>	<b>185</b>
<b>4.3. Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны дүн шинжилгээ, үнэлгээний арга зүйн үндэс .....</b>	<b>190</b>
<b>ТӨГСГӨЛ.....</b>	<b>196</b>
<b>Хавсралт .....</b>	<b>198</b>

## УДИРТГАЛ

Ардчилал, шинэчлэлийн өөрчлөлтүүд эхэлсэн 1990-ээд оны эхнээс Монгол Улсын төр, засаг, холбогдох яам, агентлаг, газрууд, түүнчлэн эрдэм шинжилгээний байгууллагууд үүсэн бий болсон түүхэн шинэ нөхцөл байдалд улс орны тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн бодлогын шинэ үзэл баримтлалыг боловсруулах талаар анхааран ажиллаж эхэлсэн юм. Энэ ажлын чухал үр дүн нь 1992 онд УИХ-аас батлан гаргасан Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль, 1994 онд шинээр боловсруулан баталж дараа нь 2010 онд шинэчлэн тодотгосон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал юм.

Өнгөрсөн 30 шахам жилд Монгол Улсын төр, нийгмийн шинэчлэл тодорхой хэмжээгээр амжилттай хэрэгжиж, ялангуяа улс орны эдийн засаг өсөн нэмэгдэх боллоо. Үүнтэй уялдаатайгаар сүүлийн жилүүдэд Монгол улс өөрийн тогтвортой хөгжлийн эдийн засаг, улс төр, нийгэм, шинжлэх ухааны үндсийг бүрдүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт гаргах болсоор байна. Үүний зэрэгцээ Монгол Улсын эргэн тойронд олон улсын шинэ нөхцөл байдал үүсэн бий болж, дотоодын хөгжлийн зарим асуудал ч улам бүр төвөгтэй, ээдрээтэй болсоор байна. Эдгээрийн улмаас үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй аюул занал ч урьд өмнө байгаагүй зарим нэг шинэ шинж чанар, түүний дотор стратегийн гэж хэлж болох эрсдэлийг агуулах боллоо. Энэ нь цаашдаа Үндэсний хөгжлийн бодлогод харгалзан үзэж буй үзэл санааг гүнзгийрүүлэн, улс орны тогтвортой хөгжлийн болон аюулгүй байдлын бодлогод учирч болзошгүй стратегийн эрсдэлийг тооцох шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйг боловсруулах зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм.

Зарим нэг тааламжгүй үйл явдал, нөхцөл байдал, ялангуяа улс төр, эдийн засаг, нийгмийн байдлаас үүдэлтэй эрсдэлийг үнэлэх, таамаглах, урьдчилан сэргийлэх оролдлого сүүлийн жилүүдэд цөөн тоотой боловч тодорхой хэмжээгээр хийгдэх болсон билээ. Ингэхдээ, тодорхой төрлийн эрсдэлийн тухай ойлголтын механизм, үндсэн үзүүлэлт, тэдгээрт дүн шинжилгээ хийх, үнэлэх, таамаглах аргыг боловсруулж, эдгээр эрсдэлд хандах ерөнхий арга зүйн чиг баримжаа болон удирдлагын зарчмыг тодорхойлоход ажлын гол нь чиглэж ирсэн юм. Эдгээр судалгаа болон арга зүйн үндэс нь ихэвчлэн байгалийн гамшиг болон

техногенийн аваар осолтой холбогдол бүхий зарим нэг тодорхой эрсдэл болон зорилгод хамаарч байсан бөгөөд харин улс төр, эдийн засаг, нийгэм болон шинжлэх ухаан, технологи зэрэг улс орны оршин тогтнохын үндэс болсон гол салбаруудтай холбоотой стратегийн эрсдэлийн судалгаа манай улсад үндсэндээ хийгдэж байгаагүй бөгөөд үүний эхлэл нь энэхүү төслийн судалгааны ажил болно.

Энэхүү төслийн судалгааны ажлын гол зорилго нь үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжил зэрэг улс орны хэмжээний томоохон асуудлуудыг учирч болзошгүй стратегийн эрсдэл, тэдгээрийн харилцан холбоо, уялдаа, үр дагавар, үнэлгээ болон таамаглал, мөн, эдгээрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврын эсрэг сөрөн зогсох, хор хохирлыг даван туулах, гай уршгийг нь арилгахад чиглэсэн удирдлагын шийдвэрийн нийтлэг арга зүй болон зарчмуудтай нягт уялдуулан судлах, үүний үр дүнгээр төрийн бодлогын тулгамдсан чухал асуудлыг шийдвэрлэхдээ болзошгүй стратегийн эрсдэлийг тооцож байх арга зүйн механизмыг боловсруулахад оршиж байсан болно.

1 дүгээр бүлэгт Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндсэн асуудлууд, түүний дотор стратегийн эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй нөхцөл байдлыг тандан судлах үүднээс манай орны эргэн тойронд болж буй гадаад орчны өөрчлөлт, шинээр бүрэлдэн бий болсон олон улсын шинэ нөхцөл байдал, Орос, Хятадын болон Зүүн хойд Ази, АНУ-ын хүчин зүйлс, түүнчлэн улс орны дотоод аюулгүй байдал, хөгжлийн салбарын өнөөгийн байдал, учирч болзошгүй аюулын тухай төсөөлөл зэргийг тусгайлан авч үзэж холбогдох дүгнэлтүүдийг хийлээ.

2 дугаар бүлэгт олон улсын болон манай орны эрдэмтдийн явуулж буй судалгаануудад хямрал болон эрсдэлүүдийн талаар хийж ирсэн дүн шинжилгээнүүд болон эдгээр ойлголтод өгч байгаа тодорхойлолтуудыг задлан шинжилж үзлээ. Мөн аливаа хямралын өрнөх үйл явцын орчин үеийн хандлагыг системчлэн үзүүлэх оролдлогыг хийсэн болно. Үр дагавар нь анхнаасаа тодорхой бус байдаг, олон утга агуулгатай, бүтээн байгуулалт ба эвдлэн сүйтгэгч гэсэн хоёр шинж чанарыг хослон агуулдаг үйл явц болох хямрал нь эрсдэлийн талаар баримтлах төрийн үзэл баримтлалтай хэрхэн уялдаж болохыг харуулах нь уг бүлгийг боловсруулах явцад хэрэгжүүлсэн судалгааны ажлын нэг чухал

зорилт байсан болно. Мөн уг бүлэгт хямралын онол болон стратегийн эрсдэлүүдийн уялдаа, харилцан холбоо, улс орны хөгжлийн үндсэн салбарууд дахь стратегийн эрсдэлүүдийн ангилал болон тодорхойлолтыг шинээр томъёолон тодорхойллоо.

3 дугаар бүлэгт улс орны хөгжлийн үндсэн салбаруудад учирч болзошгүй стратегийн эрсдэлүүдийн үнэлгээ, шинжилгээний үр дүнг тусгав. Хөгжлийн үндсэн салбарт гэдэгт улс төр, эдийн засаг, нийгмийн салбарыг хамааруулан авч үзсэн болно. Ингэхдээ хамгийн их нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлүүдийг салбар тус бүрээр тодорхойлж, тэдгээрт шинж чанарын болон тоон үнэлгээг өгсний дээр зарим нэг салбарын хувьд ойрын болон дунд хугацаанд тохиолдож болзошгүй стратегийн эрсдэлүүдийн таамаглалыг тодорхойлсон болно.

4 дүгээр бүлэгт болзошгүй стратегийн эрсдэлүүдийн үзүүлэлтүүдэд тулгуурлан тэдгээрийг тооцох төрийн удирдлагын арга зүйг боловсруулах ерөнхий хандлагыг тайлбарлав. Үүний дотор улс төр, нийгэм, эдийн засгийн нарийн төвөгтэй тогтолцооны үйл ажиллагаа болон үндэсний хөгжлийг удирдах арга зүйн үндсэн асуудлууд, төрийн удирдлагын үндсэн механизмын анализ, мөн улс орон болон бүс нутгуудын хөгжлийн таамаглалыг хийхэд стратегийн эрсдэлүүдийн үзүүлэлтүүдийг ашиглах ерөнхий зарчмыг санал болголоо. Түүнчлэн энэ бүлэгт стратегийн эрсдэлүүдийн шинжлэх ухааны үнэлгээ, шинжилгээний системийг бүрдүүлэх ерөнхий хандлагыг тодорхойлсон болно.

Энэхүү бүтээл нь улс орны оршин тогтнохын үндсэн салбаруудад учирч болзошгүй стратегийн эрсдэлүүдийг урьдчилан таамаглах, шинж чанарыг нь тодорхойлох, болзошгүй үр дагаврыг нь үнэлэх зэрэг асуудлыг төслийн судалгааны түвшинд авч үзсэн анхны эрдэм шинжилгээний ажил болно. Энд өгч буй шинжлэх ухааны дүгнэлтүүд, эрдэм шинжилгээний арга зүйн санал, зөвлөмж нь одоогоор асуудал дэвшүүлэх шинж чанартай байгаа бөгөөд үүний дотор улс орны хөгжлийн зарим салбар дахь стратегийн эрсдэлүүдийн тоон үнэлгээ нь анх удаа хийгдэж байгаа учир урьдчилсан, үзүүлэн таниулах хэлбэртэй байгаа болохыг анхааралдаа авахыг хүсэж байна.

## **Реферат. Түлхүүр үг**

### **Реферат**

Өнөөгийн дэлхий ертөнц бүхэлдээ, түүний дотор хүн төрөлхтөн өөрсдийнхөө соёл иргэншлийн хөгжлийнхөө явцад бүрдүүлсэн олон талт, хоорондоо хэлхээ холбоо, харилцан уялдаа бүхий элдэв төрлийн аюул заналт нөхцөл байдлаас улам бүр хамаарал бүхий эмзэг болсоор байна. Ирээдүйг дан ганц эдийн засаг, амьжиргааны түвшний ашиг сонирхлын үүднээс харах, төлөвлөх боломжгүй болоод удаж байна. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа юуны өмнө улс орон, ард иргэдийнхээ аюулгүй байдлыг харгалзах явдал XXI зууны эхээр улам бүр чухал болсоор байна. Үүнтэй уялдаатайгаар сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлаа хангах төрийн бодлогын арга зүйн шинэ үндэслэлийг боловсруулахад илүү анхаарал тавих болсон бөгөөд үүний нэг чухал хэсэг нь “стратегийн эрсдэлийн үзэл баримтлал” гэдэг цоо шинэ ойлголтыг дэвшүүлэн тавих болсон явдал юм. Ингэхдээ ихэнх судлаач, төр, нийгмийн зүтгэлтэн стратегийн эрсдэл гэдгийг улс орны тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлын түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулахад хүргэж болох хямралт үйл явдал, гамшигт үзэгдэл, сүйрэгч нөхцөл байдал үүсэх магадлал болон тэдгээрийн болзошгүй үр дагаврын хослол гэж ойлгох нь улам бүр түгээмэл болсоор байна.

Бий болсон нөхцөл байдлыг тооцон үзсэний үндсэн дээр БСШУЯ шийдвэр гаргаж Монголын Геополитик судлалын хүрээлэнгийн дэргэд тусгайлсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулж “Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн судалгаа” сэдэвт суурь судалгааны төслийн ажлын тайланг нэгтгэн боловсрууллаа. Энэхүү ажлын үр дүнгээр санал болгож буй стратегийн эрсдэлийн үзэл баримтлалын хувилбар, түүнд тулгуурлан боловсруулсан тэдгээрийг үнэлэх, болзошгүй хор хохирлыг багасгах зорилго бүхий эрсдэлийн удирдлагын арга зүй, холбогдох бусад санал, зөвлөмж нь Монгол Улсын эргэн тойронд бий болсон олон улсын шинэ нөхцөл байдал, улс төр, эдийн засаг, нийгмийн дотоод амьдралын өнөөгийн амаргүй нөхцөлд улс орны тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангах салбарт төрөөс баримтлах бодлогын биелэлтийг хангахад тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулна гэж үзэж байна.



Энэхүү суурь судалгааны төслийн ажилд хувь хүн, нийгэм, төр засгийн амьдралын үндсэн салбарууд дахь стратегийн эрсдэлийг тогтоох, үнэлэх, таамаглахад ашиглаж болохуйц шинжлэх ухааны арга зүйн үндсийг анх удаа системчлэн авч үзлээ. Уг бүтээлд Монгол Улсын эрдэм шинжилгээ, судалгааны олон байгууллагын эрдэмтэн, судлаачдын явуулсан өргөн цар хүрээтэй ажлын үр дүнг нэгтгэн тусгасан байгаа бөгөөд энэ ажил нь стратегийн эрсдэлийн үзүүлэлтийг тооцсон төрийн удирдлагын арга зүйг шинээр бүрдүүлэхэд чухал хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

Суурь судалгааны төслийн үндсэн үр дүн:

1. “Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн судалгаа” сэдэвт суурь судалгааны тайлан.

2. “Стратегийн эрсдэлийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийн төсөл.

3. “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдэд тодотгол хийх санал зөвлөмж.

## **Түлхүүр үг**

Олон улс, эрсдэл, стратегийн эрсдэл, аюулгүй байдал, гадаад бодлого, батлан хамгаалах,

## Гүйцэтгэгчийн нэрсийн жагсаалт

### Төслийн удирдагч:

Довчингийн Мягмар

Геополитик судлалын хүрээлэнгийн захирал, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал.

(Удиртгал, 3, 4-р бүлэг, Төгсгөл. Хавсралтууд)

### Гүйцэтгэгчид:

Ноосгойн Алтанцэцэг

ГПСХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, доктор, профессор

(1-р бүлгийн 1-р дэд бүлэг)

Ринчингийн Батмэнд

ГПСХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, гавьяат эдийн засагч, доктор, профессор

(2-р бүлэг)

Хасбазарын Бэхбат

ГПСХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, доктор, Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд

(1-р бүлгийн 2-р дэд бүлэг)

Тойнхүүгийн Баярмагнай

Орчуулагч, редактор.

Дугаржавын Сүрэнбаяр

Туслах ажилтан, магистр

## Нэр томьёо, товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНДБН	Ази, Номхон далайн бүс нутаг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БХЯ	Батлан хамгаалах яам
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЗХА	Зүүн Хойд Ази
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
НАТО	Умард Атлантын гэрээний байгууллага
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
АБХАГБ	Аюулгүй байдал, хамтын ажиллагааны гэрээний байгууллага
ОУАЭА	Олон улсын атомын энергийн агентлаг
ОУЭСА	Олон улсын энхийг сахиулах ажиллагаа
ТУХН	Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг
ЦЗАС	Цөмийн зэвсгээс ангид статус.
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ШХАБ	Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
ЭҮНХ	Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн

## Нэгдүгээр бүлэг.

### МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧИН: СУДАЛГАА, ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн хойд Ази болон Төв Азид улс төр, эдийн засгийн нөлөөллийн дахин хуваарилалт явагдаж, үүний улмаас том гүрнүүдийн гео улс төр, гео эдийн засаг болон гео стратегийн ашиг сонирхол өөр хоорондоо хүчтэй зөрчилдөх болсон нь эдгээр бүс нутгийн аюулгүй байдалд хүчтэй нөлөөлөх боллоо. Энэ их өөрчлөлт биднийг тойрон өнгөрөхгүй нь улам бүр тодорхой болсоор байгаа бөгөөд Монгол Улс үүнд нэлээд гүнзгийгээр татагдан орж болзошгүй байна. Сүүлийн жилүүдэд манай орны хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах гэсэн бие даасан эрмэлзэл, стратегийн ач холбогдол бүхий газар зүйн байршил, ашигт малтмалын асар их баялаг, нүүдлийн ахуй соёл болон онгон уудам байгаль орчин зэрэг нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, бидний оршин сууж буй газар нутаг тэдний зөрчил, сөргөлдөөний шинэ талбар болон хувирах магадлал хүчтэй мэдрэгдэж эхэллээ.

Үүний зэрэгцээ манай орны өөрийн улс төр, нийгэм, эдийн засаг, хувь хүний амьдралд олон шинэ эрсдэл тулгарах болж, зарим нь лавшрах хандлагатай байна. Улс төрийн дотоод нөхцөл байдал хурцадмал хэвээр, нийгмийн хэсэг бүлэг хоорондын зөрчил сөргөлдөөн үргэлжилсээр, эдийн засгийн тэнцвэртэй хөгжил төдийлөн хангагдаж чадахгүй, сайн засаглал бий болгох ажил удаашралтай, авилаг, шударга бус явдал, хуулийг үл тоомсорлох үйлдэл газар авсаар, ард түмний нэлээд хэсгийн амьдралын түвшин сайжрахгүй байгаа зэргээс улбаалан нийгэмд тогтворгүй, хуваагдмал байдал бий болох шинж тэмдэг ажиглагдаж байна.

Түүнчлэн, өнөө үед том гүрнүүд хоорондын харилцан сөргөлдөөний агуулга аажмаар өөрчлөгдөж улам бүр геополитикийн орон зайн төлөөх шинж чанартай болсоор байгаа нь манай орныг эдгээр улсын гео стратегийн өрсөлдөөний гүн эргүүлэгт татан оруулах хүчтэй магадлалыг бий болгож байна. Монгол орон улс хоорондын харилцаанд энхийг эрхэмлэх, итгэлцлийг бэхжүүлэх үйл хэрэгт идэвх, санаачилга гарган оролцож, дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн зүгээс дэмжлэг олж авч чадсан хэдий боловч улс төр, эдийн засаг, нийгэмд тулгарч болох эрсдэлийн хувьд маш эмзэг орчинд оршиж байна.

Иймээс шинээр үүсэн бий болж байгаа аюулгүй байдлын үүдэл, сэдэл бүхий эрсдэлийг нээн илрүүлж, цоо шинээр ухаарч ойлгох, Монгол улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр хүчтэй нөлөөлж эхэлж буй эдгээр эрсдэлийг судлан тодорхойлох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах практик шийдлийг хайн олох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евроазийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны гео стратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг улам бүр хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн гео стратегийн сэргэлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болжээ. Энэ нь:

- нэгдүгээрт, нүүрс, зэс, молибден, алт, уран болон бусад ашигт малтмалын асар том ордууддаа бусад оронтой хамтран ашиглаж эхэлсэнтэй;
- хоёрдугаарт, үндсэндээ тоталитар дэглэмтэй дэлхий хоёр том гүрний дунд хавчигдан оршиж байгаа боловч нийгмийн ардчиллыг хөгжүүлэх талаараа социализмын дараах орнуудад, ялангуяа Азийн улсуудад үлгэр жишээ болж байгаатай;
- гуравдугаарт, дэлхий нийтийн хувьд тогтворгүй байдлын нэг үндэс болоод байгаа лалын ертөнцтэй хил залгаа оршдогтой;
- дөрөвдүгээрт, магадгүй хамгийн чухал нь, Орос, Хятад гээд өөр хоорондоо болон АНУ тэргүүтэй барууны орнуудтай багагүй зөрчил, сэргэлдөөнтэй хоёр том улсын дунд оршдог стратегийн чухал байршилтай зэрэгтэй холбоотой байна.

Эдгээр нь манай орныг их гүрнүүдийн зүгээс Зүүн хойд болон Төв Азид явуулж буй гео стратегийн бодлогынхоо хүрээнд байлгах зайлшгүй ашиг сонирхлыг үүсгэж байгаа болно.

Монгол улс хоёр их хөрш, АНУ болон гуравдагч бусад улс оронтой олон талт, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа боловч их гүрнүүдийн зүгээс Монгол Улсад улс төрийн нөлөөллийнхөө давамгайл байдлыг бий болгох, эдийн засгийн тодорхой салбаруудыг нь хараандаа оруулах, улсынх нь хөгжлийг зөвхөн уул уурхайн болон хөдөө аж ахуйн салбарын түүхий эдийн экспортод түшиглэсэн, олон улсын зах зээлээс хэт хамааралтай байдал руу хөтлөхийг оролдох буюу эцсийн дүндээ өөрсдөөсөө хараат байдалтай орон болгох гэсэн хандлага сүүлийн жилүүдэд хүчтэй ажиглагдаж эхэллээ.

Удаа дараа явуулсан судалгааны дүнгээс харахад энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлого, Гадаад бодлогын үзэл баримтлал болон Батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг тулгуур баримт бичигт улс орны аюулгүй байдал, хөгжлийн бодлогыг хангахад тулгарч буй эрсдэлийн хүчин зүйлсийг тооцох асуудал төдийлөн сайн, тодорхой тусгагдаагүй болох нь улам бүр ойлгогдсоор байна.

Үүний зэрэгцээ, аливаа улс дэлхий ертөнцөд, түүний дотор оршин тогтнож буй бүс нутгийнхаа хүрээнд өөрийн орон зайг эзлэх буюу хадгалах, газар зүйн байршил, нөөц баялаг, цаг агаарын нөхцөл байдал, хүн амын тоо, чанар зэрэг давуутай талуудаа ашиглан тусгаар тогтнолоо бэхжүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх, ард иргэдийнхээ энх амгалан, элбэг хангалуун амьдралыг хангах зорилгоор геополитикийн салбарт баримтлах өөрийн эрсдэлээс хамгаалах үзэл баримтлалтай байж үүнийгээ хэрэгжүүлэх зорилго бүхий төрийн бодлогыг боловсруулж мөрддөг. Энэ нь улс орны хөгжлийн хэтийн зорилго, ойрын зорилтуудыг үндэслэлтэй төсөөлөх, учирч болзошгүй аюул заналыг урьдчилан тодорхойлох, тэдгээрээс сэргэмжлэх, хамгаалах арга замыг оновчтой сонгох, хүч хөрөнгө, нөөц бололцоогоо зөв хуваарилах бололцоог олгох чухал ач холбогдолтой байдаг.

Энэ бүхнээс үүдэн улс оронд учирч болзошгүй стратегийн эрсдэл хэмээх өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийн асуудлыг тусгайлан авч үзэх нь зайлшгүй шаардлага болон тавигдаж байгаатай уялдуулан энэхүү судалгааг явууллаа.

Ер нь үндэсний үнэт зүйлсээ хадгалан хамгаалахтай холбогдол бүхий онцгой асуудлыг үе үеийн хаад ноёд, төрийн жолоодогч нар ухаантнуудынхаа хязгаарлагдмал хүрээнд тусгайлан бодож боловсруулан, үүнийхээ цөм үндсийг “хар хайрцгийн бодлого” хэмээн нэрлэж, хамгийн чандаар хадгалан хамгаалж, эрхэмлэн баримталж, үйл ажиллагаандаа тууштай мөрдлөг болгон, дараагийн залгамжлагчдаа өвлүүлэн үлдээж ирсэн нь Монгол төрийн эрхэмсэг уламжлал билээ.

## **1.1. Аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт**

### **1.1.1. Ерөнхий хандлага**

XXI зууны эхэнд даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж, олон улсын харилцаа, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ улам бүр тэлэн өргөжиж байна. Энэ үйл явц дэлхий нийтийн шинж чанартай болж улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг-стратегийн зэрэг бүхий л салбарыг хамарч, улс хоорондын харилцааг өөр хоорондоо нягт уялдаатай, ихээхэн түгээмэл агуулгатай болгож байна.

Дэлхийн улсууд, ялангуяа хөгжиж байгаа орон түүний давалгаанд өөрийн эрхгүй татагдан орохдоо давуу талыг нь үр өгөөжтэй ашиглах, сөрөг талыг нь даван туулж, үндэсний өвөрмөц шинж чанар, тогтвортой хөгжил, эцсийн дүндээ үндэсний аюулгүй байдлаа хадгалж үлдэх талаас нь ихээхэн анхаарах боллоо.

“Хүйтэн дайн”-ы дараах олон улсын харилцаанд, ялангуяа 2001 оны 9 дүгээр сарын 11-нд АНУ-д болсон террорист халдлагаас хойш олон улсын аюулгүй байдлын асуудалд хандах дэлхий нийтийн байр суурьт онол, үзэл санааны гэхээр томоохон өөрчлөлтүүд гарлаа. Эдүгээ улс орнууд хэдий хүчирхэг

хөгжилтэй ч байлаа гэсэн аюулгүй байдлаа дангаараа хангах боломжгүй нь улам бүр ойлгомжтой болсоор байна.

Дэлхийн II дайнаас хойш бүрэлдэн тогтсон улс хоорондын цэрэг-улс төрийн харилцааны хэв шинж өөрчлөгдөж оронд нь хэн ч төсөөлж байгаагүй цоо шинэ үйл явц өрнөж эхэлсэн нь үүний угтвар нөхцөл болсон юм. Энэ үйл явц удаан хугацаагаар үргэлжлэх төлөвтэй бөгөөд өнөөдөр хэдийгээр эсрэг тэсрэг хоёр өөр тогтолцоонд хамрагдаж байсан олон улс орны харилцаа зарим талаар сайжран, түншлэлийн чанартай болж байгаа ч улс, үндэстэн хоорондын зөрчил, сөргөлдөөн шинэ өнгө аясаар даамжирсаар байгаа бөгөөд бүрмөсөн зохицуулагдах нь ирээдүй цагийн асуудал хэвээр байна.

Дэлхийн улс орнууд зэвсэглэлээр хэт хөөцөлдөж, цөмийн дайны ирмэгт тулж очоод байсан аюул тодорхой хэмжээгээр тодорхой хугацаагаар хойшлогдон, нэг талаас хүн төрөлхтнийг хувааж байсан үзэл суртлын саад арилж, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, технологи, мэдээллийн харилцаа үндэсний болоод цэрэг-улс төрийн болон эдийн засаг-улс төрийн эвсэл холбоодын хил хязгаараар зааглагдахаа больж байгаа ч нөгөө талаас энх тайван, аюулгүй байдлын асуудлыг дэлхий нийтэд шийдвэрлэх гэсэн хүний нийгмийн хөгжлийн нэг гол хандлага зарим сорилттой тулгараад байна.

Цаг хугацааны хүчин зүйлтэй өрсөлдөн явагдаж буй дэлхий нийтийг хамарсан эдгээр өөрчлөлт янз бүрийн үүдэл шалтгаан бүхий шийдвэрлэгдээгүй олон асуудал, аюул заналыг араасаа дагуулж буй нь бас тодорхой болж байна.

Эсрэг тэсрэг хоёр тогтолцооны захиргаа, нөлөөлөлд байсан бүс нутгуудын зарим хэсэгт янз бүрийн шалтгаанаас үүдэлтэй зөрчил сөргөлдөөнүүд хадгалагдан улам бүр даамжирсаар байна. Тухайлбал: Кавказ, Балканы хойг, Төв Ази, Ойрх Дорнодод иргэний дайны хэлбэрээр дэгдсэн угсаатан, ястан, шашин шүтлэгтэн хоорондын зэвсэгт мөргөлдөөн, тэдгээрт өөрийн ашиг сонирхлоо хамгаалах гэсэн их гүрнүүдийн тэмцэл, Өмнөд болон Зүүн Өмнөд Ази, Африкийн зарим оронд болж буй цус асгаруулсан хэрэг явдлууд үүний нотолгоо болж байна.



Түүнчлэн хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, ядуурал, цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, бүх төрлийн зэвсэг, тэсрэх болон мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого гэх мэт уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж, хамрах орчин, хил хязгаар нь тэлж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхийн улс түмэнд бүхэлд нь нүүрлэсэн шинэ аюул занал болон хувирч байна.

Уламжлалт бус эдгээр аюул занал иргэд хувь хүмүүсийн төдийгүй, улс гүрнүүдийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх болж байгаатай холбогдон дэлхий нийтийн аюулгүй байдлыг улс орон бүрийн идэвхтэй оролцоотойгоор, тэр дотроо олон улсын зэвсэгт хүчний нэгдсэн чармайлтаар хангах асуудал улс хоорондын харилцааны нэг гол агуулга болон тавигдах боллоо.

Баруун Европт аюулгүй байдлыг хангах бие даасан өөрийн гэсэн тогтолцоог бүрдүүлэх ажил нэгэнт эхэлж, тэрчлэн эрчимтэй хөгжиж буй бусад салбар бүс нутаг, улс орнуудын бие даах эрмэлзэл улам бүр тодорхой болсоор байна.

Өрнөдийнхөн НАТО-г дорно зүгт тэлж, хуучин Дорнод Европын орнуудыг өөртөө элсүүлсний дээр Балтийн тэнгис хавийн орнуудаар эгнээгээ нэгэнт сэлбэж чадлаа. ОХУ үүний хариуд НАТО-гийн нөлөөллийн өргөжилтийг хязгаарлахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж, үүндээ ТУХН-ийн орнууд, Төв, Зүүн, Өмнөд Азийн хүчирхэгжиж буй, түүний дотор Хятад, Энэтхэг, Пакистан зэрэг зарим улсыг хамруулах, тэдэнтэй цэрэг-ул төрийн талаар түншлэх бодлогоо сүүлийн үед идэвхжүүлж эхэллээ. Үүний нэг илэрхийлэл нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллага болж байна.

Үүний зэрэгцээ дэлхийн шинэ дэг журам тогтоох үйл ажиллагаа, аюулгүй байдал, улс хоорондын харилцааны өнөөгийн нөхцөл байдлыг удирдлага хяналтад байлгахад олон улсын нэр хүнд бүхий байгууллагууд, ялангуяа НҮБ-ын үүрэг чухлаар шаардагдах хандлагатай болж улмаар олон улс, ялангуяа бага орнууд энэ чиглэлийг гадаад бодлогодоо улам бүр эрхэмлэх болж буй цаг үед бид амьдарч байна.

### 1.1.2. Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын өөрчлөлт

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын геополитикийн нөхцөл байдал сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой шинж чанарыг агуулсаар байгаа юм. Энэ нь дэлхий нийтийг хамарсан эрс өөрчлөлт болон бүс нутагт өөрийнх нь хүрээнд болж буй үйл явдлуудын аль алиных нь үр дүн юм.

1990-ээд оны эхээр дэлхийн том гүрнүүд үзэл суртал, цэргийн хүчийг “ялалт” байгуулах гол хэрэгсэл гэж үзэх дайнч үзлээсээ зарим талаар татгалзаж, улмаар “Хүйтэн дайн” төгсгөл болсон нь энэ бүс нутгийн олон улсын аюулгүй байдал тогтворжиход хүчтэй нөлөө үзүүлсэн билээ. Түүнчлэн бүс нутгийн улс хоорондын найрсаг харилцаа, итгэлцэлд тулгуурласан, улам бүр өргөжиж буй эдийн засгийн хамтын ажиллагаа нь энэхүү тогтвортой байдлыг хангах нэг гол хүчин зүйл болж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийг зааглан хувааж байсан хоёр тогтолцооны сэргэлдөөн үгүй болсны дээр Орос-Хятадын харилцаа үндсэндээ бүрэн хэвийн болж, стратегийн түншлэл тогтоож, тэд өөрсдийн дотоод байдлыг тогтвортой болгох, эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд голлон анхаарах болсон нь бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлж байна.

Үндэстэн дамжсан томоохон эвслүүд бий болж АСЕАН, АПЕК, НАФТА, ПЕКК, ШХАБ зэрэг олон улсын байгууллагуудын нэр нөлөө, байр суурь дэлхийн үйл хэрэгт улам бүр жинтэй болсоор байна. Иймээс ойрын ирээдүйд Номхон далайн баруун, зүүн эргийн улс үндэстнүүд дэлхийн хөгжлийн нэг гол хөтлөгч хүчин зүйл байх болно гэдэг нь тодорхой боллоо.

Үүний зэрэгцээ Европын нийтлэг эрх ашгийг хамгаалах мэт ойлголт Ази, Номхон далайн бүс нутагт өнөө хэр бий болоогүй байна. Энэ бүс нутгийг хэд хэдэн салбар бүс нутаг болгон зааглан үзэж болох бөгөөд одоогоор тэдгээрийн дотор ойртон нягтрах, түүний дотор хамтын аюулгүй байдлын нийтлэг зүйлийг бий болгох чармайлт ид явагдаж байна.

Энэ хүрээнд Хятадын эдийн засгийн эрчимтэй өсөлт нь анхаарч үзэх нэг хүчин зүйл болж байна. АНУ, ОХУ-ын улс төр, эдийн засгийн нөлөө Азид зарим талаар суларч түүний оронд эдийн засгийн тогтвортой, эрчимтэй хөгжилд тулгуурласан Хятад улсын оролцоо өсөж байгаа нь сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Энэ нь ЗХУ задран тарснаар болон лалын ертөнц бүхэлдээ АНУ-ын эсрэг байр суурьтай байгаагаар нөхцөлдөх бөгөөд үүнээс үүдэн Ази, Номхон далайн бүс нутагт өөртөө ашигтай эдийн засаг, цэрэг-улс төрийн байр суурь эзлэх бололцоо Хятадад бий болох талтай юм.

Улс хоорондын харилцааны хувьд Ази, Номхон далайн бүс нутагт Европт бий болсон шиг ардчилсан орнуудын эвсэл, аюулгүй байдлын нэгдмэл тогтолцоо бүрэлдэн тогтох үйл явц харьцангуй удаан хугацааг шаардах бололтой. Гэвч терроризмын эсрэг олон улсын хамтын ажиллагааг бий болгоход чиглэсэн нийтлэг зарчим давамгайлсан улс үндэстний цэрэг-улс төрийн харилцаа бий болох эхлэл ажиглагдаж байна. Харин энэ харилцаанд лалын зарим улс орон төдийлөн хамрагдахгүй нь ойлгогдож байгаа бөгөөд тэд нийгмийн болон хувь хүний амьдралын бүх хэв шинжийг хатуу чанд зохицуулахад тулгуурласан төр, нийгмийн байгуулалтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ үүнийгээ олон улсын чанартай болгохыг эрмэлзэх нь илэрхий болж байна.

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын геополитикийн нөхцөл байдалд нөлөөлж болзошгүй, улс хоорондын харилцааны талаасаа шийдвэрлэгдээгүй асуудлууд ч бас хадгалагдсаар байна.

Энэ бүс нутгийн нэлээд олон улс орны зэвсэгт хүчнүүд харьцангуй олон хүнтэй бөгөөд тэдний зэвсэглэл, тоо хэмжээнд хяналт тавих буюу хязгаарлах, үнэлэх олон улсын бодитой механизм одоогоор бий болоогүй байна.

Хуучин ЗХУ задран тарсан боловч түүний эзэлж байсан цэрэг-улс төрийн орон зай өөрчлөгдөх үйл явц дуусаагүй байна. ОХУ-ын гадаад бодлогын нэг чухал чиглэл нь Ази, Номхон далайн бүс нутагт, ялангуяа ТУХН-ийн хүрээнд нөлөөгөө хадгалах явдал болж байна. Гэтэл ТУХН-ийн улсуудын зургаа нь Ази тивд оршиж, дэлхийн тэргүүлэх бусад гүрнүүд, тухайлбал АНУ болон бүс нутгийн хүчирхэгжиж буй лалын ертөнцтэй харьцаж, зарим тохиолдолд шашны болон үндэстний хэт даврах байр сууринаас, эсвэл түүний эсрэг тэмцэх зорилгоор

эвсэн нэгдэх, бие даахыг эрмэлзэх нь нэмэгдсээр байна. Өрнөд-Дорнодын сөргөлдөөн үгүй болсон нь эдгээр улс орнуудын дотор нуугдмал шинжтэй байсан орон нутгийн зөрчил, үндэстэн ястан, шашин шүтлэг, нутаг дэвсгэрийн маргаан илрэн хурцдах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Энэ нь Кавказ, Төв Ази, Ойрх Дорнодод бусдаас илүүтэй мэдрэгдэж байна.

Цөмийн заналхийлэл Ази, Номхон далайн бүс нутагт бодитой хадгалагдсаар байгаа бөгөөд цөмийн зэвсэг тархах, улмаар дарангуйллын буюу дангаар захирах дэглэмтэй улс орнууд өөрсдийн явцуу эрх ашгаа хамгаалахын тулд түүнийг хэрэглэж болзошгүй магадлал ч ажиглагдаж байна. АНУ, ОХУ хоёр цөмийн зэвсгээр түрий барихаа багасгаж, Хятад улс цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнд нэгдсэн нь түүнд тавих хяналтыг сайжруулах эерэг талтай боловч цөмийн зэвсгийг өөр бусад орон эзэмших, мөн тархаж болзошгүй асуудал санаа зовоох боллоо. Умард Солонгос, Ираны цөмийн хөтөлбөр сэрдлэг төрүүлж, Энэтхэг, Пакистан хоёр бие биеэсээ цөмийн зэвсгээр давамгайлахаар өрсөлдөж буй нь тогтворгүй байдлын шинэ эх сурвалж болж байна.

Хурц, хувьсмал харилцаа бүхий хоёр Солонгос, Хятад-Тайван, Энэтхэг-Пакистан, Хятад-Энэтхэг хоорондын харилцааны зөрчилдөөнтэй асуудлууд, Курилийн арлууд, Энэтхэг-Хятадын хойг хийгээд Зүүн Азийн эрэг хавийн хэсэг арлуудын талаарх маргаан, тэрчлэн Ойрх Дорнодод хэд хэдэн орны нутаг дэвсгэрийг хамарсан зэвсэгт мөргөлдөөн үргэлжилж, олон улсын терроризм, улс үндэстэн дамжсан мансууруулах бодисын зөөвөр, шашны ба үндэстний хэт даврах үйл ажиллагаа улам бүр Ази тивд төвлөрөх болсон зэрэг нь энэ бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх голомтууд болж байна.

### 1.1.3. Бүс нутгийн аюулгүй байдалд тулгарч буй зарим эрсдэл

Хэдийгээр дээр дурдсан шийдвэрлэгдээгүй асуудлууд байгаа боловч Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын геополитикийн нөхцөл байдал ноцтой хүндрэх, томоохон зөрчил сөргөлдөөн үүсэх магадлал бага байна. “Хүйтэн дайн” Азийн өргөн уудам нутагт Европынх шиг тэгтлээ хүчтэй нөлөөлөөгүй, улс үндэстнүүдийн хооронд гүн гүнзгий, урт удаан хугацаагаар үргэлжлэх үзэл суртлын ан цав үүсгэж чадаагүй билээ. Энэ утгаараа дэлхийн хоёр том туйлын

нэг алга боллоо гээд энэ бүс нутгийн аюулгүй байдлын орчинд хүчний тэнцвэр алдагдахад хүргэсэн ноцтой өөрчлөлт ажиглагдаагүй болно.

Ази, Номхон далайн бүс нутагт цэргийн хүчний харьцааны эрс өөрчлөлт гараагүй, Өмнөд Солонгос, Япон, Афганистан, Ирак, Сирийг эс тооцвол Азид бусад орны зэвсэгт хүчний оролцоо одоогоор төдийлөн шаардагдахгүй байна. Ази тив нь зэвсэглэлээр хэт хөөцөлдөх болон цөмийн зэвсгийн өрсөлдөөнд бусдаас харьцангуй бага нэрвэгдсэн юм. Солонгосын дайн, Вьетнам, Афганистан, Ирак, Сирид болсон хэрэг явдлууд бүгд гаднын оролцоотойгоор үүсэж өрнөсөн бөгөөд Дэлхийн II дайнаас хойш азичууд өөр хоорондоо тэгтлээ дайтаж байлдаагүй болно.

Гэхдээ энэ нь Ази, Номхон далайн бүс нутагт улс хоорондын харилцааны тогтвортой байдлыг хангах асуудал чухал болохыг үгүйсгэсэн хэрэг биш юм. Хельсинкийн төгсгөлийн баримт бичиг /1975 он/, эсвэл Парисын тунхаглал /1990 он/ шиг улс хоорондын маргаантай асуудлыг улс төрийн аргаар зохицуулах механизм бий болгох гэж энэ бүс нутгийн улс орнууд удаа дараа санал, санаачилга гаргаж байгаа нь үүний илэрхийлэл болно.

Европт хэрэглэсэн түншлэл дээр тулгуурласан аюулгүй байдлын хамтын тогтолцоог бий болгох ерөнхий зарчмууд Ази, Номхон далайн бүс нутагт ач холбогдолтой юм. Гэхдээ энэ бүс нутгийн онцлогийг тооцох нь зайлшгүй зүйл болно.

Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын асуудлыг зохицуулах үйл ажиллагаа нь зэвсэгт мөргөлдөөн үүсэж болзошгүй районуудад сэргэлдэгч талуудын үйл ажиллагааг хянах, бүс нутгийн хүрээнд цөмийн болон химийн зэвсгийг хязгаарлах буюу тэдгээрээс чөлөөтэй бүсүүдийг бий болгох, харилцан тохиролцох үндсэн дээр улс орнуудын цэрэг, зэвсгийн тоо хэмжээг хорогдуулах, цэргийн үйл ажиллагаа, түүний дотор томоохон хээрийн сургууль, маневр явуулах асуудлыг ил тод болгох, зэвсэглэлийн тоо хэмжээг харилцан хязгаарлах, зэвсэгт хүчнүүдээ зөвхөн өөрийгөө хамгаалах, энхийг сахиулах, терроризмтой тэмцэх болон хүмүүнлэгийн үүрэг биелүүлэх бүтцэд аажмаар шилжүүлэх, цэргийн томоохон бүлэглэлүүдийн байршлыг улсын хилээс холдуулах, цэргийн бодлого, цэргийн номлолоо ил тод болгож, бие биедээ

харилцан мэдээлэх замаар цэргийн итгэлцлийг бэхжүүлэх зэрэг хэлбэрээр хэрэгжих боломжтой юм.

Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулж, маргаантай асуудлуудыг эвийн аргаар шийдвэрлэж байх улс хоорондын механизмыг бүрдүүлэх нь чухал болж байна. Ингэхдээ голлох улс орнуудын оролцоотойгоор зөрчил маргалдааныг улс төрийн аргаар зохицуулах үүрэг бүхий салбар бүс нутгийн байгууллагуудыг бий болгох нь улс хоорондын харилцааны тогтвортой байдлыг хангах, итгэлцлийг нэмэгдүүлэх үндсэн арга байж болох юм.

Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлыг хангахад улс хоорондын цэргийн тэнцвэрийг алдагдуулахгүй байх явдал ихээхэн чухал байна. Энэ нь аль нэг салбар бүс нутаг, улс орны зэвсэгт хүчнийг хэт бэхжүүлэх эсвэл бүр хорогдуулахыг хязгаарлах, тэнцвэрт байдлыг алдагдуулахаар огцом өөрчлөлт гаргахгүй байх нэгдсэн бодлогоор хэрэгжиж болох юм. Ер нь энэ бүс нутагт цэрэг, зэвсгээр хөөцөлдөх явдал одоогоор олон улсын гэрээ хэлэлцээний хүрээний гадна ямар нэгэн хязгаарлалт, хяналтгүйгээр явагдаж байгаа нь үнэн болно.

Хоёр том туйлт сөргөлдөөн үндсэндээ төгсгөл болсонтой уялдан Ази, Номхон далайн эрэг хавийн бүс нутагт АНУ-ын цэргийн оролцоо багассаар, үүнтэй холбоотойгоор, мөн эдийн засгийн бололцоо нь хязгаарлагдмал байгаагийн улмаас ОХУ-ын Зэвсэгт хүчний хөгжилд саад бэрхшээл учирсаар байхад шинээр хөгжиж буй зарим орон, түүний дотор БНХАУ зэвсэгт хүчнийхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх тууштай бодлогоо амжилттай хэрэгжүүлсээр байна.

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутагт зэвсэг экспортлох, импортлох, зөөвөрлөх цар хэмжээ байнга өсөх боллоо. Бүс нутагт олон улсын харилцаа Европтой харьцуулахад нэгдмэл бус байгаа нөхцөлд зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлах асуудал амар хэрэгжих боломжгүй юм. Ер нь том гүрнүүд, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудаас энэ бүс нутагт шинэ зэвсэг, цэргийн технологи нэвтрүүлэхийг хязгаарлах нэгдсэн бодлого явуулах нь хойшлуулушгүй зорилт болж байна. Зэвсэг үйлдвэрлэгч зарим орнуудын экспортыг хязгаарлах хүртэл арга хэмжээ авч болох юм. Япон болон Европын

хамтын нийгэмлэгийн санаачилгаар 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан “Зэвсэглэл нийлүүлэлтийн ил тод байдлыг дээшлүүлэх, ердийн зэвсгийн нийлүүлэлтийг бүртгэх арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэх нь энд нэн чухал байх болно.

#### 1.1.4. Олон улсын аюулгүй байдлын цаашдын төлөв

Олон улсын аюулгүй байдлыг хангахын тулд өнөөдөр мэдрэгдэж байгаа зүйлүүдэд үндэслэлтэй дүгнэлт хийх, ойрын ирээдүйд үүсэж болох нөхцөл байдлыг аль болох бодитойгоор төсөөлөн хооронд нь харьцуулж үзэх нь чухал бөгөөд ер нь иймэрхүү харьцуулалтыг үе үе хийж байх нь ойрын ирээдүйд гарч болох өөрчлөлтийг тухай бүрд нь тодорхойлох бололцоог олгох ач холбогдолтой байдаг. Эдгээрийн дотроос сүүлийн жилүүдэд бий болоод байгаа дараах хүчин зүйлс анхаарал татаж байгаа юм. Үүнд:

1. Юуны өмнө ойрын ирээдүйд улс орнуудын улс төр, эдийн засаг, нийгэм, түүний дотор техник, технологи, цэрэг-стратег, байгаль орчныг хамгаалах болон соёлын хүрээнд гарах өөрчлөлт өмнөх жилүүдтэй харьцуулбал маш өндөр хурдацтай, хамгийн гол нь улам бүр геополитикийн өрсөлдөөний агуулга бүхий, харилцан хамааралтай, маш нягт уялдаатайгаар өрнөх нь тодорхой байна.

2. Үндэстэн улсууд хоорондын гео стратегийн харилцаанд цоо шинэ хандлагууд бий болж Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Холбоо, Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сангаас эхлээд АСЕАН, АПЕК гэх мэтийн улс хоорондын олон талт харилцааг зохицуулах зорилго бүхий байгууллагуудын үүрэг чухлаар шаардагдах төлөвтэй байна. Энэ нь бага буурай орны хувьд төр, засгийн бие даасан үйл ажиллагаа тодорхой хүрээнд хязгаарлагдахад хүргэх, өөрөөр хэлбэл, тусгаар тогтнол, геополитикийн аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудлаа олон улсын харилцааны хэм хэмжээ болон дээрх байгууллагуудын “дохио, зангаа”-тай уялдуулан шийдвэрлэж байх гарцаагүй шаардлагыг үүсгэж болох юм.

3. Үндэстэн дамнасан корпорац, олон улсын байгууллагууд болон гаднын дэмжлэг бүхий янз бүрийн зорилготой иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжиж үндэсний засгийн газруудад хүчтэй

нөлөөлөхийг оролдох, зарим тохиолдолд зөрчилдөөн, тэмцэлдээн, бослого, үймээн үүсгэх явдал газар авах хандлагатай байна. Эдгээрийн жишээ нь хэд хэдэн оронд гарсан “өнгөт” хувьсгал, арабын орнуудад болж буй үйл явдлууд юм.

4. Үүний зэрэгцээ хүмүүс өөрсдийгөө үндэстэн улсын иргэн гэж үзэх нь ойрын ирээдүйд давамгайлсан хэвээр байх нь бас тодорхой байна. Ялангуяа ийм байдал Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад, түүний дотор Зүүн Хойд Азид нэлээд удаан хугацаагаар хадгалагдах бололтой.

5. Мэдээллийн технологи урьд үзэгдээгүйгээр хөгжиж аль ч улс оронд хэрэгтэй мэдээллээ хамгийн хямд өртгөөр, асар өндөр хурдтайгаар авах бололцоог бий болгох бөгөөд энэ нь том бага гэлтгүй бүх улс орон хоорондын улс төр, эдийн засаг, соёл урлагийн гээд бүхий л харилцааны уялдаа холбоог нэмэгдүүлэн нээлттэй байдлыг гүнзгийрүүлж, улмаар хүний нийгмийн нарийн нандинд тооцогддог зүйлсийг танигдашгүйгээр өөрчилж болзошгүй нь улам бүр тодорхой болсоор байна.

6. Шинэ материал, биотехнологи, нано технологи, генийн инженерчлэл зэрэг нь ойрын ирээдүйд хөгжлийнхөө шинэ түвшинд гарах бөгөөд энэ нь улс орнуудын үйлдвэрлэл, ахуй хөтлөх арга ухааныг болон хүний амьдралын хэв загвар, эрхэмлэж ирсэн үнэт зүйлсийн тогтолцоог үндсээр нь өөрчилж болзошгүй байна.

7. Олон улсын гео стратегийн харилцаа, олон улсын эрх зүйн хүрээнд батлан хамгаалах гэдэг нэр томъёо улам бүр өөр агуулгыг илэрхийлэх болж үүнтэй уялдаатайгаар аливаа улсад учирч болзошгүй дайны аюул заналхийлэл, үндэсний зэвсэгт хүчин, түүний үүрэг зориулалтын тухай ойлголт ч эрс өөрчлөгдөж байна.

8. Хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, ядуурал, цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого, терроризм гэх мэт уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж, хамрах орчин, хил хязгаар нь тэлж, байгаагийн дотор коронавируст Ковид-19 гэх мэт амьтны



гаралтай аюулт халдварт өвчний цар тахал олон улсын дэлхийн улс түмэнд бүхэлд нь нүүрлэсэн шинэ аюул занал болон хувирч байна. Эдгээр уламжлалт бус аюул заналхийлэл нь иргэд хувь хүмүүсийн төдийгүй, улс гүрнүүдийн оршин тогтнохын аюулгүй байдалд шууд нөлөөлөх болж байгаатай холбогдон дэлхий нийтийн аюулгүй байдлыг улс орон бүрийн идэвхтэй хамтын ажиллагаагаар, тэр дотроо олон улсын зэвсэгт хүчний нэгдсэн чармайлтаар хангах асуудал улс хоорондын харилцааны нэг гол зангилаа асуудал болон тавигдах боллоо.

Эдгээр нь олон улсын аюулгүй байдалд дараах шинэ хандлагыг үүсгэх боллоо. Үүнд:

1. Дэлхий нийтийг хамарсан даяаршлын үйл явц зарим талаар удаашрах болж, АНУ-ын хэт давамгайлал сааран, үүнтэй уялдаатайгаар улс хоорондын харилцаа дахин олон туйлт хэлбэрт шилжих төлөвтэй байна. Соёл иргэншлийн гэж хэлж болох эдгээр туйлын тоонд юуны өмнө АНУ тэргүүтэй улс төр, цэргийн холбоотон улсууд, ОХУ, түүнийг дагасан хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан зарим орныг хамааруулж болохоор байна.

Үүний зэрэгцээ Хятадын бие даасан, гэхдээ Зүүн Өмнөд Азийн болон Африкийн зарим орныг оролцуулсан гео бодлого улам бүр өргөжих болж, Баруун Европын харьцангуй бие даах эрмэлзэл үргэлжилсээр, Энэтхэгийн хурдацтай хөгжил, харьцангуй ганцаарчилсан тоглолт, ОХУ-БРИКС-ийн улсууд болон ОХУ-Ойрх дорнод, Хойд Африкийн орнуудын улс төр, эдийн засаг, цэргийн харилцаа, Лалын ертөнцийн болон Латин Америкийн улс орнуудын нэгдэх үйл явц алхам, алхмаар урагшилсаар байна.

2. Цаг хугацааны хүчин зүйлтэй өрсөлдөн явагдаж буй энэ үйл явц шийдвэрлэхэд амаргүй олон асуудлыг араасаа дагуулж, бүс нутгуудад хадгалагдсаар буй хуучин сөргөлдөөнийг улам бүр гүнзгийрүүлж, үүний зэрэгцээ янз бүрийн үүдэлтэй дараах шинэ эрсдэлийг бий болгох төлөвтэй байна. Үүнд:

- Улс орнууд олон туйлд хуваагдах энэ үйл явц Хойд Америк, Баруун Европ, Еврази болон Дорнод Европ, Зүүн Ази, Өмнөд Ази, Өмнөд Америкийн эсвэл христийн, лалын гэх мэт ахуй хөтлөх арга ухаан, хэл, соёл шашин

шүтлэгийн түүхэн уламжлал, нэгдмэл үзэл санаа, үндэстэн болон бүс нутгаараа сондгойрох эрмэлзэл дээр үндэслэх;

- Энэ үйл явц аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт ч мөн хүчтэй нөлөөлж, зарим тохиолдолд улс төр, цэргийн эвсэл холбооны хэлбэрт шилжих, улс хоорондын зөрчил, сөргөлдөөнийг улам бүр зэвсэгт мөргөлдөөн, дайнаар шийдвэрлэхийг эрмэлзэх агуулгатай болж улс, үндэстнүүд энх тайвнаар зэрэгцэн орших үзэл санаа хойш тавигдах ;
- Эдийн засгийн уналтын шинэ давлагаан үүсгэж, түүний дотор валютын, юуны өмнө долларын зах зээлийн хямралыг бий болгон энэ нь улмаар улс төрийн харилцааны болон өргөжих;
- Хөгжиж буй эдийн засагтай орнуудыг аль нэг туйлыг дагахаас өөр аргагүйд хүргэн ирээдүйгээ буюу түншээ сонгох талаасаа хүнд сорилтод оруулах;
- Ойрх Дорнод,Өмнөд Ази болон бусад бүс нутагт хэрэгжүүлж буй цэргийн хүчээр асуудлыг шийдвэрлэх элдэв оролдлого амжилтгүй болж олон арван жилээр үргэлжилж буй зэвсэгт мөргөлдөөнүүд хяналтаас гарах;
- Цөмийн зэвсгээр хөөцөлдөж буй Хойд Солонгос, Ираны эсрэг хориг арга хэмжээ АНУ-ын хэт тулгалт болон ОХУ, Хятадын эдгээр орныг битүүхэн дэмжсэн бодлогын улмаас төдийлөн амжилтад хүрэхгүй байх, үүний улмаас цөмийн зэвсэг бүхий орнууд энэ төрлийн зэвсгийг хэрэглэхэд тавих хязгаарлалтаа тодорхой хэмжээгээр сулруулах, улмаар бусад оронд цөмийн зэвсэг бүтээх эрмэлзэл үүсэх, үүнээс үүдэн уг зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ үндсэндээ утга агуулгаа алдах;
- НАТО-г өргөтгөх зорилго бүхий АНУ-ын хатуу бодлогын хариуд ОХУ Зэвсэгт хүчнээ өргөтгөх, хүчирхэгжүүлэх, олон улсын харилцааны салбарт цэрэг-зэвсгийн давамгайл байдлаа ашиглах байр суурь баримтлах;
- ОХУ-аас Хятадтай цэргийн салбарт ойртон нягтрах, ойр зэргэлдээ орнуудад цэрэг-стратегийн нөлөөгөө бэхжүүлэх зорилго бүхий идэвхтэй үйл ажиллагаа явуулах, ТУХН-ийн зарим орныг багтаасан болон БНХАУ,

Монголыг оролцуулсан, өөрөөр хэлбэл Евроазийн гэж хэлж болох улс төр-цэргийн шинэ эвсэл байгуулахыг оролдох.

3. Ойрын ирээдүйд байгалийн гамшигт үзэгдлийн давтамж олшрох, дэлхийн цаг уурын дулаарал хадгалагдах, хүний амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, өлсгөлөн үргэлжлэхийн зэрэгцээ аюулгүй байдлын улс хоорондын хамтын ажиллагаа суларсны улмаас үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, олныг хамарсан цагаачлал, эмх замбараагүй дүрвэлт, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого гэх мэт уламжлалт бус аюулын занал нэмэгдэх, хамрах орчин, хил хязгаар нь өргөжих, олон улсын терроризм хүрээгээ тэлж шинэ улс орнуудыг хамрах, түүний дотор Монгол Улстай хил залгаа Төв Ази, Хятадын Шинжаанд өргөн хүрээтэйгээр нэвтрэн орж ирэх шинж төлөвтэй байна.

### **Коронавируст ковид-19 хэмээх цар тахалтай уялдаатайгаар бий болсон нөхцөл байдал**

Дэлхийн бүх улс оронд тархаад буй коронавируст Ковид 19 хэмээх цар тахлын улмаас улс орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа, дотоодын нийгмийн харилцаа, хүмүүсийн ахуй хөтлөх, боловсрох, шинжлэх ухааны хөгжүүлэх, бие биестэйгээ харилцах арга ухаанд эргэлт буцалтгүй шинэ өөрчлөлт гарч эхэллээ.

Коронавируст Ковид-19, түүнчлэн ДОХ, САРС, Гахайн болон шувууны ханиад гээд амьтнаас гаралтай өвчнүүдээс үүдэлтэй дэлхий нийтийг хамарсан хямралаас үүсэж буй хандлагыг ерөнхийд нь утгачлан “Бүх зүйлийг зайнаас” гэсэн томъёоллоор илэрхийлж болохоор байна. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн улам бүр тоон ертөнц рүү шилжих бөгөөд үүний хурд нь энэ салбарт аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанаас илүү түргэн байгаа учир олон шинэ ноцтой эрсдэлийг дагуулах бололтой. Нэг үгээр бол өвчин тараагч коронавирусын дараагаар хаа сайгүй нэвтрэх тоон коронавирус гарч ирэх магадлал өндөр байна

Удирдлага, үйлдвэрлэл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд гээд хүний үйл ажиллагаа, амьдрах арга ухааны бүх салбарт энэ хямралаас өмнө амжин үйл ажиллагаагаа зайнаас удирдах, автоматжуулах хэлбэрт шилжүүлж, онлайн процессор, мэдээлэл дамжуулах орон зайн хэрэгсэлтэй болж, үүгээрээ хөдөлмөрийн бүтээмжээ өндөрт гаргаж чадсан, шинэ технологийн хувьд хүчирхэг болсон байгууллага, компаниуд л амьдрах чадвараа хадгалан үлдэх бололтой. Энэ нь эдгээрт цөөн тооны ажиллах хүчин буюу аливаа өвчинд өртөх хүний тоо бага шаардагдахтай холбоотой юм. Гэхдээ энэ нь ажилгүйдэл хүчтэй нэмэгдэх өөр нэг шинэ том сорилт авчрах болно.

Түүнчлэн эдгээр өөрчлөлт нь коронавирусын дараах ертөнцөд гарах шинэ бололцоог хүлээж байгаа жижиг, дунд бизнесийн байгууллага, компаниудад илүү ашигтай байж тэдний хөгжлийг давуу байдалтайгаар хурдасгах нь бас тодорхой байна. Энэ нь шинээр буй болж буй зайн, тоон технологи нь ийм байгууллага, компаниудад бүх төрлийн зах зээлд элдэв саад, бэрхшээлгүй нэвтрэх бололцоог өмнө нь байгаагүйгээр олгох болсонтой уялдаатай байна

Энэ хямрал хуучинсаг үзэл бодлыг чөлөөт сэтгэлгээ бүх зүйл дээр ялах бололцоог бий болгоод байна. Жишээлбэл, импортыг орлуулах үйлдвэрлэл бүх оронд маш эрчимтэй хөгжиж эхэллээ. Нэг компанийг бүтэн циклийн үйлдвэрлэлд шилжүүлэх үйл явц хамтарсан болон үндэстэн дамжсан компаниудын эрин үеийг үндсэндээ төгсгөл болгож байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн бүх үйл ажиллагаагаа өөрөө бие даан явуулах чадвартай буюу бусдаас юм бараг худалдаж авдаггүй, эсвэл цөөн хамтрагчтай компаниуд илүү хамгаалагдсан байсан нь одоо тодорхой болж байна.

Эдгээрээс харахад олон улсын аюулгүй байдлын асар хурдацтай өөрчлөлт дэлхий ертөнцийг ойрын ирээдүйд хүлээж байна. Мэдээж энэ өөрчлөлт улс орон бүрд харилцан адилгүй нөлөөлөх боловч юуны өмнө бага улсуудын үндэсний аюулгүй байдалдаа хандах байр суурьд шинэчлэлийн гэж хэлж болох тодотгол хийх шаардлагыг үүсгэж болох нь улам бүр ойлгогдсоор байна. Орчин үед аливаа нэг улс нөгөөгийнхөө тусгаар тогтнолд цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул ихээхэн багассанаар хүн төрөлхтөнд тайвшрах бололцоо гарч ирж байгаа мэт боловч улс болгоны үндэсний ашиг сонирхолд харшлах, аюулгүй

байдлыг нь хэврэгшүүлэхэд хүргэж болзошгүй олон шинэ эрсдэл бий болж байгаа нөхцөлд бид амьдарч байна.

### **Товч дүгнэлт**

Улс хоорондын харилцаанд бүх оронтой найрсаг харилцааг хөгжүүлэх, олон улсын энхийг сахиулах болон терроризмын эсрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, ардчилал, хүний эрх эрх чөлөөг эрхэмлэсэн иргэний нийгэм байгуулах зорилго бүхий Монгол Улсын гадаад, дотоод бодлого нь нийт ард иргэдийн болон бусад орны хүчтэй дэмжлэгийг хүлээн манай үндэсний аюулгүй байдлыг хангах нэг үндсэн баталгаа болсоор байна.

Үүний зэрэгцээ олон улсын харилцаанд бүх оронтой, түүний дотор дэлхийн тэргүүлэх гурван гүрэн болох АНУ, ОХУ, БНХАУ, тэгээд Европын холбоотой бүгдтэй нь найрамдалт харилцаатай байхыг эрмэлзэж ирсэн, гуравдагч хөршийн гэж нэрлэгддэг, тодорхой хугацаанд үр дүнтэй байсан манай улсын гадаад бодлого хүссэн хүсээгүй зарим асуудал дээр үүнийгээ эргэж харах, юуны өмнө ОХУ, БНХАУ нэг талаас, АНУ, Европын холбоо нөгөө төлөөс оролцож буй тэмцэл, өрсөлдөөнд хэрхэн хандах талаар өөрийн гэсэн тодорхой байр суурьтай байхаас өөр аргагүйд хүрэх төлөвтэй байна.

Түүнчлэн АНУ болон Европын холбооны эсрэг байр суурь дээр одоохондоо нэгдмэл байгаа боловч Монголын талаар хэзээнээс өөрсдийн гэсэн өөр өөр, уламжлалт үзэл бодолтой ОХУ, БНХАУ-тай тодорхой зарим асуудал дээр, тухайлбал, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаанд хэнтэй нь арай давуу байдалтай, ойр нягт байхаа сонгох зайлшгүй шаардлага үүсэх цаг үе нэг их хол биш байгаа бололтой.

Ийм учраас:

- ОХУ, БНХАУ-ын зэрэгцээ АНУ, Европын холбоо болон бусад Барууны улс орон болгонтой аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах үндсэн чиглэл, агуулгаа шинэчлэн гүнзгийрүүлэх, өөр хоорондоо нягт уялдаатай боловч бие биеэсээ тодорхой хэмжээгээр ялгагдах, гэхдээ эдгээр улсын аль нь ч ойлгон,

хүндэтгэн хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдлаар тодотгон томъёолох нь шаардлага үүсэж магадгүй байна.

Магадгүй энэ нь ОХУ-тай батлан хамгаалахын, БНХАУ-тай гадаад худалдааны, АНУ-тай ардчилал, зах зээл, иргэний нийгмийн харилцааны, Японтой хөрөнгө оруулалтын, Энэтхэг улстай соёл иргэншил, шашны гэх мэт агуулгыг голлосон хэлбэртэй байж болох юм;

## **1.2. Аюулгүй байдлын дотоод орчны өөрчлөлт**

### 1.2.1. Аюулгүй байдлын дотоод орчны өөрчлөлтийн өнөөгийн байдал, ерөнхий хандлага

Монгол Улсын аюулгүй байдал нь дан ганц гадаад орчны өөрчлөлтөөс бус, бас нийгэм-улс төрийн сэтгэлгээний дотоод нөхцөл байдлын өөрчлөлтөөс ихээхэн шалтгаалсан хэвээр байна.

Монголын Их гүрэн задран унаснаас хойших олон зуун жилд анх удаа монголчууд төр улсдаа жинхэнэ ёсоор эзэн болж, манай тусгаар тогтнол, газар нутагт харийн цэрэг шууд заналхийлээгүй тийм цаг үетэй бид золголоо. Гэвч ингэснээр Монгол Улсын аюулгүй байдал дотооддоо найдвартай хангагдлаа гэсэн төгс баталгаа бүрэн дүүрэн бий болоогүй байна.

Дотоодын аюулгүй байдлын тухай монголын төсөөлөл нь манай ард түмэн хувь заяагаа өөрсдөө шийдвэрлэх, түүний дотор нийгмийн хөгжлийн замаа чөлөөтэй сонгох, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх ойлголтод тулгуурлаж байна. Мөн улс орны харьцангуй бие даасан хөгжил, төр, засгийн бодлого, үйл ажиллагааны бусдаас хараат бус байдал, шинж төлөв нь аюулгүй байдлыг хангах нэг чухал нөхцөл гэж ойлгогдож байгаа юм. Эдгээрийг олон улсын хамтын нийгэмлэг болон өндөр хөгжсөн орнууд хүндэтгэн анхаарч байгаа болно.

Үүний зэрэгцээ улсын хөгжлийн зарим салбар зогсонги байдалд удаан байх, түүний дотор улс төрийн амьдрал, нийгмийн ухамсарт тогтворгүй байдал давамгайлах нь өнөөдөр Монгол Улсад гаднаас учирч болох аюулаас ч илүү хор хөнөөлтэй байж болзошгүй юм. Улс төрийн намууд хоорондын зөрчилдөөн,

нийгмийн баялгийн хуваарилалтад гарч буй гажуудал, эдгээрээс үүдэлтэй ядуурал, бухимдал, тэрчлэн элдэв гэмт хэрэг, халдварт өвчний тархалт нэмэгдэж байгаа, хүрээлэн буй орчны асуудал сэтгэл түгшээх болсон зэрэг нь аюулгүй байдлын цэргийн бус хүчин зүйлд нухацтай анхаарахыг шаардаж байгаа бөгөөд эдгээр нь ардчилал өндөр хөгжсөн бусад орны зүгээс манай улсын талаар баримтлах бодлогод болгоомжлох байдал үүсгэж мэдэхээр зүйл юм.

Ойрын ирээдүйд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй дотоод хүчин зүйлс нь улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчны гээд янз бүрийн үүдэлтэй байх нь тодорхой боловч үндсэндээ цаг үеийн гэж хэлж болох хоёр том багц үйл явдлаас шалтгаалах нь тодорхой байна.

1 дүгээрт: дэлхий нийтийг бүрхсэн коронавируст Ковид-19 хэмээх цар тахлаас үүдэлтэй эрсдэл, сорилтууд.

Хэрэв энэ цар тахал улам бүр нэмэгдэж нийтийг хамарсан өвчлөл болон олон хүний амь нас үрэгдэх, ард иргэд эрүүл мэнд, мөнгө санхүүгээрээ хохирох байдалд очих юм бол улс орны эдийн засгийн ачаалал дааж давахгүйд хүрэх, үүнээс улбаалан эрүүл мэндийн салбар, магадгүй энэ цар тахалтай тэмцэж буй хүчний байгууллагуудын дампуурал хэлбэрээр илэрч болохоор байна. Энэ нь хүссэн хүсээгүй засаглалын хямрал буюу өнөөгийн Засгийн газарт ард иргэдийн итгэл алдрахад хүргэж болохоор байна.

Эсвэл энэ тэмцэлд Засгийн газар ялалт байгуулан цар тахлыг тогтоон барьж улмаар бүх нийтийн вакцинжуулалтаар аюулыг хэсэг хугацаанд чиг болтугай дарж авах юм бол хэдийгээр энэ нь Засгийн газрын нэр хүндийг тодорхой хэмжээгээр өргөх боловч улсын эдийн засгийг дахин сэргээх дааж давахад бэрхшээлтэй олон асуудал, түүний дотор төр улс, ард иргэд аль аль нь даж давшгүй их өртэй болоход хүргэж магадгүй байна. Энэ нь эргээд л мөн нийгмийн хямрал, тогтворгүй байдлыг үүсгэх магадлалтай юм.

2 дугаарт Монгол Улсад улс төрийн соёл, ардчилал төдийлөн төлөвшиж чадахгүй, нийгэмд янз бүрийн үүдэлтэй хуваагдмал байдал хадгалагдсаар, дээр нь хэдийгээр 2019 онд Үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулж гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн боловч засаглалын

хуваарилалт төдийлөн оновчтой бус хэвээр байгаагаас үүдэн гарч болзошгүй эрсдэл сорилтууд. Энэ нь 2021 онд болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох улс төрийн хоёр гол хүчний эвлэршгүй эсрэг тэсрэг байр суурь, үүнээс үүдэх дүрэмгүй зөрчил сөргөлдөөнөөр илрэх шинжтэй байна.

Үүнээс үүдэн хэрэв сонгуульд сөрөг хүчний төлөөлөл ялбал төрийн өндөрлөг хоорондын эрх мэдлийн төлөөх тэмцэл шинэ эрч хүчтэйгээр өрнөх, харин засгийн эрх барьж буй улс төрийн хүчний төлөөлөл ялах юм бол бас нэг тодорхой хэмжээний эрсдэл дагуулсан нэг намын хүчтэй засаглал тогтох магадлал бий болохоор байна.

Дээрхтэй уялдаатайгаар ойрын гурван жилд юуны өмнө коронавируст Ковид-19 хэмээх цар тахлын эсрэг хийж буй тэмцлийг аль болох оновчтой, манай орны нөхцөлд тохирсон, хамгийн гол нь бодит үр дүнтэй явуулах нь амин чухал асуудал байх болно.

Засаглалын хуваарилалтыг дахин оновчтой, тодорхой аль болохоор сонгомол утгаар нь болгох, үүгээрээ эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, сайн засаглалыг бэхжүүлэх бодит нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн буюу Үндсэн хуульд дахин тодотгол хийх арга одоогоор хэрэгжих бололцоогүй учир улс орны өмнө ойрын ирээдүйд тулгарах асар их бэрхшээл саад угтаж байгааг харгалзан магадгүй ард түмэн улс төрийн гол хоёр хүчин, мөн бусад намаас сонгуульд оролцох үндэсний эв нэгдлийн нэгдсэн байр суурийг илэрхийлсэн хамтын хөтөлбөрийг боловсруулах, магадгүй үндэсний манлайлагчаа хамтран тодруулахыг шаардахад хүргэж чиг болохоор байна

Ямар ч тохиолдолд сонгуулийн компанит ажлын явцад аль нэг намын явцуу байр суурь, өөрийгөө нэр дэвшүүлсэн, дэмжиж тусалсан цөөн хэдэн хүний үзэл бодлыг бус улс орны үндэсний эрх ашгийг илэрхийлэх, ялалтынхаа дараа хүчний тэнцвэрийг хадгалан, улс төрийн аль ч намтай үг хэлээ олж ажиллан, үндэсний эв нэгдлийг илэрхийлэгч байж чадах тийм хүмүүсийг дэвшүүлэх нь чухал байж чиг болох юм.

### 1.2.2. Үндэсний үнэт зүйлсийн тухай ойлголтын өөрчлөлт



Аливаа бага улс, түүний дотор үндсэндээ нэг үндэстнээс бүрддэг орны хувьд аюулгүй байдлаа хангах үзэл баримтал, бодлого, үйл ажиллагаа нь үндэснийхээ үнэт зүйлс, улмаар үндэснийхээ язгуур эрх ашгийг тунгаан ойлгож ухамсарт үнэмшил болгон хөгжүүлэхтэй ихээхэн холбоотой байдаг. Ийм учраас төрөөс стратегийн эрсдэлийн удирдлагын салбарт баримтлах бодлогын үндсийг боловсруулах асуудлыг авч үзэхийн тулд юуны өмнө бидний эрхэмлэн шүтэх ёстой үндэсний үнэт зүйлс, язгуур ашиг сонирхлыг өнөө үед хэрхэн ойлгож байгаад дүн шинжилгээ хийх, ер хэрхэн ойлгох ёстойг тунгаан бодож, нээн илрүүлэх нь ихээхэн чухал юм.

Энэ нь улс орны аюулгүй байдлыг хангах зорилгоор төрөөс явуулах бодлого, үйл ажиллагаа нь нэг талаас Монголын иргэдийн эрхэмлэн шүтэх үндэсний үнэт зүйлсийг түүхэн уламжлал, өнөөгийн шаардлагын үүднээс зөвөөр тодорхойлсноор, нөгөө талаас тэдгээрийг улс төр, эрх зүй, нийгэм, эдийн засаг, цэргийн зэрэг бодит үйл ажиллагаа, эдгээрийн эрх зүйн оновчтой зохицуулалтаар хамгаалахад оршдогтой холбоотой юм. Энэ нь эцсийн дүндээ үндэсний үнэт зүйлсээ хадгалан хамгаалах нь үндэсний язгуур ашиг сонирхол байдаг гэсэн үг юм.

Сүүлийн үед монголын нийгэмд хоёр төрлийн үнэт зүйл зэрэгцэн оршиж байгаа нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

Нэгдүгээрт. 1990-ээд оны эхээр “пролетарийн интернационализм” ийн эсрэг сөргүүлэн гаргаж ирсэн нийт хүн төрөлхтний эрхэмлэх үнэт зүйлс орно. Энэ ойлголт нь хүний нийгмийн олон үеийн хөгжлийн явцад хуримтлуулсан ардчилал, хүний эрх, эрх чөлөө, зах зээлийн эдийн засаг, хувийн өмч, гэр бүл, орон гэр, гал голомт, шашин шүтлэг зэргийг хүндэтгэх үзэл бодолд тулгуурладгаараа яах аргагүй эрхэм, нандин үнэт зүйлс юм.

Үүний хажуугаар монголын нийгмийн сүүлийн жилүүдийн бодит амьдралаас харахад маргах аргагүй эдгээр үнэт зүйлс нь барууны, түүний дотор христийн шашин бүхий орнуудад хэвшил болсон үзэл бодол, нийгэм, амьдралын тухай ойлголт, шашин шүтлэг, биеэ авч явах зарчмыг бидэнд тулган хүлээлгэх хэлбэрийг хойноосоо дагуулж яваа нь бас ажиглагдаж байна.

Гэтэл Монгол улс олон зууны турш хуримтлуулсан эрхэмлэн шүтэх өөрийн гэсэн үндэсний үнэт зүйлстэй, бурхны шашинтай, нүүдэлчин ардын бие даасан соёл иргэншлийн уламжлал бүхий орон билээ. Иймд тодорхой чиглэл зорилготой, сэхээ авах зав зайгүй нэвтэрч буй гаднын гэж болох дээрх нөлөөлөл нь хэдийгээр хүн төрөлхтний эрхэмлэх нийтлэг уриа лоозон дор хийгдэж байгаа ч монголын нийгмийн уламжлалт ёс суртахуунтай зөрчилдөөн үүсгэж байна.

Хоёрдугаарт. Үүний эсрэг, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг сөргүүлэн зөвхөн "Монголын үнэт зүйлс" гэгчийг дэвшүүлэн тавих нь элбэг байна. Үзэл суртлын олон жилийн хүлээснээс салсан 1990-ээд оны эхээс энэ үзэл баримтлалыг эрхэмлэгчдийн бодлого, үйл ажиллагаа нь эцсийн дүндээ нүүдлийн монголын соёл иргэншлийн оюун санааны уламжлал, бурхны шашин, ахуй хөтлөх арга ухааныг голлох, үүн дээрээ тулгуурлан Монголын Их гүрний үеийнхтэй төсөөтэй төр, нийгмийн хатуу дэг журмыг үндэслэл болгосон улс орныг байгуулахад чиглэж байна. Эдгээр хүмүүс нь үүнийгээ их гүрнүүдийн олон янзын санаархлын үр нөлөөгөөр монголын ард түмэн өөрийн өвөрмөц ахуй соёл, төрт ёсны уламжлалаа алдах тал руугаа явж байна гэсэн үндэслэлээр тайлбарлаж байгаа болно.

Эдгээрээс харахад зах зээлийн эдийн засаг, ардчилал, хүний эрх, эрх чөлөө зэрэг нь монголын ард түмний ирээдүйн хөгжил, төр улсын оршин тогтнох цаашдын замд хөтлөх гол хүчин зүйлүүд мөн ч монгол үндэстний уламжлал дээр тулгуурласан өөр бусад зүйл дутагдаж байгаа нь улам бүр ойлгогдсоор байна.

Үүний зэрэгцээ, зөвхөн нүүдлийн соёл иргэншил, ардын уламжлалт зан заншил, ахуй хөтлөх арга ухаан, бөө мөргөлөөс уламжлалтай мухар сүсэг болон дан ганц зарим талаар цаг үеэсээ хоцрох болсон бурхны шашныхаа тогоонд хязгаарлагдах нь хүн төрөлхтний хөгжил дэвшлийн түгээмэл замд хөл нийлүүлэхэд монголын ард түмэнд тийм ч их тус дөхөм болж чадахгүй нь бас тодорхой болж байна.

Ямар ч болов Монголын нийгмийн өнөөгийн бодит байдал нь хувь хүн, нийгэм, төр улсыг хооронд нь холбох шинэ үзэл бодол, үнэт зүйлсийн тогтолцоог зүй ёсоор шаардаж байгаа нь тодорхой бөгөөд энэ нь үндэсний аюулгүй

байдлын салбарын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх ажлын нэг гол агуулга байх ёстой нь ойлгогдож байна.

Тэгвэл энэ шинэ үнэт зүйл нь юу байх вэ?

Сүүлийн үед Монголын улс төр, нийгмийн амьдралд бий болоод байгаа хямралт байдал нь эцсийн дүндээ ард түмний эрхэмлэн шүтэх шинэ үнэт зүйл нь үндэсний эв нэгдэл байх ёстой гэдгийг улам бүр тодорхой болгосоор байна.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд, сүүлийн үед Монгол Улсын өмнө тулгарч буй бэрхшээл болгоныг түүний дотор хүний аюулгүй байдал, амьжиргааны түвшинтэй холбогдол бүхий тулгамдсан асуудал бүрийг үндэсний аюулгүй байдлын түвшинд авч үзэх, тэр байтугай эдгээрийг улс төржүүлэн дэвэргэх явдал ихээхэн газар авах шинжтэй байна.

Гэтэл эдгээр нь дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн үзэл бодлын үүднээс үндсэндээ улс орны хөгжлийн асуудал байдаг бөгөөд улс орны хөгжилд тулгарсан бэрхшээл саад болгоныг үндэсний аюулгүй байдлын асуудал болгон авч үзэх нь ихээхэн учир зүйл дутагдалтай юм.

Хүнсний чанарын асуудал, амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, ядуурал, эдгээрээс үүдэлтэй нийгмийн бухимдал, цагаачлал, хүний наймаа, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого гэх мэт өнөөдөр монголын нийгмийн бухимдлын үндэс болж буй цөөнгүй зүйл нь хүн төрөлхтний хувьд нийтлэг зүйл бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгийн нэгдсэн чармайлт, улс орон бүрийн зөв ухаалаг үндэсний хөгжлийн бодлогоор шийдвэрлэгдэж болох асуудал юм.

Харин улам бүр даяаршиж буй өнөөгийн ертөнцөд үндсэндээ нэг үндэстнээс бүрдсэн, том хөршүүдийн дунд түгжигдмэл байдлаар оршдог, хөгжиж буй жижиг орон болох Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хөгжлийн бодлогын түгээмэл асуудлуудтай хэт хутгалгүйгээр зөвхөн тусгаар тогтносон үндэстэн улсын хувьд оршин тогтнох, өвөрмөц соёл

иргэншил, хүн амын удмын сан, угсаа гарвалиа буюу өмнө дурдсанаар үндэсний язгуур эрх ашгаа хадгалан хамгаалж, хойч үедээ үлдээх асуудалд гол анхаарлаа хандуулах учиртай болох нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

Энэ нь стратегийн эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах, улмаар бусад үзэл баримтлал холбогдох хууль тогтоомжийг тодотгон шинэчлэх ажлын гол агуулга байж болох юм гэж үзлээ.

### 1.2.3. Үндэсний ашиг сонирхлын тухай ойлголтын шинэчлэл

Аливаа улсын аюулгүй байдал нь аюулгүй байдлын гадаад орчин, үүнээс үүдэлтэй дотоод нөхцөл байдал гэсэн хоёр хүчин зүйлийн нөлөөлөл дор бүрэлдэн бий болдог зүй тогтолтой. Үүний дотроос аюулгүй байдлын гадаад орчны нөлөөлөл нь тухайн улс орныг хүрээлсэн улс орнуудын гео стратегийн бодлого болон түүний өөрийнх нь геополитикийн ашиг сонирхол хоорондын харьцааны шинж чанараас үүсдэг байна.

XXI зуун даяаршлын эрин болох төлөвтэй байгаа бөгөөд улс орнуудын эдийн засаг, технологи, соёл, улс төрийн харилцаа улам бүр өргөжин, нягт уялдаатай болж орон бүрд хөгжлийн асар их боломж нээгдэж байна. Даяаршлын үйл явцаас Монгол Улс хол хөндий байж чадахгүй нь ойлгомжтой. Гэвч даяаршил улс орнуудын аюулгүй байдалд тодорхой эрсдэлийг бий болгож байгааг анхаарахгүй байж бас болохгүй юм. Тийм эрсдэлийн тоонд улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн гэх мэт үүдэлтэй улс хоорондын харилцааны ашиг сонирхлын зөрчил, сөргөлдөөн багтаж болох юм. Гэхдээ аливаа улс орон зөрчил, сөргөлдөөн болгоныг аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд авч үздэггүй бөгөөд зөвхөн эдгээрийн өрнөлт нь үндэсний ашиг сонирхолд харшлах хэмжээнд хүрэх тохиолдолд тэдгээрийг сэрэмжлэн зайлуулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Ийм учраас эхлээд улс хоорондын харилцааны ашиг сонирхлыг олон улсын харилцааны шинж чанараар нь ангилан үзэх нь чухал юм.

Эсрэг тэсрэг ашиг сонирхол: Энэ бүлэгт улс хоорондын зөрчил сөргөлдөөн үүсгэж болох огт эвлэршгүй, бие биеэ үгүйсгэгч улс хоорондын харилцааны

үүдэлтэй ашиг сонирхол багтдаг. Аливаа нэг улсын буюу улс хоорондын эвсэл, холбооны ашиг сонирхол нь нөгөө улс, эвсэл, холбооныхоо ийм төрлийн ашиг сонирхлыг үгүйсгэх тохиолдолд тэдгээрийн хооронд эвлэршгүй зөрчил, сөргөлдөөн үүсдэг. Ингээд эсрэг тэсрэгийн энэ зөрчилдөөн нь түүнийг хязгаарлах хүчин зүйл байхгүй буюу хангалтгүй тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд хүргэдэг байна. Үүнтэй холбогдуулан хэлэхэд улс хоорондын ашиг сонирхлын ийм зөрчилдөөн нь янз бүрийн агуулгаар түүний дотор үзэл суртлын ялгаа, зах зээлийн төлөө тэмцэлдээнээс эхлээд шашны эвлэршгүй үзэл бодол хүртэл маш олон хэлбэрээр илэрдэг болно. Үүний нэг тод жишээ нь социалист, капиталист гэж нэрлэгдэж байсан хоёр тогтолцооны зөрчилдөөн байлаа.

Ангид ашиг сонирхол: Үүний тоонд хоорондоо зөрчилдөх боловч, бие биеэ үгүйсгэдэггүй улс хоорондын харилцааны үүдэлтэй ашиг сонирхол хамаардаг. Ийм ашиг сонирхол нь хэдийгээр эсрэг тэсрэг маягийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэдэг боловч өөр ашиг сонирхлыг шахан хязгаарлах бодлогыг гол болгодоггүй. Ангид ашиг сонирхол нь эсрэг тэсрэг ашиг сонирхлоос зөрчил сөргөлдөөн үгүйгээр биш харин тэдгээрийн эрч хүч, хор нөлөө нь бага байдгаар ялгагддаг юм. Гэхдээ зөрчил сөргөлдөөн хурцадвал энэ нь эсрэг тэсрэг ашиг сонирхол болон хувирах талтай байдаг. Олон улсын практикт тохиолддог ангид ашиг сонирхлын тод илэрхийлэл нь тодорхой бүс нутагт гео улс төр, гео эдийн засаг, өөрийн соёл иргэншлийн нөлөөллөө бий болгохын төлөөх том гүрнүүдийн өрсөлдөөн байдаг.

Зэрэгцээ ашиг сонирхол: Энэ бүлгийн улс хоорондын харилцааны ашиг сонирхлын хооронд эсрэг тэсрэгийн зөрчил сөргөлдөөн бараг байдаггүй. Харин ч улс орнууд мөн чанартаа ойролцоо, агуулгын хувьд үндсэндээ нэг ашиг сонирхлыг эрхэм болгодог онцлогтой юм. Гэхдээ аливаа улс орон өөрийн ашиг сонирхлыг бие даан, бусдын оролцоогүйгээр шийдвэрлэхийг эрмэлздэгээрээ энэ бүлэг нь ялгагддаг. Энэ нөхцөл байдалд улс хоорондын харилцаанд хурцадмал байдал бараг үүсдэггүй боловч хамтран ажиллах явдал бас сайнгүй байдаг. Зэрэгцээ ашиг сонирхол тодорхой нөхцөлд хоорондоо холдох буюу ойртон нийлэх талтай байдаг.

Хамтын ашиг сонирхол: Энэ ойлголтод хоёр буюу хэсэг бүлэг улс орны тодорхой асуудлаар олон улсын харилцааны салбарт баримтлах бодлого үйл

ажиллагаа, өөрсдийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх арга, зорилт үндсэндээ бүрэн дүүрэн ижил байхыг хамааруулж болох юм. Ийм нөхцөл байдал тухайн улс орнууд, өөрсдийн ашиг сонирхлыг тус тусдаа бие даан хэрэгжүүлэх бололцоогүй буюу бэрхшээлтэй үед ихэвчлэн бий болдог бөгөөд үүнд оролцогч улс орнууд бүх талаар хамтран ажиллах шаардлагыг үүсгэдэг байна.

Олон улсын аюулгүй байдлын шинэ нөхцөл дэх үндэсний язгуур ашиг сонирхол: Одоо мөрдөгдөж буй Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндэсний язгуур ашиг сонирхлыг “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана” хэмээн харьцангуй үндэслэлтэй зөв тодорхойлсон байна. Гэхдээ энэхүү төслийн ажлаар явуулсан судалгааны үр дүнд тулгуурлан энэ тодорхойлолтыг өнөө үед бий болсон олон улсын аюулгүй байдлын нөхцөлтэй уялдуулан бага зэрэг цомхотгох, гэхдээ зарим тулгуур ойлголтын агуулгыг тодотгож, хэллэг найруулгын хувьд арай оновчтой болгон дараах байдлаар томъёолох нь зүйтэй санагдаж байна. Үүнд:

“Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдал, монгол соёл иргэншил, үндэсний эв нэгдэл, монгол хүний удмын сан, угсаа гарвал, төр, уламжлалт шашнаа дээдлэх үзэл санаа багтана” хэмээн томъёолбол олон улсын аюулгүй байдлын өнөөгийн шинэ нөхцөлд илүү оновчтой болно гэж бодож байна.

Олон улсын аюулгүй байдлын шинэ нөхцөл дэх үндэсний амин чухал ашиг сонирхол: Энэ ашиг сонирхолд үндэстэн улсын хувьд оршин тогтнох хувь заяанд шийдвэрлэх нөлөө үзүүлэхгүй боловч түүний чанар чансааг тодорхойлохтой холбоотой хүчин зүйлүүд хамаарах юм. Энд юуны өмнө өнөө үед бий болсон олон улсын аюулгүй байдлын шинэ нөхцөл байдалд улс орны нийгэм, эдийн засаг, оюун санааны тогтвортой хөгжил, иргэдийн элбэг хангалуун, энх амгалан амьдрал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, аюулгүй байдал, үндэстэн ястан, шашин шүтлэгийн зөрчилдөөн, зохион байгуулалттай

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавх гэх мэт хүчин зүйлсийг нийцүүлэх асуудал байж болох юм.

Олон улсын аюулгүй байдлын шинэ нөхцөл дэх үндэсний чухал ашиг сонирхол: Энэ ашиг сонирхлын тоонд өвөг дээдсээс өвлөн үлдээсэн монгол үндэстний өвөрмөц түүх, соёл, төрөлх хэл, удмын сан, угсаа гарвал, хүрээлэн байгаа байгаль орчин зэрэг маш олон зүйлийг бий болсон олон улсын аюулгүй байдлын шинэ нөхцөлд хадгалан хамгаалах асуудал багтах бөгөөд тэдгээрийн үнэлэмжтэй холбоотой олон хүчин зүйлүүдийг өөртөө агуулдаг болно.

**Хоёрдугаар бүлэг.**  
**ЭРСДЭЛ СУДЛАЛЫН ҮНДЭС, ХЯМРАЛ, СТРАТЕГИЙН**  
**ЭРСДЭЛ ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО**

**2.1. Хямралын тухай ойлголт, хямрал стратегийн эрсдэлийн угтвар нөхцөл болох тухайд**

2.1.1. Хямралын тухай тодорхойлолт, үндсэн ойлголт

Орчин үеийн хүн төрөлхтний түүх бол дэг журам ба эмх замбараагүй байдал, тогтвортой байдал ба эмзэг үе, урагшлах хөдөлгөөн ба эргэлт буцалт, бүтээн байгуулах ба бусниулах зэрэг үзэгдэл, үйл явдлууд сүлжилдсэн нарийн төвөгтэй үйл явцын өнгөрсөн ба үргэлжлэл юм. Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн хөгжил дэвшилтэй холбоотойгоор улс орнууд болон дэлхийн хамтын нийгэмлэг улс төр, эдийн засгийн асуудлуудаа шийдвэрлэхдээ байгаль орчин, техногенийн болон нийгмийн шинж чанартай аливаа шинэ хямралтай тулгарч, эдгээрийг даван туулах замдаа янз бүрийн бэрхшээл, алдаа оноо гарган, эдгээр нь даамжирснаар хүний өдөр тутмын хэвийн амьдрал ахуй, эрүүл мэнд, үйл ажиллагаанд заналхийлсэн аюулуудыг үүсгэж ирсэн түүхтэй юм. Хэрэв нийгэм эдгээр аюул заналд өгөх зохих ёсны хариуг цаг тухайд нь хэрэгжүүлээгүй эсвэл тодорхой шалтгаанаар хариу олж чадахгүй байгаа бол элдэв сүйрэл, ядуурал, мөргөлдөөн, эмх замбараагүй байдал, хувьсгал, үймээн самуун, террорист үйлдэл гардаг байна. Өөрөөр хэлбэл, хөгжил дэвшлийн тасралтгүй үйл явц өөрөө нийгэм-эдийн засгийн болон улс төрийн тогтолцооны буюу хот суурийн газраас эхлэн бүс нутаг, улс орон, тэдгээрийн хамтын нийгэмлэгийн бүрэн бүтэн байдлыг эвдлэн бусниулагч аюулыг бий болгодог юм.

Дэлхий нийтийн түүхээс үзэхэд улс орон, ард түмэн оршин тогтнох хугацааныхаа сайндаа 5 хувийг энх амгалан байдалд, харин дийлэнх үеийг өөр хоорондоо эсвэл байгаль орчинтойгоо байлдаж, зөрчилдөн тэмцэлдэж өнгөрөөсөн байна. Нэг ч тив, нэг ч улс түмэн аюул занал, гай зовлон дагуулсан өвөрмөц, гунигт үйл явдлаас ангид байж үзээгүй бөгөөд тэдгээр үйл явдлын зарим тохиолдолд аюул, гамшгийн бэлгэдэл нэр болж хувирсан байдаг. Тухайлбал, дэлхийн II дайн, Хиросима-Нагасаки, Суэц, Кубын хямрал, АНУ-ын 2001 оны 9 дүгээр сарын 11, Чернобыль, Фукушима, Монгол Улсын 2008 оны 7



дугаар сарын 1-ны хэрэг явдал гэх мэт. Энэ бол хямрал, хямралт байдал гэсэн нийтлэг нэр бүхий үйл явдлын зөвхөн цөөн хэдэн жишээ болно.

Хэдийгээр хямралын тухай нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт одоогоор шинжлэх ухааны эргэлтэд байхгүй байгаа боловч олон төрлийн лавлагаа, тайлбар тольд түүнийг хоорондоо ихээхэн төсөөтэйгөөр тайлбарласан байдаг. Тухайлбал, орос болон англи хэлний тайлбар тольд хямралыг үйл явдлын өрнөл дэх огцом саатал, шилжилтийн хүнд бэрх нөхцөл байдал, эсвэл хурц бэрхшээл тохиолдох болон хүнд нөхцөл байдал үүсэх үйл явц хэмээн тодорхойлсон байдаг. Хямралын энэхүү тайлбар нь эдгээр үйл явдал дан ганц сөрөг үр дагаврыг бий болгоно гэж шууд тодорхойлоогүй ч эл нэр томъёо нь ийм агуулгыг авч явдаг бөгөөд хямрал бол хүсэх зүйл бус гэсэн санаа илт байна.

Хямрал судлалаар мэргэшсэн нэр хүнд бүхий Голландын судлаачдын өгсөн тайлбараар хямрал бол “нийгмийн тогтолцооны үндсэн бүтэц, суурь үнэт зүйлс болон хэм хэмжээнд учирсан, хязгаарлагдмал цаг хугацаанд, үлэмж тодорхой бус байдалд эрс шийдэмгий шийдвэр гаргахыг шаардсан ноцтой аюул занал” юм. Эл тодорхойлолт нь өрнөдийн улс төр судлал болон нийгэм судлалын сонгодог хоёр онол болох хямралыг нийгмийн хөгжил дэх “тасралт” гэж үздэг хөгжлийн онол ба эсвэл тасалдал гэж тайлбарладаг сонголтын онолыг зохицуулсан дундаж тодорхойлолт юм.

Нарийвчлан судалж үзэхэд дээрх тодорхойлолтууд нь хямрал бол ноцтой аюул занал гэхдээ осол, гай гамшиг, сүйрэл болон зэвсэгт мөргөлдөөн зэрэг хүний амь нас болон эдийн засгийн гарз хохирол авчирдаг үйл явдлын зэрэгцээ мэдэгдэхүйц эвдрэл сүйрэл, гарз хохирол авчирдаггүй боловч олныг хамарсан илт бус, нийгэм-сэтгэл зүйн дам нөлөө бүхий аюул занал учруулж буй нөхцөл байдал гэсэн санааг агуулсан байна. Нийгмийн амьдралд тохиолдох ийм материаллаг “ул мөргүй” үйл явдлын үр дагавар нь осол, сүйрлээс дутуугүй хүнд байдаг. Энэ үүднээс авч үзвэл хямралын аюул заналыг бүх нийтийн сэтгэл санааны бухимдал, цухалдал гэж тодорхойлж бас болох талтай юм.

Дээрх тайлбараас үүдэн гадаад дотоодын нийгэм судлаачид хямралыг нийт нийгмийн эсвэл нийгмийн тодорхой хэсэг бүлэг, эсвэл хувь хүмүүсийн бүрэн бүтэн амьдрал, тогтвортой байдалд аюул занал учруулагч хүчин зүйл хэмээн

үздэг юм. Ойролцоогоор 1950-аад оны эцэс 1960-аад оны эхэнд өрнөдийн шинжлэх ухааны зохиол бүтээлд хямралыг дээрх элементүүд, дэд тогтолцоо болон тогтолцоонд гаднаас учирдаг, гол төлөв байгалийн шинж чанартай аюул занал гэж үздэг байсан. Үүний дараа хямралыг байгалийн шинж чанартай аюулаас гадна хүмүүст үхэл, гай зовлон авчрагч, улс үндэстэнд гол занал учруулагч бусад /дайн, хувьсгал, зэвсэгт мөргөлдөөн/, юуны өмнө цэрэг-улс төрийн аюул, гай зовлон гэж тайлбарлах болсон юм. Ингэснээр 1970-аад оноос инженерийн системүүдээс гаралтай, тодруулбал хүн ба машин техникийн хоорондын харилцаанаас үүдэн хүн болон байгаль орчинд хамааралтай болон “бурхнаас заяасан” сүйрэл гэж хувааж байсан ангилал хуучирч халагдсан юм.

1980-1990-ээд оны завсарт өрнөдийн шинжлэх ухаан хямралын хуучин ойлголтоос татгалзаж, технологийн хөгжил дэвшил болон өндөр хурдтай холбоотой шинэ шинж чанар бүхий дэлхий ертөнцийн нөхцөл байдлыг харгалзах болсон. Хямрал бол хаа нэгтэйгээс хүний амьдрал ахуйд нөлөөлдөг гаднын хүчин зүйл гэж үзэхээ больж хүний ахуй амьдралын хэв маягийн салшгүй хэсэг гэж тооцох болсон байна. Орчин үед хямрал бол ямар нэг салангид үйл явдал бус харин төрөл бүрийн хүчин зүйл болон хүчнүүд үл таамаглах байдлаар харилцан нөлөөлж, өдөр тутмын амьдрал ахуйн хэмнэлийг алдагдуулж, хүн амын дунд түгшүүр, бухимдал, цухалдал төрүүлж, нийгмийн тогтолцооны үндсэн үнэт зүйлс болон бүтцэд болзошгүй болон бодитой аюул авчрагч үйл явц гэж тодорхойлох болсон байна. Орчин үед хямралын тухай ойлголтод нарийн түвэгтэй, харилцан хамааралтай, улс төржсөн гэж хэлж болох тодорхойлолтууд илүү тохирох болсон. Ирээдүйд болох хямрал нь өнөөдөр өчигдрөөс ямар ялгаатай байгаатай яг адилаар өөр байх болно.

1980-аад оны сүүлч үеийг хүртэл манай нийгэм судлалд, ялангуяа эдийн засаг болон улс төрийн ном зохиолд социализмд хямрал гэж байдаггүй. Энэ нь зөвхөн капиталист нийгмийн мөлжигч үйлдвэрлэлийн үзэгдэл гэж тайлбарлаж байсан юм. Эл нөхцөл байдалд “хямрал” гэсэн ухагдахууныг нийгэм, улс төр, экологи, эдийн засгийн салбар дахь төрийн бодлогыг боловсруулахдаа харгалзах ёстой бодит хүчин зүйл гэхээсээ илүү үзэл суртлын арга хэрэгсэл болгон олон жилийн туршид ашиглаж иржээ. Ингэхдээ хямрал нь нийгмийн аливаа тогтолцооны хөгжлийн үе шатуудад тохиолддог нийтлэг үзэгдэл бөгөөд үүний үр дүнд уг тогтолцоо эсвэл чанарын шинэ шатанд (хөгжлийн хямрал) гарч

эсвэл алга болж өөр тогтолцоогоор солигддог (уналтын хямрал) болохыг үгүйсгэж ирсэн байна.

Гэтэл бүр 1922 онд хэвлэгдсэн ЗХУ-ын нэрт эрдэмтэн А.А.Богдановын “Тектологи. Бүх нийтийн зохион байгуулалтын шинжлэх ухаан” хэмээх сонгодог бүтээлд хямрал бол тогтолцооны нийтлэг онолын нэгэн хэсэг бөгөөд бүх нийтийн болон нийтлэг шинж чанартай болох тухай ерөнхий онолыг дэвшүүлсэн байдаг. Үүнд “тогтолцооны өөрчлөлт болгоныг онцгой хямрал гэж үзэх ёстой. Аливаа тасралтгүй үйл явцыг дүн шинжилгээ хийх замаар хямралын эцэс төгсгөлгүй цувралд хувааж болохыг” тэмдэглэжээ. Ингэхдээ, “тэнцвэр бол хямралуудын онцгой тохиолдол. Тухай бүрд энэ нь хөдөлгөөний тодорхой хямрал бөгөөд эл хөдөлгөөний тектологийн нийлбэр болно... Хямралын тухай ойлголт нь тектологийн хувьд нийтлэг зүйл” гэсэн байдаг.

А.А.Богданов дээрхийг нотлохдоо хямралын давхар мөн чанарыг анхааруулан: «Хямрал бол тэнцвэрийн алдагдал, гэхдээ өөр нэгэн төрлийн тэнцвэрт шилжих үйл явц мөн. Эл үйл явцыг хямралын үед болж буй өөрчлөлтүүдийн хязгаар эсвэл түүний чиг хандлагын хязгаар гэж үзэж болно. Хэрэв бид хямралын чиг хандлага болон түүний өрнөж буй нөхцөл байдлыг мэдэж байгаа бол хямралын эцсийн үр дүн – түүний хэлбийж буй тодорхой тэнцвэрийг таамаглаж болно». Үүнтэй холбогдуулан тэр бээр тогтолцооны хөгжил дэх хоёр төрлийн хямралыг тодорхойлсон байдаг (А.А.Богдановын тодорхойлсноор цогцолбор): «хямрал С» — холбогч — шинэ хэлхээ холбоо үүсэх; «хямрал Д» — таслагч — хэлхээ холбоо тасарч, урьд өмнө нь байгаагүй газарт шинэ зааг хязгаар үүсэх». Гэхдээ эл зааг хязгаар нь хийсвэр бөгөөд хямрал нь үнэн хэрэгтээ төрөл тус бүрийн энгийн хямралуудын цуврал. Эхлэх цэг нь үргэлж С, харин хүрэх үе шат нь үргэлж Д байна. Үйл явцын схем СД гэсэн ганц хувилбартай бөгөөд ингэхдээ тэмдэг бүр нь тодорхой ганц энгийн хямрал бус харин харилцан уялдаатай олон тооны хямралуудын нэгдэл мөн».

Хямралын онолын тухай А.А.Богдановын аль 1920-иод оны эхэнд боловсруулсан эдгээр суурь үндэслэлийг өрнөдийн нийгэм судлаачид тавин жилийн дараа л олж харсан бөгөөд эдгээр нь өдгөө ч мөн адил чухал хэвээр байна. Нэг талаас, тэдгээр нь өмнөх соёл иргэншлүүдийн хямралын тухай ойлголтыг тусган хөгжүүлсэн бөгөөд энэ нь “хямрал” гэсэн үгийн утгад

илэрхийллээ олсон байна. Грек хэлэнд уг нэр томьёо шийдвэр эсвэл эргэлтийн цэг гэсэн утгыг илэрхийлдэг бол латин хэлнээ – хуваарь, эргэлт, хятад хэлнээ – аюул занал болон боломж, бололцоо гэсэн хосолсон утгатай байна. Нөгөө талаар, хямралын талаарх орчин үеийн үндэсний үзэл баримтлалд тэдгээрийг «тогтолцооны хөгжлийн программын өөрчлөлтийн үе», «чанарын үсрэлтийн зайлшгүй урьдчилсан нөхцөл», «нураан эвдлэгч ба бүтээн байгуулагч» гэх мэтээр тодорхойлох нь бас тохиолдож байгаа юм.

Үүний зэрэгцээ эдгээр үзэл баримтлалын зарим нь хямралыг үйл явц бус харин муруй шугам тасралгүйгээр нэг функц нөгөөгөөр солигдох онцгой цэг хэмээн тайлбарласан байдаг. Энэ нь А.А.Богданов болон орчин үеийн өрнөдийн хямралын тухай онолын бусдаас ялгагдах чухал шинж чанар юм. Ингэхдээ функцүүдийн дифференциал үүсдэггүй. Энэ төсөөлөл нь А. Пуанкаре, Р. Том, В.И. Арнольд нарын боловсруулсан бүхэнд танил болсон сүйрлийн математикийн онолд тулгуурладаг байна.

Хямрал бол бүтээн байгуулах, эвдлэн сүйтгэх хоёр үйлдэл хавсарсан үйл явц бөгөөд үр дүн нь олон утгатай, урьдчилан мэдэгдэхгүй гэсэн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч, хямрал болон сүйрлийг зарчмын хувьд ялган, сүйрэл бол хямралт нөхцөл байдлын тааламжгүй үр дагавруудын нэг гэж ойлгож болох юм. Гэхдээ энэ нь хямралын тодорхойлолтод цаг хугацааны шинж чанарын талаарх Голландын болон бусад зарим судлаачдын үзэл бодолтой зөрж байгааг тэмдэглэх хэрэгтэй юм. Хямрал нь үргэлж яаруу шийдвэр гаргасантай холбоотой гэж тэд үздэгтэй санал нийлэхэд бас амаргүй юм.

Шийдвэр гаргахад, тэр тусмаа хямралын үед шийдвэр гаргахад цаг хугацааны хязгаарлалт үргэлж байдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч хэт хязгаарлалт (өдөр, цаг, минут) нь зөвхөн хямралын хурц /А.А.Богдановын тодорхойлсноор тэсрэлтийн/ хэлбэрүүдэд хамааралтай гэж үзэж болох юм. Ийм төрлийн хязгаарлалт бол хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, материаллаг эд хөрөнгө болон хүрээлэн буй орчинд шууд аюул занал учруулсан (аваар осол, сүйрэл, зэвсэгт мөргөлдөөн гэх мэт) үйл явдалтай холбоотой байдаг. Харин цаг уурын өөрчлөлт, цөлжилт эсвэл дэд бүтцийн элэгдэл, хоцрогдол зэрэг сунжирсан хямралын үед шийдвэр гаргах хугацаа нь сар, жилээр ч үргэлжилж болох юм.

Дээрхийг хямралын үед шийдвэр түргэн гаргах ёстой гэж үздэг талынхан ч хүлээн зөвшөөрдөг нь тэдгээрийн байр суурь зөрчилтэй байгаагийн илрэл юм. Тэдний үзэж байгаагаар, сунжирсан хямралын үед “нийгэм болон засаг захиргаа эдгээр асуудалд анхаарал тавилгүй удаж, шийдвэр гаргалгүй цаг хугацаа алдсанаа нөхөхийн тулд яаруу, бодлогогүй шийдвэр гаргаснаараа асуудлыг улам хүндрүүлдэг» байна. Шийдвэр гаргагчид таагүй байдлын сулавтар дохиог шууд хариу арга хэмжээг шаардсан хүчтэй аюул заналтай хольж хутгах, мөн сунжирсан хямрал удаан үргэлжлэх тусам түүнийг эрс огцом зогсоох шаардлага байгаа мэтээр алдаа гаргах магадлалтай юм. Эцэст нь, улс төрчдийн хувьд шийдвэрийг яаруу түргэн гаргах хүсэл эрмэлзэл нь хямралт байдлын бэлэн байдлын төлөвлөгөөний алдаагаа далдлах, эсвэл хямралт байдлыг ашиглан улс төрийн ашиг хонжоо олох хүсэлтэй холбоотой байх нь цөөнгүй тохиолддог. Хямралын үед цаг хугацааны хязгаар зааж, хурцадмал байдлыг багасгахын оронд тулган шаардсан, айлган сүрдүүлсэн мэдэгдлүүдийг олон нийтийн өмнө хийх нь хямралын үр дагаврыг улам хүндрүүлдэг байна.

Хямралын талаарх дээр дурдсан ойлголтууд нь өдгөө хүн төрөлхтний туулж буй хөгжлийн үеийн онцлог буюу аливаа хямралын бүх нийтийг хамарсан шинж чанарт мөн адил тохирно гэж үзэж болохоор байна. Хямралууд өнөө үед дэлхий нийтийн амьдралын бүхий л талыг нийтэд нь хамаарч байна. Ялангуяа хямралын энэ шинж чанар нь улс төр, эдийн засгийн тогтолцоогоо өөрчлөх хүнд бэрх, урт удаан хугацааны шилжилтийн үеийг туулж буй Монгол Улсын хувьд дэлхий нийтийг хамарсан хүнд бэрх томоохон асуудлууд (олон улсын терроризм, зэвсэгт мөргөлдөөн, бүс нутгийн дайн, нийтийг хамарсан эдийн засгийн хямрал, нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшний ялгаа, хүрээлэн буй орчны доройтол, цаг уурын өөрчлөлт зэрэг) онцгой хүндрэлтэй тусч байгаа юм. Гэхдээ үүний зэрэгцээ энэ үйл явц нь чанарын шинэ өөрчлөлтүүдийг дагуулж, цаг үеэ элээсэн, хуучирсан, үр нөлөө багатай, улс төржсөн, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий байсан тоталитар тогтолцоог халан чанарын гүнзгий шинэчлэлүүдийг авчирсаар байна. Үүнд орчин үеийн Монгол Улсад учирч буй хямралын бүтээн байгуулагч гэж хэлж болох шинж чанар оршиж байгаа нь тодорхой юм.

### 2.1.2. Хямралын орчин үеийн хандлага

Хямралын ертөнц өөрчлөгдөж байна. Хямрал, тэр тусмаа ирээдүйд тохиолдож болох хямралуудын тухай бидний ойлголт хязгаарлагдмал боловч улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил, хүрээлэн буй байгаль орчны хувьслын өнөөгийн шинж чанарт дүн шинжилгээ хийх арга замаар орчин үеийн хямралуудын ерөнхий шинж чанарыг тогтоож, ирээдүйн хямралуудын зарим нэг онцлогийг таамаглах боломжтой юм. Манай орны болон гадаадын шинжээчдийн үнэлгээгээр орчин үеийн болон ирээдүйн хямралууд нийгэм эдийн засгийн тогтолцоонууд дахь технологи, санхүү болон улс төрийн хэлхээ холбоо гүнзгийрэхтэй холбоотойгоор ерөнхийдөө улам бүр нарийн төвөгтэй болж тэдгээрийн шинэ, өмнө байгаагүй хувилбарууд бий болох нь тодорхой байна.

Үүнээс гадна, хямралууд нь улам бүр өөрөө өөрийгөө дэмжих үйл явц болж хувиран тодорхойгүй шалтгаан, шалтгаан-үр дагаврын хэлхээ холбоо, “эрсдэлийн нийгмийг” үр нөлөө муутай удирдах гэсэн гурван ойлголтын хүрээнд мухардмал тойргийг үүсгэх боллоо. Ингэхдээ, эсвэл өөрөө өөрийгөө шинэ хэлбэрээр төрүүлэх эсвэл өөр бусад төрлийн хямралд шилжих ирээдүйн хямралуудын хэлбэрийн хувирлаас болж нийгэм-эдийн засгийн тогтолцооны хуучин хэвийн нөхцөл байдалд эргэн орох боломжгүй болох нь олонтой тохиолдож байна. Энэ нь тухайн үеийн тэргүүлэх ач холбогдлуудыг эргэн харж, хөгжлийн тогтвортой, аюулгүй байдлын шинэ шалгууруудыг сонгохыг улс төрчид болон мэргэжилтнүүдээс шаардах болж байгаа юм.

Тодруулбал, цэвэр эсвэл далд байдлаар илэрч, улам хүчээ авч байгаа даяаршлын хэлбэр, үр дүн болох XX зууны эцэс XXI зууны эхэн үеийн хямралын хөгжлийн үндсэн хандлагууд нь дараах үйл явцуудыг хамарч байна.

**Хямралын хил дамнасан шинж чанар нэмэгдэж байна.** Орчин үеийн хямралууд нь улам бүр үндэстэн дамнасан шинжтэй болж байна. Тэдгээрийн эх үүсвэр урьдын адил орон нутаг эсвэл бүс нутгийн түвшинд байгаа хэвээр боловч үр дагавар нь дэлхийн бүхэл бүтэн бүс нутаг, тэр ч атуугаа тив, дэлхийг хамрах болсоор байна. Үүний нэг тод томруун жишээ бол олон улсын терроризмын хүчин зүйлүүдтэй холбоотой хямралууд юм. АНУ-д болсон 2001 оны 9 дүгээр сарын 11-ны террорист халдлагаас өмнө террорист халдлага болон түүнээс учрах хор уршиг, үр дагаврыг нь арилгах асуудлыг зөвхөн үндэсний хил хязгаарын хэмжээнд авч үздэг байсан. Гэтэл бодит байдал дээр уг халдлагаас

үүдэлтэй бүх төрлийн хорт үр дагавар нь дэлхийн бараг бүх оронд нөлөөлсний дээр Монгол Улсын улс төр, нийгмийн амьдралд чиг шинэ нөхцөл байдлыг үүсгэсэн билээ. Өөр нэг жишээ хэлэхэд, ЗХУ задран унасны дараа дэлхийн улс төрийн газрын зурагт гарсан өөрчлөлтүүдийн үр дүнд цөмийн зэвсэг болон цацраг идэвхт бодисын тархалт /хууль бус арилжаа наймааны шугамаар/ улам нэмэгдсэн нь урьд өмнө нь харьцангуй тайванд тооцогдож байсан бүс нутгуудад цөмийн террорист халдлага гарах эсвэл эдгээр бодисыг өөр бусад аюултай хэлбэрээр ашиглах эрсдэл өсөхөд хүргэсэн билээ.

Бас нэг жишээ бол Японы Фукушимогийн атомын цахилгаан станцад гарсан гал аваар ослоос үүдэлтэй экологийн зэрэгцээ олон улсын сэтгэл санааны гүн хямрал юм. Уг ослоос үүдэн дэлхийн олон оронд атомын цахилгаан станцаас болгоомжлох, айх явдал газар авсаар байна. Үүнээс илүү хэмжээгээр нийтийг хамарсан аюул нь цаг агаарын өөрчлөлт /дулаарал/, озоны давхаргын цооролт, хүчиллэг бороо, ан амьтан, ургамлын төрөл зүйл устаж үгүй болох зэрэг олон улс орны хамтарсан хүчин чармайлтыг шаардсан дэлхий нийтийн хэмжээний экологийн хямралуудаар илэрч байна. Шинжээчдийн үнэлгээгээр, иймэрхүү хямралыг даван туулахад холбогдох арга хэмжээ авахад хэдэн тэрбумаас эхлээд их наядаар тоологдох асар их хөрөнгө хүч шаардагддаг цаашдаа ч шаардагдах нь тодорхой юм. Тодорхой квоттой байдаг дан ганц нүүрстөрөгчийн зах зээлд л гэхэд хүлэмжийн хийг багасгахад олон зуун тэрбум доллар шаардлагатай байгаа юм. Үүний дээр уг асуудлын дэлхий нийтийг хамарсан, ихэнхдээ судлагдаагүй байгаа шинж чанар нь маш тодорхой бус байдлыг төрүүлж, зарим тохиолдолд экологийн хямралыг шийдвэрлэх асуудлыг геополитикийн тоглоом болгон хувиргаж байна гэж нэлээд орон үзэж байгаа юм. Энд жишээ болгож дэлхийн дулаарлын асуудлаарх Киотогийн протокол тойрсон үйл явдлыг дурдаж болох байна.

Бусад төрлийн хямралууд ч, тодруулбал компьютерийн гэмт хэрэг болон эбола, шувууны ханиад зэрэг вирусийн гоц халдварт өвчин олон улсын цар хүрээтэй болж байна. Үүнээс гадна, аль нэг улс орны хил орчмын нутаг дахь таагүй нөхцөл байдал (эдийн засгийн зогсонги байдал, хэт хотжилт, асар олон хүн амтай аварга хотуудын өсөлт, хэт үйлдвэржилт гэх мэт) нь хөрш зэргэлдээ орнуудын нийгэм, улс төрийн байдалд улам бүр нөлөөлөх болсоор байна. Цэрэг-улс төрийн мөргөлдөөн, мөн байгаль орчны доройтлоос үүдэн Ази, Африкт хүн

ам олноор дүрвэн шилжиж байгаа нь улс орнуудын тогтоогдсон хил хязгаарыг ч өөрчлөгдөхөд хүргэж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх гол арга хэлбэр нь олон улсын хүмүүнлэгийн тусламж болж байгаа хэдий ч тусламж үзүүлэхдээ улс хоорондын эмзэг асуудлуудад ухаалаг хандаагүйгээс зарим тохиолдолд энэ нь ялгаварлаж үзэх, хоёр стандарт баримтлах, улс төржүүлэх байр сууринаас хандах байдал гаргалаа гэх шүүмжлэлийг ч бас төрүүлж байгаа юм. Зарим тохиолдолд хямралд нэрвэгдсэн хүмүүс үзүүлсэн тусламжийн үр дүнд амьдрал дээрдэхээсээ илүү харин ч улам дорддог байна.

Ирээдүйд зөвхөн газар зүйн /үндэсний/ хил хязгаар бус мөн цаг үеийн, өөрөөр хэлбэл хүний амьдралын хэдэн үеийг дамнасан хямралуудын тоо өсөн нэмэгдэнэ гэж үзэх үндэслэл бас нэлээдгүй яригдах болж байна. Ийм төрлийн хямралын нэг тод жишээ бол өмнө нь танил байсан боловч генийн хувиралд орж, үндэсний болон олон улсын эрүүл мэндийн байгууллагаас хянах боломжгүй эсвэл бараг хянах боломжгүй болсон “хуучны” гоц халдварт (цэцэг өвчин, сүрьеэ, хумхаа, томуу гэх мэт) өвчин дахин дэлгэрэх болсон явдал юм.

**Хямралын үүсэл, өрнөлтөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (цаашид ОНМХ гэх) хүчтэй нөлөөлөх боллоо.** ОНМХ нь аливаа үйл явдлын талаарх нийгмийн төсөөлөл бүрэлдэхэд үлэмж нөлөөлдөг бөгөөд тайлбар нь үргэлж субъектив шинж чанартай байдаг. Хямралын асуудлаарх субъектив үзэл бодлыг Томасын теоремд: «Хэрэв хүмүүс тодорхой нөхцөл байдлыг хямрал гэж үзсэн бол түүнээс гарах үр дагавар нь жинхэнэ хямрал байдаг» гэж тодорхой заасан байдаг. Хэрэв ээдрээтэй нөхцөл байдлыг хүмүүс болон эрх баригчид хямралын эсвэл онцгой байдал гэж хүлээн авч үнэлсэн бол энэ нь уг үйл явдлын цаашдын өрнөлтөд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг болох нь бараг тодорхой болсон зүйл юм. Тухайлбал, энэ нь бүх нийтийн бухимдлаас эхлэн цаашдаа эрх баригчдын зүгээс авсан арга хэмжээгээр улам гүнзгийрэх хэт эмзэг хурц хариу үйлдлийг өдөөж болох юм. Гэхдээ иймэрхүү үнэлгээ ойлголт нь бас хямралыг давахад чиглэсэн хамтын хүчин чармайлтыг дайчилж хямралыг удирдах онцгой дэглэмийг нэвтрүүлэхэд тус дөхөм үзүүлж болох сайн талтай юм.

Ойрын ирээдүйд хямралын асуудлаарх ОНМХ-ийн хүчин зүйлийн ач холбогдол өсөх бөгөөд хямралууд нь ОНМХ-ийн “өдөөн хатгагч” үүргийн талаарх Томасын теоремын гаргалгаанд улам бүр захирагдах бололтой. Жишээлбэл:



хэрэв СНН агентлаг тухайн нөхцөл байдлыг хямрал гэж нэрлэсэн бол тэр нь жинхэнээсээ хямрал болж, үр дагавар нь ч үүнтэйгээ зохицсон байх болно. Мэдээллийн эрчимтэй хөгжил нь ирээдүйн хямралуудын хөгжлийг тодорхойлогч хандлага бөгөөд бас түүний ирээдүйн шинж чанар нь байх болно. ОНМХ-ийн хүчин зүйл нь хямрал үүссэн газар болон хямралт байдалд өртсөн бусад район, бүс нутгуудыг хоорондын зайнаас нь үл хамааран улам бүр ойртуулах болно. ОНМХ нь хямрал, сүйрлийн улам нэмэгдэж буй нөлөөллийн бүсэд нэвтрэх чадвартай тул бүх нийтийг хамарсан глобалчлал буюу даяаршил нь түүнийг улам бүр хүчирхэг хүчин зүйл болгож байна.

ОНМХ, тухайлбал телевиз, мэдээллийн сайтууд холыг ойртуулах чадвартай тул тухайн нөхцөл байдлын талаарх хямралын бүс болон түүнээс гадна байгаа хүмүүсийн хүлээн авалт, ойлголтын зөрүүг багасгах боломжтой юм. Энэ нь бүх улс орон, тэдгээрийн дотор хамгийн ардчилсан улс орон хэмээн нэрлэгддэг улс үндэстнүүдийн хувьд үнэн зүйл юм. Жишээлбэл, 1991 онд Персийн буланд, 2002 онд Афганистанд, 2003 онд Иракт, 2011 онд Арабын орнуудад, 2014 онд Украйнд болсон үйл явдлуудын үед америкийн ОНМХ-үүд хямралын талаарх баримт материалыг хэрхэн өрөөсгөлөөр хүргэж болдгийг харуулсан билээ. Үүний үр дүнд шинэ аюул занал бий болсон: “хямралын үед хүмүүс зөвхөн ерөнхий зүйлээс бусдыг мэдэх хүсэлгүй байдаг. Сэтгүүлчид өөрийн мэргэжлийн хамгийн гол шинж чанарыг шуурхай байдал гэж үздэг бол харин уншигчид болон үзэгчид өөрсдөө асуудлын талаар ойлгож мэдэх, дүгнэлт хийхийн оронд бослогыг дарах даалгаврыг хэрхэн биелүүлсэн тухай цэргийнхний мэдээллийг хүлээж байх жишээтэй юм».

Хямралын үед ОНМХ-ийн үйл ажиллагаанд дээр дурдсан хорио эсвэл дотоод хязгаарлалтаас эхлэн сэтгүүлчдийн ихээхэн таалдаг дуулиан дэгдээх хүртэл арга хэлбэрүүд ажиглагддаг. Хямралын талаарх ОНМХ-ийн тодорхойлолтын ялгаа нь бодит байдал дээр чухам юу болж байгаа болон эрх баригчид, онцгой байдлын албадын зүгээс хямралд өртсөн хүн ам болон олон нийтэд өгч буй мэдээллийн ялгаагаар илэрдэг. Дээрхээс үзэхэд ОНМХ нь хямралын эдийн засгийн /амь үрэгдэгсдийн тоо, хохирлын хэмжээ/ болон нийгэм-сэтгэл зүйн /олон нийтийн бухимдал, сэтгэл санааны хямрал г.м./ бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл ойлголт бүрдүүлэхэд тус дөхөм болдоггүй, харин материаллаг хохирол эсвэл хүний амь нас гэхээсээ илүү олон нийтийн гүн

гүнзгий бухимдлыг голлосон “уламжлалт” хямрал болон мөргөлдөөн, гай зовлонгийн шинэ төрлүүдийг илүү тод харуулдаг байна.

Үүний зэрэгцээ ОНМХ нь өнгөрсөн үеийн хямралуудын “эдийн засгийн” тайлбарууд болон ирээдүйн мөргөлдөөн, гай гамшгийн “нийгэм-сэтгэл зүйн” талбарыг зохицолдуулахад тус нэмэр болох чадвартай юм. Хэтдээ ОНМХ-үүд хямралын дараах хоёр төрлийг харуулахыг илүүд үзэх бололтой. Үүнд: нэгдүгээрт, хүн амын болон материаллаг бодит болон болзошгүй хохирол гэсэн эдийн засгийн үзүүлэлтээр тодорхойлогдох томоохон /мега/ сүйрэл, хоёрдугаарт, материаллаг үндэсгүй /бодит үйл явдал/ байхгүй боловч дам яриа, өдөөн хатгалга зэргээр тэжээгдэн бүх нийтийн айдас, бухимдал, нийгмийн хагаралд хүргэхүйц хямралууд. Ийм төрлийн хямралууд нь улс орны нийгмийн болон засаг захиргааны бүтцийг ч ноцтой гажуудуулж болох юм.

**Хямралын бүтэц болон хөгжилд шинэ болон нэн шинэ технологийн гүйцэтгэх үүрэг нэмэгдэж байна.** Сүүлийн жилүүдэд холбоо болон мэдээллийн технологийн салбарт гарсан хувьсгалт өөрчлөлтүүд нь хурдаараа болон улс орны эдийн засаг болон нийгмийн хөгжилд нэвтрэх цар хүрээ, үзүүлэх нөлөөллийн хувьд үнэхээр гайхал төрүүлж байгаа юм. Хиймэл дагуулын холбоо, интернэт, өгөгдөхүүн дамжуулах системийн хөгжилт зэрэг нь цаг хугацаа болон орон зайн хязгаарыг үлэмж тэлсэн бөгөөд даяаршлыг улам хүчтэй болгосоор байна. Ажил хөдөлмөр болон өдөр тутмын ахуй амьдралд компьютерын технологи нэвтэрснээр хүний амьдрал ахуй, хөдөлмөр, харилцан ажиллагааны хэв маяг эрс өөрчлөгдөж байна. Компьютерын технологийн хурд асар хурдтай өссөн нэмэгдэхийн хэрээр технологийн цогцолборуудын нарийн харилцан хамаарал маш өндөр болж байгаа бөгөөд эл нөхцөл байдалд сүлжээний бага зэргийн саатал ч маш том үр дагаварт хүргэх магадлалтай болсоор байна.

Компьютерын вирусийн томоохон довтолгоонууд, 2003 онд АНУ, Баруун Европ, Гүржид болсон цахилгаан хангамжийн системийн томоохон хэмжээний саатлууд, нисэх онгоцны удирдлагын асуудлууд (2002 онд Лондоны Хитроу буудалд онгоц буулгахтай холбоотой гарсан хямрал) зэрэг нь үүнийг нотолж байна. Мөн, 1994 онд бараг 900 хүний амь насыг авч одсон “Эстония” гатлагч онгоцны сүйрэл, 2001 оны 9-р сарын 11-ний үйл явдлаас хойш 600-800 хүний суудалтай том хөлгүүдийн ирээдүй бүрхэг болсон явдал ч үүнд мөн хамаарна.

Өндөр технологиос үүдэлтэй гай гамшгийн талаарх төсөөллийг Чернобылын дараа нь Фукушимагийн сүйрэл нэг мөр өөрчилсөн (АЦС-д осол гарах магадлалыг 33 мянган жилд нэг удаа гэж тооцдог байсан). Компьютерын технологиос хамааралтай нийгэм-эдийн засгийн тогтолцооны эмзэг байдал дээр хакерууд болон цахим террористуудын аюул занал нэмэгдэж байна. Шинжлэх ухаан, мэдлэг болон нөгөө талаас шийдвэр гаргагч захиргааны болон улс төрийн хүчнүүдийн ойлголтын хоорондох зөрчил өсөн нэмэгдэж байгаа нь эл байдлыг улам даамжруулж байгаа юм.

**Эдийн засагт төрийн оролцоо улам бүр буурах болж улмаар хямралын аюулт үр дагавар нэмэгдэх хандлагатай байна.** Өнгөрөгч зууны сүүлийн арван жилд өрнөдийн орнууд болон манай улсад эдийн засагт оролцох төрийн гүйцэтгэх үүрэг мэдэгдэхүйц буурсан. Энэ нь төрийн зарлага багасах болон төрийн удирдлагын үр нөлөөг дээшлүүлэх зорилго бүхий “менежмент” хөгжих болсон гэсэн хос хандлагаар илэрч байна. Эдийн засаг болон нийгмийн шинэчлэлийн эл нөхцөл байдалд нийгэм, эдийн засгийн хямралуудаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг зөөллөх арга хэмжээнд анхаарал бага тавигдах болж, харин төрийн эрх мэдэл, төрийн удирдах байгууллагуудын хямрал гэж ойлгогдох болсон улс төрийн агуулга бүхий асуудлуудыг илүүтэй анхаарах болжээ.

Үүний зэрэгцээ, хөрөнгө мөнгөний дутагдал нь хямралын аюулыг багасгахтай холбоотой ажил эрхэлж буй техникийн үйлчилгээ, засвар, туршилт, төлөвлөлтийн ажилтнуудын тоо, мэргэжлийн ур чадварын түвшин болон материал-техникийн хангалт буурах сөрөг үр дагаварт хүргэж байна. Хямралыг бууруулах удирдлагын үйл ажиллагааны зардалтай харьцуулахад үр дүнг нь тооцоход арай төвөгтэй тул удирдлагын хүчин зүйл, түүний дотор санхүүжилтийн төлөвлөлтийн ач холбогдлыг дутуу үнэлэх болсон байна.

Төр засгийн үүрэг багасахын хэрээр хямралын аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг нь бууруулах үйл ажиллагааг хувийн болон төрийн удирдлагын субъектүүд хамтран гүйцэтгэх ёстой болж байна. Жишээ нь, өрнөдийн орнуудад нийгмийн аюулгүй байдлыг хангах салбарт хамгаалалтын хувийн агентлагууд улам бүр идэвхтэй үүрэг гүйцэтгэх болж байна. Томоохон байгууллагууд, тэдгээрийн дотор олон нийтийн байгууллагуудад хямралын

асуудлыг удирдлагын асуудал эрхэлсэн зөвлөхүүд хариуцах болсон байна. Үүний үр дүнд төр, засгийн бүтцүүд нь олонх хямралын асуудлыг зохицуулахад оролцогч зөвхөн нэг субъект болон хувирах боллоо.

Хямралын асуудалд оролцогсод, тэдгээрийн дотор удирдлагын субъектүүдийн тоо нэмэгдсэн ч хямралын менежментийн талаарх мэдээлэл, мэдлэг, шинжээч мэргэжилтнүүд хуваагдмал байдалтай байгаа тул хямралын аюулыг багасгах үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдэх магадлал бага юм. Үүний дээр, хямралын удирдлагад оролцогсдын тоо өсөх нь тэдгээрийн хамтын ажиллагаа, ялангуяа онцгой байдал болон бусад төрлийн хямралын үеийн төлөвлөлтийн шатны хамтын ажиллагааг хүндрэлтэй болгох талтай байна. Үүнээс үүдэн, хүмүүс төрийн зүгээс үр нөлөө бүхий шийдвэр, үйл ажиллагааг хүсэн хүлээж буй хямралын нөхцөл байдалд засгийн газар нь дээр дурдсан шалтгаануудаас үүдэлтэйгээр хямралын удирдлагыг хангах хязгаарлагдмал боломж ба засаг захиргааны бүх үйлдлийг “томруулдаг шилээр” харж, шаардлагатай гэж үзвэл буруушаах гэсэн хүн амын зарим хэсгийн хүсэл эрмэлзэл гэсэн “хоёр галын дунд” ордог боллоо. Хямралын үед засаг захиргааны үйлдэлд шүүмжлэлтэй хандах нь түүний үйл ажиллагааны хууль ёсны давуу байдлыг буруулахад хүргэж, энэ нь төрийн албан хаагчдын зүгээс ирээдүйн хямралаас урьдчилан сэргийлэхэд зохих ёсны анхаарал тавих хүслийг багасгахад хүргэж болзошгүй юм. Тиймээс хямралт нөхцөл байдал нь гарцгүй мухардмал тойрогт улам бүр ойртож, хямралуудын удирдлагагүй сүлжээс үүсгэх аюултай юм.

**Хямрал болон түүний үр дагаврыг улс төржүүлэх нь нэмэгдэж байна.** Аливаа хямрал нь агуулгын хувьд ч (улс төрийн зөрчлүүдийн янз бүрийн хэлбэртэй байдгаараа) хэлбэрийн хувьд ч (улс төрийн мөргөлдөөнүүдээр илэрхийлэгддэгээрээ) эсвэл үр дүнгийн хувьд ч (улс төрийн үр дагавраараа) үргэлж улс төрийн гойд үзэгдэл байсан. Мөн хямралын асуудал нь улс төрийн хүрээний, түүний дотор “том улс төрийн” яриа хэлцлийн хамгийн чухал, гэхдээ хамгийн түвэгтэй сэдэв байсаар ирсэн. Хямрал нь ирээдүйн үйл явдлын аль нэг хувилбарын босго бөгөөд түүний хөгжлийн тодорхой үр дагавар нь тодорхой бус хүнд байдалд гаргасан стратегийн шийдвэрээс бага боловч хамаардаг нь эл шийдвэрийн улс төрийн ач холбогдлыг улам нэмэгдүүлдэг юм. Хямралыг аюул заналхийлэл эсвэл сүйрлээс тааламжтай боломж болгон хувиргахын тулд

шийдвэр гаргах салбарт зохих ёсны мэдлэг, туршлага зайлшгүй шаардагдах бөгөөд энэ нь тухайн этгээд, нам, албан байгууллагын улс төрийн нэр хүндийг баяжуулах чухал хүчин зүйл юм. Харин эл хувирлыг хангах чадваргүй байх нь хямралыг улам даамжруулан түүнийг өөр бусад хүнд хэлбэрт /бослого, үймээн, гай гамшиг эсвэл сүйрэлд/ оруулаад зогсохгүй уг хямрал нь байгалийн эсвэл үйлдвэрлэлийн ослын онцгой байдал эсвэл тэр тусмаа нийгэм-улс төрийн зөрчил аль нь байхаас үл хамааран хариуцлага хүлээх этгээдийн буюу засгийн газрын нэр хүндийг алдагдуулж, бүхэлдээ улс төрийн байр суурийг нь сулруулахад ч хүргэж болох юм.

Ирээдүйд хямралын удирдлагад оролцогсдын тоо нэмэгдэж, хямралын учир шалтгаан, хэлбэр нарийн төвөгтэй болохын хэрээр тэдгээрийг улс төржүүлэх хандлага лавшран хямралын удирдлагад оролцогсдыг улс төрийн тоглогчид болгон хувиргахын зэрэгцээ тухайн хямралыг улс төрийн тоглоомын, үүний дотор олон улсын томоохон улс төрийн зөрчил маргалдааны талбар болгоход хүргэх болно. Үүнтэй холбоотойгоор, улс орны төр, засгийн болон улс төрийн удирдагчдын гаргах стратегийн шийдвэрийг оролцуулан шийдвэр гаргагч этгээдийн хариуцлага өндөрсөх бөгөөд буруутан этгээдийг хаа нэг өөр газраас хайх, улс төрийн элдэв шошго наах, буруушаах оролдлого улам бүр нэмэгдэж болзошгүй юм. Энэ нь эргээд засгийн газар болон түүний эрх мэдэл бүхий байгууллагуудад ирэх улс төрийн дарамт шахалтыг нэмэгдүүлэх бөгөөд ингэснээрээ хямралыг зохицуулах, мөн түүнээс сургамж авах үйл явцыг хүндрүүлэх болно. Үүний зэрэгцээ, хямралын үед аюулгүй байдлыг хангах үүднээс аливаа мэдээллийг тараахад тодорхой хязгаарлалт тавих болон хямралт байдалд зөв үйл ажиллагаа явуулах бололцоогоор хангахын тулд ард иргэдийг цаг тухайд нь тодорхой мэдээллээр хангах хэрэгцээ шаардлагын хооронд зөрчил үүсэж асуудлыг улам төвөгтэй болгох талтай юм.

Хямралын улс төрийн хэмжигдэхүүн нь тодорхой үйл явдал болон тэдгээрийн ойрын үр дагаврын цаг хугацааны хил хязгаараас хол давдаг бөгөөд түүхчид, улс төр судлаачид, цэргийн стратегийн болон хямралын удирдлагын мэргэжилтнүүд түүхэн чухал үйл явдлын хувьд тухайн хямралын байдлыг зохих ёсоор сэргээж, сургамж авах үүднээс олон жилийн дараа ч энэ асуудлыг эргэн сөхсөөр байдаг. Үүний зэрэгцээ, улс төрийн зүтгэлтнүүд, тэдгээрийн шинэ үеийнхэн уг хямралыг өөрт хэрэгтэйгээр өнөөгийн нөхцөл байдалд тохируулан

тайлбарлан үнэлж, өөрсдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээг зөвтгөх, өмнөх үеийн улс төрийн удирдагчид болон өнөөгийн өрсөлдөгчдөө шүүмжлэхэд ашигладаг. АНУ-ын Ерөнхийлөгч асан (эцэг) Ж.Бушийн имижийн өөрчлөлт үүний тод жишээ болно. 1991 онд Персийн буланд дайнд ялсны дараа түүнийг хямралыг амжилттай зохицуулагч гэж байсан бол АНУ-д нүүрлэсэн эдийн засгийн хүндрэлээс болж түүнийг улс төрийн “азгүй амьтан” буюу “тэтгэврийн хөгшин” гэх болсон байна. Оросын анхны Ерөнхийлөгч Б.Елцины хувьд байдал эсрэгээр эргэсэн. 1990-ээд оны эхэн үеийн ардчилагч, шинэчлэгч гэсэн улс төрийн өндөр нэр хүнд нь дараах арван жилийн нийгэм, эдийн засгийн бодлогын сүйрэл болон Умард Кавказад явуулсан цэрэг-улс төрийн кампани нь амжилтгүй болсноор богино хугацаанд сарнин алга болсон билээ.

### 2.1.3. Хямрал үүсэх учир шалтгаан, үр дагавар, тэдгээрийн уялдаа холбоо

Хямралын хоёрдмол (бүтээн байгуулагч-эвдлэн сүйтгэгч, үргэлжлэгч-тасалдалтай явагдагч, үйл явц ба үйл явдал гэсэн) шинж чанарууд нь тогтолцооны шилжилтийн үед шийдвэр гаргах үйлдлийн тодорхой бус болон нарийн түвэгтэй байдлыг бий болгодог. Хямралын чухал шинж болох ердийн бус, өвөрмөц нөхцөл байдал нь үйл ажиллагааны хэвшсэн журам, загварыг хэрэгцээгүй, үр нөлөө багатай болгодог бөгөөд стандартын бус шинэ гэхдээ үр дүн нь баталгаатай бус хандлагыг эрэлхийлэхэд хүргэдэг байна.

Энэ талаар бид хуучин ЗХУ-ын эрдэмтэн А.А.Богдановын “хямралын цаг бол тодорхой бус байдал, хэлбэлзлийн төгсгөл-аль нэг талын ялалт эсвэл хоёр талын эвлэрэл: өмнөхөөс өөр ямар нэг шинэ, зохион байгуулалтын хувьд ялгаатай зүйлийн эхлэл” гэсэнтэй санал нийлэхгүй байгаа болно. Бидний үзэж байгаагаар, тодорхой бус байдал нь, нэгдүгээрт, нийгмийн хөгжлийн бүхий л үйл явцад зайлшгүй байдаг, эл үйл явцын аль ч шатанд өөрчлөгдөх, үүний дотор чанарын өөрчлөлтийн боломж үргэлж байдаг бөгөөд энэ боломж нь мэдлэг дутсан эсвэл шийдвэр гаргаж буй этгээдүүдийн алдаа мэдгээс хамаарч тооцогдолгүй үлддэг дотоод эсвэл тогтолцоо хоорондын хүчин зүйлээс шалтгаалдаг. Үүнтэй холбогдуулан Г.Саймон болон бусад судлаачдын тэмдэглэснээр, улс төрчид, албан тушаалтнууд болон эрх мэдэлтнүүд тухайн үед өөрсдийнх нь байгууллага дотор эсвэл гадна нь юу болж байгааг ердийн нөхцөлд ч ойлгох чадвартай байх нь ховор байдаг ажээ.

Хоёрдугаарт, хямралын үе болон хямралын өрнөлтийн үе шатанд үйл явдлын өрнөл хамгийн тогтворгүй, хугарлын шинжтэй, холбирах боломжтой байдаг тул тодорхой бус байдал хамгийн дээд цэгтээ байдаг. Эдгээр нөхцөл байдал нь аюул заналын шинж чанар болон тэдгээрийн талаарх хүмүүсийн хандлагаас үүдэлтэй анхан үеийн тодорхой бус байдал, үйл явдлын өрнөлт болон хямралын цаашдын үр дагаврыг хүчтэй болгодог. Үүнд үйл явдлын (жишээ нь нийгмийн зөрчилдөөн, байгалийн эсвэл техногенийн сүйрлийн) тааламжгүй өрнөлтийн эхлэл гол хүчин зүйлүүдийн нэг болдог бөгөөд энэ нь авч болох мэдээллийн хэмжээ, чанар үүнээс үүдэн тогтолцооны хариу арга хэмжээг хязгаарладаг хүчин зүйл болдог байна. Чухамхүү иймээс л тодорхой бус байдал нь нарийн төвөгтэй нөхцөл байдлын хамтаар хямралын тодорхойлогч шинж чанар болдог юм.

Тодорхой бус байдлын өөр нэг чухал тал бол гэнэтийн хүчин зүйл юм. Энэ хүчин зүйл хамгийн хүсэн хүлээгээгүй газар болон цаг хугацаанд байгалийн сүйрүүлэгч хүч үйлчлэх үед гойд илэрдэг. Гэнэтийн хүчин зүйл нь төлөвлөлтийн дутуу дулимаг байдал, үл ялиг хайхрамжгүй хандлага, мэдээлэл дутмаг байх, эсвэл санаатайгаар тодорхой бус байдал үүсгэх гэсэн тоглоомын нэг хэсгийн үр дагавар байж болно. Мэдээлэл хангалтгүй байх эсвэл “дуулиант мэдээлэл” хэт ихсэх үед гэнэтийн хүчин зүйл нь шийдвэр гаргагч этгээд болон түүний албатууд баримжаа алдах, яаруу сандруу, буруу зөрүү үйлдэл хийх, хүмүүс айж тэвдэх эсвэл идэвхгүй ажиглагчийн байдалд ороход болон бусад хүнд асуудлуудад хүргэж болзошгүй байдаг. Сэтгэл зүйчдийн үзэж байгаагаар аналитик чадвартай буюу юмыг эргэцүүлэн бодох дуртай хүмүүст гэнэтийн хүчин зүйл хамгийн сөргөөр нөлөөлдөг байна.

Гэнэтийн хүчин зүйлээс гадна хямралын өөр нэг онцгой шинж бол ямарваа нэг хор хохирол, гарз, үүний дотор хүний амь нас, эрүүл мэнд, материаллаг болон оюун санааны үнэт зүйлсэд хохирол учруулах гамшгийн шинж чанар юм. Хямралын бодит болон зохиомол аюул занал, шийдвэрийн тодорхой бус байдал, үүний үр дагавар нь микро- (хувь хүн, гэр бүл), мезо- (нийгэм-эдийн засгийн тодорхой тогтолцооны доторх нийгмийн хэсэг бүлгүүд), макро-(тухайн нийгэм-эдийн засгийн тогтолцоо бүхэлдээ эсвэл түүний нэг хэсэг нь) түвшин дэх аюул болон эмзэг байдал, өөрөөр хэлбэл нийгмийн тогтвортой хөгжил болон аюулгүй

байдалд учрах аюул заналыг нэмэгдүүлдэг. Дээр дурдсан түвшнүүд дэх хямралууд болон тэдгээрийн үр дагаврын шалтгааны тухай ойлголт нь тухайн объектыг түүнийг бүрдүүлэгч элементүүд болон дэд системүүдийг хүрээлэн буй /гаднах тогтолцоо/ орчинтой харилцан нөлөөл талаас нь судлах салбар хоорондын системчилсэн хандлагыг шаарддаг болно.

Микро түвшинд эл хандлага нь хүний хүчин зүйл буюу юуны өмнө хүний алдаанд гол анхаарлаа төвлөрүүлдэг. Энд ихэнх хямрал энгийн иргэн хүн, ажилтан, менежер болон удирдагчийн зүгээс нөхцөл байдлыг буруу үнэлэх, анхаарал болгоомжгүй хандахаас үүдэн гардаг байна.

Сэтгэл зүйчид ийм төрлийн алдааны учир шалтгааныг гүнзгийрүүлэн судлахдаа юуны өмнө үйлдвэр, албан байгууллага, төр засгийн удирдлагын дунд болон дээд түвшинд шийдвэр гаргаж буй хүмүүсийн тодорхой үйл ажиллагааны далд сэдэлтийн үүргийг онцгойлон тэмдэглэсэн байдаг. Тэдгээрийн хийсэн дүгнэлтээс үзэхэд, ямар ч нөхцөлд хүмүүс зайлшгүй алдаа гаргадаг. Хүмүүст оновчтойгоор биеэ авч явах бололцоо хязгаарлагдмал байдаг бөгөөд тэд байгаа мэдээлэл нь хэдийгээр эсрэг байсан ч аюул заналын талаарх өмнөх төсөөллөө баримтлахыг илүүд үздэг байна. Цөөн тооны хүн харилцан ажилласан ч гэсэн энэ нь шинэ төрлийн алдаа, харилцан үйл ойлголцлыг төрүүлж, эцэстээ хямрал бий болоход хүргэж болзошгүй юм.

Мезо түвшинд хямралын учир шалтгааныг зохион байгуулалтын хүчин зүйл болон үйл явцаас хайх хэрэгтэй. Энд хамгийн чухал асуудал бол хүний алдаа болон шинжлэх ухаан, технологийн үүдэлтэй аюул заналыг аливаа байгууллагууд бууруулах чадвартай эсэхэд оршино. Тухайлбал, шинжлэх ухаан, технологийн болон хүний хүчин зүйлийн аюултай нөлөөг сөрөн зогсоход шаардагдах тэсвэр боломж тухайн байгууллагад бий юу гэдэг нь чухал. Эл асуултад олон судлаач сөрөг хариу өгсөн байдаг. Тэдний үзэж байгаагаар, хувь хүний алдаанаас урьдчилан сэргийлэх, үр дагаврыг нь зөөллөх чадвар дийлэнх байгууллагад байдаггүй бөгөөд тэр ч байтугай байгууллагууд хамтын алдаа болон хямралын үйл явцыг даамжруулах бусад төрлийн үйлдлийг гаргадаг байна. Тухайлбал, Б.Тернерийн онцгойлон тэмдэглэсэнээр, байгууллагуудад дийлэнхдээ хямралыг төрүүлэгч өөрчлөлтүүдийг анзаарахгүй байхын дээр



хямралын удирдлагыг зохион байгуулахдаа алдаа гаргах давхардсан магадлал ихтэй байдаг байна.

Гэхдээ өөр бусад судлаачийн үзсэнээр, аливаа байгууллагад эрх мэдлийн хувьд нөлөөтэй боловч ухаан дутмаг удирдагчдын алдааг нөхөх боломж үргэлж байдаг юм. Гэхдээ энэ нь доод шатны ажилтнуудын алдаа болон түүнээс үүдэн хямрал үүсэх боломжийг багасгах нь маш ховор ажээ. Дээд зэргийн найдвартай байгууллагын онолыг баримтлагч нэг хэсэг эрдэмтэд зарим байгууллага болзошгүй хямралыг хамгийн доод түвшинд хүргэх чадвартай байх бололцоотой гэж үздэг. Эдгээр мэргэжилтний үзэж байгаагаар, төлөвлөлт, удирдлага сайтай байгууллагууд хүний алдаа болон гаднын нөлөөг “жийргэвчлэх” чадвартай бөгөөд байгууллагуудад “төрөлхийн” гэж хэлж болох дутагдлуудаас урьдчилан сэргийлэх боломжтой байдаг. Байгууллагын удирдлага төрөл бүрийн стратегийн хуримтлуулсан туршлагаа ашиглан өөрийн хамаарлын өндөр эрсдэлтэй системүүдийг дээд зэргийн найдвартай байгууллага болгох бололцоотой ажээ. Судалгааны энэ чиглэлийг баримтлагчид өөрсдийн санааг нотлохдоо, хэрэв захиргааны бүтцийг зөв зохион байгуулж чадах юм бол уг байгууллага үр нөлөөтэй ажиллах боломжтой гэсэн санааг агуулсан ном зохиолыг иш үндэс болгодог байна.

Макро түвшинд, хямралын онол судлаачид хямралын шалтгааныг орчин үеийн нийгэмтэй холбон үзээд өнөөгийн нийгэмд аливаа хямрал гарах нь их бага хэмжээгээр зайлшгүй зүйл гэж тооцдог байна. Тухайлбал, олон улсын нэр хүнд бүхий судлаач Ч.Перроу техникийн томоохон тогтолцоонууд нь хэзээ нэгэн цагт сүйрлийг төрүүлэх бөгөөд энэ нь тэдгээрийн асар их хүчин чадал (жишээ нь цөмийн эрчим хүчний), техникийн нарийн төвөгтэй байдал (АЦС-ийн дотор юу болж байгааг зөвхөн цөөн хэдэн хүн ойлгодог) болон бүрдүүлэгч элементүүдийн харилцан холбооны (нэг алдаа доголдол гинжин урвалд хүргэдэг) нэгдлийн үр дүн мөн гэж тэмдэглэжээ. Бусад эрдэмтэд эрдэс баялгийн нөөцийг хэт шунахайран ашигласнаас болж байгаль орчинд үзүүлэх нөлөөг жишээ татан, аливаа байгууллага нь аюулгүй байдлын зорилгыг бус харин үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асуудлыг илүүтэй анхаардаг гэсэн дүгнэлт хийжээ.

Бүгд биш юм аа гэхэд хямралуудын ихэнх нь хүний /энгийн ажилтан, иргэн, шийдвэр гаргагч этгээд/ алдаа, байгууллагын буруу ажиллагаа, хүн болон

байгууллага хоорондын үйл ажиллагааны байнга өөрчлөгдөн буй харилцан хамаарал, орчноос үүдэлтэй байдаг. Хямрал тухай бүрд эдгээр хүчин зүйлийн хослол өөр өөр байдаг тул хямралын өрнөлтийн зам мөр ялгаатай. Тиймээс уг зам мөрийн гол зангилаа цэгүүдийг тодорхойлохын тулд хямралын явцыг сэргээн судлах арга зүй, дүн шинжилгээний аргууд шаардлагатай болно. Энэ нь хямралын аюулыг багасгах шийдвэрийг гаргахад тулах цэгүүд болох ёстой юм.

Мэдээж хэрэг энэ нь хүний алдаа, мэдээллийн тодорхой бус байдал, нөхцөл байдал болон үр дагаврын өвөрмөц байдал, байгууллагын сул тал, орчны нөлөөллөөс үүдэлтэй хүндрэл бэрхшээлийг арилгахгүй. Гэхдээ хямралуудын зам мөрийг харьцуулах сэргээн дүгнэх аргаар яагаад, ямар нөхцөлд зарим нэг түгшүүртэй байдал, асуудал эсвэл тааламжгүй нөхцөл байдал хямралд хүргэдэг байхад өөр бусад тохиолдолд ийм үр дагавар гардаггүйг тогтоох боломжтой юм. Мөн, аливаа хямралын /байгууллага, орон нутаг эсвэл дэлхий нийтийг хамарсан/ өрнөлт, гүнзгийрлийн механизмыг энэ аргаар тогтоож болно.

Хямралын үр дагаврын тухайд бол үүнд тухайн хямралын шинж чанар бүрэн дүүрэн илэрдэг. “Хямрал” гэсэн нэр томъёог ашиглахдаа гол төлөв үүнтэй холбоотой аюул занал, бодит хор хохирол зэрэг сөрөг үр дагаврыг ойлгодог. Аваар осол, сүйрэл, террорист халдлага зэрэг хямралын төрлүүдийн үед дээрх утга хамгийн тодоор илэрдэг. Мөн, эдийн засгийн хямралын үед ч энэ утга илэрдэг. Ажилгүйдэл, нийгмийн тодорхой хэсгийн ядуурлаас хамааралтай үл итгэх байдал, сэтгэл санааны бухимдал, эсвэл байгалийн гамшиг, террорист халдлагатай холбоотой бүх нийтийн сандрал зэрэг нь нийгмийн тогтворгүй байдлыг гүнзгийрүүлж, тэр ч атуугаа хямралын өмнөх байдалд буцаж орох боломжгүй болгодог.

Хямралын зарим төрөл, тодруулбал нийгмийн сэтгэл санааны хямралыг онцгойлон тэмдэглэх хэрэгтэй. Эл хямралын ойрын хугацааны үр дагавар нь энгийн иргэд эсвэл удирдагчдын хувьд их ноцтой биш мэт санагдавч, зарим тохиолдолд энэ нь алс хэтдээ нийгмийн бүтэц, бүх нийтийн үнэт зүйлсийг эргэлт буцалтгүй эвдлэн сүйрүүлэх аюултай ч байж болно. Зарим тохиолдолд төлөвлөлтийн алдаа мадаг эсвэл үр дүн муутай зохицуулалтаас болж хямрал нь даргаагийн дахин хямралд шилжиж болох бөгөөд энэ нь урьдчилан таамаглах

аргагүй шинэ, өмнөхөөсөө илүү аюултай хямралыг ч авчирч болох юм. Өөрөөр хэлбэл, олон судлаачийн тэмдэглэж байсанчлан энгийн хямралуудын гинжин цуврал буюу төвөгтэй сүлжээ үүснэ гэсэн үг.

Гэхдээ хямралын үр дүн үргэлж сөрөг байдаггүй. Тэдгээр нь нийгмийн болон улс төрийн хөгжилд түлхэц өгч, өөрчлөлтийг авчрах нууц чадавхыг дайчлан эдийн засаг, улс төрийн хөгжлийн өвөрмөц гарцыг нээж болно. Хэрэв нийгмийн байгууллын үндсэн бүтцүүд аюул заналыг- нийгэм-улс төрийн зөрчил мөргөлдөөн ч байг, эсвэл техногенийн осол, сүйрэл ч байсан эдгээрийг дийлж чадаагүй бол энэ нь өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага бий болсныг харуулж, нийгмийн байгууллын хуучин бүтцүүдийг болон тэдний үйл ажиллагааг шинэчлэн өөрчлөх нөхцөл, боломжийг бүрдүүлнэ гэсэн үг юм.

Тухайлбал, олон мянган хүний аминд хүрсэн байгалийн гамшиг, техногений осол эрх баригчдын алдааг тодорхой харуулж, зарим мэдлэг чадваргүй албан тушаалтнуудыг халж солих болон тогтолцооны шинэчлэл хөгжилтийн үүдийг нээж болно. Алс хэтдээ энэ нь, жишээ нь үндэстэн хоорондын эсвэл бүс нутгийн, сунжирсан хямралыг шийдвэрлэх, эрх мэдэлтнүүдийг шуурхай солих, нийгмийн тогтолцоог бүхэлд нь үндсээр нь өөрчлөх нөхцөл болох талтай юм. “Сөрөг нөлөөлөл нь санаатай бус үр дагавар болон хам үр дүнгийн цорын ганц боломжит төрөл байдаггүй” гэсэн Хиршманы үгийг энэ нь баталж байна.

Хямрал, ялангуяа урт удаан хугацааны хямралын үр дагаврын үнэлгээний тухай ойлголт нь тухайн үнэлгээг хийгч этгээдийн суурь үнэт зүйлс, түүний суурин хэм хэмжээ болон шалгуур үзүүлэлтүүдээс хамаардаг нь тодорхой юм. Тухайн үйл явдалд хамрагдсан хүмүүс уг үйл явдлыг хэрхэн ойлгож байгаа нь чухал бөгөөд үүнийгээ уг хүмүүс хямрал гэж хүлээн авсан нөхцөлд л ийнхүү ангилж болно гэдгийг хямрал судлаачид үргэлж ойлгосоор ирсэн. Хямрал болон үр дагаврын тухай субъектив үзэл баримтлал сүүлийн жилүүдэд өрнөдийн улс төр судлал болон нийгэм судлалд өргөн дэлгэрч байгаа бол манайд дөнгөж нэвтэрч байгаа юм.

Судлаачид хямралын үр дагаврыг зөвхөн сөрөг эсвэл эерэг гэж үнэлэх талаар их болгоомжтой хандах болсон бөгөөд эдгээр үр дагаврыг хэтийн төлөв талаас нь ахин дахин үнэлэн шинжилж, анх гаргасан үнэлгээ дүгнэлтээ эргэн

харах болсон байна. Үүний үр дүнд, жишээ нь Карибийн тэнгисийн хямрал (Кубыг тойрсон 1961 оны үйл явдал), Нидерландын Амстердам хотын нисэх буудалд 1992 онд гарсан нисэх онгоцны сүйрэл, 2014 онд Украйнд болсон Малайзын онгоцыг сөнөөсөн хэрэг явдал зэргийг ахин дахин эргэн судалж, цэвэр онолын зэрэг талаас нь янз бүрээр дүгнэж байна. Чернобылийн ослын талаар олон сар, жилийн дараа ил болсон мэдээлэл дээр үндэслэн тухайн үеийн нөхцөл байдал болон шийдвэр гаргасан (өдгөө нэгэнт солигдон алга болсон) эрх баригчдын үйл ажиллагааны талаарх үнэлгээ зарчмын хувьд өөрчлөгдөөд байна. Хэдийгээр үнэлгээний шинж чанар үнэлгээ гаргагч этгээдээс шууд хамаарсан хэвээр байгаа боловч олон нийт эл сүйрлийг техногенийн шинжтэй онцгой байдал, үндэсний болон үндэстэн дамнасан томоохон гай гамшиг гэж үзэж байгаа бол эрх бүхий байгууллагууд, юуны өмнө ОХУ-ын Цөмийн эрчим хүчний яам болон түүний мэргэжилтнүүд эл үйл явдлыг зөвхөн томоохон осол байсан гэж дүгнэж байх жишээтэй юм.

## **2.2. Хямрал ба стратегийн эрсдэл**

Хямрал болон түүний үр дагаврын хоёрдмол шинж чанарыг авч үзэхдээ хямралын нэг үндсэн шинж болох аюул заналын агуулгыг онцгойлон тэмдэглэх нь зүйтэй. Дээр дурдсанчлан аюулын зэрэглэл нь хүн амын амь нас, эрүүл мэнд, эд материалын болон сэтгэл санааны үнэт зүйлсийг оролцуулан нийгэм-эдийн засгийн тогтолцоонд учруулах хохирлын түвшнийг харуулдаг. Түүний цар хүрээ нь нийт тогтолцоо (нийгэм, улс орнуудын хамтын нөхөрлөл, дэлхий нийтийн соёл иргэншил), дэд тогтолцоо /нийгмийн бүлгүүд) болон элементүүд (хувь хүн, гэр бүл)-ийн эмзэг байдлын түвшнийг тусган харуулдаг.

Хямралаар бий болсон эсвэл нэмэгдсэн аюул занал, эмзэг байдлын түвшин нь нийгэм-эдийн засгийн тогтолцоо болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн эрсдэлийн түвшнийг харуулдаг гол үзүүлэлт юм. Чухамхүү эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүд, тухайлбал тоон хэлбэрээр (чанарын томьёоллоор, эсвэл тоон илэрхийллээр) илэрхийлсэн хямралын өрнөлтийн болзошгүй аюул болон үр дагаврын хэмжээ нь аюул ба эмзэг байдал гэсэн хоёр ойлголтыг нэгтгэдэг болно.

Үүнийг онцгойлон тэмдэглэх нь чухал. Учир нь аюулын зэргээс эрсдэлийн түвшин үргэлж хамааралтай байдгийг судлаачид тэмдэглэсээр ирсэн.

Тухайлбал, энэ салбарын нэрт эрдэмтэн Н.Луманн өөрийн сонгодог бүтээл “Эрсдэлийн социологи” номдоо “орчин үеийн нийгэм нь аливаа аюулыг эрсдэл талаас нь авч үздэг бөгөөд ингэхдээ тэдгээрийг зөвхөн осолтой эрсдэл гэж ойлгон хүлээж авдаг” гэжээ. Эрсдэлийн социологийн салбарын орчин үеийн өөр нэг томоохон судлаач, “эрсдэлийн нийгмийн” онолыг зохиогч У.Бек мөн адил байр суурийг баримталдаг. Гэхдээ тухайн этгээд (объект) өөрт нь үйлчилж буй таагүй нөлөөлөлд тэсвэртэй байдлаа (хамгаалагдсан байдал) алдах шинжийг илэрхийлсэн эмзэг байдал ба эрсдэл хоорондын салшгүй холбоог бүх эрдэмтэд тэр болгон хүлээн зөвшөөрдөггүй юм.

Зөвхөн аюул заналын эх сурвалж (гадаад эсвэл дотоод, нэг бол хамтдаа), түүний нөлөөлөл, түүнд хамрагдсан байдал, уг нөлөөллөөс хамгаалагдсан байдал хангалтгүй, эмзэг байдал байгаа нөхцөлд л тухайн объект (субъект)-ын хувьд эрсдэл бий болдог гэдгийг тэмдэглэх хэрэгтэй юм. Үүний нэгэн адилаар, зөвхөн тухайн субъект эсвэл объектод хор хөнөөл (хохирол) учруулах аюул байгаа бол тодорхой үйлчилгээ (шийдвэрийн эрсдэл) бүхий эрсдэл бий болно. Ингэхдээ уг шийдвэр нь эл аюулаас хангалттай хэмжээгээр хамгаалах (даатгал гэх мэт) арга хэмжээг нэг бол тусгаагүй эсвэл тусгасан байдаг. Тиймээс аюул, эмзэг байдал байх нь эрсдэл үүсэх зайлшгүй нөхцөл бөгөөд шинж чанар нь болдог.

Хямралын цар хүрээ, түүнийг тодорхойлогч шинж чанар бол хэмжээ бөгөөд энэ нь эрсдэл болон тодорхой бус байдлын тухай ойлголтуудыг ялган салгах боломжийг олгодог. 1921 онд эдгээр шалгуур үзүүлэлтийн ялгааны тухай ойлголтыг анх боловсруулсан америкийн эрдэмтэн Ф.Найт эрсдэлийн хэмжигдэх чанарыг онцгойлон тэмдэглэж түүнийг “хэмжигдэх тодорхой бус байдал” хэмээн тодорхойлсон байдаг. Ийм төрлийн тодорхой бус байдал буюу ямар нэг тааламжгүй байдал бий болох магадлалыг тоон үзүүлэлтээр тодорхойлох боломжтой бол ердийн тодорхой бус байдал (үл хэмжигдэх тодорхой бус байдал), тухайлбал ирээдүйн үйл явдлыг хэмжих боломжгүй гэж тайлбарласан байна.

Дээр дурдсан тайлбарыг харьцангуй нийтлэг шинж чанартай гэж үзэж болно. Уг тайлбар нь “эрсдэлийн” статистикийн (рациональ) болон үйл хөдлөлийн (нийгэм-сэтгэл зүйн) хандлагуудын шалгуур үзүүлэлтүүдийн

тайлбарыг нэгтгэж байгаа юм. Шинжлэх ухаанд одоогоор ноёрхож буй рациональ хандлагын хүрээнд эрсдэлийг аюултай буюу тааламжгүй үйл явдал бий болох бололцоо /магадлал/ болон эсвэл ийм үйл явдлын (гарз хохирлын) тоон хэмжээ гэж үздэг байна. Ингэхдээ дээр дурдсан үйл явдлын боломжийг хохиролд үржүүлэх аргаар эрсдэлийг тооцоолдог бөгөөд энэ нь үнэн хэрэгтээ хүлээгдэж буй аюул заналын цар хүрээ болон ноцтой байдлын түвшнийг тусган харуулдаг юм.

Хүний зан үйлдлийг таамаглах боломжтой, бүх үйл явдал болон үйлдлийн үр дүнг урьдчилан хэлэх бололцоотой бөгөөд эрсдэлийн асуудал бол тун тааламжгүй үйл явдал болон түүнтэй холбоотой хохирлыг харьцангуй нарийн тооцоолох аргыг олоход оршино гэж үздэг рациональ хандлагатай харьцуулахад нийгэм-сэтгэл зүйн хандлага нь эрсдэлд хүн эсвэл хүмүүс хэрхэн хандаж байгаа онцлогийг гол болгодог. Эл хандлага нь эрсдэлийг зан үйлдлийн шалгуур үзүүлэлт, хүмүүс уг хүлээгдэж буй үйл явдалд, тэдгээрийн болзошгүй аюулыг харгалзан хандаж байгаа хандлага мөн бөгөөд нөхцөл байдал болон шийдвэр гаргалт тодорхой бус байна гэж тайлбарладаг.

Үүний дээр, эрсдэлийн дээр дурдсан тайлбарт эрсдэл нь хямралын илрэл ба үр дүн болохын хувьд хямралтай холбоотой бөгөөд уг холбоо нь нөхцөл байдлын тодорхой бус байдлыг тусган харуулж, тоон үзүүлэлтээр түүнийг үнэлээд зогсохгүй нийгэм-эдийн засгийн тогтолцоонд хамаарах аюул занал, эмзэг байдлыг бүхэлд нь тодорхойлдог.

Ингэснээр уг тайлбар нь улс орны тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлын салбарт “улс оронд учирч болзошгүй стратегийн эрсдэл” гэсэн шалгуур үзүүлэлтийг бий болгох үндэслэл болдог юм. Өнөөг хүртэл бараг зуун жилийн туршид эл ухагдахууныг зөвхөн компанийн төлөвлөлт, удирдлагад болон компанийн буюу бизнесийн аливаа байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ хийхэд ашиглаж ирсэн байна. Улс оронд учирч болзошгүй эрсдэл гэдэг нь алдаатай шийдвэр эсвэл шийдвэр гаргаагүй, шийдвэрийг биелүүлэхэд дутуу дулимаг хандах, гаднын өөрчлөлтөд буруу ташаа хариу үйлдэл хийснээс үүдэн компанийн ашиг орлого, хөрөнгө үлэмж буурах, тэр ч атуугаа дампуурах боломж гэсэн утгыг илэрхийлсээр ирсэн бөгөөд одоо ч хэвээр байна. Ингэхдээ, компанийн үйл ажиллагааны урт хугацааны зорилтуудтай холбоотой шалгуур

үзүүлэлт болох стратегийн эрсдэлийг компанийн тухайн үеийн үйл ажиллагаа болон богино хугацааны санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлүүдээс ялган заагладаг.

Сүүлийн жилүүдэд төр засгийн бүтцүүдэд хамааралтай эрсдэлийн менежмент, хямралын эсрэг удирдлага, стратегийн эрсдэлийн менежментийн нэгдэл бий болсоор улс оронд учирч болзошгүй эрсдэлийн ухагдахуун нь төрийн бодлогыг боловсруулах хэрэгсэл болж хувирсан бөгөөд гадаадын зарим улс оронд санхүүгийн бус салбарууд болон төрийн гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд мөн ашиглагдах болсон байна. Тухайлбал, Канадад 1990-ээд оны сүүлчээс эхлэн хэрэгжүүлж буй 2020 оныг хүртэл засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх тусгай төслийн хүрээнд тус орны сангийн яамны стратегийн эрсдэлийн нэгдсэн менежментийн туршлагыг батлан хамгаалах яаманд хэрэгжүүлэхээр болсон байна.

Ингэхийн тулд ирээдүйн үйл явдлын үр дагавар тодорхой бус гэсэн утга агуулга бүхий “эрсдэл” гэсэн ойлголтоос салж, стратегийн зорилтууддаа “хүрэхгүй байх”, үндэсний аюулгүй байдлыг оролцуулан үүнтэй холбоотой өргөн цар хүрээ бүхий сөрөг үр дагавар гарах гэсэн утга бүхий стратегийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлэх шаардлага гарсан байна. Канадын Батлан хамгаалах яамны хувьд шинжээчийн дүгнэлтийн аргаар үнэлэх ёстой стратегийн эрсдэлийн хоёр бүлэг хүчин зүйл байхаар уг төсөлд тусгасан байна. Нэгдүгээрт, Батлан хамгаалах яамны үйл ажиллагаанд шууд хамааралтай хүчин зүйл: алдаатай үйл ажиллагааны боломж, нөөц хүрэлцэхгүй байх, мэдээллийн системийн найдваргүй байдал г.м. Хоёрдугаарт, дам хүчин зүйл: засгийн газрын олон утгат шийдвэр, улс орны хүн амын онцлог, бусад салбаруудтай хамтран ажиллах зэрэг. Үүний зэрэгцээ энэ нь улс болон гадаадын бусад орны хувьд стратегийн эрсдэл гэсэн ойлголтыг нийт улс орны аюулгүй байдал болон тогтвортой хөгжлийн салбарт бүхэлд нь бус харин улс орны амьдралын тодорхой салбаруудад хамааралтайгаар хэрэгжүүлж байгаагийн илэрхийлэл гэдгийг анхаарах ёстой.

Бидний санал болгож буй улс оронд учирч болзошгүй эрсдэлийн тодорхойлолтод эрсдэл гэдгийг өргөн утгаар нь аюулын төрөл бүрийн эх сурвалж болон хүчин зүйлийн гамшигт нөлөөллөөс үүдэлтэй хүн ам, аж ахуйн объект,

хүрээлэн буй орчны эмзэг байдлаас хамааран үндэсний аюулгүй байдал, улс орны тогтвортой хөгжилд учирч болзошгүй аюул заналыг хамааруулан ойлгож байгаа юм. Ингэхдээ бид Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” болон “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн бодлого”-д өгсөн “үндэсний аюулгүй байдал”, “тогтвортой хөгжил” гэсэн ухагдахууны норматив тодорхойлолтыг ашигласан болно. Харин удирдлагын шалгуур үзүүлэлтийн хувьд нарийвчилсан утгаар нь улс оронд учирч болзошгүй эрсдэлийг төрийн удирдлагын салбарт үр нөлөөгүй буюу огт шийдвэр гаргаагүйгээс үүдэн тогтвортой хөгжил болон үндэсний аюулгүй байдалд сөрөг үр дагавар учрах боломж гэж үзсэн болно.


Эдгээрт үндэслэн улс оронд учирч болзошгүй эрсдэлийг “Гадаад, дотоод үүдэлтэй аливаа аюул заналаас хувь хүн, нийгэм болон төр улсын хамгаалагдсан байдлын түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулж болзошгүй тааламжгүй үйл явц /хямралт үйл явдал, элдэв сүйрэл, байгалийн гамшиг/ болон тэдгээрээс болж учрах хор хохирлын үүсэх магадлалын хослол” хэмээн тодорхойлж болохоор байна.

Энэ утгаар нь авч үзвэл улс оронд учирч болзошгүй эрсдэлийн энэ салбарын үйл ажиллагаанд хэрэглэдэг дадал болсон бусад ойлголтоос ялгагдах зарчмын онцлогуудыг тодотгох нь чухал юм. Эдгээр нь, Нэгдүгээрт, аливаа аюулын эх сурвалж, хүчин зүйлүүд үргэлж бодитойгоор оршиж байдгаас болон ерөөсөө нийгэм болон хүрээлэн буй орчин тэдгээрийн нөлөөлөлд эмзэг өртөмтгий шинж чанарыг /хамгаалалт болон тогтвортой байдал хангалтгүй байх/ агуулж байдгаас урган гардаг ямар нэгэн аюул заналхийлэл хэзээ ч гарч болох магадлалтай шинж чанар. Эдгээр аюул заналхийллийн хослол нь ямагт тохиолдлын хэмжигдэхүүн байдаг. Хоёрдугаарт, дээр дурдсан аюул заналын хэмжигдэх болон тооны хувьд харьцуулагдах боломж бөгөөд тэдгээрийг дүн шинжилгээ-шинжээчийн арга ажиллагааг ашиглан хооронд нь харьцуулан үнэлэх боломжтой юм. Гуравдугаарт, бүх төрлийн аюулаас тогтвортой хөгжил болон үндэсний аюулгүй байдалд ойрын болон удаан хугацаанд /тав болон түүнээс олон жил/ нөлөөлөх аюулуудыг ялган зааглах ёстой болно.

Эдгээр нь улс оронд учирч болзошгүй эрсдэлийн бусад төрлийн аюулуудаас хамгийн дээд, тэргүүлэх ач холбогдолтой болохыг илтгэн харуулж



байгаа бөгөөд тэдгээрийг өвөрмөц пирамидаар харуулах бололцоог олгож байна. Үүний дээр, улс оронд учирч болзошгүй эрсдэлүүдийн дотор ч гэсэн цар хүрээний хувьд бусдаас илүү хор хохирол учруулж болох аюулуудыг тодорхойлж болох бөгөөд энэ нь тэдгээрийг ангилах шалгуур үзүүлэлтүүд дээр тулгуурлан хийгдэх бололцоотой юм. Улс оронд учирч болзошгүй эрсдэл ангилах өөр бусад үндэслэлд аюул заналын орон зайн хязгаарлалт /тухайн нийгэм-эдийн засгийн тогтолцооны хүрээнд/, аюул занал өрнөх механизм, аюул заналын үүсэх эх сурвалж болон өрнөх хүрээ, салбар зэрэг багтааж болох юм. Эцэст нь, эдгээрт тулгуурлан хийсэн улс оронд учирч болзошгүй эрсдэлийн ангиллыг доор харуулав.



Зураг 2.1. Улс оронд учирч болзошгүй эрсдэлийн ангилал

Монгол Улсын хөгжлийн өнөөгийн шатанд аюулгүй байдал, үндэсний хөгжлийн удирдлагыг боловсронгуй болгох, юуны өмнө аливаа аюул, заналаас урьдчилан сэргийлэх арга, хэлбэрийг тодорхойлох ач холбогдлын үүднээс улс

төр, эдийн засаг, нийгмийн болон бусад үндсэн салбарт үүсэж болзошгүй стратегийн эрсдэлийг онцгойлон авч үзэх нь чухал болоод байгаа юм. Эдгээр салбарт болон учирч болзошгүй эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнг 3 дугаар бүлэгт тусгасан болно.

## Хүснэгт 2.1

### Улс оронд учирч болзошгүй эрсдэлийн үндсэн үзүүлэлтүүд

Салбар хүрээ	Хямрал, эрсдэлийн учир шалтгаан	Хямралын өрнөлтийн үзүүлэлтүүд	Үр дагавар
Улс төрийн	<p>Гадаад:</p> <p>улс хоорондын зөрчил сөргөлдөөн, олон улсын терроризм</p> <p>Дотоод:</p> <p>эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлын доройтол, үндэстэн, ястан, шашин шүтлэгтэн хоорондын зөрчил сөргөлдөөн. Хүчний байгууллагуудын доройтол</p>	<p>Дотоод улс төрийн хямралын социологийн үзүүлэлтүүд:</p> <p>-эдийн засгийн шинэчлэлийн үйл явцад шинжээчид, хариуцагчдаас өгөх үнэлгээ;</p> <p>-нийгэм-улс төрийн амьдралд иргэдийн оролцооны байдал;</p> <p>-улс төр, нийгмийн тогтолцоог шинэчлэх шаардлага</p> <p>-улс төр, нийгмийн байгууллагуудад итгэх шинжээчид, хариуцагчдын итгэлийн түвшин;</p> <p>-ардчилсан нийгмийн хэм хэмжээг тогтоох төрийн үйл ажиллагаа;</p> <p>Улс төр нийгмийн харилцааны тогтолцоог эдгээр үзүүлэлтүүдээр хэмжсэн үр дүнгээр түүний тогтвортой байдлын нэгдсэн индексийг тооцон гаргах боломжтой юм</p>	<p>Үймээн самуун, төрийн эргэлт гарах, улс орон задрах магадлал</p>
Эдийн засгийн	<p>Улс орны хөгжлийг удирдах стратегид оновчгүй шийдвэр гаргах, Авлигал газар авах Шинжлэх ухаан, технологийн салбарын хямрал</p>	<p>Үйлдвэрлэлийн үндсэн нөөцийн элэгдлийн түвшин;</p> <p>Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт (ДНБ-д эзлэх хөрөнгө оруулалтын хувь, %)</p> <p>Аж үйлдвэрийн үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ;</p> <p>Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ</p>	<p>Эдийн засгийн алдагдал (хангалттай бус ДНБ)</p>
Нийгмийн	<p>Амьжиргааны түвшний бууралт, нийгмийн сэтгэлгээний хомсдол</p>	<p>Хүн амын эрүүл мэндийн буюу өвчлөлтийн түвшин, халдварт өвчин гарах боломж, согтууруулах ундаа, мансууруулах бодис, хар тамхины хэрэглээний түвшин.</p> <p>Хүн амын амьдралын түвшин: хэрэглээний түвшин (хэрэглээний сагс), үүнд зайлшгүй шаардлагатай хоол хүнс, орон байр, ахуй</p>	<p>Зуурдаар нас барах нь нэмэгдэх, дундаж наслалт багасах; нийгмийн тэсрэлт үүсэх магадлал</p>

		<p>үйлчилгээний болон тээврийн үйлчилгээ багтана;</p> <p>Хүн амын орлогын ялгааны түвшин (амьжиргааны доод түвшнээс бага орлоготой хүн амын эзлэх хувь, %), ажилгүйдлийн түвшин (эдийн засгийн идэвхтэй хүн амын, %),</p> <p>гэмт хэргийн түвшин</p>	
Батлан хамгаалах	<p>Гадаад:</p> <p>цэргийн түрэмгийллийн аюул, заналхийлэл нэмэгдэх</p> <p>Дотоод:</p> <p>батлан хамгаалах чадавх буурах</p>	<p>Болзошгүй дайснууд, тэдгээрийн эвсэл холбоотой өрсөлдөх цэрэг-эдийн засаг, цэргийн чадавхын харьцуулалт;</p> <p>Зэвсэгт хүчний байлдах чадварын түвшин, орчин үеийн зэвсэг, техникээр хангагдсан байдал, Цэргийн алба хаагчдын сэтгэл санааны байдал; Дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн гарах магадлал;</p>	<p>Дайнд ялагдах магадлал;</p> <p>Дайнд эдийн засгийн хохирол хүлээх</p>
Шинжлэх ухаан-технологийн	<p>Боловсролын системийн хямрал</p> <p>Боловсролын системийн хямрал, “оюуны дайжих”-аас шалтгаалан улс орны шинжлэх ухаан, технологийн, инновацийн чадавх буурах;</p> <p>Суурь болон салбарын шинжлэх ухааны хямрал</p>	<p>Хүн амын боловсролын түвшин;</p> <p>Нийт ажиллагсад шинжлэх ухааны чиглэлээр ажигладаг хүмүүсийн эзлэх хувь, %;</p> <p>Шинжлэх ухаанд үзүүлж буй төрийн дэмжлэгийн түвшин (ДНБ- д шинжлэх ухааны зардлын эзлэх хувь, %);</p> <p>Шинэ технологийг хөгжүүлэх ажлын хоцрогдлын түвшин (өндөр Технологид тулгуурлан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эзлэх хувь)</p>	<p>Улс орны экспортын чадавх буурах; өндөр зардлаар гадаадаас мэргэжилтэн урих шаардлага үүсэх</p>
Технологийн	<p>Үндсэн хөрөнгийн элэгдэл ба түүнийг шинэчлэх явдал удаашралтай байх</p>	<p>Үйлдвэрлэл болон тээврийн салбарын ослын тоо хэмжээ;</p> <p>Онцгой нөхцөл байдлын давтамж, эдгээрээс үүдсэн эдийн засгийн алдагдал;</p> <p>Осол аваарын улмаас нас барсан, хохирсон хүмүүсийн тоо</p>	<p>Эдийн засгийн алдагдал өсөх</p> <p>Зуурдаар нас барах магадлал өндөрсөх</p>
Хүн ам зүйн	<p>Төрөлт буурах, нас баралт нэмэгдэх</p>	<p>Хүн амын ердийн бууралт, 1000 хүн тутамд</p>	<p>Хүн амын тоо болон ажиллах хүчний нөөц буурах</p>
Оюун санааны	<p>Шашин, соёл, урлагийн хямрал</p>	<p>Хүн амын соёлын түвшин, эх оронч үзлийн түвшин, үндэсний үзэл</p>	<p>Улс орон сулран доройтох</p>
Байгалийн	<p>Хүний бодлогогүй үйл ажиллагаа,</p> <p>Гамшиг ослоос сэргийлэх ажлын хангалтгүй санхүүжилт</p>	<p>Аюул дагуулсан үйл явц, үйл явдлаас үүдсэн эдийн засгийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь, %</p>	<p>Эдийн засгийн алдагдал өсөх</p> <p>Зуурдаар нас барах магадлал өндөрсөх</p>

Экологийн	Хүний бодлогогүй үйл ажиллагаа	Экологийн сүйрлийн давтамж, үүнээс үүдсэн шууд бус эдийн засгийн алдагдал; Хүрээлэн буй орчны байдал: хөрс, агаар, усны бохирдлын зэрэг; Биологийн төрөл зүйлүүдийн хорогдлын түвшин; Химийн болон биологийн бохирдол, цацраг туяаны боон цахилгаан соронзон бохирдлын түвшин; Байгалийн баялгийн нөөц барагдах түвшин (байгалийн баялгийн нөөцийн хэмжээ, эрдэс, түүхий эд олборлох үйл ажиллагааны өсөлтийн хурд); Хүрээлэн буй орчныг хамгаалахад зарцуулж буй зардлын түвшин; Дэлхийн байгаль орчин, цаг уурын өөрчлөлтийн харьцангуй үзүүлэлтүүд	Байгаль орчны чанар доройтох
-----------	--------------------------------	---	------------------------------

### 2.3. Эрсдэл судлалын тухай ойлголтын үндэс, стратегийн эрсдэл

#### 2.3.1. Учирч болзошгүй эрсдэлийн тухай ойлголт, онол, эрх зүйн үндэс

Тухайн өгүүлэлд эрсдэл хэмээх ухагдахууны орчин үеийн нийгэм-философийн тайлбар болон монголын нийгэм дэх статистикийн судалгааны мэдээллийг ашиглан тодорхойлсон түүний улс төр, эдийн засаг, нийгмийн онцлогийг харуулсан болно. Мөн, орчин үеийн Монгол Улсын эрсдэлийг тодорхойлогч “түүхэн” ухамсар гэсэн үндсэн үзүүлэлтийг хангалтгүй тооцож байгааг энд хөндсөн болно.

Эрсдэлийн талаарх дахь бүх онол, үзэл бодол, санааг нэгтгэн дүгнэж, шинжлэх ухааны салбарууд дундын, тухайлбал, улс төр, эдийн засаг, нийгмийн ухааны энэ чиглэлээрх хандлагыг тооцож, эрсдэлийн онцлог, илрэх хэлбэрүүдийг тогтоох нь тийм ч хялбар биш. Шинжлэх ухааны цаашдын хөгжил нь шинэ ухагдахуун, нэр томъёо нэвтрүүлэх, шинэ агуулгаар дүүргэх эсвэл орчин үеийн бодит байдалд нийцэхгүй хуучин, ёс суртахууны хувьд хоцрогдсон зүйлийг халахыг шаарддаг. Нөгөө талаас, “эрсдэл” гэсэн ухагдахуун, “улс төр” гэсэн зүйлд тодорхойлолт өгснөөрөө бид тодорхой асуудлыг харьцангуй зөв байдлаар хэлэлцэж, онол дэвшүүлж, дүн шинжилгээ хийх боломжтой болдог.

Эрсдэлийн илрэлийн онцлогийг хүний хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааны төрөл бүрийн салбарт хамааруулан судлах нь тодорхой салбарт, тодорхой шинжлэх ухааны давуу тал мөн боловч нийгэм бол тэдгээрийг удирдах ямар нэг механизм, арга хэрэгслийн (заавар, баримт бичиг, хуулийн) цуглуулга биш. Аль нэг шинжлэх ухааны салбар дахь судалгаа шинжилгээ, шийдвэрийн эрэлхийлэл, боловсруулалтын үр дүнг яаж ч нэмж хассан бид эрсдэлийн загварын бүрэн дүүрэн дүр зургийг (тухайлбал, улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт) гарган авч чадахгүй гэдгийг ойлгож, хамгийн гол нь хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Бид зөвхөн нийгэм, олон нийт, улс төрийн үйл явц дахь эрсдэлийн бүхэл бүтэн механизмын цуглуулга, түүний тодорхой элемент, эд ангиудыг л олж харах бөгөөд түүнд нөлөөлөх, удирдах, өөрчлөн байгуулах боломж байхгүй.

Чухамхүү нийгэм-философийн хандлага нь эрсдэлд дүн шинжилгээ хийхээс гадна түүнийг удирдан чиглүүлэх, мөн хүний үйл ажиллагаа болон өргөн утгаар нь хүрээлэн буй дэлхий ертөнцийн байгууллын төрөл бүрийн салбар дахь суурь үнэт зүйлс, зарчим, аксиом, тогтсон дүрэм журмыг түүхийн үүднээс ойлгох боломжийг олгож байгаа болно. Эрсдэл нь тааламжгүй үйл явдлын боломж (бий болох), эл үйл явдлын (гарз, хохирол, алдагдал) цар хүрээ (үр дагавар) гэсэн ойлголтыг өөртөө агуулдаг. Энэхүү, өнгөц харахад, энгийн арга хэмжээ нь тодорхой бус эсвэл аюултай байдлын нөхцөл дахь субъектийн (хувь хүн, нам, нэгдэл эсвэл өөр төрлийн эвсэл) үйлдлийг тодорхойлдог.

Субъект нь бий болсон нөхцөл байдалд тохирох төрөл бүрийн хувилбар (хослолууд)-удыг авч үзээд тодорхой бус байдлын (эрсдэлийн) түвшнийг үнэлж, шаардлагатай үйл ажиллагааны талаар шийдвэр гарган эдгээр үйл ажиллагааны тоон болон чанарын бүрэлдэхүүн хэсэгт засвар залруулга хийнэ. Хямралт (субъектийн үзэж байгаагаар таагүй) нөхцөл байдалд нөлөөлөхөөр авсан арга хэмжээ нь субъектийг шинэ сонголт хийхэд хүргэдэг бөгөөд ингэснээр тодорхой бус байдлын дараагийн тойргийг үүсэж, тухайн аюулын (эрсдэлийн) түвшний хэмжээг субъект өөрийн ойлголтоороо тодорхойлдог. Үүнтэй холбоотойгоор, аюул, түүний зэргийн талаарх субъектийн үзэл бодолд логикийн хувьд зөрчилдөөгүй, ил тод дараах гурван нөхцөл байдал (нэн тааламжтай) байж болох юм:

- нөхцөл байдал үүсэх боломж их өндөр, гэхдээ уг үйл явдалтайгаар холбоотойгоор субъектэд учрах хохирол тэгтэй тэнцүү (эсвэл маш бага) бөгөөд

эл нөхцөл байдалд аюул учрахгүй (эрсдэл тэгтэй тэнцүү) гэдгийг субъект сайтар ойлгож байгаа;

- нөхцөл байдлаас учирч болох хохирол маш их, гэхдээ нөхцөл байдал үүсэх магадлал тэгтэй тэнцүү: тиймээс аюул байхгүй (эрсдэл тэгтэй тэнцүү);

- нөхцөл байдал болон түүнээс үүдэж болох хохирол тэгтэй тэнцүү: аюул занал баттай алга байгаагаар уг нөхцөл байдал тодорхойлогдож байна (үнэмлэхүй аюулгүй байдал).

Болзошгүй байдал болон гарз хохирол тодорхой утгатай болсон бусад бүх тохиолдолд субъект нь бий болсон нөхцөл байдлыг холбогдох эрсдэл бүхий аюул занал хэмээн үнэлнэ [12]. Үүний зэрэгцээ, эрсдэлт нөхцөл үүсэх, эл үйл явдлаас субъектэд учрах хохирол (болзошгүй азгүйдэл, аюул, материаллаг болон бусад гарз хохирол) тодорхой бус байдлыг тэмдэглэхийн зэрэгцээ эрсдэлийн нөгөө тал (тодорхой хэмжээгээр эерэг) буюу “нөгөө талаас эрсдэл нь аз тохиох, үйл явдал нааштай төгсөх боломжтой холбож үздэгийг” тэмдэглэх хэрэгтэй [1].

Эл ажлын хүрээнд бид болзошгүй байдал болон хохирол тодорхой утгатай гэж тооцон нөхцөл байдалд аюултай (таагүй, зорилго ба зорилтод нийцээгүй) гэсэн субъектив үнэлгээ өгч, “улс төрийн” гэсэн нэмэлт тодорхойлолтыг оруулснаараа философийн “эрсдэл” категорийн шигтгэмлийн нэгэн талстыг тодорхой болгож байгаа юм. Орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийн хөгжлийн онцлог нь Монгол дахь улс төр, эдийн засаг, нийгмийн эрсдэл, түүний илрэлийн онцлогийн нийгэм-философийн судалгааг хийх, түүний тоон болон чанарын бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээг хийснээр эрсдэлийг таамаглах ба удирдах зэрэг хавсарга ач холбогдолтой боломжийг бий болгох бололцоог төдийгүй, хэрэгцээг ч бүрдүүлж байна.

Үүнтэй холбогдуулан “эрсдэлийн түвшин” хэмээх ухагдахууныг тодорхой болгох хэрэгцээ бий болж байна. Эрсдэлийн түвшин гэдэг нь гаргаж буй шийдвэрийн хүсэн хүлээгээгүй, болзошгүй үр дагавраас үүдэлтэй гарз хохирлыг тооцсон эрсдэлийн нөхцөл байдлын (шийдвэр гаргахад оршиж буй тодорхой бус байдлын түвшнийг тусгаж буй) тоон үнэлгээ болно. Бодитоор бол эрсдэлийн түвшин нь асуудлыг шийдвэрлэх замыг сонгож буй этгээдийн хариуцлагын эсвэл хариуцлагагүй байдлын түвшнийг тодорхойлдог. Бодит байдал дээр улс төр,

эдийн засаг, нийгмийн эрсдэлийн үнэлгээг цаг хугацааны өөр өөр цар хүрээнд зориулан гаргадаг бөгөөд тэдгээрийн сонголт нь эрсдэлийн үнэлгээг тооцон гаргасан шийдвэрийн онцлогоор тодорхойлогддог байна. Үнэлгээг “дэлхийн, бүс нутгийн, үндэсний, улс орны дотоодын бүс нутгийн (хот, аймаг)” гэсэн төрөл бүрийн түвшинд гаргадаг [5].

Улс төр, эдийн засаг, нийгмийн эрсдэлийг тодорхойгүй байдлын олон хүчин зүйл нөхцөлдүүлдэг бөгөөд үүнд, юуны өмнө, уг салбарын бодлого оновчтой бус, ээдрээтэй, цар хүрээ өргөн байхаас хамаардаг. Тэдгээрийг дараах төрлүүдэд багцаагаар хувааж болно. Үүнд:

- мэдээллийн – болж буй улс төрийн бүхий л үйл явцын талаарх яв цав, бүрэн дүүрэн мэдээлэл алга байх, бүхэлдээ улс төрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ чанаргүй байх, түүнд эрх баригчдын зүгээс зохих хариу үйлдэл үзүүлэхгүй байх, авах ба алдахын яв цав тооцоо алга байх, улс төрийн үйл ажиллагааны бусад оролцогчдын ашиг сонирхлыг үл ойшоох зэргээс үүдэлтэй эрсдэл;

- нийгмийн – явуулж буй тогтворгүй, түрэмгий, хэт түрэмгий улс төрийн бодлого, улс төрийн зарим байгууллагын үйл ажиллагаа, улс төрийн бодлого ард түмний дунд дэмжлэг олоогүй, улс төр, үндэстэн хоорондын болон бусад төрлийн зөрчил мөргөлдөөн, ажилгүйдэл, эдийн засгийн хүнд байдал, нийгмийн шийдвэрлэгдээгүй олон тооны асуудал зэргээс үүдэлтэй эрсдэл;

- хувийн – улс төрчийн хувийн зан байдал, үйлдэл, улс төрийн үйл ажиллагааны хамтын шинж чанарыг үл харгалзан хувийн тоглолт хийх, эрсдэлд хэт их шүтэхтэй холбоотой. Гэхдээ зарим улс төрчид чухамхүү ер бусын, аюултай нөхцөл байдалд илүү үр дүнтэй ажилладаг, таашаал авдаг бөгөөд заримдаа ийм нөхцөл байдлыг өөрсдөө бий болгодог гэдгийг тэмдэглэх хэрэгтэй;

- эрх зүйн – зарим тохиолдолд эрх зүйн болон ёс суртахууны үгүйсгэх үзэл, улс төрийн харилцан ажиллагаа болон харилцаа холбооны тогтсон нөхцөлийг үл биелүүлэх, хууль тогтоомж болон ёс суртахуун-улс төрийн шинж чанартай гэрээ хэлцлийн хэм хэмжээний шаардлагыг зөрчих явдлаас улс төрийн эрсдэл үүсдэг;

- эдийн засгийн – аль нэгэн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө мөнгө байхгүй байх, эдийн засгийн хөгжингүй, тогтвортой дэд бүтэц үгүй

байх, төрийн өмчийн үйлдвэрийн газрын өр зээл төлөгдөөгүй байх, эдийн засгийн оновчтой хөтөлбөр үгүй байх, шууд хөрөнгө оруулалт байхгүй, валют-зээлийн яв цав бодлого дутагдах зэрэг нь улс төрийн эрсдэлийг бий болгодог;

- тохиолдлын – дээр дурдсан хүчин зүйлүүдээс гадна аль нэг бодлого тохиолдлоор бүх талын аюул занал тэрүүлэгч, хүсэн хүлээгээгүй, таамаглаагүй нөхцөл байдалд (өвчин зовлон, улс төрийн зүтгэлтнүүд огцрох, золгүй тохиолдол, байгалийн гамшиг гэх мэт) хүргэдэг [4, 140].

Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын дүн шинжилгээг хийхдээ өөрийн түүх, соёл, үндэсний язгуур бүхий олон талт, цогц үзэгдэл болох улс орны улс төр, эдийн засаг, нийгмийн эрсдэлийн талаарх нэгдмэл төсөөллийг тодорхойлогч тэдгээрийн мөн чанар, зөрчилдөөн, шинж чанар, элементүүдийг тогтоох шаардлагатай. Орчин үеийн Монгол Улсын нийгэм-улс төрийн нөхцөл байдлыг судлан үнэлэхдээ бид дараах шалгуур үзүүлэлтүүдийг удирдлага болгох болно:

- төрийн болон улс төрийн шийдвэр гаргахад бодит нөлөө үзүүлэгч гол нам, нэгдлүүд оршин байх болон тэдгээрийн байр суурь;

- хямралын өмнөх ба хямралын үеийн улс төрийн нам, нэгдлүүдийн нөлөөллийн динамик болон нийгмийн хариу үйлдэл;

- нам болон нэгдлийн удирдагчдын хувийн байр суурь ба бодлого.

Тоон болон чанарын объектын хийсвэр дүн шинжилгээ хийхийн тулд МИГС-ийн мониторингийн мэдээллийг ашиглая. Эрх баригчид (засаг захиргаа болон улс төрийн элит) ба нийгэм хоорондын харилцааны асуудлаар хийсэн судалгаанаас үзэхэд “иргэдийн дийлэнх олонх нь улс орны улс төрийн тогтолцоог өөрчлөх хэрэгтэй гэж үздэг: эрс өөрчлөх – 16% эсвэл олон тооны алдаа дутагдлыг арилгах - 50%. Энэ нь нийгмийн зүгээс улс төр, олон нийтийн бүтцийн байгууллагуудад ерөнхийдөө нааштай ханддаг хэдий ч улс оронд улс төр, захиргаа, нийгмийн өөрчлөн байгуулалт явуулах “эрсдэл”-ийн түвшин өндөр хэвээр байгааг харуулж байна.

Өнөөгийн тоон үзүүлэлтээс үзэхэд: “санал асуулгад оролцогчдын дөнгөж 33% нь МАН, 11% нь АН, 9% нь ХҮН, 7% нь бусад намыг дэмжиж” байгаа нь



ардчилсан нийгмийн гол шинж тэмдэг болсон олон намын тогтолцоо байгааг харуулж байна. Нөгөө талаар, “санал асуулгад оролцогчдын дөрөвний нэг (22%) нь ямар нэг намыг дэмждэггүй, 19% нь хариу өгөөгүйгээс үзэхэд [9] нийгмийн үлэмж томоохон хэсэг улс төрийн шинэчлэлийн үйл явцад оролцдоггүй, идэвхгүй, зарим тохиолдолд намын талаар сөрөг байр суурь эзэлдэг нь харагдаж байна. Энэ бол зөвхөн үр дагавар бөгөөд учир шалтгаан нь улс орны түүхэн, үндэсний, шашин шүтлэгийн болон бусад онцлогд оршиж байна. Үүнээс, “тогтвортой үйл ажиллагаа явуулах чадвартай нам-улс төрийн тогтолцоо байгуулах болон нийгмийн бат цул бүтцийн талаар ярихад эрт байна” гэсэн дүгнэлт хийж болох юм [9].

МИГС-ийн судалгаагаар, “иргэдийн 40-өөс арай бага хувь нь өөрт хамгийн тааламжтай үзэл суртлын чиглэлийг сонгож чадаагүй” нь намын талаарх нийгмийн хандлагын талаарх бусад судалгааны үр дүнг баталж байна. Тэдгээрийн үзэл бодол, үзэл санаа-улс төрийн чиг баримжаа нь хямралын өмнөх үед ба хямрал эхэлсэн үеийн нөхцөл байдалд эрс биш гэхэд үлэмж өөрчлөгдөх ёстой мэт. Гэтэл социалист үзэл санаа, нийгмийн шударга ёс, тэгш эрх, хөдөлмөрчин хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалахыг эрхэмлэдэг “зүүний” үзэлтэй иргэд 18 хувийг (2008 оны 11 дүгээр сард хямралын эхний шинж тэмдэг илрэх үед 24 хувь) эзэлж байсан. Харин либерал үзэл санаа, эдийн засгийн эрх чөлөө, хүний эрх, улс төрийн ардчилал, Өрнөдтэй ойртох талыг эрхэмлэгч иргэд 13 хувь (11-дүгээр сард – 14%) болж байв.

Үндэсний уламжлалт үнэт зүйлс, улс орны тусгаар, бие даасан байдал, хүчирхэг гүүрэн болгон бэхжүүлэхийг эрхэмлэгч “үндэсний хуучинсаг үзэлтнүүд” хамгийн их дэмжлэг - 31% (11-дүгээр сард - 33%) хүлээсэн байна. Энд бид түүхэн болон үндэсний язгууртай холбоотой улс орны онцлог, хүмүүсийн зан байдал, харьцааг дахин харж болно. Чиг баримжааны насны онцлогоос ч бид түүхэн (1985-2009) бодит байдлыг харах боломжтой. 60 гарсан ахмад үеийнхний хувьд “зүүний” үзэл санаа илүү ажиглагдаж байна (тэдгээрийн 24% нь “зүүний” үзэл баримтлалтай бол 35 хүртэлх насны залуучуудын дунд энэ үзүүлэлт 14%). Залуу хүмүүс “либерал” үзэл сурталд илүү татагддаг байна (35 хүртэлх насны хүмүүсийн 17%, харин 60-аад насныхны ердөө 8 хувь нь “либералууд” байна [2].

Дүгнэлт: төр засгийн өөр хэлбэрт (тодруулбал, газар нутгийн болон улс төрийн бүрэлдэхүүн хэсгийн эрс өөрчлөлт) амьдарч байсан туршлагатай ахмад

үеийнхэн “либерал” бүлгийн үлэмж хэсгийг бүрдүүлж, үүний дараа тоон үзүүлэлтийн хэсэг уналт (1990-2000 оны нийгмийн хатуухан донсолгооны үетэй холбоотой) байгаад “зүүний” үзэл санаа (залуусын дунд) дахин аажмаар нэмэгдсэн байна. Гэхдээ бид энд дахиад л манай орны онцлогтой тулгарна: «үндэсний хуучинсаг үзэлтнүүд бүх насны бүлгүүдэд бараг тэнцүүхэн хуваарилагдсан” бөгөөд түүгээр ч үл барам “монголын уламжлалт үнэт зүйлс, тусгаар тогтнол, бие даасан байдал, хүчирхэг гүрэн болгон бэхжүүлэхийг эрмэлзэгч “үндэсний хуучинсаг үзэлтнүүд” хамгийн их (31%) дэмжлэг авсан байна [2].

Улс төрийн чиг баримжаанаас (зүүний, барууны, эх оронч) үл хамаарах хүчирхэг эвслийг улс төрийн тавцангийн хамгийн төвд байгуулах гол сэдэлт бол “улс орны төрт ёсыг бэхжүүлэх хамгийн суурь, амин чухал үнэт зүйлсийг тойрон нягтрах нийгмийн хэрэгцээ” бөгөөд ард иргэдийн “улс төрийн нэгдмэл үзэл санааг” ноомой байдал, иргэний ухамсар доройн илэрхийлэл гэж үзэх учиргүй. Улс төрийн тулаан тодорхой хугацаагаар хойшилсон нь ойлгомжтой. Энэ хариу үйлдлээс үзэхэд, нийгэм маань санал болгон хэрэгжүүлж буй шинэчлэлийг эсэргүүцэхгүй байгаа бөгөөд өнөөгийн байгууллыг (төр, улс үндэстэн) хадгалж үлдэх далд ухамсартаа хөтлөгдөн тэдгээрийг (өөрчлөлт шинэчлэлт) хоёрдугаарт тавихад бэлэн байгаа харагдаж байна.

Нийгэм олны нийтлэг ухамсар нь өөрчлөлт шинэчлэлтийн зорилго бус, харин тэдгээрийг хэрэгжүүлэх хэлбэр, хэрэгслийг л чухалчилж байна. Өнөөгийн манай иргэний нийгэм нь улс төрийн нэг зүтгэлтнийг (У.Хүрэлсүх (45%) илүү өндөрт тавьж байгаа бөгөөд үүнээс үүдэн нам-улс төрийн сонголтоороо онц ялгарахгүй байна. Манай улсын түүхэн замналаас үзэхэд, бүрэн эрхт нэг удирдагч, дарангуйлагч эсвэл захиран тушаах эрхийг гартаа авсан улс төрийн аль нэг зүтгэлтэн ямагт байж, харин нийгэм түүнтэй “нэгдэн”, түүний үзэл санаа, улс төрийн дүр төрх, үйл ажиллагааны хандлагыг тээгч болсоор ирсэн. Чингэхдээ, дундах үе зангилаа (засаглалын ардчилсан байгуулал, олон нийтийн болон үйлдвэрчний эвлэлийн байгууллага зэрэг) алдагддаг байснаас гаргаж буй улс төрийн болон бусад шийдвэрийн үр дагавраас үүдэлтэй эрсдэл, тодорхой бус (таамаглашгүй) байдал нэмэгдэж байв.

Эл байдал нь субъектээ хүчин зүйлийн бүлэгт хамаарна. Орчин үеийн Монголын улс төрийн нөхцөл байдлыг авч үзэхдээ бид улс төр дэх зорилго

тодорхойлох асуудлыг судлах ёстой. Аливаа улс төрийн технологийн эхлэх цэг бол хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагааны үндсэн зорилт, чиглэл, эцсийн үр дүнг томъёолох явдал мөн. Улс төрийн онолын чухал элемент зорилго тодорхойлох ажиллагаа нь өмнөө тавьж буй эдгээр зорилгоор дамжуулан улс төрийн субъектүүдийн үйл ажиллагааг тайлбарлах, зорилгоо хэрэгжүүлэх нөхцөл, хэрэгслийн талаарх мэдлэгийг нь харуулахад тус дөхөм үзүүлнэ.

Үйл ажиллагааны дараах категори бий:

а) улс төрийн хөтөлбөр, үзэл суртлын чиглэл тогтоох замаар улс төрийн зорилгоо боловсруулах;

б) тодорхойлсон зорилго, нийгэм-улс төрийн нөхцөл байдлыг харгалзан субъектүүд улс төрийн шийдвэр гаргах;

в) улс төрийн тодорхой үйл ажиллагаа явуулах замаар улс төрийн зорилгоо хэрэгжүүлэх.

Гегелийн шашны сургаалын үзэл бодлоор, “хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь зүйд нийцэх эцсийн зорилгоос давуутай”. Гегелийн үзэж байгаагаар, хэрэгжилт нарийн төвөгтэй байх асуудал нь зорилго өөрөө субъектив ба үйлдлийн шинж чанартай байдагтай холбоотой гэхээсээ илүү түүнийг бодит байдлаар хэрэгжүүлэх ёстой буюу түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, бодит үйл ажиллагаатай хамаарна. Зөвхөн энэ л зорилгод тодорхой агуулга өгч, бодит үр дүн болгон хувиргадаг. Хэн нэгний тавьсан зорилго тухайн нийгмийн нийгэм-эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдалд нийцээгүй бол түүнийг хэрэгжүүлэх боломжгүй, гэхдээ энэ нь тухайн нийгмийг нэг талыг баримталсан, дутуу дулимаг, хэвийн бус болгож, ийм нийгэм мөхөж эхэлдэг ажээ.

Тавьсан зорилго, зорилтуудыг тодорхойлон хэрэгжүүлэх үйл явцад хэрэгжилтийн арга хэрэгслийн хувьд тодорхой нөлөө бүхий үндсэн намууд (и их политическая элита) өөр хоорондоо бараг ялгаагүй. Тавьсан зорилго хэтэрхий ерөнхий, орчин үеийн Монголын хүрээнд үндэсний үзэл санааг тодорхойлоогүй (мусульман шашинтай үндэсний цөөнхийн онцлогийг тооцоогүй), хэрэгжүүлэн гүйцэтгэх тодорхой механизмыг боловсруулаагүй. Бодит байдал дээр, түүхэн хөгжлийн явцад нийгмийн ухамсарт хуримтлагдсан оюун санааны төсөөлөл нь хүн төрөлхтний шинэ үзэл санаа (ардчилал, үг хэлэх эрх чөлөө зэрэг), нийгмийн

асуудлууд (татвар, газрын түрээс гэх мэт), улс төрийн бодит байдал (либерал, ардчилагчид, иргэний нийгэм, улс төрийн ухамсарт байдал зэрэг)-тай зөрчилдөж болзошгүй юм.

Төрийн болон улс төрийн шинэчлэлтийн үр дүнд зах зээлийн харилцаа бүрэлдэн хөгжихөд дараах нийгмийн үр дагавар гарна:

- ашиг орлого нэмэгдэх уламжлалт бус эх үүсвэр;
- ард иргэд нийгэмд шинэ статустай болно
- эдийн засгийн бүтцийн шинэчлэлт;
- бусад улс орон, ард түмэнтэй аж ахуйн болон соёлын харилцаа холбоо өргөжсөнөөр иргэний нийгэмд зөрчил үүсэх магадлалтай;
- улс төрийн үр дагавар нэмэгдэнэ
- нийгмийн зөрчилдөөн.

Орчин үеийн Монголын улс төрийн тавцан дахь зөрчил маргаан нь нийгмийн амьдралын улс төржилтийг улам нэмэгдүүлж, бүлгүүдийн хоорондох харилцаанд тэнцвэргүй байдалд хүргэж байна. Улс төрийн янз бүрийн урсгалуудын зөрчилдөөн ноцтой хямрал дагуулж, нийгмийн үнэт зүйлсийн хагаралд түлхэц өгч, нийгмийн өргөн олон давхаргын эсэргүүцлийг өдөөж байна [6]. Монгол түмний олон зуун жилийн түүх, оюун санааны үнэт зүйлс болон төсөөллөөс үүдэлтэй “оюун санаа бол цаг хугацаа, үе үеийн залгамж халааны холбоос мөн” гэсэн ард олны нийтлэг ухамсрын онцлогт энэхүү хямралын шалтгаан оршиж байгаа болно [8]. Нийтийн ухамсар бол нийгмийн ухамсрын нэг төрөл, практик оршин тогтнолын бодит хэлбэр, улс төрийн бүтцэд хамрагдаагүй олон тооны хүмүүст (олон нийт) байдаг онцгой, өвөрмөц төрөл. Түүхэн бодит байдлын ямар нэг цаг үед (сэтгэл зовнил төрүүлсэн нийгмийн асуудлуудыг сэтгэл зүрхээрээ хурцаар мэдрэх) нийгмийн янз бүрийн бүлгүүдийн ухамсрын үндсэн (эсвэл илүү ач холбогдолтой) бүрэлдэхүүн хэсгүүдийн давхцал, гэхдээ энгийн нийлбэр биш.

Бүтцийн хувьд нийтийн ухамсар нь сэтгэл хөдлөлийн ба оновчтой гэсэн хоёр түвшинтэй. Нийтийн ухамсрын илэртэл нь үндсэндээ зохион байгуулалтгүй,

тодорхой нөхцөл байдал, цаг хугацаатай холбоотой байдаг. Нийтийн ухамсар нь сэтгэл хөдлөлд өртөмтгий, олон янз, өөрчлөгдөх хөдөлгөөнтэй байдаг ч, ямагт тодорхой байна. Олон нийтийн санаа бодол, нийтийн сэтгэл санааны байдал нь хөгжлийн тодорхой цаг үед нийтийн ухамсрын макро хэлбэр болж байдаг.

Олон нийтийн санаа бодол нь болж буй үйл явдлын талаарх ил ба далд хандлагыг агуулдаг. Түргэн өөрчлөгдөж буй нөхцөл байдалд (байгаль, эдийн засаг, улс төрийн гэх мэт) түргэн шуурхай зохицох шаардлага “олон нийтэд” тулгардагтай холбоотойгоор нийтийн ухамсар үндсэндээ түргэн өөрчлөгддөг хэсгүүдээс бүрддэг. Үүний харьцангуй бага боловч амин чухал хэсгийг “хүмүүсийн зүгээс өөрийгөө хүрээлж буй байгалийн болон нийгмийн орчныг ухамсарлах арга хэлбэр болох сэтгэлгээ” эзэлдэг бөгөөд энэ нь “нийтийн болон нийгмийн ухамсрын суурь” болдог [8].

Сэтгэлгээ гэсэн ухагдахуунд үеэс үед дамжин ирж байдаг уламжлал, соёл зэрэг хувь хүнээс дээгүүр онц чухал бүрэлдэхүүн хэсэг багтдаг. Ухамсарт суусан дүрс ба төсөөлөл нь дотоод, гадаад нөлөөллийн дор нийгмийн үзэл суртал, нийгмийн байгуулал өөрчлөгдсөн ч (хувьсгал, төрийн эргэлт, сонгууль гэх мэт) өөрийн өвөрмөц байдлыг хадгалж үлдэх боломжийг олгодог. “Сэтгэлгээ бол философийн, шинжлэх ухааны эсвэл гоо зүйн систем бус, харин нийгмийн ухамсрын тодорхой түвшин бөгөөд уг түвшинд бодол санаа нь сэтгэл хөдлөл, ухамсрын далд дадал зуршлаас салангид байдаггүй” [5].

Мэтгэлцээний ухагдахуунд “улс төрийн” сэтгэлгээ гэх хийсвэр тодорхойлолт байдаг. Эл ухагдахууныг янз бүрээр тайлбарладаг ч ихэнх судлаачид дараах ерөнхий шинж чанарыг тэмдэглэдэг: “хүмүүсийн нэгдэл болон тодорхой хувь хүний зүгээс эрх баригч бүтцэд хандах хандлага, үнэлгээнээс үүдэлтэй амьдралын цогц үзэл баримтлал, сэтгэхүйн дадал заншил, ёс суртахууны чиг баримжаа, итгэл үнэмшил, зан үйлийн хэлбэр; улс төрийн субъектүүдийн улс төрийн үйл ажиллагаанд шууд илрэлээ олж буй сэтгэл хөдлөл, сэтгэл санааны байдал; нийгмийн аль нэг нэгдлийн өдөр тутмын ухамсарт болон ухамсарт бус төсөөлөл, үнэт зүйлс» [9].

Сэтгэлгээ бол хүн ба нийгмийн хувийн болон хамтын ертөнцийг үзэх үзэл, тусгалын гүн гүнзгий үндэс суурь мөн. Тодорхой үндэстний туршлагыг өөртөө шингээсэн сэтгэлгээ нь “өнгөрсний тухай санамжийг” ухамсарт бий болгон үнэт

зүйлсийн тогтолцоо бус, харин үнэ цэнтэй зэрэгцүүллийг боловсруулах тогтолцоо болдог бөгөөд тодорхой хүмүүс (удирдагч, тэргүүлэгчид зэрэг) болон бүхэлдээ нийгмийн сэтгэхүй, зан үйлийн арга хэлбэрийг тодорхойлдог. Түүхэн урт хугацааны явцад нийгмийн боловсрол нь улс төр, эдийн засаг, нийгмийн зан үйлийн тодорхой загвар, үнэлгээ, тусгалыг бий болгож, “аливаа, үүний дотор сүйрлийн нөхцөл байдалд өөрийн түүхэн “дүрэм журамд” үнэнч сая сая хүний зан үйлийн тодорхойлогч хүчин зүйл” болдог. [9].

Сэтгэлгээ нь давхар мөн чанартай: нэг талаас, идэвхтэй байр суурь нь ард түмнийг цаашдын түүхэн хөгжилд түлхэц өгдөг, нөгөө талаас, идэхгүй, чанар нь хуримтлагдсан түүхэн туршлагад харш бүхнийг (шинэлэг зүйлийн хувьд эсвэл үнэлгээ байхгүйгээс) цааш түлхэгч саад тотгор болдог. Нийтийн болон нийгмийн ухамсар дахь сэтгэлгээний гол зорилт бол өөрчлөлтийн механизмд бус, харин үндэстний аюулгүй, тогтвортой байдлыг хангахад оршино. Шийдвэр (хөтөлбөр, ямар нэг шинэчлэл зэрэг) гарган хэрэгжүүлэхээс өмнө эл төслийг боловсруулахад чухал үүрэг ногддог.

Улс төр, эдийн засаг, нийгмийн хувьд асар түргэн өөрчлөгдөж буй өнөөгийн Монголын нөхцөлд боловсруулан нэвтрүүлэх үе шат туйлын бага бөгөөд энэ нь эдгээр төслийн чанарт тавих шаардлагыг өндөржүүлж байна. Үүнтэй холбоотойгоор, боловсруулах ба нэвтрүүлэх үе шат бараг нэгэн зэрэг явагддаг. Шинэчлэлийг боловсруулагчид тодорхой бусын бүсэд байгаа бөгөөд эхний тодорхой бус байдал нь өөр нэг тодорхой бус байдлыг төрүүлж, энэ нь ахин дахин давтагдана. Энэ тохиолдолд, эрсдэлтэй нөхцөл байдлыг (эрсдэлийн түвшин) зөвхөн “боломжит”, “зөвшөөрч болох” түвшинд тогтоон барих хэрэгтэй. Тодорхой бус байдал гэдэг нь энд төрөл бүрийн хүчин зүйл байгаа бөгөөд “үйл ажиллагааны үр дүн тодорхойгүй ба үр дүнд эдгээр хүчин зүйл хэрхэн нөлөөлөх нь мэдэгдэхгүй” байна гэсэн үг [13].

Эдгээр хүчин зүйлийн жишээ бол:

а) мэдээллийн бүрэн бус, яв цав биш,

б) эрсдэл ба түүний үр дүнгийн тухай мэдээлэлтэй байх,

в) мэдээллийг санаатайгаар (нийгмийн тодорхой бүлгийн ашиг сонирхлын үүднээс санаатайгаар) нуун дарагдуулах эсвэл эсрэгээрээ илт ташаа (хуурамч) мэдээлэл тараах гэх мэт.

Шинэчлэлийн онолын үндэслэлийг боловсруулан урагшлуулах явцад Да.Ганболд зэрэг “нусгай шинэчлэгчид” (онолчдын суурь бүтээлүүдийг судлаагүй) хүн төрөлхтний амьдралын нэн чухал мөн чанар болох соёл, түүнээс хүний (бүлэг, нийгэм гэх мэт) харилцаа ба зан үйл, шинэчлэлийг зөвшөөрөх эсвэл үгүйсгэхэд үзүүлэх нөлөөг орхигдуулсан бололтой. Онолын үндэслэл ба практик хэрэглээний хоорондох зай асар том байсан бөгөөд шинэчлэл нь ашиг тус гэхээсээ илүү улс төр, эдийн засаг гэх мэт бүх салбарт хор хохирол авчирсан байна.

Бүр өнгөрсөн зууны эхэнд антропологч Б. Малиновский “...хэлбэрийг ямагт үйлдэл тодорхойлж байдаг бөгөөд эл хамаарлыг тогтоогоогүй байсан цагт бид шинжлэх ухааны эргэцүүлэлдээ хэлбэрийн элементүүдийг ашиглах боломжгүй” [2]. Функционализмын тухай өөрийн ажилдаа тэр бээр соёлын гоц үзэгдэл, улс төрийн тогтолцоо болон эдийн засгийн үйлдвэрлэлийн талаарх үзэл санааны соёлын бодит байдлын тухай тодорхой ойлголтыг үйл ажиллагаандаа иш үндэс болгож байхыг санал болгосон байна. Зөвхөн шалтгаан-үр дагаврын харилцан үйлчлэл, харилцан нөлөөллийн механизмыг тодорхойлсны дараа л аливаа шинэчлэлийн онолын үндэслэл, төслийн шийдлийг боловсруулах ёстой.

Өөрийн судалгаандаа Б.Малиновский хүний зохион байгуулалттай зан үйлийн илрэлийн таван аксиомыг тодорхойлсон байна:

- соёл бол үнэн хэрэгтээ нэг ёсны зэмсэг бөгөөд түүний ачаар хүн төрөлхтөн өөрийн хэрэгцээг хангах явцаа байгаль орчинд учирч буй тодорхой асуудлуудыг илүү сайн шийдвэрлэх боломжтой байдаг;

- энэ бол тавьсан зорилгодоо хүрэхэд ашиглах объектуудын тогтолцоо, үйл ажиллагаа болон чиг баримжааны төрөл;

- энэ бол бүх элемент нь харилцан холбоотой байдаг нэг бат цул мөн;

- амин чухал зорилтуудыг тойрон зохион байгуулагддаг үйл ажиллагаа, чиг баримжаа, объектууд нь гэр бүл, эвсэл, орон нутгийн нийгэмлэг, омгийг үүсгэдэг

ба эдийн засгийн нэгдэл, улс төр, эрх зүй, боловсролын үйл ажиллагаагаар нэгтгэгдсэн зохион байгуулалттай бүлгүүдийн эхлэлийг тавьдаг;

- өрнөл буюу үйл ажиллагааны төрлөөс нь хамаарч соёлыг дараах асуудлуудад хувааж болно: боловсрол, нийгмийн хяналт, эдийн засаг, мэдлэг, итгэл үнэмшил, ёс суртахууны тогтолцоо болон өөрийгөө илэрхийлэх бүтээлч, уран сайхны төрөл бүрийн арга хэлбэр [12].

Сэтгэлгээний тодорхойлолтыг (үндэстний улс төр, түүхэн өв уламжлалын хувьд) өгч, функционализм талаас нь соёлыг авч үзэх онолын үндэслэлийг гаргасныхаа дараа бид улс орны өнгөрсөн түүх рүү өнгийн товчхон судалгаа хийж үзье.

Хүмүүс болон бүлгүүдийн соёлын (язгуур) ба нийгмийн шинж чанарыг адилтгах дээр тулгуурласан мэтгэлцээн нь нийгмийн мэтгэлцээн, засаглалын үзэл суртлын хөтөлбөрүүд болон хүн амын янз бүрийн категорийн өдөр тутмын сэтгэлгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Судалгааны төвд орчин үеийн онолын болон практик асуудлууд байгаа хэдий ч түүний мөн чанарыг ойлгохын тулд уламжлал тогтох өмнөх үе шат, социалист үеийн “үндэсний асуудлууд”-ын талаарх онол, нийгмийн хөгжлийн язгуур загвар бүрэлдэх орчин болсон социализмын үеийн нийгмийн амьдралын онцлог, хамгийн гол шинж чанарын дүн шинжилгээ, академик болон нийтийн ухамсарт тархсан байдал ба хэрэгжүүлж буй төрийн бодлогын хүрээн дэх практик хөтөлбөрүүдэд үзүүлж буй тэдгээрийн нөлөөллийг тогтоох шаардлагатай.

“Социализмын үед ард олны “сэргэн мандалтын” зорилт дээр намын бодлогын дагуу удирдлага болгож байсан категорид түүнийг “шингээх” хэрэгцээ нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, нэгдмэл социалист төр улсын ивээл дор нэгдмэл нэг үндэстнийг бүрэлдүүлэх [10]. Нийгмийн шинэчлэлийн цаашдын явцад “үндэстэн” хэмээх ухагдахуун иргэн-газар нутгийн бус, харин намын төсөөллөөр тодорхойлогдох болсон. Ухагдахууны энэхүү хоёрдмол тайлбар нь өнгөрсөн түүхийн “алдарт” цаг үе, үндэсний болон төрийн түвшинд алдар гавьяа байгуулсан өмнөх үеийнхнийг тодруулах сонирхол бий болсон. Үүнээс үүдэн, шинжлэх ухаан болон нийгмийн амьдралд давамгайлж байсан “үндэстэн” хэмээх ухагдахууныг бүрдүүлэгч хэсгүүд дээр бас нэг элемент нэмэгдсэн нь “намын



захиргаадалтаас бүрэн ангижрах бүдэг боловч улам бүр мэдрэгдэхүйц эрмэлзэл” байв [13].

Энэ эрмэлзэл нь “тааламжгүй” өнөө үеэс “өнгөрсөн үе рүү очих” хандлагаар илэрч байсан бөгөөд “антропологийн дүр төрх, ахуй байдлын “уламжлалт” (өдгөө алга болсон) онцлог зэргээрээ гарцаагүй ялгаатай хүмүүс нь нийгмийн хэрэгцээ болон улс төрийн сонирхлоороо маш гүн гүнзгий зөрчилдөөнтэй байсан бөгөөд “өөрийн” гэсэн үндэсний төр улс тэдэнд хэрэгцээтэй байсан” гэсэн төсөөлөл төрүүлэх оролдлого явагдаж байсан. Эл эрэгцүүлэл онолын судалгаануудтай шууд зөрчилдөж байгаа юм. Бусад (магадгүй түүхэн болон соёлын илүү туршлагатай) үндэстний бүрэлдэхүүнд байгаа аль нэг үндэстний антропологийн эсвэл соёлын онцлог нь үндэсний төр улс байгуулах зайлшгүй хэрэгцээг нөхцөлдүүлдэггүй. Гэсэн хэдий ч улс орны нутаг дэвсгэр дээр “соёлын” үеллийн үйл явц зогсолтгүй үргэлжилсээр байгаагийн тод жишээ бол хил орчмын нутаг дэвсгэрүүдэд тасрахгүй гарсаар байгаа мөргөлдөөн, нутаг дэвсгэрийн маргаан юм.

Янз бүрийн “үндэсний нийгэмлэгүүд” буюу үнэн хэрэгтээ өөрсдийнх нь соёлын шинж төрх тэд бүгдийн нийгмийн хэрэгцээ мөн гэдэг ухамсраар нэгдсэн бүлэг хүмүүс бий болж, бүр чухал нь уг нийгэмлэгт өөрийн гэсэн үзэл суртал буюу тодорхой зорилгоор бүрэлдүүлж буй нийтийн төсөөлөл бий болж байгааг бид харж байна. Үйл явдал цаашид хэрхэн өрнөх нь тодорхой: тодорхой бус байдал (ийм эрсдэл, улс төрийн эсвэл эдийн засгийн гэх мэт), явуулж буй шинэчлэлийн үр дүн тогтворгүй, таамаглашгүй байдал өсөн нэмэгдэнэ.

Тодорхой бус байдал цаашид өсөх бөгөөд шинэчлэлийг хийхэд дараах нөхцөлийг хангалтгүй харгалзсаныг улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн судалгааны үр дүн харуулж байна:

- нийгмийн ухамсрыг шилжүүлэх талаар эрх баригчдын хэрэгжүүлсэн шинэчлэл, стратеги нь ард түмний “түүхэн” сэтгэлгээг сайтар тооцоогүй, үл зохицолдож байгаа.

- тухайн үе шатанд харш бөгөөд нийтийн ухамсрын сэтгэлгээний онцлогийн эсэргүүцэлтэй тулгарсан барууны улс төр, эдийн засгийн байгуулал, шилжилтийн загварыг ашигласан;

- өөрчлөлт шинэчлэлтийн талаарх өөрийн түүхэн сэтгэлгээний төсөөллийг агуулсан, орчин үеийн Монголын онцлог бүхий соёл, үзэл суртал, улс төрийн суурь, эдийн засаг, шашны шүтлэгийн хэлбэрийг тооцоогүй;

- нутаг дэвсгэр дамнасан хил хязгаар (түүх, улс төр, үндсэрхэг өнгө аястай хил орчмын газар нутгийн маргаан, хүрээлэл).

Эцэст нь, улс төр, эдийн засгийн элитүүд өөрчлөлт шинэчлэлт хийхдээ орчны болон субъектив хүчин зүйлүүдийг хангалттай тооцоогүй, үзэл суртал ба нийгмийн өөрчлөлт шинэчлэл нь нийгмийн сэтгэлгээний идэвхгүй байдалтай (хүмүүс хүлээн авч, зохицож чадаагүй) тулгарсан, орчин үеийн Монголын эрсдэлийн тодорхойлогч хүчин зүйлд цогц бусаар хандсан болохыг бид харж байна. Өөрчлөлт шинэчлэлтийн замаар цаашид ахихдаа түүхэн болон орчин үеийн материалыг нягт нямбай авч үзэн тооцох, нийтийн ухамсрын өрнөлт ба идэвхгүй байдлыг харьцуулах ёстой. Өнгөрснийг тооцохгүйгээр улс оронд ирээдүй байхгүй.

### 2.3.2. Стратегийн эрсдэлийн мөн чанар

Шинэ зуун гарсаар дэлхий даяар тийм ч амар амгалан байсангүй. Жил болгон зэвсэгт мөргөлдөөн, дайн, бослого, аллага хядлага хаа нэгэн газарт гарч, ямар нэгэн төрлийн хямрал, хомсдол, өлсгөлөн болж, шинэ төрлийн өвчин тархаж, хүн төрөлхтөнд тохиолдох аюулын тоо, хэмжээ өссөөр байна. Энэ бүх аюулын тоон өсөлт чанарын өөрчлөлтөд шилжиж байна. Чанарын эдгээр өөрчлөлт юунд хүргэх, энэ нь монголчуудын өмнө ямар асуудал босгож байгаа, хямрал, эрсдэлийг хэрхэн давах зэрэг асуудалд бид бага анхаарч иржээ. Энэ байдал монголчууд бидний амар тайван амьдрах хүсэл, хөгжил дэвшлийн төлөөх тэмүүлэлтэй зөрчилдөж байна. Хүн амжилтад хүрэхийн тулд эрсдэлийг давах, улс нийгэм, ард түмэн ч бага эрсдэлтэй зорилтыг сонгох замаар амжилтад хүрэх арга замыг хайх шаардлагатай тулгараад байна. Улс орны хөгжилд инноваци (төгөлдөршил) тэргүүлэх ач холбогдолтой болж байгаа нь бас эрсдэлийн хэмжээг нэмэгдүүлж байна. Энэ бүхэн нь биднээс өнөө болон алс хэтэд эрсдэлд өртөгдөхгүй, бас амжилтад хүргэх арга замыг сонгохдоо “алтан дундаж”-ийг сонгох арга ухаанд суралцахыг шаардаж байна. Энэ арга ухаан нь – “Эрсдэлийн онол” юм. Эрсдэлийн онолд эрсдэлийн талаар олон янзын тодорхойлолт байдаг.

ОХУ-ын судлаач П.Г.Грабовый “үйлдвэр, үйлчилгээний байгууллагын нөөцөд учрах хохирол, нэмэгдэл ашиг олох боломжийн алдагдал эсвэл үйлдвэр, санхүүгийн үйл ажиллагаа явуулахад үр өгөөж гаргахын тулд нэмэгдэл зардал шинээр үүсэх магадлалыг эрсдэл хэмээн ойлгож” байна.

Л. Растринг и Б. Райзберг нар болохоор ажил, үйлчилгээний эрсдэлийн сонгодог онолд эрсдэлийг “болзошгүй алдагдал, хохирол” гэж үзсэн байна.

Харин Л.Н.Тепман ажил, үйлчилгээний хүрээний эрсдэлийн тухай тодорхойлолтыг “эрсдэл бол төлөвлөгөөт үр дүн, өгөөжийн хазайлтын магадлал” гэж арай илүү нийцтэй, тохиромжтой хэлбэрээр өгсөн байна. Тэгвэл, А.В.Воронцовский «Управление рисками» гэсэн номдоо “эрсдэл бол үр дүнгийн хэлбэлзэл юм” гэсэн байна.

Харин ОХУ-ын “Аюулгүй байдлын тухай” хуульд “улс, нийгэм, хувь хүний амьдралын язгуур эрх ашигт аюул бий болгогч нөхцөл, хүчин зүйлсийн нэгдлийг аюулын занал гэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтууд нь эрсдэлийн агуулгыг бүрэн илэрхийлж чадахгүй байна гэж нэлээд судлаачид үзэж байна. Тухайлбал, В. Д. Рудашевский “эрсдэл бол хэд хэдэн сонголт, тохиолдолд аль нэгийг сонгоход алдах, онох, амжилт гаргах, сүйрэх тохиолдлын магадлал юм” гэсэн байна.


Энэ бүхнээс бид эрсдэлийн онолууд дахь тодорхойлолтуудын нийтлэгээс “эрсдэлийн тухай асуудал нь хүсэн хүлээгүй, таагүй үзэгдэл, үйл явц тохиолдож болзошгүй байдал, магадлалын тухай, байгаль, нийгмийн хууль, зүй тогтолт үзэгдэл, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх цэгцтэй мэдлэгийн тогтолцоо юм” гэсэн дүгнэлтийг хийж байна.

Үүнээс харахад, эрсдэлийн нөхцөлийн тухай ойлголт нь хүний үйл ажиллагааны үр дүн, төгсгөл, түүнд нөлөөлөгч бодит хүчин зүйлсийн учир шалтгааны нэгдэл юм. Тиймээс өнөөдөр эрсдэлийн тодорхойлолтыг бүлэглэн авч үзэх боломж байна. Нэгдүгээрт, тодорхойгүй нөхцөл байдалд үйл ажиллагааны сонголт хийх, эсвэл үр дүн, төгсгөл санамсаргүй байдлаар

тодорхойлогдох эрсдэл; Хоёрдугаарт, аюул, занал байгаа нөхцөлд амжил олох, гаргах тодорхой бус үйл ажиллагааны эрсдэл; Гуравдугаарт, ямар нэгэн зайлшгүй үйл явц, үзэгдлийн сөрөг нөлөө, тааламжгүй байдал дахь эрсдэл (ямар нэгэн шийдвэрээр эсвэл хүрээлэн буй орчны нөлөө дор хэрэгжүүлэхэд алдаж онох, хохирол учрах, ашиг олох магадлал). Эрсдэлийн ерөнхий төлөв, ойлголт тодорхойлолт олон янз ч эрсдэлийн тухай ойлголтод нэн чухал хэдэн шинж байна. Бүх тохиолдолд, тодорхойгүй нөхцөл дэх ажиллагаа ба шийдвэр гаргах үйл явцын тухай юм. Эрсдэлийн байдалд дараах гурван нөхцөл ёс мэт дагалдаж байна. Үүнд:

- Тодорхойгүй байдал;
- Зайлшгүй сонголт хийх байдал;
- Сонголт хийхэд магадлалыг үнэлэх боломж.

Судалгааны явцаас эрсдэлийн талаарх онол нь сонгодог онол, шинэ онол гэсэн хоёр янзаар хөгжиж байна.



Зураг 2.2. Эрсдэлийн сонгодог болон шинэ онол

Стратегийн эрсдэл нь хямралт үзэгдэл, үйл явц, сүйрэлд хүргэх нөхцөл байдал үүсэх, тэдгээрээс үзүүлэх хорт үр дагавар, хохирол нь улс, нийгэм, хувь хүний хамгаалалтын төвшнийг эрс бууруулах магадлал юм.

Стратегийн эрсдэлийн категорин зарчмын онцлог шинж нь:

1). Аюулын эх сурвалж, хүчин зүйлсийн заналын болзошгүй шинж, түүний нөлөө, үйлчлэлээс улс, нийгэм болон байгаль орчин нь хамгаалагдсан байдлын хангалттай биш байдал;

2). Заналын тоон үзүүлэлтийн тайлбарлал, хэмжигдэх байдал;

3). Үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжилд дунд (ойрын таван жилд) болон алс хэтэд (10 жил болон түүнээс цааших хугацаанд) занал учруулахуйц эрсдэлийн илрүүлэх.

Өнөө үед “эрсдэлийн онол, арга зүй”-д суралцаж, байгаль, техник, нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд уг асуудлыг үнэлж дүгнэх, эрсдэлийг удирдах оролдлогыг хийх боллоо.Тиймийн учир стратегийн эрсдэлийн үнэлгээ, таамаглалын арга зүйн судалгаа чухал болоод байна.

Байгаль, техникийн эрсдэлийн үнэлгээ хийх асуудлаар манайд хэд хэдэн бүтээл гарч, Онцгой Байдлын Ерөнхий Газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн зарим тодорхой газар, орон нутаг (Улаанбаатар хот)-т тохиолдож болох эрсдэлийн үнэлгээг хийж үзсэн байна.

Харин улс төр, нийгэм, эдийн засаг, хүн ам, экологи, мэдээлэл, цэргийн эрсдэлээр буюу стратегийн эрсдэлээр дорвитой судалгаа шинжилгээний ажил явуулаагүй, тоймтой бүтээл туурвигдаагүй байна.

Өмнөх нэг ба хоёрдугаар бүлэгт тэмдэглэснээс харахад, улс орны тогтвортой хөгжлийн төлөв байдал нь дараах хоёр хүчин зүйлтэй холбоотой байна: Нэгдүгээрт, гадаад буюу дэлхийн олон улсын улс төр, эдийн засгийн хүрээн дэх сөрөг нөлөө; Хоёрдугаарт, дотоодын буюу улс орны хөгжлийн үндсэн асуудлаарх (улс төр, цэрэг-улс төр, нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан технологи, экологи) стратегийн буруу шийдвэрийн үр дагавар, тийм байдалд хүргэх нөхцөл.


Стратегийн эрсдэлийг заналын орших цар хэмжээ; түүний эх үүсвэрийн орон зай; эрсдэл үүсэх эх сурвалжийн хүрээ; эрсдэл орших салбараар нь 1.1 дүгээр зурагт үзүүлсэн байдлаар ангилж байгаа нь нийцтэй юм.

#### 2.3.4. Эрсдэлийн шинжилгээний хандлага

Эрсдэлийн шинжилгээ нь эрсдэлийн удирдлагын онол, практикийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Байгаль, техноген, нийгэм-эдийн засаг, нийгэм-улс төрийн тогтворгүй байдалтай холбогдуулан янз бүрийн объектын эрсдэлд шинжилгээ хийх нь байгууллага, объектын үйл ажиллагаа тогтвортой байх нөхцөл, хөгжлийн явцад сөрөг нөлөөл үзүүлэх боломж, ажиллагаанаас хүлээгдэж буй бодит үр дүн, гаргасан шийдвэрийн үр өгөөжийг бууруулах явдалтай зайлшгүй холбоотойд оршдог.

Ийм шинжилгээний ач холбогдол, чухал хэрэгцээт чанарыг өндөр хөгжилтэй улсуудын хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчны стандарт, хэв хэмжээг тогтоох хууль эрх зүйг бүрдүүлэх, түүгээр тогтохгүй сөрөг нөлөө үзүүлж болзошгүй төвшин, зөвшөөрөгдөх хэмжээ, түүнтэй холбоотой үүсэх эрсдэлийг тогтооход ашиглаж байгаа практик харуулж байгаа юм. Өнөө үед, нийгмийн амьдралын хүрээ, шинжилгээ хийх объект, тэдгээр дэх эрсдэлийн илрэл зэргээс хамаарч эрсдэлийн шинжилгээний хэд хэдэн хандлага, аргууд (3.3 дугаар зураг) байна. Үүнд:

- Шинжилгээний объектод хамаарах технократ хандлага;
- Судалж буй объектын эдийн засгийн харилцааны тогтолцоог авч үзэх эдийн засгийн хандлага;
- Судалж буй объектод холбогдох эрсдэлд нийгмээс хандах харилцааг авч үзэх нийгмийн хандлага;
- Судалж буй объектод холбогдох эрсдэлд хувь хүнээс хандах харилцааг авч үзэх сэтгэл зүйн хандлага.



### Зураг 2.3. Эрсдэлийн шинжилгээний хандлага, арга.

Эрсдэлийн шинжилгээний үзэл баримтлал (хандлага)-аас технократ үзэл баримтлал нь хүсэн хүлээгээгүй үр дагавар бүхий аюулт үзэгдлийн харьцангуй давтамжийг шинжилсний үндсэн дээр түүний магадлалыг хөтөлбөржүүлэх арга юм. Түүнийг ашиглах үед статистик өгөгдөхүүнүүдийг хэмжээ, цаг хугацаа, хүн амын бүлэглэл зэргээр дундчилдаг. Тухайлбал, технологийн хүрээний объект дахь ослын эрсдэлийг үнэлэх үед анхдагч үйл явц (ослын нөхцөл), ослын өрнөл явц (динамик)-ыг магадлал хэрэгжихтэй болон ослын төгсгөлд үүсэх янз бүрийн үр дагавартай холбон үзнэ.

Эрсдэлийн шинжилгээний эдийн засгийн үзэл баримтлал (хандлага) нь зардал – үр ашгийн ерөнхий шинжилгээний нэг хэсэг нь юм. Энэ тохиолдолд, эрсдэл нь зарим үйл ажиллагаа, үйлдлийн үрээр үүссэн хүлээгдэж буй үр ашгийн алдагдал, бууруулсан хохирол юм. Эцсийн зорилго нь нийгмийн тогтолцоо дахь нөөцийн хуваарилалтын үр ашигтай байдлыг дээд зэргээр нэмэгдүүлэхэд оршдог.

Сэтгэл зүйн үзэл баримтлал (хандлага) нь хувь хүний эрсдэлийн магадлал, түүний харьцангуй чанарыг тайлбарлан таних, магадлалын дундаж утгыг ашиглан өөрийн хүлээх эрсдэлд ухаалаг буюу шинжлэх ухаанч байдлаар хандах, эрсдэлээс зайлсхийх, өртөгдсөн ч хохирол бага амсахад чиглэдэг. Энэ үзэл баримтлал (хандлага) нь ялангуяа шийдвэр гаргагч албан тушаалтан, байгууллага, объект хариуцагч нарт илүү хамааралтай байна.

Нийгэм, соёлын үзэл баримтлал (хандлага) нь нийгэм, хамтлагийн үнэт зүйлс, язгуур эрх ашгийг нийгмийн хөгжлийн явцад хүлээгээгүй, хүсээгүй үр дагавар амсахаас хамгаалахад чиглэдэг. Ялангуяа PR технологийг ашиглан мэдээллийн өрсөлдөөн дунд хувь хүн, хамт олон, нийгмийн бүлэглэл, хэсэг, давхаргад учруулж болзошгүй сөрөг үр дагаврын магадлалыг тогтоох, тодорхойлоход оршдог.

## Гуравдугаар бүлэг.

### УЧИРЧ БОЛЗОШГҮЙ СТРАТЕГИЙН ЭРСДЭЛИЙН ТААМАГЛАЛ

Энэ бүлэгт улс төр, эдийн засаг, нийгэм, түүний дотор шинжлэх ухаан, технологи зэрэг улс орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндсэн салбаруудад учирч болзошгүй эрсдэлд үнэлгээ, таамаглал хийсэн судалгааны дүнг нэгтгэн боловсруулав.

Ингэхдээ энэ бүлэгт тусгагдсан дүгнэлтүүд нь анх удаа хийгдэж байгаа учир ерөнхий шинж чанартай, цаашид шинжлэх ухааны ул суурьтай, суурь болон хавсарга судалгаанууд, эрэл хайгуул хийх үндэс суурь болох урьдчилсан шинж чанартай болохыг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ. Түүнчлэн эдгээр дүгнэлт нь манай улсын эрдэм шинжилгээний байгууллагууд, түүний дотор Монголын Геополитикийн хүрээлэнгээс 2010-2019 онд явуулсан аюулгүй байдлын ерөнхий судалгаануудын үр дүнд тулгуурласан учир субъектив шинж чанартай бөгөөд эдгээрийг үргэлжлүүлж, нарийсган баяжуулах, мөн эрсдэл судлалын төрөлжүүлсэн судалгаануудын үр дүнгээр гүнзгийрүүлэх нь чухал болно. Ер нь улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн талаар бодитой дүгнэлт таамаглал хийхийн тулд тэдгээрийн төрлүүдээр тусгайлсан сэдэвчилсэн судалгаануудыг хийх, энэ бүгдийн мөн чанар, өрнөлтийн байдлын талаар дор хаяж 10-15 жилийн дүр зургийг гаргах шаардлагатай юм. Энэхүү төслийн гүйцэтгэгчид нь өөрсдийн боловсруулсан арга зүйдээ тулгуурлан цаашид энэ чиглэлээр ажиллахаар төлөвлөж байгаа болно .

Улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ, урьдчилсан таамаглалыг цаашид гүнзгийрүүлэн боловсруулахад, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон төрийн цогц бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан стратегийн удирдлага, учирч болзошгүй аюул заналын талаарх үнэлгээ, урьдчилсан таамаглал, эдгээрийг харгалзсан нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө зэрэг нь гол эх сурвалж болох ёстойг тэмдэглэж байна.

#### **3.1. Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэл**

##### 3.1.1. Улс төрийн салбарт учирч болох эрсдэлийн тухай ойлголт



Улс төрийн салбарт эрсдэл учруулж болзошгүй аливаа аюул нь төрт ёсны уламжлалаа хадгалах, үндэсний тусгаар тогтнол, газар нутгаа хамгаалахын тулд Монголын ард түмний олон зуун жилийн турш явуулж ирсэн түүхэн тэмцэлтэй буюу гадаад хүчин зүйлийн нөлөөлтэй шууд холбоотой ойлголт юм. Үүний зэрэгцээ гадаад үүдэлтэй эдгээр аюул занал нь дотоод улс төрийн нөхцөл байдалд хүчтэй нөлөөлж үймээн самуун, зэвсэгт бослого гарах шалтаг, шалтгаан болж улс төрийн том эрсдэлийг үүсгэж байсан нь бас олонтой тохиолдож ирсэн байдаг.

Үндэсний аюулгүй байдал, түүний дотор улс төрийн тогтвортой байдлаа хангаж, тохиолдож болох эрсдэлээс сэргийлэхийн тулд аливаа улс орон улс төр, эдийн засгийн удирдлагаа төрийнхөө гарт төвлөрүүлж, хууль сахиулах болон хүчний бусад байгууллагынхаа хүч чадлыг дайчлан, хөрөнгө, мөнгөө энэ зорилгоор нэгтгэж, захиран зарцуулах зайлшгүй шаардлага үүсдэг бөгөөд энэ нь нийгмийн хүрээнд бас багагүй сөрөг үзэгдлүүдийг бий болгодог байна. Эдгээрт ядуурал, хүнд суртал газар авах, шүүх засаглалын бие даасан байдал алдагдах, төрийн удирдлагад гарсан хэсэг бүлэг хүмүүс эдийн засгийг хэт дураараа удирдах зэргээс үүдэн тэдний болон олонхын хооронд эвлэршгүй сөргөлдөөн үүсэх зэргийг хамааруулж болох юм.

Улс төрийн салбарт эрсдэл учруулж болзошгүй гадаад, дотоод аюул, занал нь хоорондоо харилцан уялдаатай байдаг. Энэ нь гадаад хүчин зүйлс хүчтэй, аюултай байх тусам, түүний эсрэг авч буй арга хэмжээний улмаас нийгэмд ихээхэн дарамт шахалт ирдгээр илэрхийлэгддэг юм Ийм нөхцөл байдал нь улс оронд тогтворгүй байдлыг үүсгэдэг бөгөөд улмаар гадаадын аюулын эсрэг явуулж буй тэмцэл нь дотоод улс төрийн эрсдэлийг бий болгож улс оронд хямрал үүсэх, нийгэмд тогтворгүй байдал даамжрахад хүргэдэг байна.

Өнөө үед манай орны эргэн тойронд өрнөж буй олон улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлтийн улмаас Монгол Улсад учирч болзошгүй гаднын аюулын эрсдэл ихээхэн багассан дүртэй байгаа юм. Өөрөөр хэлбэл ойрын ирээдүйд ямар нэгэн улс гүрэн, цэрэг-улс төрийн эвсэл, холбооны зүгээс Монгол Улсад учруулж болох гамшгийн үр дагавар авч ирэх дайн, байлдааны аюул занал төдийлөн харагдахгүй байгаа юм.

Ийм нөхцөл байдал нь Монгол Улсад өөрийн төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэлээ харьцангуй тайван байдалд явуулах боломж олгож байна. Гэвч энэ нь гадаад улс төрийн аюулгүй байдал бүр мөсөн хангагдсан гэсэн үг бас биш юм. Хөрш орнууд, бусад улс орон эвсэл, холбоодтой сайн харилцаатай байх нь олон улсын хүрээнд үүсэж дам буюу шууд манай оронд нөлөөлж болох улс төрийн эрсдэлүүдийг судлах шаардлагыг үгүйсгэдэггүй болно. Эдгээр эрсдэл нь олон улсын харилцааны хүрээнд байнга агуулагдаж байдаг, хэдийд ч хурцдаж болох тогтворгүй хүчин зүйлст тооцогддог бөгөөд ирээдүйд ийм нөхцөл байдалд хүргэхгүйн тулд тэдгээрийг тасралтгүй хянаж, ажиглаж байх нь зүйтэй юм.

XX зууны сүүлчээр үүссэн олон улсын улс төрийн хямралд Монгол Улс төдийгүй бүхэл бүтэн социалист систем, түүний тэргүүлэх хүчин ЗСБНХУ өртсөн нөхцөл байдлыг нарийвчлан судалж үзэх юм бол, уг хямрал нь дэлхий нийтийн хувьд стратегийн шинж чанартай байсан болох нь тодорхой байдаг. Социалист улсууд нийтээрээ үзэл суртал, эдийн засаг, нийгмийн тогтолцооны хямралд өртсөнөөс тэдгээр орны олон арван жил эрхэмлэн дээдэлж ирсэн үнэт зүйлс утга учраа алдаж, оронд нь ардчиллын гэж нэрлэгддэг цоо шинэ үнэт зүйлс дэвшигдэн гарч ирсэн байна. Үүний улмаас төр, нийгмийн байгууламжийн мөн чанар, эдийн засаг дахь өмчлөлийн хэлбэр, агуулгад эргэлтийн гэж хэлж болох өөрчлөлтүүд явагдсан юм. Социалист системийн улс орнууд оршин тогтнох хугацаандаа улс төрийн эрсдэлийн онол, арга зүйг огт судалж байгаагүй, тийм учраас мэдээж хэрэг ийм төрлийн эрсдэлийн үнэлгээ хийж байгаагүй нь тодорхой юм. Энэ нь тэрхүү эрсдэлд өртөх боломжийг бүрдүүлж өгсөн нэг хүчин зүйл байсан гэж үзэх үндэстэй юм.

Тэгвэл өнөөдөр улс төр судлаачдын цөөнгүй хэсэг нь дэлхийд Америк, Европын ноёрхлын үе дуусах шат руугаа явж, Хятад, Энэтхэг, Орос улсын нөлөө ихсэх хандлагатай байгаа нь дэлхий нийтийг хамарсан бас нэг улс төрийн эрсдэлийг дагуулж магадгүй гэсэн дүгнэлтийг хийж байна. Дэлхийн банкны судалгаагаар ойрын 10 жилд Хятад, Энэтхэгийн эдийн засаг гурав дахин өсөх бөгөөд 2020-иод оны эцэст Хятадын эдийн засаг АНУ-ын эдийн засгийг гүйцэж түрүүлэх төлөвтэй байна. Газрын тос олборлогч орнуудын эдийн засаг маш хүчирхэг болох шинжтэй байгаа бөгөөд энэ хэрээр дэлхийн эдийн засгийн нөлөөллийн бүсүүдийн тэнцвэрт хүчний дахин хуваарилалт явагдана гэж үзэж

байна. "Түүхийн буцан ирэлт ба мөрөөдлийн төгсгөл" (The Return of History and the End of Dreams) номын зохиогч Роберт Коган дэлхийн ардчилсан улсуудын нэгдэл болон хатуу дэглэмтэй улсуудын холбооны хооронд мөргөлдөөн болох бодит аюул байгааг анхааруулсан байдаг. Үнэхээр ч өнөөдөр эдийн засаг нь сэргэж байгаа Хятад, Орос, Венесуел, Персийн булангийн болон хуучин ЗХУ-ын харьяанд байсан Төв Азийн орнууд гээд нэлээд улсууд хатуу дэглэмтэй байгаа бөгөөд улс төрийн хатуу дэглэмийг эдийн засгийн либералчлалтай, үндэсний үзлийг бизнесийн эрх чөлөөтэй хослуулах хэлбэрийг нэлээд үр дүнтэйгээр хэрэгжүүлж чадаж байгаа учир цаашдаа тодорхой урт хугацаагаар амь бөхтэй орших бололтой байгаа юм.

Эдгээр орон олон улсын либерал дэг журмыг үл тоомсорлон ижил төстэй автократ түншүүдтэйгээ хамтран холбоо байгуулж өөрсдийн бие даасан байдалд халдсан бүхэнтэй эрс хатуугаар тэмцэх болно гэж Р.Коган бичжээ. Үүний хариуд АНУ, Европ тэргүүтэй ардчилсан орнууд нэгдэж "Ардчиллын Лиг" байгуулах нь тулгамдсан асуудал боллоо гэж тэр бээр санал болгосон бөгөөд үүнийг АНУ-ын гол хоёр нам хоёулаа болон Барууны гэж нэрлэгддэг орнуудын улс төрийн удирдлагууд үндсэндээ дэмжиж байгаа нь олон зүйл дээрээс харагддаг болно.

Үүний зэрэгцээ цаг үеийн тулгамдсан асуудлууд болох Ирак, Афганистанд болж буй хэрэг явдал, Иран, Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр, Израиль-Палестиний ужгирсан сөргөлдөөн, Африкийн улс, овог аймаг хоорондын мөргөлдөөн, "Аль-Каида" бүлэглэлийн алан хядлага зэрэг хурц асуудлууд намдах биш улам ширүүсэх төлөвтэй байна. Дэлхийн дулааралтай тэмцэх Киотогийн протоколыг хэрэгжүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагын худалдаа, тарифын хэлэлцээрүүд болон цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээ хэлэлцээрүүдийг шинэчлэх цаг тулж ирээд байна.

Олон улсын байгууллагуудын нэр хүнд унаж, татваргүй цалин, өндөр төсөв, тусгай хангамжтай, ямар ч улсад тайлан тавьдаггүй, аудит хийлгэдэггүй хүмүүс бүх дэлхийгээр хөлхөлдөн бодит зүйл хийхгүй зөвхөн хар амиа борлуулж байна гэсэн шүүмжлэл их гарах боллоо. НҮБ-ыг эрс шинэчлэх, эс чадвал түүнийг "Ардчиллын Лиг"-ээр солих санал АНУ-д улам газар авч байна. НАТО-г татан буулгаж зөвхөн Европын улсууд оролцсон цэргийн байгууллага байгуулах нь зүйтэй гэсэн санал ч бас их яригдах боллоо.

"The Los-Angeles times" сонинд "НАТО одоо хамтын батлан хамгаалах байгууллага гэхээсээ хэдэн баян орны улс төрийн клубтэй илүү төстэй болсон. Энэ эвсэл дайныг сэрэмжлэн зайлуулах, эсвэл түүнд бэлтгэхээсээ илүү олон улсын хурал, зөвлөгөөнийг л чадварлаг зохион байгуулах боллоо" гэж шүүмжилжээ. Дэлхийн банкиг ч гэсэн "зөвхөн ядуу буурай орнуудыг өрөнд унагахаас өөр зүйл хийдэггүй" гэж бичигцгээж байна.

Зөвхөн ойрын жишээ авахад л ОХУ, БНХАУ дахь өнөөгийн улс төрийн дотоод нөхцөл байдал төдийлөн тогтвортой биш байна. Ийм байдал ялангуяа, өмнөд хөршид цаашид ээдрээтэй байдалд хүрч болохоор байгаа юм. Төвд, ӨМӨЗО, Шинжаан-Уйгар дахь улс төрийн нөхцөл байдал, хүний эрхийн асуудал, үндэстэн хоорондын далд зөрчил, баян ядуугийн ялгаа, зөрүү энэ бүхнийг тухайн улс төдийгүй манай улсын улс төрийн стратегийн эрсдэлийг нэмэгдүүлэх нэг гол далд хүчин зүйл хэмээн үзэж болохоор байна.


Эдгээр нь дэлхийд хүчний шинэ харьцаа тогтож олон улсын хамтын нийгэмлэгийн байгууллагуудын тогтолцоо ямар нэгэн шинэчлэлд өртөх нь зайлшгүй болж улс орнуудыг нийтэд нь хамарсан улс төрийн эрсдэл дахин гарах магадлал өсөн нэмэгдэх хандлагатай болохыг харуулж байгаа юм.

Улс төрийн салбарын эрсдэл гэдэг нь ерөнхий утгаараа улс орны улс төрийн амьдралын ирээдүй тодорхойгүй байдалтай болох, эсвэл стратегийн нөөцийн (хүн хүч, материаллаг баялаг, мэдээлэл, цаг хугацаа, санхүүгийн гэх мэт) хомсдол үүсэн ийм цаг үед гаргаж буй улс төрийн шийдвэрийн үр дагавар нь дотооддоо болон хөрш орнууд, хамтрагч улсуудад тааламжгүй нөхцөл байдлыг үүсгэх, улмаар ард иргэдийн хүсээгүй үйл явдлыг хэрэгжүүлэх, ингэснээрээ улс орны улс төрийн амьдралд тасалдал учруулж эцсийн дүндээ нийтийг хамарсан үймээн самуун, цаашлаад төрийн эргэлт гарах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх магадлал юм.

Эндээс улс төрийн салбарын эрсдэл нь улс үндэстний дотоод улс төрийн бодлого, үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж, гадна талдаа олон улсын хэмжээнд байгуулсан гэрээ, нэгдэн орсон гэрээ хэлэлцээр, конвенцоо зөрчих, гадаадын хөрөнгө оруулалтыг зогсоох, хамтарсан аж ахуйнуудыг дампууралд

оруулах, дотоод талдаа хүн ам, нийгмийн амьдрал, эдийн засгийн болон дэд бүтэц, хүрээлэн буй орчинд хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг үйл явдал болох нь харагдаж байна. Улсын хэмжээний улс төрийн эрсдэл нь улс даяар эмх замбараагүй байдал үүсэх, улс төрийн тогтолцоо бүхэлдээ тогтворгүй болох, авлига дэлгэрэх, ядуучууд, ажилгүйчүүдийн тоо олшрох, гэмт хэрэг гарах нь нэмэгдэх зэрэг олон сөрөг зүйлс, үйл явцаар илэрдэг болно.

Улс төрийн салбарын эрсдэл нь улс орныг бүхэлд нь хамарсан эсвэл тодорхой бүсчилсэн нутаг, нийслэл, муж, аймгийн нутаг дэвсгэрээр хязгаарлагдсан байж болох юм. Ер нь улс төрийн эрсдэлийг цар хэмжээгээр нь олон улсын, бүс нутгийн, нэг улсын хэмжээний гэж хуваан үздэг. Олон улсын болон бүс нутгийн улс төрийн эрсдэл жижиг, буурай хөгжилтэй улсуудад хүчтэй нөлөө үзүүлдэг бөгөөд тэдний хувьд улс төрийн эрсдэлийн үндсэн хэлбэр байх нь олонтой тохиолдсон болно. Нэг улсын хэмжээний улс төрийн эрсдэл гэдэгт дотооддоо үүсээд улс орны улс төрийн тогтвортой байдлыг бүхэлд нь алдагдуулахад хүргэж болзошгүй нөхцөл байдлыг хамааруулан ойлгодог юм. Ийм төрлийн эрсдэл нь ихэвчлэн Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны алдаа, тэргүүлэх салбаруудын хямралт байдал, тэдгээрийн эрс хувьсал өөрчлөлттэй холбоотойгоор үүсдэг байна.



Зураг 2.4. Улс төрийн салбарт эрсдэл үүсэхэд нөлөөлөх үндсэн хүчин зүйлс

### 3.1.2. Улс төрийн салбарт эрсдэл үүсгэж болзошгүй дотоод хүчин зүйлс

Сүүлийн жилүүдэд манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд бий болсон шинэ нөхцөл байдал нь дотоод улс төрийн аюулгүй байдлын асуудлыг тэргүүн зэрэгт авч үзэхийг шаардаж буй нь улам бүр тодорхой болсоор байна. Өөрөөр хэлбэл дотоодын шинж чанартай улс төрийн хямралт үзэгдлүүд газар авах болж энэ нь нийгмийн зүгээс төр, засгаа дэмжихгүй байх, итгэл алдарснаа мэдрүүлэх байдлаар илэрч эхэлж байгаа бөгөөд үүнийг засаж залруулах дорвитой бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй бол манай оронд дотоод улс төрийн хүчтэй эрсдэлтэй учирч болзошгүй байдал үүсэж болзошгүй нь тодорхой байна.

Энэ хэсэгт дотоод улс төрийн амьдралд учирч болзошгүй эрсдэлүүдийг авч үзэхдээ нийгмийн салбар, дотоод улс төрийн амьдралын зааг дээр илэрдэг аюулуудыг авч үзээгүй болно. Тэдгээр нь мөн чанартай нийгэм, улс төрийн хосолмол шинж чанартай байдгийн зэрэгцээ үр дагавар нь нийгмийн хэсэг бүлэг, давхаргуудын хүрээнд ихэнхдээ илэрдэг учир нийгмийн салбарын эрсдэлүүдийн тухай бүлэгт тусгасан болно.

#### 3.1.2.1. Дотоодын үймээн самуун гарах болон улс төрийн экстремизм үүсэж болох нөхцөл байдал

Дотоод улс төрийн хүрээнд аюул учруулж болох үндсэн гэж хэлж болох нөхцөл байдал нь манай улсад зарим нэг орны адил өнөөг хүртэл тогтвортой, сайн засаглалын баттай суурь тавигдаж чадаагүй байгаа явдал юм. Монгол Улсын улс төрийн аюулгүй байдал нь олон зууны туршид үнэн чанартаа төрт ёсыг дээдэлж, үүнийхээ тулд эвлэрэн нэгддэг байсан монгол түмний түүхэн уламжлалд тулгуурлаж ирсэн билээ. Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд Монгол Улсын улс төрийн тогтвортой байдал нь ардчиллын үнэт зүйлсийг үндсэндээ бүх ард түмэн хүлээн зөвшөөрөх болсонтой бас ихээхэн уялдаатай байгаа нь ойлгогдож буй юм. Гэхдээ зөвхөн үндэсний эх оронч сэтгэлгээ, ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэх нь удаан хугацааны тогтвортой байдлыг хангаж чадахгүй, ер нь эдгээрийг хослуулах нь ихээхэн амаргүй зүйл болохыг өнөөгийн болж буй олон хямралт үзэгдэл улам бүр тодорхой харуулсаар байна.

Өөрөөр хэлбэл хүн амын цөөнгүй хэсгийг хамарсан ядуурал, нийгмийн шударга бус байдал, авилаг, хүнд суртал газар авах зэрэг эцсийн дүндээ улс төр, эдийн засгийн зөв мэргэн бодлого дутагдсанаас үүдэн гардаг хүчин зүйлс дотоод улс төрийн амьдралд хүчтэй нөлөөлж улс төрийн экстремизмийн хэлбэр агуулсан зөрчил сөргөлдөөнийг үүсгэх магадлалыг бий болгосоор байна.

Монголын дотоод улс төрийн амьдралд ийм төрлийн аюул үүсэж болох магадлал бодитой байгааг 2008 оны 7 дугаар сарын 1-нд болсон үйл явдал тодорхой харуулсан билээ.

Ойрын жилүүдэд учирч болзошгүй үйл явдлын таамаглалаар бол дотоод улс төрийн амьдралд аюул учруулж болохоор хамгийн хүчтэй зүйл бол нийгмийн шударга ёсны төлөөх иргэдийн зүй ёсны тэмцэл хэт хувьсгалжсан, улс төрийн экстремизмийн хэлбэрт шилжиж болзошгүй байгаа явдал юм. Энэ нь өмнөх нийгмээ санагалзсан хүн амын ахмад гэж хэлж болох багагүй хэсэг, дээр нь ажилгүйдэл, ядуурал, боловсролын гадна орхигдсон дэл сул хэмээх залуусын дунд түгээмэл болсоор байна. Сүүлийн жилүүдэд нийгмийн шударга ёсонд итгэл алдарсан болон төр засагт итгэхээ больсон хүмүүсийн тоо эрс өссөн судалгаа байгаа бөгөөд ийм байдал цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Энд хамгийн ноцтой нь нийгэмд эзэлж байгаа байр сууриндаа сэтгэл дундуур, бүхнийг эсэргүүцэгч ахмад үеийн хэсэг бүлэг хүмүүсийн зэрэгцээ залуусын дунд бүх шатны дарга нар болон мөнгө хөрөнгөтэй хүмүүсийг үзэн ядах явдал багагүй дэлгэрэх болсон байна. Тэд Монгол Улсыг, түүний дотор, газар нутаг, ахмад үеийн хөдөлмөрөөр хуримтлуулсан материаллаг баялгийг дээдэс, баячууд гадаадынханд худалдсан, эдийн засгийн хувьд Хятадын мэдэлд орсон, улс төрийн хараат байдлаараа АНУ-ын дуу хоолойг дуурайгчид болсон гэж буруутгаж байна. Мөн улс орны эдийн засгийн амьдрал, бага, дунд бизнест гадаадын иргэдийн ялангуяа хятадуудын оролцоо ихээхэн нэмэгдэж байгаад дургүйцэж байгаа юм. Энэ бүхэн нь эцсийн дүндээ монголын ард түмэн өөрийн газар нутаг, нийгмийн болон байгалын баялгийнхаа эзэн байх эрхээ бусдад булаалгаж улмаар үндэсний аюулгүй байдлаа алдаж эхэлж байна гэсэн сэтгэлгээг нийгмийн дунд бий болгосоор байна.

Эдгээрийн дотроос анхаарал татаж байгаа нэг зүйл бол хаа сайгүй хүчтэй өрнөж буй байгаль орчин, орон нутгийнхаа газар нутаг, бэлчээр, усаа хамгаалах хөдөлгөөнүүд болон Улаанбаатарт эрчимтэй өрнөж байгаа газрын төлөө маргаанууд нь төрөөс энэ тал дээр шийдвэртэй арга хэмжээ авахгүй байх тохиолдолд улс орны улс төрийн тогтворгүй байдалд улс төрийн агуулгатай эрсдэл сорилт үүсэх бас нэг эх сурвалж болж магадгүй байгаа явдал юм. Хэдийгээр эдгээр хөдөлгөөн, маргаан, тэмцэл нь үндсэндээ шударга гэж хэлж болох зорилгыг агуулсан болох нь тодорхой боловч цаана нь асуудлыг хуулийн бус аргаар шийдвэрлэх, өөр хоорондоо тооцоо бодох, хууль бус амар аргаар хөрөнгө мөнгө олж авах, гадаадын хөрөнгө оруулагчдын эсрэг туйлширсан тэмцэл явуулах зэрэг санаануудыг хадгалсаар байгаа нь бас тодорхой байгаа юм. Одоохондоо тэдний тоо, нөлөө харьцангуй бага бөгөөд олны дэмжлэгийг ч төдийлөн сайн авахгүй байгаа юм. Гэвч тэдний үзэл бодол, ялангуяа хэсэг бүлэг ахмадууд, зарим нэг малчид, оюутан, залуусын хөрөнгө мөнгөгүй хэсгийн дунд ихээхэн дэмжлэг хүлээсээр байгааг анхаарах хэрэгтэй юм.

Залуучуудын туйлшрах нь амархан, хуулийг үл тоомсорлох буюу ойлгож мэддэггүй явдал нь байгаль хамгаалагчид болон хууль сахиулагч нартай хийж байгаа сөргөлдөөнтэй хослох юм бол олныг хамарсан хэт даварсан шинжтэй экологийн хөдөлгөөн үүсгэж чаддаг болохыг олон оронд болсон үйл явдал харуулсан билээ. Барууны орнуудын туршлагаас үзэхэд ийм хөдөлгөөн нь хүч хэрэглэх, экологийн аюул учруулж болзошгүй байгууламжуудад халдах, тэдгээрийг эзлэн авч барьцаалах, хүн амыг эмх замбараагүй байдалд турхирах зэрэг шинж чанартай болж хувирах нь олонтой тохиолдсон байдаг. Өөрөөр хэлбэл экологийн хөдөлгөөн нь экологийн фашизм болох магадлал өнөөгийн олон улсын практикт ихээхэн түгээмэл болоод байна. Энэ нэр томъёог Баруун Европын зарим орны улс төрийн хэллэгт аль хэдийнээс хэрэглэж эхэлсэн бөгөөд хэт туйлширсан байгаль хамгаалагчид буюу эко фашистууд нь улс төрийн хүрээний хэт даврагсадтай ойртон нягтарч улс орны улс төрийн амьдралд ноцтой эрсдэл учруулах нь багагүй тохиолдсоор байгаа юм. Манай оронд энэ төрлийн үйл явдлын эхний шинж тэмдгүүд аль хэдийнээ мэдрэгдэж эхэлсэн бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдын болон бие биеийнхээ эд хөрөнгөнд халдах, эвдэж сүйтгэх, тэр ч байтугай галт зэвсэг хэрэглэн буудаж танхайрсан явдал гарсан бөгөөд эдгээрт хууль сахиулах байгууллага хайхрамжгүй болон олонх иргэд өөгшүүлэх маягаар хандаж буй нь тийм ч сайн зүйл биш юм.



Ойрын ирээдүйд улс орны улс төрийн тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж болох ноцтой аюул дагуулж магадгүй өөр нэг зүйл бол олныг хамраад байгаа иргэний хөдөлгөөн хэт даварсан шинжтэй болон хувирч болзошгүй явдал юм. Өнөөгийн иргэний хөдөлгөөнүүд нь хэдэн жилийн өмнөхийг бодвол улс орны улс төрийн тогтвортой байдалд ноцтой эрсдэл сорилт учруулахааргүй байгаа билээ. Гэвч эдгээрийн дотроос хэт түрэмгийлэх байр суурь баримталдаг нэг хэсэг тасарч гарах, эсвэл хэт зүүний үзэл баримтлалтай нам, хөдөлгөөнүүд нэгдэж нягтрах болон эдгээрийн хосолмол хэлбэр үүсэх нөхцөлд нийтийг өргөнөөр хамарсан хэт даврах хэлбэрийн нам, хөдөлгөөн гарч ирэх магадлал бодитой байгаа болно.

Ер нь ойрын жилүүдэд үндэсний үзэлт радикал байгууллагууд, хэт даврах үзэл суртлыг номлогчид, байгаль орчин болон өөр өөрийн сум, багийнхаа газар нутгийг хамгаалагчид, даяаршлыг эсэргүүцэгчид, дэлхийг өөрчлөх зорилго бүхий “хувьсгалч” байр сууриа хадгалсаар байгаа хэт коммунист үзэлтнүүд ойртон нийлж нөлөө бүхий улс төрийн томоохон хүчин болон хувирч магадгүйг огт үгүйсгэж болохгүй юм. Нийгэм, улс төрийн хөгжлийн өнөөгийн ээдрээтэй, тогтворгүй байдал үргэлжилсэн хэвээр байвал ойрын жилүүдэд дээр дурдсан улс төрийн хүчин сонгогчдын олонхын дэмжлэгийг авахуйц эвсэл, холбоог байгуулж чиг болох юм. Энэ нь эцсийн дүндээ хэт туйлширсан, магадгүй хэт даврах үзэл баримтлалтай хүчин засгийн эрхэнд хүч хэрэглэхгүйгээр гарах боломжийг бий болгож болох талтай юм.

Төрийн эрхийг хууль бусаар авахыг буюу улс төрийн хэт даварсан хөдөлгөөнд уриалагчдын дуу хоолой одоогоор олны дунд төдийлөн дэмжлэг авахгүй байгаа нь төөрөгдөлд оруулах үндэслэл болж, тайвшруулах шалтгаан байж болохгүй юм. Хэрэв дотоод улс төрийн байдал хурцадсан нөхцөлд ийм төрлийн хүчин богино хугацаанд зохион байгуулалтад орж, нийгмийн олонхын дэмжлэгийг хүлээн, үндсэрхэгч болон хэт даврагч үзэлтнүүдийн хүсэл бодлыг гүйцэлдүүлэгч болж хувирдаг нь олон оронд болсон үйл явдлаас харагдсан билээ. Манай оронд 2008 оны 7 дугаар сарын 1-нд болсон хэрэг явдал болон Монгол Улсын 3 дахь Ерөнхийлөгчид хууль сахиулах байгууллагуудаас хэрхэн хандсаныг олон нийтийн багагүй хэсэг ямар байдлаар хүлээж авсан явдал үүний тод жишээнүүд юм.

Ийм байдал үүсгэхгүй байх хамгийн гол нөхцөл нь юуны өмнө сайн засаглалыг бэхжүүлэх, эдийн засгийг эрүүлжүүлэх, нийгмийн тулгамдсан асуудлуудыг иргэдэд ашигтайгаар шийдвэрлэх, түүний дотор шударга ёсыг хангах, иргэний нийгмийг хөгжүүлэх, авилаг, гэмт хэрэгтэй бүхэлд нь шийдвэртэй тэмцэх зэрэг бололцоог олгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгох явдал юм. Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал нийт иргэдийн итгэлийг хүлээх, тэдэнтэй ойр дотно харилцааг өргөжүүлэх, шинэ төрлийн өөриймсөг холбоо тогтооход чиглэсэн тодорхой алхмууд хийх нь энд мөн эерэг үүрэг гүйцэтгэх болно

### 3.1.2.2. Үндэстэн ястан, шашин хоорондын мөргөлдөөн гарч болзошгүй нөхцөл байдал

Орчин үед үндэстэн ястан, шашин хоорондын мөргөлдөөнийг олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдал хурцдаж байгаагийн нэг шууд үр дагавар гэж үзэх болоод байна.

Монгол Улс хэдийгээр олон үндэстэнтэй, цөөнгүй шашинтай оронд тооцогддоггүй боловч манайд халх монгол, казах гэсэн хоёр томоохон үндэстэн, мөн өөр өөрийн гэсэн түүх, соёл, уламжлал, зан заншил, шашин шүтлэг, онцлогоо хадгалсан 20 гаруй ястан оршин сууж байна. Өнөөдөр хүн амын 82 хувийг халх монголчууд болон монгол хэлт бусад ястан, 18 хувийг казахууд болон түрэг угсаат бусад үндэстэн, ястан эзэлж байгаа гэсэн тоо байдаг.

Манай орны түрэг угсааны үндэстэн, ястнууд нь бүгд лалын шашинтнууд бөгөөд тэдний дунд их бага хэмжээгээр төр, засгаас үндэсний цөөнхийн талаар болон тэдний бөөнөөрөө оршин суудаг газар нутгийн хувь хэрэгжүүлж буй зарим бодлогод сэтгэл хангалуун бус байх явдал мэр мэр илэрсээр байгаа юм. Хэдийгээр үндэстэн хоорондын ноцтой мөргөлдөөн гарах магадлал ихээхэн бага боловч төр засгийн зүгээс алдаатай улс төрийн бодлого явуулах, магадгүй гаднаас чиглэл зорилготой хагалан бутаргах үйл ажиллагаа нэвтрэн орж ирэх тохиолдолд ийм төрлийн улс төрийн эрсдэл сорилт үүсэхийг огт үгүйсгэж бас болохгүй байгаа юм. Хэрэв ийм байдалд хүрвэл үр дагавар нь маш ноцтой байх бөгөөд энэ нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлэх, хөрш улсуудтай сөргөлдөх, гадаад ертөнцтэй зөрчилдөх, түүний дотор том

гүрнүүд, ялангуяа лалын холбооны орнуудтай харилцаа муудахад хүргэх аюулыг дагуулах нь тодорхой юм.

Улс орны аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулдаг шашин хооронд үүсэж болзошгүй улс төрийн үр дагавартай эрсдэл сорилт ч манай оронд бодитой оршсоор байгааг сүүлийн үед явуулсан олон тооны судалгаа, гарч буй хэрэг явдлууд харуулсаар байна. Хүн амын дунд давамгайлж буй бурхны шашин хэдийгээр энх амгалан амьдралыг номлодог боловч дэлхий нийтэд газар аваад буй тэрслүү үзэл суртлын нөлөөнд манай лалын шашинтнууд автагдаж болзошгүй байдал болон сүүлийн үед нэлээдгүй хэмжээгээр өргөнөөр тархаж буй Христийн шашны төрөл бүрийн урсгалууд хоорондын янз янзын учир шалтгаантай зөрчил, сөргөлдөөн, түүнчлэн Монголд социализмын үед үүсэн бий болоод одоог хүртэл амь бөхтэй үргэлжилсээр байгаа шашингүйн орон зайг аль болох өргөнөөр эзлэх гэсэн тэдний өрсөлдөөн зэрэг нь тодорхой нөхцөл байдалд ноцтой мөргөлдөөнд хүргэж болзошгүй юм.

Ер нь үндэстэн, ястан болон шашин хоорондын зөрчил үүсэн тохиолдолд онц хэрцгий хэлбэртэй дотоод улс төрийн аюул тулгардаг болох нь олон оронд харагдсан юм. Үүний зэрэгцээ ийм аюул үүсгэж болзошгүй төрөл бүрийн шашны дотоод гэж хэлж болох өөрсдийн үйл ажиллагааны хажуугаар эдгээр зөрчил сөргөлдөөнийг өдөөх гэсэн гадаад үүдэлтэй олон янзын оролдлого, дотоодын улс төрийн тодорхой хүчний хатгалга, төрөөс шашин сүм хийдийн салбарт баримтлах бодлогын санамсартай, санамсаргүй алдаа зэргийг бас тооцож байх хэрэгтэй юм.

Монгол Улсын хувьд үндэстэн хоорондын тэмцэл, үүнээс үүдэн газар нутгийн хувьд салан тусгаарлах хөдөлгөөн үүсэх магадлал ихээхэн бага юм. Гэхдээ дэлхий нийтэд болж буй энэ төрлийн үйл явдал улам бүр өргөжиж, хамгийн тогтвортой гэгдэж байсан Европын орнуудыг хүртэл хамрах болсныг харвал бас огт үгүйсгэж болохгүй зүйл болно.

Төр, үндэстэн хоорондын харилцаан дахь салан тусгаарлах бодлого мэт сөрөг хандлагуудын эсрэг улс орон болгон удаан хугацааны, цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар асуудлыг шийдвэрлэж ирсэн. Ийм бодлогын үндсэн агуулга нь аливаа улсын бүх үндэстэн, ястан тус тусын үндэсний онцлог,

ахуй хөтлөх арга ухаан, нийгэм, соёл, шашин шүтлэгийнхээ уламжлалыг хадгалсан тэгш эрхтэй байж, хөгжил дэвшилд хүрэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийн хоорондын нэг улсын иргэдийн ахан дүүсийн харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй, эрх зүйн хатуу зохицуулалт, баталгаатай, иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршдог болно.

### 3.1.2.3. Шүүх засаглалын болон хууль сахиулах байгууллагын доройтол гарч болох нөхцөл байдал.

Улсын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох гаднын үүдэлтэй зүйлийн эсрэг сөрөн зогсох арга хэрэгсэл талаас нь авч үзвэл нь аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий, юуны өмнө шүүх засаглал, хууль сахиулах байгууллагын хүч чадал, бие даасан болон шударга байдал ихээхэн чухал хүчин зүйл байдаг .

Аливаа орны ийм төрлийн байгууллагын үндсэн үүргээ биелүүлэх чадвар доройтох нь тухайн улсын улс төрийн салбарт гаднаас учирч болох аюулыг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болдог. Энэ нь гадаад, дотоод хоёр үр дагавартай байдаг. Юуны өмнө эдгээр байгууллагын чадавх сул, үйл ажиллагаа нь шударга бус байна гэдэг нь гаднын үүдэлтэй элдэв дарамт шахалтын эсрэг сөрөн зогсох болон дотоодын улс төрийн болон бусад төрлийн элдэв бүлэглэлийн хууль бус санаархлуудыг тогтоон барих, таслан зогсоох чадвараа алдана гэсэн үг юм. Өөрийнхөө төр нийгмийн тогтолцооны бүрэн эрхийг хамгаалах чадвартай, үүнд бэлэн байгаа гэдгээ харуулж, олон улсын харилцааны хүрээнд болон өөрийнхөө нийгэмд хүлээн зөвшөөрүүлэх нь шүүх засаглал, хууль сахиулах байгууллагын үндсэн үүрэг байдаг.

Шүүх засаглал, хууль сахиулах байгууллагын чадавх суларснаас үүдэн улс төрийн салбарт үүсэж болох аюулын тухайд бол энэ нь хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын хүч сулрах, ард түмэн, иргэдийн төрдөө итгэх итгэл алдрах, цаашлаад, улс төрийн тогтворгүй байдал үүсэх, янз бүрийн үүдэлтэй хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг газар авч, хараа хяналтаас гарах зэрэг хэлбэрээр өргөждөг байна.

Ийм байгууллагын хүч чадал суларснаас үүдэн үүсэж болох дээр дурдсан үндсэн аюул нь үндсэндээ хоёулаа дотоод улс төрийн амьдралд хамаарч болох

юм. Учир нь эдгээрээс сэргийлэх болон ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд засаж залруулах нь мөн чанартаа төр засгийн зөв мэргэн оновчтой бодлого, улс орны дотоод нөөц бололцоог үр дүнтэй дайчлах болон улс төрийн удирдлагын дотоод шинж чанарыг зөв голдрилд нь оруулах замаар шийдвэрлэгддэг болно.

Үүнтэй уялдуулан тэмдэглэхэд төр, нийгмийн шилжилтийн эхэн үед буюу 1990-ээд оны эхэн хагаст Монгол Улсад болсон олон талт хямралын нэг тод илрэл, үр дүн нь аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий, түүний дотор Зэвсэгт хүчин, шүүх засаглалын болон хууль сахиулах байгууллагууд ихээхэн суларсан явдал байсан юм. Эдгээр байгууллагад маш том цохилт авчирсан зүйлүүд бол юуны өмнө ОХУ-ын энэ чиглэлийн дэмжлэг, тусламж бүрэн зогссон явдал байлаа. Үүний дараа улс орныг бүхэлд нь хамарсан эдийн засгийн хямрал болон ер нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хамгаалах бие даасан тогтолцоог цоо шинээр бүрдүүлж хөгжүүлэх онолын үндэслэл, үзэл баримтлал, дадлага туршлага тэр үед үндсэндээ байгаагүй нь ихээхэн бэрхшээл учруулсан билээ.

Шүүх засаглал, хууль сахиулах байгууллагад үүссэн дээрх хямралын үр дагавар олон хэлбэрээр одоо хүртэл үргэлжилсээр байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд төр засгаас энэ асуудалд илүү анхаарал хандуулах болж байдал зарим талаар сайжирч байгаа боловч Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бүрэн хэмжээгээр, найдвартай хамгаалах хэмжээнд хүртлээ өөрчлөгдөх нь ирээдүй цагийн асуудал хэвээр байгааг энэ чиглэлээр явуулсан олон тооны тусгайлсан судалгаанууд харуулсаар байгаа юм.

### 3.1.3. Улс төрийн салбарт эрсдэл үүсгэж болзошгүй гадаад хүчин зүйлс

#### 3.1.3.1. АНУ-ын гео стратегийн бодлогын үр дагавар

Орчин цагийн хамгийн хүчирхэг гүрний хувьд АНУ-ын хүчин чадал байнга өсөж, энэ улс Зүүн Хойд болон Төв Азид өөрийн нөлөөний бүсийг өргөтгөн тэлэхийг чармайсаар байгаа нь хүссэн хүсээгүй Монгол Улсад учирч болзошгүй стратегийн эрсдэлийн нэг үндэс суурь болох магадлалтай юм. АНУ-ын геополитикийн бодлогын гол шинж чанар бол бусад орны эсрэг цэрэг, улс төр, эдийн засгийн хориг үйл ажиллагаа явуулахдаа ихэнх тохиолдолд өөрсдөө аль

болох хариуцлага хүлээхгүй байхыг зорилго болгодог бөгөөд хамгийн бага хохиролтой үлдэхийг эрмэлздэг явдал юм.

Ийм том гүрэнтэй үндсэндээ цэрэг, улс төрийн холбоотны түвшинд харилцаж нэг талаасаа түүний ашиг сонирхлыг Зүүн Хойд Азийн бүс нутагт хамгаалагч, илэрхийлэгч болж байгаагаараа Монгол Улс АНУ-ын ашиг сонирхлыг энэ бүс нутагт хязгаарлахын төлөө байдаг бусад их гүрэн, юуны өмнө хөрш, зэргэлдээ хоёр орныхоо хувьд олон улсын улс төрийн эрсдэлийн нэг голомт болж байгаа нь хэн бүхэнд тодорхой байгаа болно. Ийм учраас АНУ-ын Зүүн Хойд Азид хэрэгжүүлж буй цэрэг, стратегийн бодлогын улмаас үүдэн гарч болох аливаа аюул занал манай орны хувьд улс төрийн ямар эрсдэл үүсгэж болохыг бид байнга судалж байх нь чухал юм.

Ер нь АНУ-ын энэ бүс нутагт явуулж буй бодлогоос улбаалан олон улсын улс төр, эдийн засгийн шинж чанартай цэргийн болон цэргийн бус эрсдэлүүд тохиолдох бодитой магадлал байгаа бөгөөд энэ нь Монгол Улсыг тойрч өнгөрөхгүй нь тодорхой юм. Энэ нь өрсөлдөгчид мөн хамтрагсад тэр ч байтугай холбоотнууддаа улс төр, эдийн засаг, зарим тохиолдолд цэргийн шахалт, дарамт үзүүлж өөрийн зорилгодоо хүрч болно гэж үздэг улс төрийн хүчин АНУ-д байгаагаар холбоотой бөгөөд цаашид ч ийм байдал үргэлжлэх болно.

2012 оны эхээр АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамо тус улсын олон улсын цэргийн үйл ажиллагааны анхаарлын төвийг Ази тивд шилжүүлэх нь зөв гэсэн утгатай үг хэлсэн болон үүний мөрөөр Пентагон энэ тивийн хувьд явуулах батлан хамгаалах бодлогоо шинэчлэх төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь Зүүн Хойд Азийн орнуудын хувьд гадаад улс төрийн шинэ эрсдэлүүдийг бий болгож магадгүй болоод байгаа юм.

Үүний зэрэгцээ АНУ-тай тогтоосон олон талт, нягт хамтын ажиллагаа нь Монгол Улсын хувьд олон улсын улс төрийн багагүй эрсдэлийг дагуулж байгаа боловч одоохондоо манай орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах нэг гол чухал хүчин зүйл байсаар байна. Ойрын ирээдүйд ч ийм байдал тогтвортой үргэлжлэх нь үндсэндээ тодорхой юм.

### 3.1.3.2. БНХАУ-ын гадаад бодлогын үр дагавар

Хятад нь эдийн засгийн хувьд өнөөгийн ертөнцөд хамгийн хурдацтай, далайцтай хөгжиж байгаа орон бөгөөд өөрийн өсөн нэмэгдэж буй эдийн засаг, цэргийн хүчээрээ ойрын ирээдүйд Зүүн Хойд Азид үүсэж болзошгүй эрсдэл, сорилтуудын гол бодит эх үүсвэр болж байгаа талаар дэлхийн хэвлэлүүд мэдээлсээр байгаа юм. Бүхэлд нь авч үзвэл ойрын 20 жилд энэ улсын эдийн засаг, улс төрийн хүчин чадал эрчимтэй өсөж, улам бүр бүх нийтийг хамарсан шинж чанартай болох нь тодорхой юм.

Энэ тохиолдолд хүчтэй эдийн засаг, зэвсэгт хүчин, их хүн амтай байдлаа ашиглан Хятад улс зөвхөн Тайван руу төдийгүй Оросын Сибирь, Алс Дорнод, түүний зэрэгцээ Монгол руу анхаарлаа хандуулахыг үгүйсгэж болохгүй юм. Хэрэв энэ үед Монгол Улсын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байр суурь, эдийн засгийн хөгжил, нийгмийн тогтвортой байдал Хятадын ийм санаархлыг давж гарах түвшинд хүрээгүй байх юм бол энэ нь Монгол Улс оршин тогтнох эсэхэд тулсан стратегийн шинж чанартай улс төрийн эрсдэл байх нь тодорхой юм. Ийм гашуун сургамж Монголын түүхэнд өмнө нь байсан бөгөөд 1919 оны эзлэн түрэмгийлэл, 1950-1960-аад оны хятад ажилчдын тайван цагаачлал, эсвэл Хятадын засгийн газрын дэмжлэг, манай төрийн зарим байгууллагын харалган бодлогын уршгаар одоо эхэлчхээд байгаа “ажиллах хүчин” нэртэй “энхийн колоницлол”-ын үр дагавраар төрөлх газар нутгаа хятадын цагаачдад ноёлуулах магадлал оршсоор байгаа билээ.

АНУ-аас ялгаатай нь Хятад нь Монгол Улстай 4000 гаруй километр урт хилээр зах нийлдэг билээ. Монгол Хятадын хоорондох хилийн зурвас хэт төвлөрсөн 1.3 миллиард хүн амтай Хятад улсыг ердөө 2,8 сая хүн амтай Монголоос зааглаж байгаа гэдгээрээ л стратегийн эрсдэлийн шинж чанартай асуудал болдог юм. Өнөөдөр гэхэд л Монголд ирж оршин сууж байгаа болон ажил хөдөлмөр эрхэлж байгаа хятад хүний тоо хэдэн арван мянгаар тооцогдох болсон нь манай орны хувьд нийгэм эдийн засгийн ноцтой асуудал болон хувирч, цаашид төр, засаг, орон нутгийн засаг захиргаа зөв бодлого явуулахгүй тохиолдолд улс төр, нийгмийн аюул занал учруулж болох шинж чанартай болон хувирч болзошгүй байгаа юм.

Мөн сүүлийн жилүүдэд өргөжин хөгжиж байгаа Монгол - АНУ-ын харилцаа, түүний дотор Монгол, Америкийн батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны асуудалд Хятадын тал ихээхэн эмзэг байдлаар хандаж байгааг бид бас мэдэрч байгаа болно.

Эдгээрийн зэрэгцээ Хятад улсын бусад оронтой харьцах харилцаанд оршиж буй үл ойлголцол, тус улсын дотоод нийгэм, улс төрийн болон үндэстэн ястнуудын хоорондох зөрчилдөөний цаашдын хандлага нь хуучин Зөвлөлт Холбоот улсад гарсантай адил нөхцөл байдалд хүргэхгүй гэсэн баталгаа бас байхгүй юм. Энэ нь Хятадтай он удаан жил хөрш оршсон манай орны хувьд сэтгэл түгшээх асуудлын нэг болсоор байна.

### 3.1.3.3. ОХУ-ын Монгол Улсын талаар явуулж буй геополитикийн бодлого үйл ажиллагаа

1960-аад оноос эхэлсэн хуучин ЗХУ, БНХАУ-ын сэргэлдөөний хүрээнд Монгол Улс тус хоёр их гүрнийг заагласан завсрын бүс болж байлаа. Энэ нь Монгол Улсын газар зүйн байрлалын цэрэг-стратегийн ач холбогдолтой ч бас холбоотой юм. Гэхдээ ийм байдал зөвхөн ХХ зууны дунд үеэс эхтэй биш бөгөөд Монголыг болж өгвөл цэрэг-улс төрийн хувьд эрхшээлдээ, үгүйдээ гэхэд геополитикийн ашиг сонирхлынхоо бүсийн хүрээнд байлгах нь Орост Азид нөлөөгөө тогтоох чухал түлхүүр болж байсан тухай олон зууны түүх өгүүлдэг билээ.

Монгол Улсын төр, нийгмийн шинэчлэлийн хамгийн хүнд үе болох 1990-ээд онд олон улсын санхүүгийн байгууллага (ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк гэх мэт) болон АНУ, Япон, Герман, Бүгд Найрамдах Солонгос Улс болон бусад өндөр хөгжилтэй зарим улс орон манай оронд идэвхтэй туслалцаж ирснээрээ тус улсад эзлэх байр сууриа олж, үр нөлөөгөө ихээхэн өргөтгөн бэхжүүлж чадсан нь ОХУ-ын геополитикийн бодлогын хувьд “алдсан зүйл” болсон юм.

2000-аад оны эхэн үеэс Орос улс системийн гүнзгий хямралаасаа мултарч, түүний улс төр, эдийн засгийн байдал аажмаар сайжирч тогтворжин, гадаад бодлогын өрнө зүгт давамгайлан чиглэсэн өрөөсгөл талаа засан



залруулж дорно зүгийн чиглэлийг нь идэвхжүүлэхийн хирээр Орос, Монголын харилцаанд бий болсон түр доройтлыг арилгах шаардлагатай болсон юм. Ийм ч учраас 2000 оны 11-р сард Орос улсын ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад албан ёсны айлчлал хийж Улаанбаатарын тунхаглалд гарын үсэг зурсан бөгөөд энэ нь тус хоёр улсын харилцааг идэвхжүүлж түр доройтол, зогсонги байдлаас татан гаргаж шинэ шатанд гаргах анхны томоохон алхам болсон гэж Оросын судлаачид бичиж байна.

Одоо Орос улс үндэснийхээ аюулгүй байдлыг дотоодын болон гадаад улс төрийн ашиг сонирхлоо үр дүнтэй хослуулан хангахыг хичээж байна. Ингэхийн тулд Сибирь, Алс Дорнодын нутгаа түлхүү хөгжүүлж, Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж байгаа эдийн засгийн интеграцийн үйл явцад идэвхтэй оролцох явдал онцгой ач холбогдолтой байгаа юм. Ийм ч учраас Ази, Номхон далайн бүс нутагт Орос улсын стратегийн гол зорилго бол тус бүс нутгийн бүх улстай гүнзгийрүүлэн тэнцвэржүүлсэн харилцаа тогтоох замаар урт удаан тогтвортой байдлыг хангах явдал мөн гэж тэд зарлаж байгаа болно.

Үүнтэй уялдаатайгаар Орос улсаас Ази, Номхон далайн бүс нутагт баримталж байгаа гадаад бодлогод Монгол Улс ихээхэн чухал байр суурь эзэлж манай орныг стратегийн түнш улс хэмээн нэрлэх болсон нь үүний нэг илэрхийлэл юм.

Оросууд тэднийг Монгол улстай нягт холбодог геополитикийн хүчин зүйлсэд дараах ойлголтуудыг хамааруулан үзэж байгаа нь олон тооны судалгааны материалаас харагдаж байгаа юм. Үүнд:

- хуурай газраар 3,5 мянга км шахам үргэлжилсэн улсын хил;
- орос, монгол ард түмний хооронд улс төр, худалдаа, эдийн засаг, соёл иргэншил, хүмүүнлэг зэрэг бусад салбарт тогтсон найрамдалт, найрсаг харилцааны уламжлал;
- өнгөрсөн XX зууны 70 гаруй жилийн дотор нэгэн адил амаргүй хувь заяа, жаргал, зовлон, ялалт, ялагдал зэргийг зэрэгцэн амсаж өнгөрүүлсэн түүх;

- хоёр улс шилжилтийн үеийн хамгийн хүнд саад бэрхшээлийг даван тулаад үндсэндээ нэг чиглэл руу, тухайлбал зах зээлийн эдийн засаг, ардчиллын зүг зэрэг хөгжин дэвшиж, найрамдал, хамтын ажиллагаагаа шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх нэгэн адил хүсэл эрмэлзэлтэй байгаа зэрэг болно.

ОХУ нь манай их хөрш. Одоогоор улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааны бүх салбарт найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай орон юм. Монгол хүний сэтгэлд оросын ард түмний их ач тус, өгөөмөр сэтгэлийг хүндэтгэх, бүх зүйл дээр тэдэнд хандаж тусламж хүсэх, түшиг тулгуураа болгох сэтгэлгээ хүчтэй хадгалагдан үлдсээр байна.

Гэвч бид даяаршиж буй энэ дэлхий ертөнц дээр юу болж байгаа, хүн төрөлхтний жам ёсны хөгжил хаашаа явж байгааг тунгаан бодох, энэ хүрээнд ОХУ ямар байр суурь эзэлж, дэлхийн хөгжлийн тулгуур болсон том гүрнүүд болон хөгжиж буй бусад орон, түүний дотор хуучин ЗХУ-аас хараат байдлаасаа салах гэж чармайж буй улс орнууд түүнд хэрхэн хандаж байгаа, ялангуяа энэ улс гүрэн юу руу тэмүүлж, юунд хүрэхийг чармайж буйг бас тунгаан бодох учиртай юм.

Энэ үүднээс ОХУ-ыг хэдийгээр урьд өмнийн их гүрний эдийн засгийн болон, оюуны өндөр чадавхаа тодорхой хэмжээгээр хадгалан үлдсэн, хүний хүчин зүйлийн болон байгалийн баялгийн асар их нөөцтэй боловч улс төрийн байгуулалт, эдийн засгийг төрөөс удирдах арга барилын хувьд цаг үеэсээ ихээхэн хоцорсон, бусад улс орон ялангуяа хил залгаа, урьд нь харьяанд нь болон хараанд нь байсан улс орнуудынхаа хувьд ихэвчлэн хүчээр түрэмгийлсэн, тулгаж тунирхсан бодлого явуулдаг, үүнээсээ болоод олон улсын тавцанд нэлээд хэмжээгээр ганцаардах талдаа орсон орон гэж олон улс орон үздэгийг бид бас тооцож байх учиртай юм.

Үүнийгээ нөхөхийн тулд их гүрний дээрэнгүй гэж хэлж болох бодлогоо үргэлжлүүлэхийг санаархах, эдийн засгийн гол салбарууддаа төрийн монополийг сэргээх, олон улсын эдийн засаг, зах зээлийн харилцаанд төдийлөн зохицохгүй бодлого явуулах, хувийн өмчийн том компаниуд нь үндсэндээ 1990-ээд оны замбараагүй хувьчлалаар бараг луйврын аргаар улсын өмчийг үнэгүй шахам авах замаар байгуулагдсан, дээр нь түүхий эдийн гадагшаа чиглэсэн асар их

урсгалыг далд эдийн засгийн аргаар бий болгож хэмжээлшгүй их хөрөнгө мөнгийг гадаадын банкнуудад төвлөрүүлсэн, энэ бохир мөнгөө хөгжиж буй орнуудын эдийн засагт хөрөнгө оруулалт хийх, дэмжих туслах нэрээр угаах, түүнчлэн эдийн засагт үр ашигтай ажиллах арга барилд суралцахын оронд аль болох луйвар хийх, сүрдүүлэх, боож хяхах, цаашлаад террорист гэж хэлж болохуйц аргыг өргөн хэрэглэдэг орон гэж гадаадын нэр хүнд бүхий олон эрдэмтэд, шинжээчид, олон улсын байгууллагууд дүгнэх болсныг анхаарах нь бас зөв юм.

Эцсийн дүндээ ОХУ-ын геополитикийн ашиг сонирхлын орон зайг болж өгвөл тэлэх, үүний тулд эхлээд ОХУ-ын дотоод нэгдлийг баталгаажуулах, дараа нь ТУХН, юуны өмнө түүний Аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагын гэрээний орнуудын хүрээнд цэргийн эвсэл холбоо байгуулах, цаашдаа ШХАБ-ын хүрээнд НАТО болон Зүүн Азийн өндөр хөгжил бүхий орнуудыг хязгаарлах орон зай бий болгох зорилго бүхий бодлого явуулж байгаа нь тодорхой байна.

Сүүлийн үед ОХУ, НАТО-г өргөтгөхийн эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэллээ. Үүний тулд НАТО-гийн эсрэг холбоотон байж болох улс орныг эрж хайх, зарим улс оронд ялангуяа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улсуудад үүндээ нэгдэхийг хатуу, зөөлөн янз бүрийн хэлбэрээр тулгах байдал ч ажиглагдаж эхэллээ. Энэ нь хуучин социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан улс орнуудад, түүний дотор Монгол улсад ямар нэг хэлбэрээр хамаарч болохыг үгүй гэх баталгаагүй болно. ОХУ-ын өндөр албан тушаалын зарим хүний ярианд ийм санаа цухалзах болсон нь бас ажиглагдаж байгаа юм.

НАТО-гийн эсрэг үйл ажиллагаандаа Хятад улсыг гол холбоотноо болгохоор бүхий л хүчин чармайлтаа гаргаж байгаа энэ үед ОХУ-ын цэргийн бодлогод Монгол улс ямар нэг тодорхой байр суурь эзлэх нь ерөнхийдөө ойлгогдож эхэлж байгаа болно. Ер нь Монгол улсаас бусад оронтой түүний дотор АНУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах ямар нэг алхам хийгдэхэд Оросын албаны зарим хүн туйлын эмзэг хандаж хүлээж авдагаас энэ нь харагддаг болно.

Дээр дурдсан зүйлүүдийг нэгтгэн дүгнэж үзэхэд бүхэлдээ Орос улсын төр, засгийн зүгээс Монгол Улсын хувьд найрсаг, сайн хөршийн уламжлалт харилцааг

цаашид хөгжүүлж стратегийн түншлэлийн түвшинд дээшлүүлж, бүх талын хамтын ажиллагааг төгөлдөржүүлэн, ялангуяа худалдаа, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг идэвхжүүлж үр ашгийг дээшлүүлж, олон улсын тавцан дээр уламжлалт хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх зэрэг гол чиглэлийг баримталж байгаа нь тодорхой юм.

Үүний зэрэгцээ сүүлийн үед Оросын Засгийн газар болон түүний зарим төв байгууллагын төлөөллийн хүмүүсийн үг хэллэгээс манай орныг өөрийн улс төрийн холбоотон байлгах сонирхлоо дахин сэргээхийг оролдсон, эдийн засгийн ашиг сонирхлоо алдахгүй байхын тулд тулгасан, барьцаалсан үйл ажиллагаа явуулж болзошгүйг ойлгуулсан, цэрэг-улс төрийн салбарт хамтран ажиллах бодлогоо хэвээр баримталж байгаагаа янз бүрийн хэлбэрээр илэрхийлсэн зэрэг цаашдаа улс төрийн эрсдэл үүсгэхээр сөрөг үр дүн авчирч болзошгүй зүйлүүд ажиглагдаж эхэлснийг анхаарах нь зүйтэй болж байна.

#### 3.1.3.4. Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын асуудал

ОХУ болон БНХАУ-ын зүгээс явуулж буй Төв Ази, Зүүн Хойд Ази болон түүний эргэн тойронд орших орон зайд улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагааны шинэ харилцааг бүрдүүлэх оролдлогын нэг тодорхой илэрхийлэл нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын идэвхжиж буй нэгдсэн бодлого, үйл ажиллагаа хэмээн Монгол Улс ойлгож байгаа болно.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь Монгол Улсыг бүрэн хүрээлсэн болон ойр зэргэлдээ орших улс орнуудаас бүрдэж байгаа бөгөөд түүнд цөмийн зэвсэг бүхий том гүрнүүд багтаж байгаа нь бидний зүгээс гадаад орчноо үнэлэхдээ өмнөхөөс өөрөөр хандахыг аргагүй шаардах боллоо.

Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын талаар баримтлах өөрийн гэсэн байр суурьтайг хэн бүхэн мэдэх билээ. ОХУ, БНХАУ-ын зүгээс энэ байгууллагад Монгол Улсыг идэвхтэй оролцуулах сонирхолтой байгаагаа илэрхийлж байсан боловч бид Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хөгжил, төлөвийг анхааралтай ажиглаж, харзнасаар байгаа юм.

Энэ нь юуны өмнө энэ байгууллага бүрэн төлөвшөөгүй, үүсэн байгуулагдах шатандаа яваа тул түүний хөгжлийн хандлагыг тодорхойлоход тодорхой цаг хугацаа хэрэгтэй байгаатай холбоотой юм. Нөгөөтээгүүр, энэ байгууллагыг голчлон цэрэг, улс төрийн болон аюулгүй байдлын өнцгөөс харах явдал бусад орны хувьд нэлээд түгээмэл байгаатай ч бас уялдаатай болно.

Сүүлийн жилүүдэд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага хамтын аюулгүй байдлаа хангах чиглэлээр үйл ажиллагаагаа ихээхэн идэвхжүүлж байгаа. Гэвч НАТО түүний Энхийн төлөө түншлэлтэй харьцуулбал түүний нэгдсэн зохион байгуулалтад орох чадвар сул, санхүүгийн эх үүсвэр тийм ч сайн биш, дээр нь олон улсын аюулгүй байдлын цөөнгүй асуудлуудаар энэ байгууллагын жинхэнэ болон ажиглагч гишүүн орнуудын үзэл баримтлал ихээхэн зөрөөтэй байгаа зэрэг нь уг байгууллага бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хүчтэй нөлөө үзүүлэхүйц чадавхтай болтол ихээхэн хугацаа хэрэгтэй болохыг харуулж байгаа юм. Нөгөө талаас Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь эцсийн дүндээ ОХУ, БНХАУ гэсэн хоёр их гүрний харилцаа, ашиг сонирхлын нийцлээс илт хамаарах бүтэцтэй гэдгийг бид бас сайн ойлгох учиртай болно.

Хэдийгээр Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь Төв Азийн бүс нутаг дахь АНУ болон өрнөдийн нөлөөг тэнцвэржүүлэх Хятад Оросын хэрэгсэл гэгддэг ч сүүлийн жилүүдэд болсон олон хэрэг явдал, түүний дотор Афганистан дахь террорист заналхийл гэх мэт олон асуудал дээр гишүүн улсууд нь нэгдмэл бус байр суурьтай байсан нь түүний энэ талын чадавх ихээхэн сул болохыг бас нотолж байгаа юм.

Үүний зэрэгцээ Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хандлага өргөжих төлөвтэй байгааг харгалзан бид энэ байгууллагын талаар баримтлах бодлого, байр суурь, хамтран ажиллах чиглэлээ гүнзгийрүүлэн боловсруулах шаардлага гарч байгааг бас ойлгож байна.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын өнөөгийн хөгжлийн байдлаас харвал цаашид улс төр, аюулгүй байдлын асуудлын сацуу эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүлэх чиглэлийн нэг болгох төлөвтэй байна. Энэ байгууллагын хүрээнд яригдаж эхэлж буй чөлөөт худалдааны бүс, ачаа тээврийн бодлогын зохицуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, байгалийн гамшигтай

хамтран тэмцэх, олон улсын терроризм, хил дамнасан гэмт хэрэг, хар тамхины наймааны эсрэг тэмцэх зэрэг асуудал нь манай улсын ашиг сонирхолтой зайлшгүй холбогдож байгаа юм.

Эдгээр үйл явцад хамрагдалгүй үлдвэл бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийн үйл явцаас хоцрох, бүс нутгийг хамарсан томоохон төслүүдийн гадна үлдэх эрсдэл байгааг бид бас тооцож байгаа болно.

### 3.1.3.5. Монгол Улс, НАТО-гийн харилцааны асуудал

НАТО нь Атлантын далайн хоёр эргийн улсууд харилцан бие биеийнхээ аюулгүй байдлыг хангахаар байгуулсан олон улсын гэрээний байгууллага юм. Гэтэл Зүүн Хойд Азид байрлалтай, хөгжлийн хувьд буурай Монгол оронтой НАТО-ийн зүгээс харилцаагаа хөгжүүлэх ямар ашиг сонирхол байна вэ, нөгөө талаасаа Монгол Улс НАТО-той албан ёсны харилцаа тогтоосноор манай орны аюулгүй байдлын болон хөгжлийн стратегид ямар нааштай өөрчлөлт гарч болох вэ, гэсэн хоёр асуулт байнга тавигдаж байгаа юм.

НАТО-гийн хувьд Монгол Улс энэ эвслийн орнуудын аюулгүй байдалд нөлөөлөхүйц шууд ашиг сонирхол бүхий улс орон биш юм. Харин улс төр, эдийн засаг, нийгмийн, түүний дотор батлан хамгаалах салбарын шинэчлэлийг ардчилсан орнуудын жишгээр амжилттай хэрэгжүүлж буй улсын хувьд социализмын дараах орнууд, ялангуяа Төв Азийн орнуудад үлгэр болох тод жишээ гэдгээрээ НАТО-ийн анхаарлыг татаж байгаа болох нь олон зүйл дээрээс харагддаг болно.

Монгол улсын оршин тогтнодог Зүүн Хойд Азид болон шууд хил залгадаг Төв Азид өнөөгийн байдлаар олон улсын аюулгүй байдал харьцангуй тогтвортой байгаа юм. Гэвч энэ бүс нутагт НАТО болон Европын орнуудын санааг зовоож байгаа тогтворгүй байдлыг үүсгэх багагүй тооны хүчин зүйлс байгааг бас тэмдэглэх хэрэгтэй юм. Эдгээр хүчин зүйлийг саармагжуулах, болзошгүй аюулаас, түүний дотор Солонгосын хойгийг тойрсон сөргөлдөөн хяналтаас гарах, ОХУ, БНХАУ-ын дотоод байдал, тэдгээрийн хоорондын харилцаанд хурцадмал байдал бий болохоос урьдчилан сэргийлэх зэрэг олон асуудал дээр НАТО болон

түүний бүрэлдэхүүнд багтдаг зонхилох орнуудын ашиг сонирхолтой Монгол Улсын ашиг сонирхол үндсэндээ нийлж байгаа юм.

Ер нь 1990 оноос хойш Монгол Улсын явуулж буй гадаад бодлогын гол агуулга нь өөрийн аюулгүй байдлын ашиг сонирхлыг олон тулгуурт гадаад бодлого, хөрш хоёр том гүрэнтэйгээ бүх салбарт найрсаг, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үүний зэрэгцээ олон улсын харилцааны хүрээнд гуравдагч хөршийн бодлогыг хүчтэй хөшүүрэг болгох замаар буюу бүс нутагт нэгэнт тогтсон олон улсын институц, бүтцээр дамжуулан хангахыг эрэлхийлж байгаа явдал юм. Энэ агуулгаараа НАТО-г манай ашиг сонирхлыг ханган баталгаажуулах чухал хүчин зүйл, гуравдагч том хөрш хэмээн үзэж болох талтай байна.

Манай хувьд НАТО-той харилцахад зайлшгүй харгалзан үзэх асуудал бол Орос, Хятадын үүнд хандах хандлагын хүчин зүйл юм. Товчдоо хэлэхэд одоогоор ОХУ нь НАТО-той хамтын ажиллагааны онцгой гэрээтэй бөгөөд хэдийгээр үйл ажиллагаанд нь төдийлөн оролцдоггүй боловч НАТО-ийн Энхийн төлөө түншлэлийн гишүүн орон юм. Монгол Улс НАТО-той албан ёсны харилцаатай болоход ОХУ-ын зүгээс хэрхэн хандах нь тусгайлсан судалгаа шаардах том асуудал бөгөөд эхний удаад хэлэхэд бид энэ зорилгоо тэдэнд хэрхэн зөв тайлбарлаж ойлгуулахаас их зүйл шалтгаална гэж бодож байна.

БНХАУ-ын тухайд бидний явуулсан олон судалгаа уг орны албаны хүмүүс болон судлаачидтай хийсэн удаа дараагийн уулзалтуудын явцад санал бодлоо солилцсон байдалдаа дүгнэлт хийж үзэхэд Монгол Улсыг НАТО-той тодорхой хэмжээгээр хамтран ажиллахад одоогоор шууд эсэргүүцсэн байр суурь Хятадын талд үгүй байгаа нь олон зүйл дээр ойлгогддог юм. Манай улс НАТО-той хамтран ажиллалаа гэхэд түүний жинхэнэ гишүүн болох асуудал тавигдахгүй гэж тэд ойлгодог, БНХАУ-ын хувьд Монгол НАТО-ийн харилцаа нь Хятадын аюулгүй байдалд нь нөлөөлөх сүрхий хүчин зүйл болж чадахгүй гэсэн байр суурьтай байдаг болох нь ерөнхийдөө мэдрэгддэг болно.

Монгол Улс НАТО-той харилцаж байгаа өнөөгийн байдлыг ерөнхийд нь дүгнэвэл 1998 онд манай талаас дэвшүүлэн тавьсан “Энхийн төлөө түншлэл-Монгол Улс” томъёолол эрх зүйн хүрээнд баталгаажуулах боловч амьдрал дээр бодитой хэрэгжиж байгаа гэж хэлж болохоор байна. Бүхэлд нь авч үзвэл НАТО-

той харилцаагаа хөгжүүлэх талаарх манай бодлогын мөн чанар нь Монгол Улс НАТО-тай хамтран ажиллах улс төр, эрх зүйн үндсийг оновчтой бүрдүүлэх, хөрш хоёр улсын эргэлзээ, дургүйцлийг төрүүлэхгүйгээр НАТО-ийн "Энхийн төлөө түншлэл" хөтөлбөрийн зарим арга хэмжээнд оролцоход оршиж тодорхой үр дүнд хүрч байгаа нь харагдаж байна.

НҮБ нь улс төрийн байгууллага учир дэргэдээ цэргийн хүчин үгүй юм. Ийм учраас Peace Enforcement буюу энхийг албадан тогтоох тухай НҮБ-ийн тогтоолыг сонирхогч гишүүн улсууд, түүний дотор Монгол Улс цэрэг хандивлан олон улсын хүчнийг зохион байгуулах замаар тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилго бүхий тодорхой үүргүүдийг гүйцэтгэдэг.

Peacekeeping буюу энхийг сахиулах ажиллагаа ч энэ зарчмаар явагддаг. НАТО цаашдаа ашиг сонирхол нь илэрхий хөндөгдөх зэргэлдээ бүс нутагтаа энхийг албадах, энхийг сахиулах гол хүчин болох хандлагатай байна. Үүний тод жишээ бол 1999 оны Косовогийн дайн, одоо үргэлжилж байгаа Афганистаны хэрэг явдал юм. Энхийн төлөө түншлэл байгуулагдсан үеэсээ эхлэн НАТО-ийн зүгээс хэрэгжүүлж байсан зэвсэгт мөргөлдөөнөөс сэргийлэх, хямралыг зохицуулах ажиллагааны идэвхтэй хэрэгсэл болж ирсэн байна.

Энхийн төлөө түншлэлийн практик ач холбогдол нь НАТО-ийн болон энэ түншлэлийн цэргийн хүчийг хамтарсан ажиллагаанд бэлтгэх гол хэрэгсэл болоход оршиж байгаа болох нь улам бүр тодорхой болсоор байна. Энэ нь IFOR /SFOR болон KFOR ажиллагаанд олон улсын цэргийн хүчнүүдийн нэгдсэн ажиллагаа амжилттай болоход Энхийн төлөө түншлэлийн хувь нэмэр их байснаар ойлгогдож байгаа юм.

Эдгээрт Монгол Улс ч өөрийн гэсэн хувь нэмрээ оруулсаар байгаа нь нэг талаасаа манай улсын аюулгүй байдлын олон улсын баталгаа болж байна хэмээн ойлгогддог боловч нөгөө талаасаа олон улсын харилцааны хүрээнд улс төрийн ноцтой эрсдэл үүсгэж болох зүйл юм гэдгийг хэлэх нь зүйтэй байна.

Өөр нэг асуудал бол Монгол Улсад учирч болзошгүй олон улсын улс төрийн эрсдэлээс сэргэмжлэх үүднээс Төв Азид олон улсын аюулгүй байдлыг хангахад НАТО, түүний Энхийн төлөө түншлэл болон ШХАБ-ын аль нь илүү үр



дүнтэй ажиллаж чадах вэ, гэдгийг тандан үндэслэлтэй дүгнэлт хийх нь ихээхэн чухал байж болох юм.

Ирээдүйд Төв Азид гарч болзошгүй мөргөлдөөнийг таслан зогсооход НАТО, түүний Энхийн төлөө түншлэл нь ШХАБ-аас ч илүү оройлох үүрэг гүйцэтгэж болох талтай нь одоогоос ажиглагдаж байгаа болно. Балканы хойгт явуулсан ажиллагаандаа дүгнэлт хийж Энхийн төлөө түншлэлийн орнуудын хүрээнд ирээдүйд НАТО тэргүүлсэн “Энхийн төлөө түншлэлийн орнуудын оперативын ажиллагаа” хэмээх номлолыг боловсруулж байгаа нь үүний нэг нотолгоо юм.

### 3.1.3.6. Солонгосын хойгийн асуудал ба Монгол Улс

Монгол Улс манай оронтой ойр дөт оршдог Солонгосын хойгт түгшүүртэй байдал үргэлжилсээр байгааг тус улсын аюулгүй байдалд нөлөөлөх нэг ноцтой хүчин зүйл гэж үздэг болно. Тийм ч учраас Солонгосын хойгийн асуудлыг эвийн аргаар шийдвэрлэх нь Монгол Улсын аюулгүй байдалд шууд эергээр нөлөөлж, олон улсын улс төрийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой байх болно гэсэн байр суурийг манай Засгийн газар баримталж байгаа нь үндсэндээ зөв зүйл юм.

Хоёр Солонгостой хоёултай нь найрсаг харилцаатай байдгийн хувьд Монгол Улс Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаахад бололцооны хэрээр тус дөхөм үзүүлэхийг зорьсоор ирсэн. Монгол Улсын хувьд цөмийн хөтөлбөрийн асуудлаарх зургаан талт хэлэлцээнд шууд оролцдоггүй хэдий ч, түүний үйл явцыг анхааралтай ажиглахын зэрэгцээ энэ хэлэлцээг цаашид Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын яриа хэлэлцээний механизм хэлбэрээр хөгжүүлэх, энэ тохиолдолд Монгол Улс уг хэлэлцээнд ямар нэг хэлбэрээр нэгдэх сонирхолтой байдгаа байнга илэрхийлж байдаг болно.

Солонгосын хойгт өрнөж байгаа үйл явцыг Монгол Улс, Монголын олон нийт анхааралтай ажиглан харж байдаг юм. Ингэхдээ Солонгосын хойгийн асуудлыг эвийн аргаар шийдвэрлэх нь юуны өмнө Зүүн Хойд Азийн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах нийтлэг ач холбогдолтой гэж бид үзэж байна. Зүүн Хойд Азид хоёр Солонгос, Япон, Хятад, Орос, Монгол гэсэн зургаан

орон багтдаг. Үүнээс үүдэн өөрсдийн оршин тогтнож байгаа энэ бүс нутагтаа өрнөж байгаа үйл явцад бололцооны хэрээр оролцох, маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд хүчин зүтгэлээ нэмэрлэх нь Монгол Улсын гадаад бодлогын идэвх санаачилгын асуудал, энх тайван, аж төрөхийн төлөө санаа тавьсан хэрэг, бүс нутгийн өмнө хүлээсэн үүрэг, бас НҮБ-ын бүрэн эрхт гишүүнийхээ нэр төрийг бодсон явдал гэж бид ойлгодог болно.

Гэхдээ аль нэг тал руу хэт туйлширсан байдлаар хандах нь төдийлөн зохистой биш гэж манай төр, засаг, ард иргэд бас үздэг болохыг энд хэлэх нь зүйтэй юм. Учир нь одоогоос 15 жилийн өмнө боловсруулж баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-д бүх улс оронтой найрамдалт харилцааг хөгжүүлэхийг зорьсон олон тулгуурт гадаад бодлого баримтална гэдгийг тов тодорхой заасан байдаг болно.

Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэхэд энэ бүс нутгийн нэг улс орны хувьд Монгол Улс санал санаачилга, идэвх зүтгэл гаргаж, идэвхтэй хамтран ажиллах нь бүрэн бололцоотой асуудал юм. Бүс нутгийн орнууд, ялангуяа энэ асуудалд онц нөлөөтэй манай өмнөд хөрш БНХАУ манай энэ санаачилгыг ойлгон хүлээж авдагт бид байнга талархаж байдгийг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.

Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийн тухайд бол энэ талаар Монгол улс тов тодорхой, өөрийн гэсэн байр суурьтай юм.

Энэ асуудлаар баримталж байгаа Монгол Улсын бодлого нь үндсэндээ хоёр хэсгээс бүрдэж байна. Нэгд: Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид бүс нутаг байлгахыг бид нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа явдал. Хоёрт: Солонгосын хойгт бий болсон өнөөгийн нөхцөл байдлыг хүчээр, яаран өөрчлөх гэсэн оролдлого нь асуудлыг улам хурцатгаад зогсохгүй, зэвсэгт мөргөлдөөнд хүргэх аюултай гэж манай улс үзэж байгаа болно. Иймд Хойд Солонгосыг олон улсын тавцанд ганцаардуулахгүй байхыг чухалчилна гэдгээ Монгол Улсын төр, засгийн удирдлага албан ёсоор зарласан бөгөөд, Солонгосын хойгийн асуудлыг бодитойгоор шийдвэрлэхийн тулд Хойд Солонгосыг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд аажмаар боловч татан оролцуулах нь илүү үр дүнтэй

бөгөөд энэ нь тус улсын цөмийн хөтөлбөрийн асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын нэг чухал хэсэг болж болох юм .

Монгол Улсаас Хойд Солонгостой харилцаа холбоогоо идэвхжүүлж, улс төрийн түвшин дэх яриа хэлэлцээг тогтмолжуулах чиглэлээр авч буй арга хэмжээ нь дээр дурдсан бодлогын илрэл юм. Хоёр орны харилцааны эдийн засгийн агуулгыг өргөжүүлж, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагааг тодорхой төслийн хэлбэрт оруулан хөгжүүлэх, түүндээ гуравдагч улс орныг татан оролцуулах чиглэл баримтлахыг манай улс чармайж байна.

Дээрх үйл ажиллагаа нь манай улс ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцад олсон амжилт, туршлагаа, үүнд ардчилсан чиг баримжаа бүхий гадаад ертөнц ямар дэмжлэг үзүүлснийг Хойд Солонгосын нөхдөдөө алгуурхан боловч танилцуулах зорилго агуулагдаж байгааг ч нуух шаардлагагүй юм. Үүний зэрэгцээ сүүлийн үед БНАСАУ-ын байр суурь зөөлөрч, түүний шинэ их удирдагч Ким Жон Ун Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид бүс болгох тухай саналаа зарлаж байгааг бид бас нааштай харж, анхаарах нь зүйтэй нь юм.

#### 3.1.4. Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал

Эрсдэл судлалын онолд улс төр, эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн гэх мэт салбарыг үнэлэх үзүүлэлт, хэмжүүр, арга, аргачлалын тухай ерөнхий, нийтлэг арга зүйг авч үздэг. Гэхдээ “эрсдэлийн үнэлгээ” хийх тохиолдол бүр нь тус тусын онцлогтой, арга зүйн ач холбогдол нь өөр, хэмжүүр, шалгуур үзүүлэлтүүд нь янз бүр байдаг болно.

Үүний дотор улс оронд тохиолдож болзошгүй улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг гадаад, дотоод нөхцөл байдалд үндэслэн хийдэг байна.

Гадаад нөхцөл байдалд үндэслэсэн улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг НҮБ болон олон улсын мэргэжсэн байгууллагуудаас янз бүрийн үзүүлэлтээр тогтоосон тусгайлсан индексийн тоон утгуудыг ашиглан

явуулдаг байна. Эдгээр үзүүлэлтийн индексийн тоон утгаар олон улсын дараалуулсан жагсаалтад өөрийн улсын эзэлж буй байраар, тухайлбал: хүний эрх, эрх чөлөөг хангаж буй байдал, хүн амын дундаж наслалт, дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд ногдох хэмжээ, улсын гадаад, дотоод өр, зээлдэх чадвар гэх мэтээр өөрийн орны эрсдэлийн түвшнийг мэдэх бололцоотой юм.

Олон улсын мэргэшсэн агентлагуудаас гаргасан янз бүрийн үзүүлэлтийг эрсдэлийн үнэлгээнд ашиглахдаа зөвхөн сөрөг нөлөө үзүүлэх хэм хэмжээ, түвшнийг харгалзан үздэг болно. Тухайлбал, Стратегийн үнэлгээ, тооцоо ба удирдлагын олон улсын лиг, Ирээдүй судлалын олон улсын академи, Эдийн засгийн стратегийн хүрээлэн хамтран дэлхийн тэргүүлэх зиндаа бүхий 50 улсын нэгтгэсэн чадавхын даяаршлын рейтингийг тогтоосон байдаг. Энэхүү төслийн арга зүйн үндсийг улс орныхоо стратегийн эрсдэлийг үнэлэх арга зүйг боловсруулахад ашиглаж болох юм.


Тиймээс энэхүү даяаршлын рейтингийг тогтоосон арга зүйн үндсийг ойлгох үүднээс түүний мөн чанарыг энд товч дурдах нь зүйтэй юм. Улс орнуудын нэгтгэсэн чадавхын даяаршлын рейтингийг тогтооход, олон хүчин зүйлсийн загварчлал “стратегийн матриц” болон дэглэлтийн арга, графикийн онол, тодорхой бус логикийн онолын хэсгийг ашигладаг. Эдгээр улсын хөгжлийн урьдчилсан таамаглал, байдал (статус)-ын үнэлгээг “Стратегийн матриц”-ын загвараар гаргахдаа дараах есөн үзүүлэлтийг ашигладаг байна. Үүнд: удирдлага, нутаг дэвсгэр, байгалийн нөөц, хүн ам, эдийн засаг, соёл ба шашин, шинжлэх ухаан ба боловсрол, зэвсэгт хүчин, гадаад бодлого (геополитикийн орчин)-ыг багтаадаг болно. Судалгаагаар гаргасан үр дүнг графикаар нэгтгэхдээ тойрогт 9 өнцөгт геометрийн дүрлэлийг ашигладаг байна. Ингэхдээ тухайн улсын өнөөгийн байдлыг ойрын 15-20 жилд хүрэх хөгжлийн төлөвтэй харьцуулан графикаар дүрсэлдэг юм. Графикт улс орнуудын зиндаа, түвшнийг харгалзаж 4 бүлэгт хувааж, тэдгээрийн төвшинд тоон утгыг гурван төвшнөөр харгалзуулдаг байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

## Шинжээчийн үнэлгээний суурь тоон утга

Улсуудын зэрэглэл	Тоон утгын төвшин		
	дунджаас доогуур	дундаж	Дундаас дээгүүр
Супер их гүрэн	8	9	10
Их гүрэн	5	6	7
Бүс нутгийн их гүрэн	2	3	4
Бага улс	1		

Дотоод нөхцөл байдалд үндэслэсэн улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг үндэсний аюулгүй байдал, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үнэлгээнд тулгуурлан хийдэг. Энэхүү стратегийн эрсдэлийн үнэлгээг дараах гурван хэлбэрээр буюу туйлын (төр, нийгэм, хувь хүний язгуур эрх ашигт хор уршиг учруулах магадлалын үнэлгээ), харьцангуй (үзүүлэлт бүрийн тоон болон чанарын үнэлгээгээр зэрэглэл тогтоосон үнэлгээ), нэгдмэл (нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодит төлөв байдлын үнэлгээ) байдлаар хийдэг байна.

Дотоод нөхцөл байдлаас үүдэлтэй улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлд улс төрийн эрсдэл багтдаг. Тухайлбал, тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдалд дотоод улс төрийн аюул нь өнөө үед, тодруулж хэлбэл сонгуулийн үр дүнгийн талаар маргаан үүсэн үед тэргүүн эгнээнд гарч ирж болох юм. Нийгэмд төрийн эрх баригч нам, эрх барих магадлалтай улс төрийн хүчнийг дэмжих хандлагад гэнэтийн өөрчлөлт гарах нь бас байдаг болно. Энэ нь сонгуулийн үед болон дараагаар нь хямрал гарч болзошгүйг харуулдаг байна. Ялангуяа сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл явцын тодорхойгүй байдал, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий цагдаа, шүүх засаглалын шударга бус байдал зэргийг энд хамааруулан дурдаж болох юм.



Зураг 3.2. Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн төвшинд нөлөөлөгч хүчин зүйлсийн тогтолцоо

Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох үзүүлэлтэд нийгэм, дотоод улс төрийн амьдралын зааг дээрх зарим аюулыг багтаагаагүйг тэмдэглэж байна. Тэдгээр нь нийгэм, улс төрийн шинж чанартай учир нийгмийн салбар дахь эрсдэлүүдийн тухай хэсэгт багтаан авч үзэх нь зохимжтой хэмээн үзсэн болно.

Эрсдэлийн онол, арга зүйг удирдамж болгохын зэрэгцээ хөрш зэргэлдээх болон коммунизмын дараах улсуудад улс төрийн стратегийн эрсдэлийн үнэлгээ хийж буй туршлага, сургамжийг үндэслэх юм бол үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжилд учирч болзошгүй гаднаас нөлөөтэй улс төрийн эрсдэлийн үнэлгээ хийх үзүүлэлтүүдийг тогтоож болохоор байна. Ийм үзүүлэлтэд:

- Дэлхийн тэргүүлэх болон хэт их гүрнүүдийн хоорондын зөрчил, тэргүүлэх байр суурийн төлөөх тэмцэл өсөх;
- Ази, Номхон далайн бүс нутагт цэрэг-улс төрийн хурцадмал байдал бий болох;
- Олон улсын терроризмын аюул нэмэгдэх;
- Урд хөршийн хүчин чадлын өсөлтийн сөрөг нөлөө үүсэх;
- Хойд хөршийн цэрэг-улс төрийн байдал хямралд өртөх;
- Хууль бус цагаачлал ихсэх, дүрвэгсэд бий болох;
- Улс орны батлан хамгаалах хүчин чадал, Зэвсэгт хүчний бэлэн байдал, байлдах чадвар доройтох;

Эдгээр үзүүлэлт нэг бүрээр улс төрийн салбарт учирч болох эрсдэлийн түвшнийг нэгтгэсэн байдлаар гаргаж болох ч үзүүлэлт нэг бүрээр мөн улс төрийн салбарын эрсдэлийн үзүүлэлтүүдийг гаргаж болно. Ингэхдээ цэрэг-улс төрийн хүрээний гадаад аюул, түүнээс үүсэх эрсдэл нь улс төрийн салбар дахь бүх эрсдэлүүд дотор голлох байр суурь эзэлдэг гэдгийг бага орны хувьд байнга санаж байх учиртай юм.

Өмнөх хэсэгт дурдсан бүхнийг харгалзан үзээд улс төрийн салбарт учирч болох эрсдэлийг үнэлэх үзүүлэлтүүдийн зэрэглэл, эрэмбийг тогтоож болох бөгөөд тэдгээрийн улс орны тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл ойрын, дунд болон алс хэтэд хэрхэн өрнөх магадлалыг тогтоож болох юм. Үүнд л улс төрийн салбарт учирч болзошгүй таамаглал, үнэлгээний арга зүйн үндсийг судлахын Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад, дотоод таатай нөхцөл байдлыг бүрдүүлэхийн ач холбогдол оршиж байна.

### 3.1.5. Улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, үндэсний ашиг сонирхол, хөгжлийн бодлогод нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж үзэхэд ойрын болон дунд хугацааны ирээдүйд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, төрийн байгуулалтад гаднаас цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул, үүнээс үүдэн гарч болзошгүй эрсдэл үндсэндээ байхгүй байна. Манай улсын олон улсын нэр хүнд сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн, хөрш хоёр оронтойгоо элдэв маргаантай асуудлаа аль эрт, олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд эцэслэн шийдвэрлэсэн, энэ хоёр улстай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин хөгжиж байгаа нь ийм дүгнэлтэд хүргэж байна.

Үүний зэрэгцээ бүс нутгийн хүрээнд үүсэн Монгол Улс татагдан орж болох эсвэл гадаад, дотоод аливаа хүчин зүйлээс үүдэн дотоодод үүсэж болох дараах эрсдэлүүд бодитойгоор оршсоор байгаа нь бас харагдаж байна.

Бүс нутгийн олон улсын байдлаас үүдэн үүсэж Монгол Улс татагдан орж болзошгүй улс төрийн эрсдэл:

- Олон улсын терроризм улам бүр хүрээгээ тэлж Зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийг, түүний дотор Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамрах;
- Улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил нь Ази тивд цэрэг-улс төрийн нөлөөллөө өргөжүүлэх түүний эрмэлзлийг



араасаа дагуулан үүний улмаас үүнтэй ижил төстэй ашиг сонирхол бүхий ОХУ болон АНУ-тай ноцтой, өргөн хүрээтэй зөрчилдөхөд хүргэх, үүнд нь Монгол Улс татагдан орох;

- Хоёр Солонгос, Хятад-Тайвань, Энэтхэг-Пакистан хоорондын эсрэг тэсрэг байр суурь, Курилийн арлуудын талаарх Орос-Японы маргаан улс хоорондын харилцааны тодорхой нөхцөл байдалд зэвсэгт мөргөлдөөнд хүргэх. Энэ нь бүс нутгийг хамарсан шинжтэй болж өргөжин Монгол Улсыг ямар нэг хэлбэрээр хамрах;
- Ази, Номхон далайн бүс нутагт улам бүр өсөн нэмэгдэж буй АНУ-ын цэрэг-улс төр, эдийн засгийн нөлөөг хязгаарлах үүднээс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн үйл ажиллагаа өргөжин үүний үр дагавраар НАТО, АНУ болон Шанхайн хамтын ажиллагааны байгууллага хооронд цэрэг, зэвсгийн хүчийг тулгуур болгосон зөрчил, сөргөлдөөн үүсэж үүнд Монгол Улс татагдан орох;
- 2008 онд тохиолдсонтой төсөөтэй нийтийг хамарсан эдийн засгийн хямрал Ази тив болон Зүүн хойд Азид бий болж энэ нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах буюу зогсонги байдалд оруулах;
- Хөрш зэргэлдээ болон бусад оронд үүссэн хямралт байдлаас үүдсэн хяналтаас гарсан цагаачлал, жирийн болон зэвсэглэсэн дүрвэлтэд нэрвэгдэх зэрэг болно.

Гадаад нөхцөл байдлаас үүдэн улс төрийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн тухай төсөөлөл:

#### Улс төрийн хүрээнд

- Гадаад, дотоод элдэв хүчин зүйлийн түүний дотор бусад орны чиглэл зорилго бүхий гео стратегийн бодлогын нөлөөллөөс болж улс орны тогтвортой, тэнцвэртэй хөгжлийн бодлого, алдагдах, аль нэг улс, улс төр-цэргийн эвсэл холбоо эсвэл үндэстэн дамжсан том корпорацуудаас хэт хараат байдалд орох;

- Өөр бусад орны, юуны өмнө хөрш улсуудын жишгийг дуурайх үүднээс ард түмний тодорхой хэсэг парламентын засаглалд ямар нэг хэлбэрээр итгэл алдрах болж засаглалын өөр хэлбэрийг хүсэмжлэгчдийн тоо нэмэгдэх, улмаар Үндсэн хуулийн хямралыг бий болгож, хөгжлийн чиг баримжааны талаар тодорхойгүй байдлыг үүсгэх;
- Улс төрийн тогтворгүй байдал удаан хугацаагаар үргэлжлэх, нийгмийн шударга бус байдал давамгайлах, ядуурал ихсэх зэргийг хөрш орнуудын нөхцөл байдалтай харьцуулан үзэх замаар хүн амын зүгээс төр засаг, хууль сахиулах байгууллагад итгэх итгэл алдрах, Эх орноороо бахархах үзэл бүдгэрч бүхэлдээ гутранги, идэвхгүй сэтгэлгээ нийгэмд ноёрхох, эдгээрээс үүдэн нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх, хуулийн бус арга хэрэгслийг хүсэмжлэх уур амьсгал бий болох, үүнийг нь дэмжих, дэвэргэх улс төрийн болон цэргийн хүч гарч ирэх.

#### Эдийн засгийн хүрээнд:

- Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, үндэсний ашиг сонирхолд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж үзэхэд ойрын болон дунд хугацааны ирээдүйд гадаадын ямар нэг том гүрний зүгээс Монгол Улсын эдийн засгийг шууд хараат байдалдаа оруулахыг эрмэлзэх бодлогын үүдэлтэй оролдлого гарах магадлал үндсэндээ байхгүй байна.  
Үүний зэрэгцээ дотоодод үүсэн эдийн засгийн гадаад харилцаанд, улмаар Монгол Улсын олон улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болох дараах аюулууд бодитойгоор оршиж байгаа нь бас харагдаж байна.
- Эдийн засгийн цэгцтэй бодлого алдагдан амьжиргааны хүрээнд ядуурал газар авч, нийтийг хамарсан хямрал үүсэх;
- Эдийн засагт байгаль орчинд халтай уул уурхайн олборлох үйлдвэрлэл, бэлчээрийн мал аж ахуйд суурилсан үр ашиг багатай хөдөө аж ахуй, худалдааны эргэлтэд өргөн хэрэгцээний барааны бөөний болон жижиглэн худалдаа хэт давамгайлах, дотоодын нийт бүтэгдэхүүний үйлдвэрлэлд ахуйн үйлчилгээний болон хөдөө аж ахуйн салбар нийлбэр дүнгээрээ голлох, хэрэглээний салбарт импортын бүтээгдэхүүн, экспортод түүхий эд, боловсруулалт хийгдээгүй бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзлэх;

- Дэд бүтцийн хөгжил удаашрах, эрчим хүч, хүнсний болон өргөн хэрэгцээний барааны импортоор хөрш орнуудаас хараат байдалд орох;
- Төр засаг өр зээлд ихээр орж, валютын нөөцөө алдах, барьцаалуулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтын тэнцвэр алдагдах, зээл, тусламжийг замаас нь завших явдал газар авснаас үүдэн гадаад орнууд, түүний дотор том гүрнүүд энэ төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээ зогсоох;
- Үйлдвэрлэх хүчний мэдлэг, мэргэжлийн түвшин, үйлдвэрлэлийн харилцааны өнөөгийн байдал нь шинээр үйлдвэрлэлд нэвтэрч буй технологийн шаардлагад нийцэхгүй болж, эдийн засгийн хөгжилд чөдөр тушаа болох;
- Авилаг газар авч эдийн засгийн хөгжлийн зохицуулалтыг үр дүнгүй болгоход хүргэх. Үүнээс үүдэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хуулийн хүрээнээс гадуур явуулах нь нийтлэг болж далд эдийн засаг цэцэглэх зэрэг болно.

#### Нийгмийн хүрээнд:

- Улс төрийн тогтворгүй байдал удаан хугацаагаар үргэлжлэх, нийгмийн хөгжил удаашрах, шударга бус байдал газар авах гэх мэт элдэв шалтгаанаар төрийн хууль ёсыг дээдлэн хүндлэх монгол сэтгэлгээ алдагдаж байгааг гаднаас дэвэргэх, хүн амын зүгээс төр засаг, хууль сахиулах байгууллагад итгэл алдрах, үүнээс үүдэн төр суларч, нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх, ард түмний чөлөөт сонголтоор байгуулагдсан төр, засгийг Үндсэн хуулийн бус аргаар огцруулахыг хүсэмжлэх үзэгдэл газар авах, үүнийг дэмжих, дэвэргэх улс төрийн болон цэргийн хүч гарч ирэх.
- Хүн амын тодорхой хэсэг оюун санаа, эрүүл мэндийн доройтлын хэмжээнд хүрэхүйц ядууралд орох, боловсролын салбар хоцрогдолд нэрвэгдэх, иргэдээ эрүүлжүүлэх, гэгээрүүлэх замаар улс орны чанар, чансааг сайжруулах бодлогын хэрэгжилт удаашрах, тасалдах, улмаар хөрш хоёр болон хөгжиж буй бусад орноос ихээхэн хоцрох;
- Гадаад орнуудын зарим найдваргүй түншүүдтэй хамтран ажилласнаас үүдэн хуурамч, хадгалах хугацаа хэтэрсэн, хүний бие организмд хортой хүнс, эм тариа, хувцас, эд хэрэглэл гэх мэт зүйлүүд гаднаас орж ирэх, дотоодод үйлдвэрлэгдэх нь хяналтаас гарах, гадаад харилцаа өргөжиж

- хүн, мал, бараа бүтэгдэхүүний урсгал чөлөөтэй болох хэрээр элдэв халдварт өвчин тархах, үүний дотор ДОХ, нэн халдварт бусад өвчнөөр өвчлөгсдийн тоо өсөх;
- Улс орны хэмжээнд үндэстэн дамнасан, зохион байгуулалттай эрүүгийн нөхцөл байдал хяналтаас гарах, эдгээр гэмт хэргийн том бүлэглэлүүд бий болох, манай улсын нутаг дэвсгэрийг мансууруулах бодис, элдэв төрлийн зэвсэг, цөмийн түүхий эд, материал, хүн худалдаалахаар зөөвөрлөх, дамжуулах талбар болгох оролдлого гарах, тэдгээрийн хор уршиг нь улс орны улс төр, эдийн засгийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрэх.

Соёл иргэншлийн хүрээнд:

- Чөлөө завгүй нөлөөлж буй барууны болон күнзийн сургаалд тулгуурласан дорнын хүч түрэлтээс үүдэн соёл иргэншлийн үнэт зүйл болсон монгол сэтгэлгээний доройтол, оюун санааны мухардмал байдал гүнзгийрэн үүнээс үүдэлтэй нийгмийн зөрчил сөргөлдөөн үүсэх;
- Ахас дээдсээ хүндэтгэх уламжлалт зан заншил алдагдан ахмадууд ба залуусын үзэл бодлын ялгаа ихсэх, үүнээс үүдэн элдэв зөрчил сөргөлдөөн гарах болж тэдний хооронд харилцан үл ойлголцох явдал газар авах;
- Эх орноо гэсэн эрхэм сэтгэлгээ ядууралд орох, үүний улмаас нийтийн дунд гутрангуй, идэвхгүй байдал нэмэгдэх;
- Хүмүүсийн оюуны соёл, боловсрол, мэдлэгийн төвшин ерөнхий хандлагаараа буурах, зааг ялгаа нь өсөн нэмэгдэх, улмаар бүх нийтийг хамарсан бүдүүлэг зан суртахуун, соёлгүй байдал нийгэмд ноёрхох;
- Нийгмийн болон оюун санааны шинийг сэтгэх чадвар саатаж, улс орны хөгжлийг хазаарлах түвшинд хүрэх;
- Удмын сан бохирдох, угсаа гарвалиа эрхэмлэхээ болих;
- Монгол Улсын гадаад харилцаа өргөжих, нээлттэй болох хэрээр бусад орны амьдрах хэв маяг, эрхэмлэх үнэт зүйлсийн хүчтэй нэвтрэлт бий болох, үүнээс үүдэн үндэстний үнэт зүйлсийн үнэлэмжид эргэж буцалтгүй өөрчлөлт гарах;
- хүн төрөлхтний нийтлэг соёлыг дээдлэх, бусад шашныг хүндэтгэх үзэл болон монгол үндэстний төрөлх хэл, соёл, бурхны шашин, ёс заншил, удмын сан, угсаа гарвалиа хадгалан хамгаалах гэсэн эрмэлзлийн хооронд

зөрчил, сөргөлдөөн үүсэх, энэ нь улс төржих замаар нийгэмд бухимдал үүсгэх зэрэг болно.

Байгал орчны хүрээнд:

- Дэлхийн цаг уурын дулаарал, өөрчлөлт болон бусад шалтгаанаас үүдэн байгалийн гамшигт үзэгдлүүд олшрох энэ нь улс орны эдийн засаг, нийгэмд дааж давшгүй хохирол учруулах;
- Гаднын хөрөнгө оруулалтад хэт дулдуйдсан эдийн засгийн хөгжил түүний дотор уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийг эрчимжүүлэх явцад байгалийн тэнцвэр алдагдах, ус, гол мөрөн, агаар мандал, хөрс бохирдох, ой сүйдэх, цөлжилт газар авах. бэлчээрийн талхидал, тариалангийн талбайн хомсдол ихсэх, эдгээрээс үүдэн хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариалангийн хөгжил зогсонги байдалд орох;
- Гаднын хөрөнгө оруулалттай үйлдвэрлэлийн болон бусад орноос ирсэн ажиллагсдын хүнийрхэг зан, хариуцлагагүй, эмх замбараагүй байдлаас үүдэн байгаль орчинд ноцтой хохирол учрах, нөхөн сэргээгдэх бололцоогүй байдалд хүрэх.

3.1.6. Батлан хамгаалах салбарт учирч болзошгүй эрсдэл

Батлан хамгаалах салбарт учирч болзошгүй эрсдэлийн тухай ойлголт.

Монгол Улсад төр, нийгмийн шинэчлэл эрчимтэй өрнөж, ард иргэд оюун санааны хүлээснээсээ тайлагдан, улс орны өнөөгийн болон ирээдүйн хувь заяатай холбоотой олон зүйл, түүний дотор дайн, цэрэг, армийн тухай асуудлаар өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсноос хойш нэлээд олон жил өнгөрлөө. Ингэснээр энэ асуудлыг нийт иргэдийн санаа бодол, хүсэл эрмэлзэлд нийцүүлэн ухаалгаар шийдвэрлэх нөхцөл тодорхой хэмжээгээр бүрдэн бий болсон юм.

Үүний зэрэгцээ энэ асуудалд хөнгөн хуудуу хандах, түүнийгээ шинжлэх ухааны үндэслэлээр биш, сэтгэлийн хөдөлгөөн, хувийн төөрөгдөл, шуугиан

дэгдээх, зарим үед улс төрийн байр сууринаас илэрхийлэх нь бас тохиолдсоор байна.

Энэ нь нэг талаасаа олон ургалч үзлийн тод илрэл, гайхаад эмзэглээд байх зүйл биш боловч нөгөө талаасаа цэргийн аюул, зэвсэгт хүчин, түүний чиг үүрэг, нийгэмд эзлэх байр суурь гэх мэт төрийн бодлогын түвшинд яригддаг, улс орны оршин тогтнохын хувь заяатай холбоотой нэр томъёонуудыг янз бүрийн утга агуулгаар ойлгох, өөрийнхөөрөө тайлбарлах, тэр тусмаа түүндээ тулгуурлан бодлого боловсруулах, ямар нэг үйл ажиллагаа явуулах нь туйлын осолтой зүйл бөгөөд ихээхэн хор уршиг, сөрөг үр дагавар дагуулж болзошгүй талтай болно. Жишээлбэл, зарим нэг хүний хэлж байгаагаар Монгол Улсад учирч болзошгүй цэргийн эрсдэл байхгүй гэдэг үзэл бодлыг төрийн бодлогын төвшинд хүлээн зөвшөөрвөл зэвсэгт хүчин огт хэрэггүй мэт болох ба нөгөө талаас ийм эрсдэл өнөө маргаашгүй нөмрөөд байна гэж нотлоод байвал улс орноо бүхэлд нь дайнд бэлтгэх шаардлага үүсэж болох жишээтэй юм.

Одоогоор манайд батлан хамгаалах салбарт учирч болзошгүй эрсдэлтэй холбогдуулан цэргийн аюул, цэргийн заналхийлэл гэсэн хоёр нэр томъёо нэлээд түгээмэл хэрэглэгдэж ихэнх тохиолдолд тэдгээрийг адилтган ойлгож байна. Гэтэл эдгээр нь хоорондоо эрс ялгаатай хоёр өөр утгыг агуулдаг болохыг цэргийн шинжлэх ухаан тодорхойлдог.

Цэргийн аюул гэдэг нь тухайн улс, үндэстний эсрэг зэвсэгт өдөөн хатгалга, түрэмгийлэл үүсэж болзошгүй буюу аливаа дайн, зэвсэгт тэмцэлд татагдан орох, өртөж болох нөхцөл байдлыг тодорхойлсон ерөнхий ойлголт юм. Энд аль нэг улс, үндэстэн, нийгмийн хэсэг бүлгийг болзошгүй дайснаа гэж тодотгодоггүй онцлогтой.

Харин дайныг үзэх өнөөгийн байр сууринаас үзвэл цэргийн заналхийлэл гэдэг нь тухайн улс үндэстний эсрэг зэвсэгт өдөөн хатгалга, түрэмгийлэл хийж болзошгүй нь тодорхой болсон бодит этгээдийн бодлого, үйл ажиллагааны тухай ярихад хэрэглэгддэг нэр томъёо болно.

Энэ утгаараа цэргийн аюул гэдэг нь хүний нийгмийн өнөөгийн бодит зүйл бөгөөд ийм аюулаас айхгүй, эмзэглэхгүй баталгаатай болсон улс орон гэж бараг байхгүй нь тодорхой байна. Үүнийг дараах хэдэн зүйлээр нотолж болох юм.

Дэлхийн болон бүс нутгийн улс орнуудад олон янзын эрх ашгийн зөрчил үе үе хурцдаж, заримдаа зэвсэгт мөргөлдөөнд хүрч байгаагийн дээр төрөл бүрийн зэвсгийн асар их нөөц хуримтлагдсан, цэргийн хүчирхэг бүлэглэлүүд оршсоор, тэдгээрийг улс төрийн зорилгоор хэрэглэх сэтгэлгээ хараахан арилаагүй, Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэх үйл явц эхлэлийн төдий байна. Социализм нийгмийн тогтолцооны хувьд үгүй болж, ЗХУ задран тарснаар олон улсын харилцааны зөрчил сөргөлдөөн улам бүр бүс нутаг, улс, үндэстэн хоорондын шинжийг агуулах болж харин ч тэдгээрээс үүдэлтэй, хязгаарлагдмал хүрээтэй зэвсэгт мөргөлдөөн, хилийн будилаан гарах болзол өсөх хандлагатай байгааг олон орны судлаачид тэмдэглэсээр байна.

Үүний зэрэгцээ Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн болон БНХАУ-ын дотоод улс төрийн байдал, ялангуяа үндэстэн ястан, шашин шүтлэгийн үүдэлтэй зөрчил тэмцэл, эдийн засгийн хямрал хурцдаж, эдгээр орнуудад, социалист, капиталист үзэл суртал, улс төрийн ардчилсан сэтгэлгээ, хуучныг баримтлагчдын хооронд ширүүн тэмцэл явагдсаар байна. Ер нь улс хоорондын харилцааны олон туйлт нөхцөл бий болсон нь орон нутгийн чанартай дайн, зэвсэгт мөргөлдөөн гарах бололцоо өргөжих нөхцөлийг харин ч нэмэгдүүллээ гэж ихэнх шинжээчид үзэж байгаа юм. Ойрх Дорнод, Кавказ, Өмнөд, Төв болон Зүүн өмнөд Азид болж байгаа хэрэг явдлууд, тэдгээрийн өрнөлт үүнийг тод нотолсоор байна.

Цэргийн аюул бүрмөсөн хэдийд үгүй болох тухайд бол энэ нь цэргийн хэрэгсэл ашиглан шийдвэрлэхэд хүргэж болзошгүй, улс хоорондын бүх зөрчил арилж, улс үндэстэн цэрэг армия тарааж, зэвсэг байлдааны хэрэгслээ нэгэн зэрэг устган, цэргийн үйлдвэрүүдээ зогсоон, иргэний хэрэгцээт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шилжүүлэн, дахин хэзээ ч дайн хийхгүй гэдгийг өөр хоорондоо дэлхийн хэмжээнд батлан тунхаглаж гэрээ байгуулсан цагт байж болох зүйл юм.

Мэдээж хэрэг ийм цаг үе ойрын хэдэн арван жилд лав ирэхгүй нь тодорхой учир хүссэн ч хүсээгүй ч цэргийн аюулаас сэргэмжлэх асуудал улс орон бүрийн, түүний дотор Монгол Улсын төрийн бодлогын нэг чухал асуудал хэвээр байх нь ойлгомжтой байна.

### Батлан хамгаалах салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ.

Өнөөгийн олон улсын цэрэг, улс төрийн байдалд сүүлийн жилүүдэд хийсэн дүн шинжилгээнүүд ойрын ирээдүйд Төв болон Зүүн хойд Азид нийтийг хамарсан том дайн, түүний дотор Монгол Улсын эсрэг шууд түрэмгийлэл гарах болзол тун бага гэдгийг харуулж байгаа болно. Үүний зэрэгцээ эдгээр бүс нутагт орон нутгийн чанартай, тодорхой хэсэг газар нутаг, үндэстэн ястныг хамарсан багахан дайн байлдаан гарах болзол улам нэмэгдсээр, ийм дайн байлдаанд Монгол Улс өртөх буюу татагдан орохгүй гэсэн баталгаа өгөх цаг хараахан болоогүй байгаа нь бас ойлгомжтой байгаа юм.

Ийм ч учраас хэдийгээр Монгол Улсад шууд заналхийлсэн дайны аюулд өртөх эрсдэл өнөөдөртөө байхгүй боловч түгээмэл ойлголтоороо манай улсад учирч болзошгүй цэргийн аюул бодитойгоор оршсоор байна гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсын батлан хамгаалах бодлого ч ийм ойлголтод тулгуурлаж байгаа бөгөөд дэлхий нийтээр эмээж байгаа цэргийн аюулыг шууд Монгол Улсыг хөндсөн цэргийн заналхийлэл болгон хувиргахгүй байх бүх бололцоог бүрдүүлэх нь дээрх бодлогын үндсэн агуулга болж байгаа юм. Үүн дээр тулгуурлан Монгол Улсын аюулгүй байдлыг хангах гол арга зам нь улс төр, дипломатын аргаар дайныг сэргэмжлэн зайлуулах, түүний дотор хойд, урд их хөршүүдтэйгээ энх амгалан байдлыг сахин харилцаж, Монгол Улсын тусгаар тогтнолын олон улсын эрх зүйн баталгааг бий болгох явдал гэдгийг хууль, тогтоомж, үзэл баримтлалуудаар баталгаажуулсан байгаа.

Цэргийн аюул гэдэг үгийг цэргийнхэн голчлон ярьдаг. Зарим тохиолдолд тэднийг өөрсдийнхөө оршин тогтнох эрхийг баталгаажуулахын тулд цэргийн аюул гэдэг зүйлийг дэвэргэн ярьж байгаа юм гэх хүмүүс ч тааралддаг. Үүний хариу болгож “ ... цэргийн хүмүүс магадгүй хэнээс ч илүүгээр дайн, гамшгийн хор



уршгийг ойлгож түүнийг битгий болоосой, цэрэг хувцсаа тайлаад энхийн хөдөлмөрт шилжих юмсан гэж хүсдэг” гэж олон орны судлаачид бичдэгийг хэлэх нь зүйтэй юм. Үүний зэрэгцээ бидний оршин амьдарч байгаа ертөнц ээдрээтэй хэвээр байгаа, монголчуудын түүхэнд эрх чөлөө, тусгаар тогтнолоо алдаж, харийн хүний хараанд орж байсан гашуун үе цөөнгүй байсан, иймд төр, засгийн энх тайвны эрмэлзэл, энхийг сахих бодлого ардаа цэрэг, армид тулгуурласан баталгаатай байх ёстой гэдгийг цэргийнхэн бусдаас илүү ойлгодог байж болох талтай юм.

Монгол Улс дайн зовлонд өртөхгүй бол цэрэг, армитай байгаагийн эцсийн зорилго биелэх юм. Аливаа зүйлийг болзошгүй гэж бодож бэлтгэснээр муу юм болохгүй. Харин болж магадгүй гэсэн хамгийн өчүүхэн таамаглал байсан цагт түүнээс хамгаалах заавал бэлтгэлтэй байдаг зүйлийн тухай ярьж байгаад хэргийн учир орших болов уу.

Үүний тулд Монгол Улс өөрийгөө хамгаалах чиг үүрэг бүхий цомхон бүрэлдэхүүнтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, зэвсэгт хүчнийг бүрдүүлэх, улс орныг батлан хамгаалах гэдгийг дан ганц цэргийн утгаар ойлгодгоосоо салж улс орноо болзошгүй дайнд бэлтгэхийн зэрэгцээ цэрэг, армия олон улсын энхийг сахиулах болон терроризмтой тэмцэх, ард иргэдээ байгалийн болон бусад гамшиг зовлонгоос авран хамгаалахад бэлэн байлгах, ард түмний үр хүүхдийг эх орондоо үнэнч, тэсвэр хатуужилтай, бие бялдрын өндөр хөгжилтэй, хүнийг хайрлах, өмгөөлөх үзэлтэй болгон сургаж хүмүүжүүлэх зорилгоор төрөөс хэрэгжүүлэх улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүй, цэргийн иж бүрэн үйл ажиллагаа гэдэг талаас нь ухаарах нь зөв бололтой.

Бид зөвхөн ийм замаар л үндэсний аюулгүй байдлаа хангах нэн чухал асуудал болох батлан хамгаалах зорилтыг шийдвэрлэж чадах бөгөөд бусад улс орон ч манайхыг улс шиг улс гэж хүлээн зөвшөөрч хүндэтгэн харилцах болно.

Түүхийн ихэнх үед Монгол цэрэг нь дан ганц дайн байлдаан хийхийн тулд биш, өвөг дээдсийнхээ өвлүүлсэн газар шороо, тусгаар тогтнол, ёс заншил, хүн ардаа хэнээс ч болов өмгөөлөн хамгаалахад бэлэн гэдгээ бусдад ойлгуулан мэдүүлэх, ард түмнээ гал, усны гашуун зовлонгоос авран туслах ариун үүрэгтэй

байсан гэдгийг бид байнга санаж байх ёстой бөгөөд цэрэг армия тийм болгон өөрчлөх учиртай билээ.

### Батлан хамгаалах салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, үндэсний ашиг сонирхолд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж үзэхэд ойрын болон дунд хугацааны ирээдүйд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, төрийн байгуулалтад гаднаас цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул үндсэндээ байхгүй байгаа тухай дээр дурдсан.

Манай улсын олон улсын нэр хүнд сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн, хөрш хоёр оронтойгоо элдэв маргаантай асуудлаа аль эрт, олон улсын эрх зүйн хүрээнд эцэслэн шийдвэрлэсэн, энэ хоёр улстай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин хөгжиж байгаа нь ийм дүгнэлтэд хүргэж байгаа юм.

Үүний зэрэгцээ өнөөдөр бий болоод байгаа аюулгүй байдлын гадаад орчин, дотоод нөхцөл байдалд цэргийн шинжлэх ухааны байр сууринаас дүгнэлт хийж үзэхэд бүс нутгийн хүрээнд үүсэн Монгол Улс татагдан орж болох эсвэл гадаад, дотоод аливаа хүчин зүйлээс үүдэн дотоодод үүсэж болох цэргийн аюулыг энэ бүлгийн 3.1.5-д дурдсан улс төрийн салбарт учирч болзошгүй стратегийн эрсдэлтэй уялдуулан шинээр тодорхойлон дараах байдлаар томъёолж болмоор санагдаж байна. Ер нь цэргийн аюул нь үндсэндээ улс төрийн салбарт бий болсон эрсдэлт нөхцөл байдлын шууд үр дагавар хэлбэрээр илрэн гардаг юм. Үүнд:

### Бүс нутгийн хүрээнд үүсэн Монгол Улс татагдан орж болзошгүй цэргийн аюул:

- Олон улсын терроризм улам бүр хүрээгээ тэлж, орон нутгийн дайн, өргөн хүрээтэй зэвсэгт мөргөлдөөн хэлбэрээр Зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийг, түүний дотор Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамрах;

- Улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил нь Ази тивд цэрэг-улс төрийн ашиг сонирхлоо өргөжүүлэх түүний эрмэлзлийг араасаа дагуулан үүний улмаас үүнтэй ижил төстэй ашиг сонирхол бүхий ОХУ болон АНУ-тай ноцтой, өргөн хүрээтэй зөрчилдөхөд хүргэж энэ нь зэвсэгт мөргөлдөөний хэлбэрт шилжих, үүнд нь Монгол Улс татагдан орох;
- Хоёр Солонгос, Хятад-Тайван, Энэтхэг-Пакистан хоорондын эсрэг тэсрэг байр суурь, Курилийн арлуудын талаарх Орос-Японы маргаан улс хоорондын харилцааны тодорхой нөхцөл байдалд зэвсэгт мөргөлдөөнд хүргэх. Энэ нь бүс нутгийг хамарсан шинжтэй болж өргөжин Монгол Улсыг ямар нэг хэлбэрээр хамрах;
- Ази, Номхон далайн бүс нутагт улам бүр өсөн нэмэгдэж буй АНУ-ын цэрэг-улс төр, эдийн засгийн нөлөөг хязгаарлах үүднээс ШХАБ-ын цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн үйл ажиллагаа өргөжин үүний үр дагавраар НАТО, АНУ болон энэ байгууллага хооронд цэрэг, зэвсгийн хүчийг тулгуур болгосон зөрчил, сөргөлдөөн үүсэж үүнд Монгол Улс татагдан орох;
- Хөрш зэргэлдээ болон бусад оронд үүссэн хямралт байдлаас үүдсэн хяналтаас гарсан цагаачлал, жирийн болон зэвсэглэсэн дүрвэлт, зугтагсдын хөлд нэрвэгдэх, тэдгээрийг мөрдөж хөөсөн гадаад орны цэргийн анги, байгууллагууд Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмрөн орж ирж зэвсэгт мөргөлдөөн үүсэх;
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа гадаад орнуудын эзэмшлийн объектууд, тэдгээр орны иргэдийг хамгаалах нэрээр бусад улсын цэрэг хил нэвтрэн орж ирж дайн байлдаан үүсгэх;
- Хөрш хоёр орны хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэн тохиолдолд Гадаадын цэргийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай Монгол Улсын хуулийг зөрчин эдгээр орны аль нэгийн цэргийг өөрийн нутагт оруулснаас үүдэн түүнтэй дайсагнагч гуравдагч орны цэрэг хил нэвтрэн орж ирж зэвсэгт мөргөлдөөн үүсгэх, эсвэл сөргөлдөгч талуудын аль нэг нь хүчээр түрэн

цэргээ оруулж ирэх тохиолдолд түүний эсрэг болон түүнтэй дайсагнагч гуравдагч орны цэрэгтэй зэвсэгт тэмцэл явуулахад хүрэх

Дотоод нөхцөл байдлын хямралтай уялдаатайгаар батлан хамгаалах салбарт үүсэж болох эрсдэлийн таамаглал:

Улс төр, нийгмийн тогтворгүй байдал удаан хугацаагаар үргэлжлэх тодорхой нөхцөлд засаглалын өөр хэлбэрийг хүсэмжлэгчдийн тоо нэмэгдэж, хүн амын зүгээс төр засаг, зэвсэгт хүчин, хууль сахиулах байгууллагын эсрэг сэтгэлгээ газар авах, эдгээрээс үүдэн нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх, хуулийн бус арга хэрэгслийг хүсэмжлэх уур амьсгал бий болох, үүнийг нь дэмжих, дэвэргэх улс төрийн болон цэргийн хүч гарч ирэх, улмаар иргэний дайн дэгдэх буюу цэргийн эргэлт хийх оролдлого гарах зэрэг цэргийн аюул үүсэж болох дотоод хүчин зүйл, стратегийн гэж хэлж болох эрсдэл бас байгаа болно.

### **3.2. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэл**

#### 3.2.1. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн тухай ойлголт

Эдийн засгийн салбарт үүсэж үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй аливаа аюул, заналхийлэл нь шилжилтийн үед гарцаагүй ажиглагддаг төрийн бодлогын түвшинд гардаг бодит учир шалтгаантай болон бодит бус алдаануудаас үүдэлтэй байдаг болно. Ойрын ирээдүйн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх магадлалтай эдгээр аюул, заналхийлэл нь Монгол Улсын хувьд яах аргагүй улс оронд учирч болзошгүй эрсдэлийн шинж чанарыг агуулж байгаа нь тодорхой байна.

Аливаа улс үндэстэн, бүс нутаг, тив, дэлхийн аюулгүй байдал нь эдийн засагтай улам бүр нягтаар холбогдох болж, түүнийг шийдвэрлэх гэсэн оролдлогууд нь тулгамдсан олон асуудлыг ар араасаа дагуулсаар байна. Ийм учраас бүх улс орон өөрийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд онцгойлон анхаарахын зэрэгцээ эдийн засгийн салбар дахь стратегийн эрсдэлийн үнэлгээ, таамаглалд ач холбогдол өгдөг боллоо.

Улс орны эдийн засаг нь ямар ч нийгмийн байгууллын үндэс, хүн амын амьдралын төвшин, улсын нийгэм, улс төрийн амьдрал, аюулгүй байдал, батлан хамгаалах хүчний бодит түвшин, чадавхыг тодорхойлж байдаг. Ийм суурь чанар нь эдийн засаг дахь эрсдэлийг стратегийн шинж чанартай болохыг илтгэн харуулдаг. Стратегийн эрсдэлийн үнэлгээ, таамаглалын үндсэн асуудлын нэг нь эдийн засгийн салбар дахь стратегийн эрсдэлийн үнэлгээ юм. Нөгөө талаас улс орны эдийн засаг дахь өсөлт, бууралт нь олон хүчин зүйлээс хамааралтай, асар өргөн хүрээг хамарсан, урт удаан хугацааны үйл явц байдгаараа өөрөө стратегийн эрсдэлийн шинжийг агуулж байдаг болно.

Монгол Улсын эдийн засгийн хэвшил 1990-ээд оноос эхлэн эргэлтийн шинж чанартай өөрчлөлтөд орсон нь жинхэнэ утгаараа “үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмч”-ийг бий болгож “хөдөлмөрийн хуваарьт үндэслэсэн” нийгэм байгуулах “хүний хамтын ажиллагааны цорын ганц ажиллагаатай, үр нөлөөтэй, систем” болох чөлөөт зах зээлд шилжих бодит үндсийг бүрдүүлсэн юм. Чөлөөт зах зээл нь өмчийн чөлөөт байдалд суурилдаг бөгөөд өнөөгийн Монгол Улсад хувийн өмчийн чөлөөт байдал нийтийн буюу оюун санаа, үзэл бодлын эрх чөлөөнөөс илүүтэй үүрэгтэй байна. Нийтийн өмчийг дээдэлсэн, хувийн өмчийг үзэн ядсан “хуурамч” зан, үзэл бодолтой эрх мэдэлтнүүдийн зүгээс хувийн өмчтөнүүд, хөрөнгөжиж буй давхаргынхныг шахан хавчих, дарамтлах байдал бүр мөсөн арилаагүй байна.

Улс орны аж ахуй, эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх хууль эрх зүйн үндсийг Монгол Улсын төр, засаг үндсэнд нь сайн бүрдүүлж өгсөн юм. Энэ шилжилтийн үйл явц асар их бэрхшээл, хүндрэлтэй тулгарч, түүнийг даван гарахдаа олон эрсдэлд өртсөн болохыг монголын ард түмэн нүдээр үзэж, биеэр мэдэрсэн юм. Энэ шилжилтийн үйл явцад манай улсын нийгэм, эдийн засаг, санхүү хямралд орж, өмнөх амжилтаасаа олон жилээр ухарсан явдал ч гарсан. Энэ бол эдийн засаг дахь нэг томоохон эрсдэл байсан болохыг бид одоо л гүн гүнзгий ухаарч байна. Энэхүү эрсдэлд өртсөн үндсэн шалтгааныг материаллаг баялгийн хүрээнд хайхаасаа илүүтэй дөнгөж бүрэлдэж буй болж байсан хувийн өмчийн эрх чөлөөг хангах, зах зээлийн боломжийг түүнд нээж өгөх нийгмийн харилцаанд хэвшил болгоход учирсан бэрхшээлүүдээс олж харахыг эрмэлзэх нь зүйд нийцнэ хэмээн үзэж байна.

Шилжилтийн үед өмчид хүнийрхэг хандах өмнөх нийгмийн зуршил, социалист нийтийн өмчийн төлөөх нийгмийн “хуурамч” үзэл бодол, өмч эзэмших хүсэл тэмүүлэл, өрсөлдөөн хооронд хурц ширүүн тэмцэл явагдсан юм. Нэг ёсондоо өмчийн төлөөх тэмцлийг “өмч хувьчлал” гэсэн хаяг доор зохион байгуулалттайгаар өрнүүлсэн юм. Өмч хувьчлалын эцсийн үр дүнг харахад, хэн эрсдэлд оролгүй, илүү хувийн өмчтэй болсон вэ, гэвэл, нэгд, мөнгө, санхүү, материаллаг үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд ажиллаж байсан хүмүүс, хоёрт, эрх мэдэл бүхий албан тушаал хашигсад, гуравт, өмч эзэмшихийн төлөө эрээ цээргүй, нэр нүүргүй зүтгэгсэд, дөрөвт, үнэхээр ажилсаг, хөдөлмөрч, хичээл зүтгэл гаргагсад, нийгмийн идэвхтэй зарим хүн багтаж байна. Эдийн засгийн эрсдэлд өртөгсөд нь нэгд, энгийн сэхээтнүүд, хоёрт, улс, нийгмийн аюулгүй байдал, батлан хамгаалах чиг үүрэг бүхий албаныхан, гуравт, залхуу хойрго, нийгмийн халамж, нийтийн тусламж, дэмжлэг горьдогсод, идэвхгүйчүүд болжээ.

Сүүлийн хориод жилд, монголын эдийн засаг эрсдэлийн хурц ширүүн аянд, аваа өгөөтэйгөөр, боломж, сүйрлийн тэнсэн дунд, хөгжил дэвшил өөд тасралтгүй тэмүүлж явна.

Эдийн засгийн салбар дахь стратегийн эрсдэлийн үнэлгээ, таамаглал нь хүн амын амьдралын түвшнийг бууруулахгүй байх, үндэсний үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй байх, тэдгээрт сөрөг нөлөө үзүүлэх гадаад, дотоод хүчин зүйлсэд автагдуулахгүй байх, тогтвортой хөгжлийг хангах, түүний өрсөлдөх чадвар, харьцангуй бие даасан байдлыг хангах, гадаадын хөрөнгө оруулалтын зохистой харьцааг хадгалахад урьдчилсан анхааруулга өгөх ач холбогдолтой юм. Ялангуяа, өнөөгийн манай нээлттэй эдийн засаг, даяаршлын үйл явцад татагдан орж их гүрнүүд болон өндөр хөгжилтэй улсуудын нөлөөнд автагдаж байгаа нь энэ салбарт учирч болзошгүй эрсдэлийг эрс нэмэгдүүлж байна.

Эдийн засгийн салбар дахь үндэсний аюулгүй байдалд учирч болох аюул нь бодит болон бодит бус шалтгаанаас үүдэн гардаг бөгөөд тэр нь Монгол Улсын эдийн засгийн бодлого, үйл ажиллагаа дахь өнөө үеийн алдаа оноогоор тодорхойлогдог байгаа юм. Улс орны эдийн засаг нь улс орны амьдрал, үйл ажиллагаа, тогтвортой хөгжилд үргэлж нөлөөгөө үзүүлж байдаг, тогтолцоот чанартай, стратегийн шинжтэй үүргийг гүйцэтгэж байдаг.

Монгол Улсын эдийн засаг нь социализмын үед аж үйлдвэр (I) нэгдүгээрт, хөдөө аж ахуй (A) хоёрдугаарт, үйлчилгээ (S) гуравдугаарт гэсэн зэрэглэлтэйгээр (IAS) гэсэн тогтолцоогоор хөгжиж байлаа.

Нийгэм, төрийн байгуулалд хувьсгал гарч, ардчилал, чөлөөт зах зээлд шилжих болсон үеэс эдийн засгийн бодит салбарын үндэсний болон дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эзлэх байр суурьд чанарын өөрчлөлтүүд гарсан байна. Үүнийг шилжилтийн үеийн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөөр хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 3.3

Монгол Улсын эдийн засгийн бүтэц /хувиар/:

Үзүүлэлт	1995-1999	2000-2004	2005-2008	2009-2012	2013-2019
Нийт	100	100	100	100	
ХАА	38,4	23,6	20,9	21,2	
Уул уурхай	10,6	12,2	25,3	22,5	
Боловсруулах аж үйлдвэр	7,4	6,4	5,9	5,9	
Цахилгаан дулаан	3	3	2,7	2,6	
Барилга	2,6	2,4	1,9	1,2	
Үйлчилгээ	38	52,4	43	46,7	

Энэ үед үйлдвэрлэл уналтад орж, үйлчилгээний салбарын эзлэх хувь хэмжээ эрс өссөн бөгөөд өнөөг хүртэл бараг энэ байдлаа хадгалсаар SAI гэсэн тогтолцоонд шилжсэн байна. Харин сүүлийн үед уул уурхай хурдтай өсөж байгаа нь тогтолцооны гэхээсээ илүүтэй нь гаднын хөрөнгө оруулалттай холбоотой байна.

Уул уурхайн салбарт оруулж буй гадаадын хөрөнгө оруулалт ийм хурдтайгаар цаашид үргэлжлэх юм бол дэлхийн эдийн засагтай Монголын эдийн засаг нягт уялдаа холбоотой болох нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн даяаршилд татагдан орно гэсэн үг. Гэтэл даяаршлын үзэгдэл эдийн засгийн хөгжилд эергээр нөлөөлж, хөгжил дэвшлийн үндэс болохын зэрэгцээ эдийн засгийн стратегийн эрсдэл, сүйрэлд “татан оруулагч хүчин” болох

хандлага бас байгааг бид хатуу санах учиртай нь олон зүйл дээрээс ажиглагдаж байгаа юм.

Дэлхийн эдийн засаг нь өөрийн гэсэн хил хязгааргүй, газар нутгаар хязгаарлагддаггүй онцлог тогтолцоо юм. Үүний үр дүнд олон оронд баялгийн хуваарилалт тэгш бус, бас шударга бишээр явагдаж буй нь хүн амын дунд төдийгүй, улс үндэстний хооронд “баян - ядуу” гэсэн хоёр туйлд ялгарах, тэдний хооронд зөрчил, сөргөлдөөн үүсэх үндэс болж байна.

Эдийн засгийн үндэс нөөцийн хомсдолтой, эсвэл арвин их баялагтай байдал нь хэдийгээр тодорхой улс, нутаг дэвсгэр, бүс нутагт байдаг ч улс гүрэн, бүс нутаг тив хоорондын харилцаанд ордог, бодит борлуулалтад шилждэг. Энэ л учраас эдийн засгийн гадаад харилцаа үүсэн хөгждөг. Улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татдаг увдистай. Буурай хөгжилтэй улсын хувьд гол төлөв гадаадын хөрөнгө оруулалт давамгайлдаг байна. Энэ нь монопол, санхүүгийн экстремизм (хүчирхийлэл) гэсэн хоёр аюул, стратегийн эрсдэлийг үүсгэдэг байна.

Манай улсын эдийн засаг нь олон улсын хөрөнгө оруулалт, улс, үндэстэн дамнасан корпорацууд, банк, санхүүгийн эргүүлэгт өртөж байгаа учраас эдийн засгийн эрсдэлд өртөгдөх магадлал ихээхэн өндөр байна. Гадаадын хөрөнгө оруулалт хэт давамгайлбал тэдний монопол тогтох үндэс болдог билээ.

**Монопол нь** эдийн засаг дахь өрсөлдөөнөөс үүсэлтэй учраас зах зээлийн эдийн засгийн либерал хандлагыг гуйвуулдаг зүй тогтолтой. Монополчлол нь нэг талаас капиталын төвлөрөл, түүний үр дагавар, нөгөө талаас зах зээлийн чөлөөт өрсөлдөөн хумигдаж, ноёрхол тогтоох нөхцөл болдог. Монополтой чөлөөт зах зээл тэмцсээр ирсэн бөгөөд энэхүү тэмцэлдээ түүний хамгийн дургүй, монополыг эсэргүүцэгч төр, хууль зүйг тусламжаа болгодог. Гэсэн хэдий ч монопол өөрөө улс үндэстэн дамнасан даяар шинжтэй учраас нэг улс үндэстний төрийн эсэргүүцэл, хууль эрх зүйн хязгаарлалтад тийм амар өртдөггүй, үйл ажиллагааныхаа олон улсын шинж чанарыг тэлэн улам өргөжүүлдэг зүй тогтолтой байдаг. Энэ нь нэг улс үндэстний хүрээ хязгаараас хальж, түүнд удирдагдахгүй, захирагдахгүй, хязгаарлагдахгүй учир аль ч улс үндэстэнд эдийн засгийн хувьд хохирол учруулах, улмаар аюул нүүрлүүлэх хор уршигтай байдаг.




Монопол олон улс үндэстэн дамнасан компани, картели (холбоо), олон улсын банк, олон улсын бизнесийн болон хөрөнгө оруулалтын банкнууд, бусад санхүүгийн институтүүдээр дамжуулан мөнгө, санхүүгийн үйл ажиллагаагаа явуулдаг учраас аль нэг улс үндэстний ямар ч компанитай адил төстэй үйл ажиллагаанаас илүүтэй аюулыг өөртөө агуулдаг бөгөөд эцсийн дүндээ улс орны эдийн засгийн стратегийн эрсдэлийн нэг амаргүй үндэс болж байдаг. Монополууд ашгаа дээд зэрэгт (максимум) байлгахын төлөө байдаг. Ашиг бол нийт орлого, зардлын зөрүү гэдгийг бид бүгд мэднэ. Тэгэхээр монополууд эрэлт, нийлүүлэлтийн харьцаанаас хамааралгүй үнийг тогтоож, шударга бус аргаар илүү ашиг завшихын төлөө тэмүүлэн байдаг нь нийтлэг үзэгдэл юм.

**Санхүүгийн экстремизм** нь гадаадын хөрөнгө оруулалтын хоёр дахь аюул (хүчирхийлэл) юм. Энэ нь монополоос илүү өргөн хүрээтэй, далд ажиллагаатай, үр дагавар илүүтэй гэж судлаачид үздэг болно. Санхүүгийн экстремизм өнгөрсөн зууны 70-аад оноос анх үүсэж бий болсон эдийн засаг дахь нэг сөрөг үзэгдэл юм. Энэ нь олон улсын мөнгө (валют)-ний эталон алтны стандарт (алттай харьцуулдаг) хэмжүүрээс татгалзаж, валютын тогтолцоог ганцхан ам.доллартой уялдуулж түүнд эрх дарх олгосонтой холбоотой гэж тооцогддог юм. Америк доллар олон улсын худалдаа, солилцооны үндсэн хэрэгсэл болсон бөгөөд түүнгүйгээр солилцоо явагдахгүй нь тодорхой юм. Энэ л үеэс “мөнгөөр-мөнгө үйлдвэрлэх” үйл явц идэвхжиж, мөнгөний үйлдвэрлэл, материаллаг баялаг бүтээхээс салж, мөнгө өсгөх дамын наймаа “даяаршсан казино” явагдах болжээ. Үүний нэг баримт бол монгол дахь барьцаат үйлчилгээ (ломбард), банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод борооны дараах мөөг лугаа олширч, түүнчлэн элдэв төрлийн бонд гаргах аргаар буюу “мөнгөөр мөнгө босгогчид” материаллаг үйлдвэрлэлийн хүрээнээс тасарсан явдал юм.

Өнөө үед санхүүгийн зах зээлийн өсөлтийн хурд бодит эдийн засгийн хөгжлийн хурдцаас хэд дахин илүү болоод байна. “Мөнгөөр мөнгө босгогчид”-ийн хүрээ тэлж мөнгөөр үнэлэгдэх үнэт цаас, лиценз, зөвшөөрөлд хүртэл нэвтэрч байна. Энэ нь монголын эдийн засагт эрсдэл дагуулах бас нэг шинэ үзүүлэлтийг бий болгоод байгаа юм. Мөнгөөр мөнгө босгох аргаар ашиг олох үйл ажиллагаа явуулахад “зөвшөөрөл” олгодог механизм буй болсноос монголд авлига дэлгэрсэн гэж хэлж болох талтай юм. Авлига нь эдийн засгийн стратегийн эрсдэл

үүсгэх нэг эх сурвалж төдийгүй, Монголын төр, эдийн засгийг бүхэлд нь дампууруулж болох нийгмийн хорт үзэгдэл юм. Африк дахь ашигт малтмалын нөөц арвин улс орнуудын өнөөгийн хямралт байдлын сургамж үүнийг харуулж байна. Тэнд үүний улмаас дайн дажин үүсэж, улс орон нь утга учиргүй зэвсэгт мөргөлдөөнүүдийн хөлд нэрвэгдэж байна.

Дэлхийн болон үндэсний эдийн засгийн үйл ажиллагааны хүрээг дүрслэн үзэх юм бол дараах байдлаар илэрхийлэгдэж байна.



Зураг 3.3. Үндэсний ба дэлхийн (олон улсын) эдийн засгийн хүрээ, бүтэц

Дээрх дүрслэлээс бид юу олж харах вэ? Үндэсний эдийн засаг нь зөвхөн өөрийн улсын нутаг дэвсгэр, улсын хил хязгаарт хумигдаж, улс төр, эдийн засгийн дэг, бүтцэд захирагддаг, ганц дан байшин, эсвэл ердийн нэг хавтгай талбай шиг юм.

Тэгвэл дэлхийн (олон улсын) эдийн засаг нь үндэсний эдийн засагт үндэслэсэн, олон бүрдүүлэгч хэсэгтэй, улс үндэстний хүрээнээс гадна, эдийн засгийн хувьд “стратосфер”-т байрлах олон давхар, багтаамж ихтэй байгууламж лугаа юм.

Эдийн засгийн хөгжил, интеграци нь даяаршлын хөдөлгөгч хүч болж буй хэдий ч зөрчил дагуулагч юм. Энэ нь хэт их гүрэн үүсэх, капитал нэг туйлд хуримтлагдах, монопол төрөх, эдийн засгийн мөргөлдөөний дэг журам тогтоох үндэс болсоор байна.

Монопол, санхүүгийн экстремизм (хүчирхийлэл) нь аливаа нэг тодорхой улс үндэстний хувьд эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж олон тулгамдсан асуудлыг төрүүлдэг байна. Тухайлбал: эдийн засаг, улс төр, шинжлэх ухаан, технологи, нийгэм-соёл, оюун санааны хүрээнд сөргөөр нөлөөлж элдэв төрлийн эрсдэлүүдийг үүсгэдэг байна. Үүнийг дараах байдлаар илэрхийлж болох юм. Үүнд:

**Нэгдүгээрт, эдийн засгийн хүрээнд** капитал нь нэг талд хуримтлагдах, монопол үүсэх нь зайлшгүй үзэгдэл бөгөөд энэ нь улс үндэстний хүрээ, хил хязгаараас давж, олон улсын тавцанд гарна гэсэн үг юм. Үүнтэй зэрэгцээд капиталыг хэрэглэх орон зай тэлэгдэж, эдийн засгийн хөгжлийн төвшинд өөрчлөлт гарах, жигд бус байршуулалтын зөрүү өсөх, байгалийн чадавхын байршлыг жигд бус байлгах эрсдэлийг бий болгодог байна.

**Хоёрдугаарт, улс төрийн хүрээнд** томоохон капиталын ашиг сонирхол нь түүний олон улсын тавцанд гарах эрх чөлөө, нээлттэй эдийн засаг, чөлөөт хил, экспортын дэмжлэгийг шаардах бөгөөд төрийн бодлого нь ийм байдлыг дэмжих хандлага руу шилждэг. Ингэхдээ капитал эзэмшигч нь өндөр хөгжилтэй, үйлдвэрийн технологийн чадавх сайтай, чөлөөт капиталтай, үйлдвэрлэлийн хямд нөөцийг эзэмшиж байдаг учир хөгжил муутай, сул дорой улс үндэстний эдийн засгийг хүчээр либералчлах түрэмгий бодлогын механизмыг үүсгэдэг байна.

Үндэсний эдийн засгийг хэт нээлттэй болгох нь хамтрагч нарт ялангуяа бага улсын нөөцөд чөлөөтэй нэвтрэх, хэт их олз ашиг олох, хамгаалалтгүй шинэ орон зайг улам бүр хүсэмжлэх дуршлыг нь нэмэгдүүлдэг байна. Үүнээс улбаалж эдгээр бага оронд “кессоны өвчин” гэсэн нэр томъёотой үзэгдэл газар авч эдийн засгийн ноцтой эрсдэлүүд үүсдэг байна.

**Гуравдугаарт, шинжлэх ухаан, технологийн хүрээнд,** шинжлэх ухаан, техник, технологийн чадавх цөөн тооны өндөр хөгжилтэй улс гүрнүүдэд хэт төвлөрдөг нь бусад улс үндэстнийг техник, технологийн бодлогоороо дарамтлах, дарангуйлах, эрхшээх боломжийг олгодог байна. Үүнийгээ мэдээлэл-сүлжээний агуу их боломжид тулгуурлан монопол эрхтэйгээр сурталчилж, нийгмийн хуучинсаг сэтгэлгээ, уламжлалыг нь эвдэж, цаг хугацаа, орон зайн бэрхшээлийг нь давдаг байна.

**Дөрөвдүгээрт, соёлын хүрээнд,** зах зээлийн үнэт зүйлсийг дээдлэх зарчимд нугалаа гарах, материал, баялгийн хэрэглээнд уламжлалт бус түрэмгий хандлага үүсэх, материаллаг баялгийг бүтээх оролцоо багасах, шашин шүтлэгт хандах хандлага хувьсан өөрчлөгдөх, хүмүүсийн өдөр тутмын харьцааны соёлд уламжлалт бус хандлага, (ёс бус, бусармаг үйлдлүүд) үүсэж бий болох зэрэг олон хүндрэл бэрхшээлүүдийг болон цөөнгүй шинэ асуудлыг бага орнуудын нийгмийн өмнө босгон тавьдаг байна.

**Тавдугаарт, оюун санааны хүрээнд:** нийгмийн анхдагч элемент хувь хүн, хамт олны ухамсар оюун санаанд хүчтэй өөрчлөлтийг оруулж, эрхэмлэн дээдлэгч үнэт зүйлс нь өөрчлөгдөж, хувийн хүсэл, сонирхол нь амиа хичээсэн байдал руу гулсан хувьсдаг байна.

Ийнхүү эдийн засгийн чөлөөт зах зээл нь нийгмийн хөгжил, үйл ажиллагааг удирдах зохицуулж чадахгүй ч нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, нөлөөгөө үзүүлдэг байна. Энэ нь эдийн засгийн аюулгүй байдалтай ч хамааралтай болох нь тодорхой учир манай улсын хувьд эдийн засгийн салбар дахь стратегийн эрсдэлийн үнэлгээг үүнд чиглүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байгаа юм.

Монополын хязгаарлалт, төрөөс эдийн засаг, зах зээлд тавих хяналт, олон улс үндэстний эдийн засгийн нээлттэй байдал, олон улсын хоорондын хөдөлмөрийн хуваарилалт, байгалийн нөөц баялгийн жигд бус тархалт, ашиглалт, санхүүгийн чөлөөт капиталын хуримтлал зэрэг нь манай орны эдийн засгийг өөрийнх нь хил хязгаараас шахан гаргах, төрийн эрх мэдэл хүрэлцэхгүй, зохицуулах боломжгүй орон зай өөд түлхэх, улс үндэстний аюулгүй байдалд нөлөөлөгч хүчин зүйлс болон хувирч болох талтай байна.

Эдийн засгийг даяаршуулах хэрэгцээ нь аж үйлдвэр өндөр хөгжсөн улсуудад тохиолдож буй хүндрэл, бэрхшээлийг даван туулахад ашигтай чанарын шинэ нөхцөлийг бүрдүүлж өгдөг байна. Тийм улс оронд эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн 29 улс, Зүүн Өмнөд Азийн бар улсууд багтаж байна.

Хөгжиж буй орнууд, түүний дотор Монгол Улс энэхүү даяаршлаар эдийн засаг нь нэгдэн нягтрах үйл явцад тун багаар хамрагдаж буй бөгөөд харин түүхий эдийн баялаг нөөцтэй улсын хувьд хөгжлийн төлөөх тэмүүлээрээ татагдан орж байгаа юм. Цаашдаа ойрын ирээдүйд манай орон мэтийн дэлхийн улсуудын дөрөвний нэгийг эзэлдэг буурай хөгжилтэй орнууд даяаршилд хүссэн хүсээгүй ч татагдан орох хандлагатай байна.

Дэлхийн буюу олон улсын эдийн засгийг ажиглахад, түүний үйл явцад оролцогчид нь эдийн засгийн өрсөлдөөнд, вавилоны үеийн спортын тэмцээний ринг дээрх ямар ч дүрэмгүйгээр явагдаж буй тулалдаан шиг хамрагдаж байна. Энэ өрсөлдөөний гол хүч нь улс төр, эдийн засаг, цэргийн хүч болж байна. Улс төр-дипломат бодлого, цэргийн стратеги, тактик улам бүр эдийн засгийн агуулгатай байна.

Орчин үеийн олон улсын эдийн засаг нь бага буурай Монгол мэтийн орны хувьд өрсөлдөөнд үндэслэсэн сонгодог зах зээлээс, огт өөрөөр хөгжиж байгаа олон орны судлаачид хүлээн зөвшөөрөх болж байна. Чөлөөт зах зээлийн хандлагаар олон улсын эдийн засгийн хөгжлийн үндсэн зүй тогтлыг, бүр нарийвчилбал үндэстэн дамнасан үйл явцыг улам бүр тайлбарлах боломжгүй болсоор байна.

Дэлхийн (олон улсын) эдийн засаг, аж ахуйн нэгдэн нягтралт нь бодит үзэгдэл юм. Түүнд түмэн зөрчил оршиж, оролцогч улс үндэстнүүдийн ашиг сонирхолтой зөрчилдөж байна. Түүнийг дуртай ч бай, дургүй ч бай дагагчдын дуу хоолой нь нэгдмэл бус, шүүмжилсэн, эсэргүүцсэн, түүнийгээ ил тодоор илэрхийлсээр байгаа нь өдрөөс өдөрт, жилээс жилд улам бүр нэмэгдэж байна. Энэ нь олон учир шалтгаантай холбоотой юм.

Малайзийн Ерөнхий сайд асан И.Мохамедын “даяаршил нь хагас зууны тэртээд колониолоос гарч, эрх чөлөөгөө олсон улс үндэстнүүдийг дахин колонилох хэлбэр юм” гэсэн байдгийг энд дурдах нь зүйтэй гэж үзлээ.

Ер нь эдийн засгийг чөлөөлөх үйл явц аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад хоёр шатлалтай явагдсан байна. Дэлхийн II дайны дараагаас буюу 1947-1970-аад оны дундуур нэг дэх шат нь явагдсан бол хоёр дахь шат нь эрчим хүчний дэлхийн хямралыг давж гарахын төлөөх буюу 1980 –аад оны дунд үеэс явагдаж эхэлжээ. Үүнд нефть, нүүрс, ураны олборлолт, эзэмшилт, нийлүүлэлтийн өсөлт хүчтэй нөлөөлсөн юм.

Манай улсын эдийн засаг олон улс, үндэстэн дамнасан корпорацууд, банк, санхүүгийн эргүүлэгт бусдын адил өртөж байгаа учраас эдийн засгийн эрсдэлд өртөгдөхгүйн тулд, эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлт, хэмжүүр, шалгуур үзүүлэлтийг шинээр авч үзэхийг шаардаж байгаа нь судалгаанаас тодорхой харагдсан болно.

### 3.2.2. Эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт

Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг энэ салбарын аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар үнэлж дүгнэж болох бөгөөд энэ нь уг шалгуур үзүүлэлтүүд дотроос эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлд хамааруулан үзэж болох үзэгдэл, үйл явдлыг салган таних бололцоог олгож болох юм.

Үүний тулд олон орны судлаачид маш олон тооны шалгуур үзүүлэлтийг ашиглан эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн босго хэмжээг тоон хэлбэрээр харуулж байна. Эдгээр шалгуур үзүүлэлт нь өндөр мэдрэмж, хувирах чанартай учир улс, нийгэм, бизнесийн хүрээнд макро эдийн засгийн байдлын өөрчлөлтөөс гарах болзошгүй аюулыг урьдчилан сэргийлж, тухайн улсын Засгийн газраас нийгэм, эдийн засгийн бодлогодоо авах арга хэмжээг тодорхойлоход тус дэмжлэг болдог байна. Өөрөөр хэлбэл, эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь эдийн засгийн аюулгүй байдлын онцгой “эмзэг” цэгүүдийг илрүүлж, тэдгээрийг эдийн засгийн аюулгүй байдлын босго үзүүлэлтүүд болгон авч үзэх, ингэснээр эдгээрээс хэтэрсэн тохиолдолд нийгэм, эдийн засгийн

хэвийн хөгжилд саад учирч, үйлдвэрлэл, хэрэглээний салбар уналтад орж болзошгүйг анхааруулах бололцоог олгодог байна.

Төслийн судалгааны баг нь эдийн засгийн аюулгүй байдлын босго шалгуур үзүүлэлтүүдийг дараах 4 бүлэг болгон тодорхойлох саналыг дэвшүүлж байгаа юм. Үүнд:

1. Үндэсний эрх ашгийн зарчмын шинж чанарыг илэрхийлсэн, Монгол Улсын Засгийн газраас батлан мөрдөх макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
2. Эдгээр үндсэн үзүүлэлтүүдийг нарийсган тодорхойлж Эдийн засгийн хөгжлийн яамнаас батлан гаргах босго үзүүлэлтүүд
3. Салбарын яамдаас батлан гаргах тус тусын салбарын болон тодорхой үйл ажиллагааны түвшнийг илэрхийлсэн босго үзүүлэлтүүд
4. Бүс нутгийн эдийн засгийн аюулгүй байдлын босго үзүүлэлтүүд зэрэг болно.

#### Хүснэгт 3.4

Эдийн засгийн салбарт эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйлсийн шалгуур үзүүлэлт (хувиар)

№	Шалгуур үзүүлэлт	Босго	2008	2019
1	ДНБ-ний өсөлт, %	5	8.9	
2	Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрийн эзлэх жин	70	16.7	
3	Аж үйлдвэрийн салбарт машин зохион бүтээх үйлдвэрийн эзлэх жин	20	0	
4	Аж үйлдвэрийн салбарт инновацын бүтээгдэхүүний эзлэх хувь	15		
5	ДНБ-д шинжлэх ухаан, судалгааны ажлын зардлын эзлэх жин	2	0.2	
6	ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх жин	- 5	-5.0	
7	ДНБ-д гадаад өрийн эзлэх жин	40	...	
8	ДНБ-д импортын эзлэх жин	30	61.9	
9	Инфляцын түвшин	20	22.1	
10	ДНБ-нд гадаадын хөрөнгө оруулалтын эзлэх хувь	50		
11	ДНБ-д дотоодын хөрөнгө оруулалтын эзлэх жин	30		
12	ДНБ-нд мөнгөний эзлэх хувь			
13	ДНБ-д батлан хамгаалах зардлын эзлэх хувь	3		
14	Нийт экспортод түүхий эдийн эзлэх жин	60	61.9	
15	Нийт экспортод боловсруулсан бүтээгдэхүүний эзлэх жин	60		
16	Нийт экспортод уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх жин	60		
17	Хүнсний хэрэглээнд импортын эзлэх жин	30	41.1	

18	Нефтийн хэрэглээнд импортоор авч буй хувь	35	100	
19	Цахилгаан эрчим хүчний хэрэглээнд импортоор авч буй хувь	30	4.9	
20	Өргөн хэрэглээний барааны хэрэглээнд импортын эзлэх хувь	10	35.2	
21	Гурилын хэрэглээнд импортоор авч буй хувь	30	68.2	
22	Ашигт малтмалын нөөцийн өсөлт, багасалтын харьцаа хувь /Өсөлт гэдэг нь хайгуул хийж нэмж тогтоогдсон нөөц, багасалт гэдэг нь олборлосон хэмжээ/	125		
23	Монгол Улсын алтаар хэмжигдэх валютын нөөц			
24	Улсын валютын алтны нөөцийн улсын жилийн төсөвтэй харьцуулсан харьцуулалт	50 хувь		
25	Нэг хүнд ноогдох ДНБ-ны хувь			
26	Ажилгүйдлийн түвшин	5		
27	Ядуурлын төвшин (амьжиргааны баталгаажих түвшнээс бага орлоготой хүн амын эзлэх жин)	30		
28	Хүн амын дундаж мөнгөн орлогыг амьжиргааны доод түвшний хэмжээтэй харьцуулсан харьцуулалт	3,5		
29	Хамгийн өндөр орлоготой хүн амын 10 хувийг хамгийн бага орлоготой 10 хувьтай харьцуулсан харьцуулалт	8		
30	Хүн амын дундаж наслалт, нас	70	67.23	

Өнөөгийн бодит үзүүлэлтүүдийг эдийн засгийн аюулгүй байдлын босго үзүүлэлтүүдтэй харьцуулсан дээрх судалгаанаас харахад дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгө оруулалт, түүний идэвхжилт зэрэг нийгмийн амьдралд чухал нөлөө бүхий гол үзүүлэлтүүдээр манай орон эдийн засгийн аюулгүй байдлаа алдах зааг дээр байгаа нь тодорхой байна. Төгрөгийн ханш тогтмол унаж, гол төрлийн түүхий эдийн үнэ дэлхийд буурч байгаа үед энэ нь хямралын шинэ үүсвэр болох аюултай юм. Ард түмний амьдралыг мэдэгдэхүйц сайжруулах нь эдийн засгийн салбарын аюулгүй байдлыг хангах бодлогын үндсэн гол агуулга байдаг. Энэ үзүүлэлт л дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн босгыг болон үүнтэй холбоотой бусад босго үзүүлэлтүүдийг тодорхойлох үндэслэл болох учиртай болно.

Энэ үүднээс хүн амын нийгмийн байдлыг дараах 3 үзүүлэлтээр тодорхойлж болох байна. Үүнд:

1. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь




2. Хамгийн өндөр орлоготой хүн амын 10 хувийг хамгийн бага орлоготой 10 хувьтай харьцуулан үзсэн үзүүлэлт
3. Хүн амын дундаж орлогыг амьжиргааны доод түвшинд хуваасан харьцуулалт

Дэлхий нийтийн туршлагыг харахад: Хэрэв амьжиргааны доод түвшнээс доогуур амьдралтай хүмүүс хүн амын 7-10 хувиас илүүгүй, баян, ядуу хүмүүсийн орлогын ялгаа 10 хувиас хэтрээгүй байвал нийгэмд сөргөлдөөн гарах аюул харьцангуй бага байдаг байна. Олонх хөгжилтэй орнуудад бэлэн мөнгөний эргэлт дотоодын нийт бүтээгдэхүүний 60-80 хувийг, заримд оронд 100 болон түүнээс дээш хувийг эзлэх нь байдаг. Манай орны эдийн засгийн хөгжлийн өнөөгийн шатанд энэ үзүүлэлт 40-60 хувьтай байхад эдийн засгийн аюулгүй байдлын энэ босго үзүүлэлт хангагдаж болох талтай юм.

### 3.1.7.3. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал.

Эдийн засгийн салбар нь эрсдэлд өртөж, үйлдвэрлэлийн өсөлт нь зогсонги байдалд хүрч, ард түмний амьдралын төвшин нь доройтож, бүгд ядуу, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар доогуур байсан улсуудын тоонд социализмын дараах улсууд бүгд ордог бөгөөд үүний нэг нь Монгол Улс юм. Энэхүү эрсдэл нь үйлдвэрлэлийн хэрэгслийн өмчлөлд гаргасан алдаа, бүтээгдэхүүний өрсөлдөөнт чанарыг бодит байдал дээр үгүйсгэсэн, өмч, ажил үйлдвэрлэлийг эзэнгүйрүүлснээс үүдэлтэй байлаа. Энэхүү эрсдэлээс улбаалсан бэрхшээл, хатуу ширүүн нөлөөллийг даван туулахын тулд 1990-ээд оноос хойш манай улсын эдийн засаг зах зээлийн чөлөөт харилцаанд шилжих гэж үйлдвэрлэлийн уналт, доройтлыг үзэж, өдгөө жам ёсны хөгжлийн замд тууштай гарч чадлаа.

Эдийн засгийн стратегийн эрсдэлийн үнэлгээ, таамаглал нь улс орныхоо тусгаар тогтнол, бие даасан байдал, монгол түмний язгуур эрх ашгийг баталгаатай хангахад эдийн засгийн стратегийн бодлого, үйл ажиллагаанд чиглэх ёстой бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлын субъектүүдээс “өөрийгөө” хянах үндсэн арга зам нь болж өгнө хэмээн үзэж байна.



Монгол Улсын эдийн засаг өнөөдөр шилжилтийнхээ төгсгөлийн үе шатан дээр явж байгаа боловч түүний өрсөлдөх чадвар сул хэвээр байна. “Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан” (2019 он)-д өөрийн улсын өрсөлдөх чадварыг: эдийн засгийн тамир тэнхээ; засаглалын үр ашиг; бизнесийн байгууллагуудын ашигтай ажиллагаа; дэд бүтэц гэсэн дөрвөн үзүүлэлтээр, тэдгээрийг задлан тус бүрийг нь тав таван дэд үзүүлэлтээр, Монголтой адилавар газар зүйн байршилтай, коммунизмын дараах, хөгжлийн хувьд янз бүрийн 14 улсын дээрх үзүүлэлтүүдтэй харьцуулан үнэлгээ өгсөн байна.

Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэнгээс жил бүр эрхлэн гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан нь улс орнууд болон бизнес эрхлэгчид өөрсдийн чадавх, чадамжийг ашиглан хэрхэн илүү хөгжил цэцэглэлтэд хүрч буйг судлан эрэмбэлдэг. Энэ тайланд 327 шалгуур үзүүлэлт ашиглан, судалгаанд хамрагдсан дэлхийн 58 орон тус бүрийн өрсөлдөх чадварыг тал бүрээс нь харуулдаг. Энэхүү судалгааны үр дүнгийн гуравны хоёр (2/3) нь статистик тоо баримт, гуравны нэг (1/3) нь санал асуулгын мэдээлэлд тулгуурласан байдаг.

Дэлхийн өрсөлдөх чадварт Монгол Улсын эзэлж буй байр суурийг дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан болон энэхүү тайланд харуулсан 15 улсыг нэгтгэсэн эрэмбээс харж болно. Энэхүү тайланд Монгол Улс өрсөлдөх чадвараа Болгарын дараа, Украйны өмнө 14 дүгээр байранд оржээ. Харин үзүүлэлт тус бүрээр нь гаргавал: “эдийн засгийн тамир тэнхээгээр – 13; засаглалын үр ашиг болон бизнесийн байгууллагын ашигт ажиллагаагаар - 12; дэд бүтцийн хувьд – 15 дугаар байрыг тус тус эзэлсэн байна.

Эндээс бид эдийн засгийн аюулгүй байдал, түүний эрсдэлийг үнэлэх асуудалтай уялдуулан дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Монгол Улс нь эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвар сул, хөгжил буурай улсуудын нэг хэвээр байна;
2. Манай орны эдийн засаг шилжилтийнхээ үеийн төгсгөлд орж ирж байгаа ч түүний өсөлтөд гадаадын хөрөнгө оруулалт давамгайлж буй онцлогтой байна;
3. Гадаадын хөрөнгө оруулалтыг алсын хараатай, хөрөнгө оруулагчид, өөрийн ард түмний эрх ашгийг тэнцүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах стратегийг баримтлах учиртай хөгжлийнхөө үед ороод байна.

Дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал болон бусад дүгнэлтүүдээс харахад Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үндсэн хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- хүн амын бодит өсөлт улам бүр нэмэгдэж буй эдийн засгийн өсөлтийн хурдыг гүйцэхгүй байгаагаас яваандаа хөдөлмөр эрхлэх хүний тоо дутагдах байдал үүсэн, хүн амын хөгшрөлт ихсэж байгаа;
- амьжиргааны түвшнээс доогуур орлоготой хүмүүсийн тоо буурахгүй, баян ядуугийн ялгаа улам бүр нэмэгдэж байгаагаас үүдэн хүмүүсийн төлбөрийн чадвар муудаж, эдийн засгийн өсөлтөд хязгаар учруулан, улмаар нийгмийн тогтвортой байдал, үндэсний эв нэгдэл алдагдах шинжтэй байгаа;
- түүхий эдийн экспортод тулгуурласан эдийн засгийн бүтэц хадгалагдсаар, өндөр технологитой, түүний дотор машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл үндсэндээ байхгүй, ер нь дотоодын хөрөнгө оруулалт маш бага байгаа;
- үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадвар сул дорой хэвээр байгаа;
- эдийн засаг гадаадын хөрөнгө оруулагчид, үндэстэн дамжсан санхүү, худалдааны байгууллагуудаас ихээхэн хамааралтай болсон, тэдний улс төр, эдийн засгийн шахалт, дарамтууд нь үндэсний эрх ашигт ноцтой нөлөөлөх хэмжээнд хүрэх төлөвтэй байгаа;
- бүтэц, чанарын хувьд шаардлага хангасан улсын дайчилгааны болон материаллаг нөөц бүрэлдэж бий болоогүй байгаа;
- мөнгө-зээлийн эргэлт болон банкны системийн тогтворгүй байдал хэвээр үргэлжилсээр байгаа;

- татвар-төсвийн бүрдүүлэлтийн салбарын өнөөгийн нөхцөл байдал нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлах хүчин зүйл хэвээр байгаа;
- үйлдвэрлэл, эрчим хүчний баазыг түүхий эдээр хангах системийн нөхцөл байдал жил ирэх тусам муудсаар байгаа;
- Нийслэл, аймгийн төв, сум багуудын нийгэм,эдийн засгийн хөгжлийн түвшний ялгаа хадгалагдсаар байгаа;
- Бүх шатны авлига газар авч, ,гэмт хэргийн шинж чанартай аж ахуй, санхүүгийн харилцаа түгээмэл болж байгаа явдал зэрэг болно.

Эдгээр хүчин зүйл бүгд улс орныг бүхэлд нь хамарсан шинж чанарыг агуулаагүй болох нь тодорхой, тэр тусмаа ихэнхийг нь тоон үзүүлэлтээр илэрхийлж, хооронд нь, бусад орны болон эдийн засгийн бус өөр үзүүлэлтүүдтэй харьцуулж үзэх боломжгүй боловч эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд харгалзах үүднээсээ ихээхэн ач холбогдолтой болох нь ойлгомжтой юм.

### 3.2.3. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал

#### Ерөнхий хандлага

1990-ээд оны эхээр социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнуудын үзэл суртал, эдийн засаг, батлан хамгаалах нэгдсэн тогтолцоо задран тарснаар үндэсний аюулгүй байдлаа, түүний дотор эдийн засгийн бие даасан, харьцангуй хараат бус хөгжлөө хангах өөрийн гэсэн арга замыг сонгон олох зайлшгүй шаардлага монголын ард түмний өмнө тулгарсан билээ.

1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж зааснаар эдийн засгийн салбарыг үндэсний аюулгүй байдлын бодлоготой нягтаар уялдуулан хөгжүүлэх төрийн бодлогын эрх зүйн үндэс тавигдсан юм.

Энэ Үзэл баримтлалд эдийн засгийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохыг төрийн албан ёсны бодлогын түвшинд анх удаа зарлан тунхаглаж “Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхтай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ” гэж тодорхойлсон байна.

Түүнчлэн энэ үзэл баримтлалд Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гадаад дотоод хүчин зүйлсийг тодорхойлон эдгээрээс хамгаалах арга хэмжээний үндсэн чиглэлүүдийг зааж өгсөн юм.

Үүнээс хойш нэлээдгүй олон жил өнгөрлөө. Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн иргэний ардчилсан нийгэм байгуулах их шилжилтдээ багагүй амжилт оллоо. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх ажил алгуур боловч урагшлахаар байна. Гэвч үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг, түүний дотор улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төрийн бодлогоор нэгтгэн хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих үр дүнтэй механизм бий боллоо гэж хэлэх бас хараахан болоогүйн дээр Монгол Улсыг хүрээлсэн гадаад орчин, улс орны хөгжлийн дотоод нөхцөл байдалд ихээхэн өөрчлөлт гарлаа. Ийм учраас энэ үзэл баримтлалыг тодотгон шинэчлэх талаар яригдах болсон нь зүй ёсны хэрэг юм.

Энэ үндсэн дээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг тодотгон шинэчлэх үндэслэлийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Стратегийн судалгааны хүрээлэнг түшиглэн байгуулагдан ажилласан.

Энэ ажлын зорилго нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын биелэлтийг нэгтгэн дүгнэх, гадаад дотоод шинэ нөхцөл байдалтай уялдуулан задлан шинжилсний үндсэн дээр түүнийг тодотгон шинэчлэх шаардлага байгаа эсэхийг тогтоох, хэрэв тийм шаардлага байвал шинжлэх ухааны үндэслэлтэй санал зөвлөмж боловсруулах, түүнчлэн үндэсний аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих төрийн тогтолцоо, арга механизмыг цаашид боловсронгуй болгох талаар санал боловсруулах, энэ асуудалд төр,

засгийн удирдлага, төрийн болон иргэний нийгмийн байгууллага, нийт иргэдийн анхаарлыг хандуулахад оршиж байсан юм.

Үзэл баримтлалыг тодотгон шинэчлэх үндэслэлийг боловсруулах ажлыг хэрэгжүүлэхдээ түүнийг дагалдан 1994 онд УИХ-ын нэг тогтоолоор батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Төрийн цэргийн бодлогын үндэс” гэсэн хоёр баримт бичгийг хамт нэг нэг мөр тодотгох зорилго тавьсан болно.

Энэ ажлын хүрээнд хийгдсэн судалгааны явцад манай улсын үндэсний аюулгүй байдлын бодлогод дээрх хоёр баримт бичигт заагдсан арга хэмжээнүүдийн зэрэгцээ улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах чиглэл, зорилготой бодлого, үйл ажиллагааг тусгайлан анхаарч үзэх нь ихээхэн чухал болж байгаа нь тодорхой болсон юм.

Үүнтэй холбоотойгоор Үзэл баримтлалыг тодотгон шинэчлэх үндэслэлийг боловсруулсан судалгааны ажлын тайланг ҮАБЗ-д хүлээлгэн өгөхдөө түүнтэй хамт Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрийн цэргийн бодлогыг үндэст өөрчлөлт оруулахын зэрэгцээ Монгол Улсын Эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлал гэсэн нэртэй байж болох баримт бичгийг шинээр боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барих нь зүйтэй гэсэн саналыг тавьсан болно.

Дээр дурдсан саналынхаа хүрээнд эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулахдаа дараах асуудлуудад гол анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

- Эдийн засгийн аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлтийг дүгнэх;
- Эдийн засагт учирч болзошгүй аюулын тухай төсөөллийг тодорхойлох;
- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиглэлийг боловсруулах

#### Гадаад орчны өөрчлөлт

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал нь олон улсын нөхцөл байдал, нэн ялангуяа хөрш хоёр оронтойгоо тогтоосон эдийн засгийн хамтын ажиллагааны шинж төлөв, эрх ашгийн тэнцвэрт байдлаас ихээхэн хамаардаг

гэдгийг бүгд мэднэ. Энэ хүчин зүйл цаашид ч хадгалагдах нь ойлгомжтой боловч сүүлийн жилүүдэд гадаад харилцаанд гуравдагч хөршийн бодлого томоохон байр суурийг эзлэх болж, үүнтэй уялдаатайгаар эдийн засгийн гуравдагч түншийн тэнцвэржүүлэгч хүчин зүйл гэдэг шинэ ойлголт бий болсон.

Үүний зэрэгцээ олон улсын харилцаа, түүний дотор Ази, Номхон далайн бүс нутагт шинээр бүрэлдэн бий болж буй эдийн засгийн хамтын ажиллагааны тогтолцоо, аюулгүй байдлын орчин нь өөр шинэ хүчин зүйлүүдийг ч гаргаж ирэхийг үгүйсгэж болохгүй байна.

Үүнтэй уялдаатайгаар өнөөдөр мэдрэгдэж байгаа зүйлүүдэд үндэслэлтэй дүгнэлт хийн, ойрын ирээдүйд үүсэж болох нөхцөл байдлыг аль болох бодитойгоор төсөөлөн хооронд нь харьцуулж үзэх нь чухал бөгөөд ер нь иймэрхүү харьцуулалтыг үе үе хийж байх нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогыг тухай бүрт нь тодотгож байх бололцоог олгох ач холбогдолтой юм. Үүнд.

1. Ойрын ирээдүйд улс орнуудын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаанд гарах өөрчлөлт өмнөх жилүүдтэй харьцуулбал маш өндөр хурдацтай, хамгийн гол нь улам бүр харилцан хамааралтай, ихээхэн нягт уялдаатайгаар өрнөх нь ойлгомжтой байна.

2. Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн банк, АСЕАН, АПЕК, ШХАБ гэх мэтийн улс хоорондын эдийн засаг, санхүүгийн олон талт харилцааг зохицуулах зорилго бүхий байгууллагуудын үүрэг эрс нэмэгдэх байдалтай байна. Энэ нь улс орнуудын эдийн засгаа удирдах бие даасан үйл ажиллагаа тодорхой хүрээнд хязгаарлагдахад хүргэх, өөрөөр хэлбэл. үндэстэн улсууд эдийн засаг, түүний аюулгүй байдлын асуудлаа олон улсын харилцааны хүрээнд бий болсон нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэж байх гарцаагүй шаардлагыг үүсгэж болох юм.

3. Үндэстэн дамнасан корпорацууд, олон улсын байгууллагууд болон гаднын дэмжлэг бүхий янз бүрийн зорилготой иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагуудын улс орны эдийн засгийн хөгжлийн асуудалд оролцох үйл ажиллагаа идэвхжиж, үндэсний засгийн газруудад хүчтэй нөлөөлөхийг оролдох,

зарим тохиолдолд зөрчил, тэмцэлдээн үүсгэх явдал ч газар авах хандлагатай байна. Эдгээрийн нэг жишээ нь хэд хэдэн оронд гарсан “өнгөт” хувьсгалууд улс төрийн шаардлагуудын зэрэгцээ, бүгд эдийн засгийн хөгжлийн хоцрогдол, иргэдийн ядуурлын эсрэг гэсэн уриа лоозонтой байсан явдал юм.

4. Мэдээллийн технологи урьд үзэгдээгүйгээр хөгжиж аль ч улс оронд хэрэгтэй мэдээллээ хамгийн хямд өртгөөр, дээд зэргээр хурдан авах бололцоог бий болгох бөгөөд энэ нь улс орнуудын эдийн засгийн тогтолцооны уялдаа холбоог нэмэгдүүлэн, нээлттэй байдлыг ихээхэн гүнзгийрүүлэх нь тодорхой байна.

5. Шинэ материалын үйлдвэрлэл, биотехнологи, нана технолги, генийн инженер зэрэг нь ойрын ирээдүйд хөгжлийнхөө шинэ түвшинд гарах бөгөөд энэ нь улс орнуудын эдийн засгийн амьдрал, үйлдвэрлэл, хэрэглээний хэв загвар, хүн төрөлхтний материаллаг болон оюун санааны хүрээнд эрхэмлэж ирсэн үнэт зүйлсийн тогтолцоог үндсээр нь өөрчилж болзошгүй байна.

6. Хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, ядуурал, цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого гэх мэт уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж, хамрах орчин, хил хязгаар нь тэлж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхийн улс түмэнд нүүрлэсэн шинэ аюул занал болж хувираад байна.

Эдгээр уламжлалт бус аюул занал иргэд хувь хүмүүсийн амар тайван амьдралд төдийгүй, улс гүрнүүдийн эдийн засгийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх болж байгаатай холбогдон эдгээрийн эсрэг тэмцлийг улс орон бүрийн идэвхтэй оролцоотойгоор, түүний дотор олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, үндэстэн дамнасан санхүү, эдийн засаг үйлдвэрлэлийн том корпорацуудын нэгдсэн чармайлтаар хангах асуудал орон бүрийн улс төр, эдийн засгийн бодлого, үйл ажиллагааны нэг гол зангилаа асуудал болон тавигдах боллоо.



7. Эдүгээ олон улсын харилцаанд хамтран ажиллах түншээ сонгохдоо стратегийн ашиг сонирхлын зэрэгцээ, тухайн орны эдийн засгийн өсөлтийн түвшин, агуулга, шинж чанарыг ихээхэн харгалздаг болж байна. Эдийн засгийн эрчимтэй хөгжил нь улс орон, олон улсын хамтын нийгэмлэгийн хөгжил дэвшлийн үндэс нь болж байгаагийн дээр аливаа орны олон улсын харилцаанд өөрийн гэсэн эн зэрэгцсэн байр суурийг эзлэх чадварын чухал үзүүлэлт болон хувирч байна.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэж үзэхэд эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны хувьд асар хурдацтай өөрчлөлт дэлхий ертөнцийг ойрын ирээдүйд хүлээж байна. Мэдээж энэ өөрчлөлт улс орон бүрд харилцан адилгүй нөлөөлөх боловч юуны өмнө жижиг улсуудын эдийн засгийн аюулгүй байдалдаа хандах байр суурьд шинэчлэлийн гэж хэлж болох тодотгол хийх шаардлагыг үүсгэж болох нь улам бүр ойлгогдсоор байна.

Орчин үед аливаа нэг улс нөгөөгийнхөө эдийн засгийг бүхэлд нь буюу аль нэг салбарыг нь хараат байдалдаа оруулахыг оролдох гэх мэт шууд заналхийлэл ихээхэн багассанаар бидэнд тайвшрах бололцоо гарч ирж байгаа мэт боловч манай үндэсний эдийн засгийн ашиг сонирхолд харшлах, аюулгүй байдлыг нь хэврэгшүүлэх олон шинэ үйл явдал, хүчин зүйлүүд бий болж байгаа нөхцөлд бид амьдарч байна

Бүс нутгийн олон улсын байдлаас үүдэн үүсэж Монгол Улс татагдан орж болзошгүй эдийн засгийн эрсдэл:

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, үндэсний ашиг сонирхолд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж үзэхэд ойрын болон дунд хугацааны ирээдүйд гадаадын ямар нэг том гүрний зүгээс Монгол Улсын эдийн засгийг шууд хараат байдалдаа оруулахыг эрмэлзэх оролдлого гарах магадлал үндсэндээ байхгүй байна. Манай улсын олон улсын нэр хүнд сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн, хөрш хоёр оронтойгоо элдэв маргаантай асуудлаа аль эрт, олон улсын эрх зүйн хүрээнд эцэслэн шийдвэрлэсэн, энэ хоёр улстай тогтоосон эдийн засгийн найрсаг харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин хөгжиж байгаа зэрэг нь ийм дүгнэлтэд хүргэж байна.

Үүний зэрэгцээ бүс нутгийн хүрээнд үүсэн Монгол Улс татагдан орж болох эсвэл гадаад, дотоод аливаа хүчин зүйлээс үүдэн дотоодод үүсэн эдийн засагт сөргөөр нөлөөлж болох дараах аюулууд бодитойгоор оршсоор байгаа нь бас харагдаж байна.

- Улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил болон их гүрний нөлөөгөө хадгалах гэсэн ОХУ-ын чармайлт нь Ази тивд эдийн засгийн ашиг сонирхлоо өргөжүүлэх тэдний эрмэлзлийг араасаа дагуулан үүний улмаас үүнтэй ижил төстэй ашиг сонирхол бүхий АНУ, Япон, Энэтхэг гэх мэт хүчирхэг орнуудтай, түүнчлэн өөрсдийнх нь хооронд ноцтой, өргөн хүрээтэй зөрчилдөөн үүсэхэд хүргэх, үүнд нь Монгол Улс ямар нэг хэмжээгээр татагдан орох;
- Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын улам бүр өсөн нэмэгдэж буй эдийн засгийн хамтын ажиллагаанд Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын нөлөөг хязгаарлах зорилго бүхий бодлого, үйл ажиллагаа нь давамгайлах, үүний үр дагвараар эдгээрийн хооронд элдэв зөрчил, сөргөлдөөн үүсэж энэ нь Монгол Улсын эдийн засгийн эрх ашгийг тодорхой хэмжээгээр хөндөх;
- 1998 онд тохиолдсонтой болон 2008 оноос хойш үргэлжилж байгаатай төстэй нийтийг хамарсан эдийн засгийн хямрал Ази тив болон Зүүн хойд Азид дахин бий болох, удаан хугацаагаар үргэлжлэх, энэ нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах буюу зогсонги байдалд оруулах зэрэг болно.

#### Улс төрийн хүрээнд үүсэж болзошгүй эдийн засгийн үүдэлтэй эрсдэл

- Гадаад, дотоод элдэв хүчин зүйлийн нөлөөллөөс болж улс орны тогтвортой, тэнцвэртэй хөгжлийн бодлого, алдагдаж улс төр-эдийн засгийн хувьд аль нэг улс орон, улс төр - цэргийн эвсэл холбоо буюу үндэстэн дамжсан том корпорацуудаас хэт хараат байдалд орох;
- Улс орны эдийн засгийн бодлогыг тодорхойлох, энэ хүрээний гол хууль, тогтоомжуудыг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл

ажиллагаанд удаа дараа ноцтой алдаа гарах, үүнээс үүдэн иргэдийн тодорхой хэсэг төр, засагтаа ямар нэг хэлбэрээр итгэл алдрах болж засаглалын өөр хэлбэрийг санагалзагчдын тоо нэмэгдэх, энэ нь улмаар Үндсэн хуулийн хямралыг бий болгож, хуулийн бус арга хэрэгслийг хүсэмжлэх уур амьсгал үүсгэх, үүнийг нь дэмжих, дэвэргэх улс төрийн хүч гарч ирэх;

- Эдийн засгийн хямралт байдал удаан хугацаагаар үргэлжлэх, нийгмийн баялгийн хуваарилалтад шударга бус байдал давамгайлах, ядуурал ихсэх тохиолдолд иргэдийн Эх орноороо бахархах үзэл бүдгэрч бүхэлдээ гутранги, идэвхгүй сэтгэлгээ нийгэмд ноёрхох, эдгээрээс үүдэн улс төрийн агуулгатай нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх, хөгжлийн чиг баримжааны талаар тодорхойгүй байдал үүсэх.

Эдийн засгийн өөрийнх нь хүрээнд үүсэж болзошгүй эрсдэл:

- Эдийн засгийн цэгцтэй бодлого алдагдан амьжиргааны хүрээнд ядуурал газар авч, нийтийг хамарсан хямрал үүсэх;
- Эдийн засагт байгаль орчинд халтай уул уурхайн олборлох үйлдвэрлэл, бэлчээрийн мал аж ахуйд суурилсан үр ашиг багатай хөдөө аж ахуй, худалдааны эргэлтэд өргөн хэрэгцээний барааны бөөний болон жижиглэн худалдаа хэт давамгайлах, дотоодын нийт бүтэгдэхүүний үйлдвэрлэлд ахуйн үйлчилгээний болон хөдөө аж ахуйн салбар нийлбэр дүнгээрээ голлох, хэрэглээний салбарт импортын бүтээгдэхүүн, экспортод түүхий эд, боловсруулалт хийгдээгүй бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзлэх;
- Дэд бүтцийн хөгжил удаашрах, эрчим хүч, хүнсний болон өргөн хэрэгцээний барааны импортоор хөрш орнуудаас хараат байдалд орох;
- Төр засаг өр зээлд ихээр орж, валютын нөөцөө алдах, барьцаалуулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтын тэнцвэр алдагдах, зээл, тусламжийг замаас нь завших явдал газар авснаас үүдэн гадаад орнууд, түүний дотор том гүрнүүд энэ төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээ зогсоох;

- Үйлдвэрлэх хүчний мэдлэг, мэргэжлийн түвшин, үйлдвэрлэлийн харилцааны өнөөгийн байдал нь шинээр үйлдвэрлэлд нэвтэрч буй технологийн шаардлагад нийцэхгүй болж, эдийн засгийн хөгжилд чөдөр тушаа болох;
- Авлига газар авч эдийн засгийн хөгжлийн зохицуулалтыг үр дүнгүй болгоход хүргэх. Үүнээс үүдэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хуулийн хүрээнээс гадуур явуулах нь нийтлэг болж далд эдийн засаг цэцэглэх зэрэг болно.

Нийгмийн хөгжлийн хүрээнд үүсэж болзошгүй эдийн засгийн үүдэлтэй аюул:

- Эдийн засгийн хөгжил удаашрах буюу зогсонги байдалд орсноос үүдэн хүн амын тодорхой хэсэг оюун санаа, эрүүл мэндийн доройтлын хэмжээнд хүрэхүйц ядууралд орох, боловсролын салбар хоцрогдолд нэрвэгдэх, иргэдээ эрүүлжүүлэх, гэгээрүүлэх замаар улс орны чанар, чансааг сайжруулах бодлогын хэрэгжилт удаашрах, тасалдах;
- Эдийн засгийн хөгжлийн хүрээнд хүн амын аюулгүй байдлыг хангах бодлого доголдсоноос хуурамч, хадгалах хугацаа хэтэрсэн, хүний бие организмд хортой хүнс, эм тариа, хувцас, эд хэрэглэл гэх мэт зүйлүүд гаднаас орж ирэх, дотоодод үйлдвэрлэгдэх нь хяналтаас гарах, гадаад харилцаа өргөжиж хүн, мал, бараа бүтэгдэхүүний урсгал чөлөөтэй болох хэрээр элдэв халдварт өвчин тархах, үүний дотор ДОХ, нэн халдварт бусад өвчнөөр өвчлөгсдийн тоо тогтмол өсөх;
- Улс орны хэмжээнд эдийн засгийн үүдэлтэй эрүүгийн нөхцөл байдал хяналтаас гарах, зохион байгуулалтай болон үндэстэн дамжсан гэмт хэргийн том бүлэглэлүүд бий болох, манай улсын нутаг дэвсгэрийг мансууруулах бодис, элдэв төрлийн зэвсэг, цөмийн түүхий эд, материал, хүн худалдаалахаар зөөвөрлөх, дамжуулах талбар болгох оролдлого олшрох, тэдгээрийн хор уршиг нь улс орны эдийн засгийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрэх.

Байгал орчны хүрээнд үүсэж болзошгүй эдийн засгийн үүдэлтэй аюул:

- Дэлхийн цаг уурын дулаарал, өөрчлөлт болон бусад шалтгаанаас үүдэн байгалийн гамшигт үзэгдлүүд олшрох энэ нь улс орны эдийн засагт дааж давшгүй хохирол учруулах;
- Эдийн засгийн хөгжил түүний дотор уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг эрчимжүүлэх явцад байгалийн тэнцвэр алдагдах, ус, гол мөрөн, агаар мандал, хөрс бохирдох, ой сүйдэх, цөлжилт газар авах. бэлчээрийн талхидал, тариалангийн талбайн хомсдол ихсэх, эдгээрээс үүдэн хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариалангийн хөгжил зогсонги байдалд орох.

3.2.4. Эдийн засгийн салбарт учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл

Дээр дурдсан, эдийн засгийн салбарт эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд манай орны хувьд эдгээрээс урьдчилан сэргийлэх үндсэн арга зам нь харьцангуй бие даасан боловч хоорондоо нягт уялдаатай хүрээ далайцын хувьд зааг ялгаатай дараах гурван хэсгээс бүрдэж болохоор байна. Үүнд:

- дэлхий дахинд болон бүс нутагт заналхийлж буй эдийн засгийн хямралаас урьдчилан сэргийлэх, түүний эсрэг тэмцэхэд чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох;
- төрөөс нэгтгэн тодорхойлсон, салбар хооронд сайтар уялдуулан зохицуулсан, үндэсний хөгжлийн бодлогыг цогцоор хэрэгжүүлэн иргэдийн амгалан тайван, элбэг хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;
- эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан үзэл баримтлал, бодлого, үйл ажиллагааг боловсруулан хэрэгжүүлж, өөрийн гэсэн нүүр царайтай үндэсний эдийн засгаа хадгалан хамгаалах зэрэг болно.

Эдгээрийн хүрээнд дараах асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

### **Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд**

- Монгол Улсын хувьд өнөөгийн нөхцөлд эдийн засгийн аюулгүй байдлаа бие даан хангах нөөц бололцоо хязгаарлагдмал байна. Ийм учраас эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогыг эдийн засгийн хямралаас сэргийлэх олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай нь тодорхой байна;
- Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын тулд юуны өмнө манай орны нэр хүндийг олон улсын тавцанд тогтмол нэмэгдүүлэх зорилго бүхий гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Монгол улс зөвхөн тогтвортой хөгжиж буй эдийн засагтай, төрийн байгуулалтын ардчилсан тогтолцоотой байж хэмээн дэлхийн бусад орнуудтай ижил түвшинд харьцах бололцоотой бөгөөд энэ нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогын нэг гол агуулга байх нь ойлгогдож байна;
- Жижиг орны эдийн засаг бүхэлдээ, эсвэл голлох салбарууд нь аль нэг их гүрэн, улс төр-цэргийн эвсэл холбоо, эсвэл үндэстэн дамжсан том корпорацуудаас хараат байх нь түүний үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болдог тухай дээр хэлсэн. Ийм ч учраас манай төрөөс хэрэгжүүлж буй олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд хоёр хөрштэйгөө аль болох тэнцвэртэй эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ өндөр хөгжилтэй бусад орнуудтай идэвхтэй хамтран ажиллах асуудлыг байнга анхаарч байх нь чухал болно;
- Гадаад бодлогодоо эдийн засгийн гурав дахь хөршийн тухай тайлбарыг тодорхой болгох, эдийн засгийн аюулгүй байдлаа олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд баталгаажуулах, манай улсын язгуур ашиг сонирхлыг хөндөөгүй нөхцөлд их гүрнүүдийн хоорондын эдийн засгийн үүдэлтэй элдэв маргаанд оролцохгүй төвийг сахисан бодлого баримтлах, үүнийгээ тэдгээр гүрнүүдээр болон олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн

зөвшөөрүүлж дэмжүүлэх, гадаад харилцааны эдийн засгийн чиглэлийг нь идэвхжүүлэх нь чухал байна.

### **Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд**

- Хувийн хэвшил тэргүүлсэн, экспортын чиглэлтэй, мэдлэгт суурилсан, нээлттэй эдийн засгийг хөгжүүлэх, Монгол Улсад ашигтай гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нь дэлхийн зах зээл дээр болж байгаа өөрчлөлтөд түргэн дасах чадвартай эдийн засгийн бүтэц бий болгох бодлого, үйл ажиллагааны үндсэн агуулга юм. Энэ нь Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд голлох үүрэгтэйн зэрэгцээ эдийн засгийн аюулгүй байдлын нэг чухал баталгаа болох учиртай гэж бодож байна.
- Экспортыг дэмжих, энэ чиглэлийн гадаад дотоодын хувийн хэвшлийн үйлдвэрүүдтэй Засгийн газраас ажиллах арга барил, тухайлбал, экспортыг урамшуулах, хөнгөлөлт үзүүлэх, санхүүжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай болгох, бүтээгдэхүүнийг олон улсын чанар, стандартын шаардлагад хүргэх асуудал чухлаар тавигдаж байна.
- Төрөөс хөгжлийн асуудалд хандахдаа бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг тулгуур болгож байгаа нь үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцэж байгаа юм. Иймээс бүс нутгуудад хөрөнгө оруулалт хийх гадаад дотоодын компаниудыг төрөөс дэмжих асуудал чухал ач холбогдолтой юм.
- Банк, санхүүгийн салбарт олсон ололтыг бататгаж, цаашид энэ салбарт хувийн хэвшил, түүний дотор гадаадын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудад үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн тааламжтай нөхцлийг хангах явдал чухал юм. Гэхдээ энд мөн л аюулгүй байдлын ашиг сонирхлын байр сууринаас хандаж гадаад дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын тэнцвэртэй байдлыг хангахад анхаарах нь ач холбогдолтой болно.

- Монгол улс жижиг орны хувьд иргэдээ хүчирхэгжүүлэх нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогын нэг чухал агуулга болох нь харагдаж байна. Иргэдээ хүчирхэгжүүлэх нь тэдний оюуны чадавх, боловсрол, эрүүл мэнд, амьдралын түвшнийг дээшлүүлэх, нийгмийн идэвхийг нь нээн гаргах, өөдрөг сэтгэлгээг хөгжүүлэх, Эх орноороо бахархах, үндэс угсаагаа хадгалах гэсэн үе дамжсан хүмүүжилтэй болгох зэрэг олон агуулгатай байдаг. Гэхдээ өнөөгийн нөхцөлд иргэдээ ядуурлаас гаргаж, амьжиргааны түвшнийг нь олон улсын жишигт ойртуулах нь иргэдээ хүчирхэгжүүлэх бодлогын тулгамдсан асуудал болж байна.
- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нь сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хүчин зүйлсийг зөв тодорхойлох, тэдгээрээс хамгаалах арга хэмжээг үндэслэлтэй боловсруулахаар хязгаарлагдахгүй бөгөөд гол нь эдийн засгийн салбарт үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах үр дүнтэй механизм бий болгоход орших юм. Үүний дотор улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад төрийн дээд удирдлага, эдийн засаг, санхүүгийн төрийн захиргааны төв байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, түүнчлэн аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүргүүдийг тодорхой болгон, зааглан салгаж, хуульчлан баталгаажуулах нь ихээхэн чухал байх болно.
- Эдгээр үүрэг нь улс орны эдийн засгийн бодлогын үндсэн чиглэл, үзэл баримтлалыг тодорхойлох, үйлдвэрлэл, банк-санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох, эдийн засаг-нийгмийн хөгжлийн байдалд дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийг тодорхойлох, улсын төсвийн төслийг боловсруулах, батлах, эдийн засгийн чухал асуудлуудаар төрийн хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр гаргах зэрэг улс орны эдийн засгийг удирдах үйл ажиллагааны бүх шатанд биелэгдэж байх ёстой болно.
- Эдийн засгийн аюулгүй байдлыг үнэлж дүгнэх тодорхой шалгуур босго үзүүлэлтүүдтэй байх, эдгээрийг Засгийн газраас тусгайлан баталж байх нь туйлын чухал болж байна. Үүн дээрээ тулгуурлан эдийн засгийн аюулгүй байдал улс орны хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгаад ҮАБЗ, Засгийн газрын зүгээс тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, тэдгээрийн энэ чиглэлийн эрх үүргийг нь өргөжүүлэх нь зүйтэй юм.



- Ер нь Улсын Их Хурлаар улс орны эдийн засгийн хөгжилтэй холбогдол бүхий аливаа хуулийн төслийг хэлэлцэж батлахдаа тухайн хууль нь үндэсний эдийн засгийн ашиг сонирхолд хир нийцэж байгаа талаар хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулж байх нь ихээхэн чухал юм. Энэ нь Монгол улсын хуулиуд үндэсний аюулгүй байдлыг хангахад үйлчлэх ёстой гэсэн үзэл санаанд бүрэн нийцэх бөгөөд хууль боловсруулах журамд зохих ёсоор тусгаж болох талтай болно.

### **Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан үзэл баримтлал боловсруулах ажлын хүрээнд:**

Аливаа улсын эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалын агуулга нь төрийн гадаад дотоод бодлого, түүний хөгжлийн түвшин, газар зүйн байрлал болон улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийн онцлог шинж, улс орны бүтээн байгуулалтын чадавх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хөгжлийн түвшин болон бусад хүчин зүйлээр тодорхойлогддог болно.

Ерөнхийдөө, эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалаар эдийн засгийн аюулгүй байдлын тухай ойлголт, эдийн засгийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж болох гадаад, дотоод хүчин зүйлс, тэдгээрээс хамгаалах арга хэмжээнүүдийг тодорхойлдог бөгөөд түүнийг эдгээр асуудлаар баримтлах төрийн албан ёсны үзэл бодлын цогц гэж ойлгож болох юм.

Олон улсын жишгээр үндэсний аюулгүй байдлын бодлогын гол объект нь төр, нийгэм, хувь хүн байдаг. Үүний дотор өнөөгийн бий болсон нөхцөл байдалд манай орны хувьд Монгол Улсын иргэн-хувь хүний аюулгүй байдлын асуудлыг энэ бодлогын цөмд тавих нь зүйтэй болоод байгаа тухай ихээхэн ярьж байгаа билээ. Үүнтэй уялдаатайгаар эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалын гол агуулга нь эцсийн дүндээ хувь хүний аюулгүй байдлыг хангахад чиглэх ёстой гэсэн санаа урган гарч ирж байгаа юм.

Энэ нь одоо мөрдөж буй Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд түүний гол агуулгыг Монгол Улсын төрийн оршин тогтнох гадаад, дотоод нөхцөлийг баталгаажуулах талаас нь ихээхэн анхаарсантай нэлээд ялгаатай

дуулдаж байж болох юм. Гэвч Үндэсний аюулгүй байдлын анхны үзэл баримтлалыг боловсруулж байхад дэвшүүлсэн төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн болон улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилт үндсэндээ биелэгдсэн гэж үзэж болохоор байгаа учир одоо хүний аюулгүй байдлыг хангах зорилтыг эдийн засгийн аюулгүй байдлын бодлогын гол болгон анхаарах бололцоотой гэж бодож байна.

Дээр дурдсан зүйлүүдийг дүгнэхэд:

1. Эдийн засгийн салбар болгонд аюулгүй байдлын өөрийн гэсэн тулгамдсан асуудлууд байгаа. Эдгээрийг шийдвэрлэх ажлыг нэгдсэн бодлогоор, шинжлэх ухааны үндэслэлтэй зохицуулалттай хийх нь амжилтад хүрэхийн нэг гол үндэс байх болно. Монгол Улсын хөгжлийн нэгдсэн бодлогын үндсийг боловсруулах, салбар хоорондын уялдаа холбоог зохицуулах үүргийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хариуцуулсан гэж ойлгож байгаа. Ийм учраас улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, салбар хооронд уялдуулан зохицуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг тус хороонд хариуцуулж, хуульчлан баталгаажуулах нь чухал байна.

2. Эдийн засгийн аюулгүй байдлын бодлого нь зөвхөн Монголын ард түмэнд хамаатай нарийн ширийн олон зүйлийг агуулах нь хэн бүхэнд ойлгомжтой бөгөөд энэ бүхнээ хориг, хязгааргүй дэлгээд байх учиргүй гэдгийг бид бас бодох учиртай гэж хэлэх байна. Ийм учраас эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулах ажлыг улс төржүүлж улс төрийн нам, эвсэл холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн хэсэг бүлгүүдийн болон өөрсдийгөө сурталчлах гэсэн хувь хүмүүсийн маргааны талбар болгохгүй байхаар зохион байгуулах нь зүйтэй юм.

### **3.3. Нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэл**

#### **3.3.1. Нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн тухай ойлголт**

Улс орны нийгмийн салбарт эрсдэл үүсэх үндсэн нөхцөл нь түүний дотоодод явагдаж буй үйл явцын үр дүнд нийгмийн давхаргын ялгаа ихээхэн гүнзгийрч өөр хоорондын зөрчил сөргөлдөөнд хамрагдсан хэсэг бүлгүүд болон

хуваагдах явдал байдаг. Энэ үүднээс Монголын нийгмийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж үзэх нь нийгмийн салбарт учирч болзошгүй стратегийн эрсдэлийг тодорхойлох бололцоог олгож байгаа юм.

Өнөөгийн монголын нийгэмд давхаргын шинэ бүтэц бүрэлдэн төлөвших үйл явц эрчимтэй явагдаж байна. Энэхүү давхарга нь нэгд, өмч эзэмших зэрэглэлээр; хоёрт, засаглах эрх мэдлээр; гуравт, нийгэмд эзлэх байр суурь, (алдар цол, албан тушаал, нэр хүнд) гэх мэт олон хэмжүүр бүхий дэс зиндаагаар өөр хоорондоо ялгаатай нийгмийн хэсэг бүлгүүдийг бүрдүүлэхийн зэрэгцээ, хэсэг бүлэг бүр дотроо боловсрол, нэр хүнд, засаглалд оролцох боломж, өмч хөрөнгийн хэмжээ, эрхлэх хөдөлмөр зэргээрээ ялгаатай байдлыг бий болгосоор байна. Энэ нь нийгмийн хэсэг бүлгүүдийн дунд болон тэдгээрийн дотоодод тэгш бус байдал үүсэх материаллаг үндэс болж байгаа юм. Ийм үзэгдэл аль ч оронд байдаг зах зээлийн нийгмийн жам ёсны үйл явц мөн боловч, нийгмийн зохицуулалт, зохион байгуулалтыг тодорхой хэмжээгээр шаарддаг зүйл бөгөөд, ингээгүй тохиолдолд хяналтаас гарч нийгмийн салбарт стратегийн гэж хэлж болох эрсдэл үүсгэдэг зүй тогтолтой байдаг.

Нийгмийн хэсэг бүлгүүдийн хоорондын тэгш бус байдлын уг чанарыг биологийн үндэстэй, байгалийн жам ёсны (бие махбодын, сэтгэн бодох чадварын гэх мэт) боломжууд, мөн нийгмийн байр суурины (эд материал, нийгмийн гарал үүсэл, нийгэмд эзлэх байр суурь, боловсролын түвшин, оршин суугаа байрлалын гэх мэт) зэрэг ялгаануудтай холбон үздэг. Энд тэмдэглэж хэлэхэд хөрөнгө, мөнгө, засаглалын эрх мэдэл, боловсрол, алдар хүнд зэрэг нийгмийн үнэт баялгийг нийгмийн давхаргын хэсэг бүлгүүдэд жигд бус хүртээх, хуваарилах нь аль ч оронд ардчилал, шударга ёсонд нийцдэггүй бөгөөд эдгээр нь нийгмийн салбарт стратегийн эрсдэл үүсэх үндсэн эх сурвалж болох нь байдаг юм.

Монголын нийгмийн хэсэг бүлгүүдийн бүтцийн өөрчлөлтийн үндсэн чиг хандлагыг 2010 онд явагдсан хүн амын тооллогын материалуудад тулгуурлан судалж үзэхэд дараах байдал ажиглагдаж байна. Үүнд:

Нэгд, баячууд (жилийн орлого нь хэдэн зуун саяар хэмжигдэх тэрбумтнууд). Үүнд, уул уурхай, худалдааны том сүлжээний эзэд, тэдний гэр бүлийнхэн, ойр дотнын хүмүүс болон улс төр, бизнесийн салбарын эдийн засаг,

улс төрийн ашиг сонирхлоороо нэгдэн холилдсон олигархууд багтаж буй бөгөөд хүн амын харьцангуй цөөхөн буюу 5 хүрэхгүй хувийг эзэлж байгаа юм. Өнөөгийн монголын нийгэмд хуримтлагдсан хөрөнгө мөнгө, капиталын 90 орчим хувь нь тэдний гарт төвлөрч байна; Хоёрт, хүн амын чинээлэг хэсэг. Үүнд, дунд, жижиг үйлдвэрлэл эрхлэгчид багтаж буй бөгөөд тэдний жилийн орлого, санхүүгийн эх үүсвэр нь ажил үйлдвэрлэлээ бие даан явуулах, сэргэлт хөгжлийн фонд бүрдүүлэх төвшинд байна. Тэд хүн амын 15-18 хувийг эзэлж байгаа бөгөөд нэлээд хэсэг нь олигархуудтай холбоотой, тэдний эрхшээлд байгаа юм. Гуравт, дундчууд. Энэ давхарга тооны хувьд ч, чанарын хувьд ч өсөлт удаан байгаа гэж судлаачид үзсэн байдаг бөгөөд түүнд үйлдвэрийн цалин хангамж сайтай гэгддэг нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчид, төрөл бүрийн мэргэжлийн менежерүүд, хөдөөгийн фермерүүд, наймаачид зэргийг багтаан авч үзсэн бөгөөд тэд хүн амын 30 орчим хувийг эзэлж байгаа аж. Дөрөвт, ядуулаг хэсэг. Энэ давхаргад, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа болон туслах ажилтан, төрийн дунд болон доогуур тушаалын албан хаагчдын дийлэнх багтаж байгаа бөгөөд тэд тогтвортой ажлын байртай, орон сууц, автомашин зэрэг үндсэн хөрөнгөтэй боловч орлогын эх үүсвэр нь зөвхөн ядмаг цалин хөлс байдаг, тэдний нэлээд хэсэг нь орон сууцын болон авто машины өр зээлтэй байна. тэд хүн амын 30 орчим хувийг эзэлж байгаа юм. Тавд, нэн ядуу хэсэг. Албан ёсны статистикаар орлого нь хүн амын амьжиргааны доод төвшнөөс доогуур орлоготой, амь зуулга төдий иргэд энэ хэсэгт багтаж байна. Тогтмол цалин хөлсгүй, авсан ч бага цалин авдаг, эсвэл ажилгүй, хөдөлмөр тогтвортой эрхэлдэггүй, улирлын чанартай ажил хийдэг, олон хүн тэжээдэг, ам бүл олон иргэд энэ бүлэгт орж буй бөгөөд тэд хүн амын бараг 10 орчим хувийг эзэлж байгаа аж. Зургаад, үгээгүйчүүд. Энд өмч хөрөнгөгүй, тогтмол орлогогүй, зарим нь орон гэргүй, олдсоноор амь зууж яваа хүмүүс багтаж байна. 2010 оны хүн ам, орон сууцын тооллогоор, өөрийн гэсэн орон гэргүй иргэд гэхэд хүн амын 1,7 хувийг эзэлж байна. Харин ажилгүйчүүдийн эзлэх хувь бараг 40 орчим хувьд хүрээд байна.

Нийгмийн бүрэлдэхүүн болох анги, давхаргын бүтэц, хэмжээ, тэдний аж амьдралын төвшин зэрэг нь удаан хугацаанд бүрэлдэн тогтдог бөгөөд энэ нь үйлдвэрлэх хүчин болон соёлын хөгжлийн хурдтай ихээхэн уялдаатай байдаг. Тийм учраас нийгмийн бүтцийн зогсонги байдал ба уналттай холбоотой урт хугацааны эрсдэлийн тухай чухалчлан авч үзэх нь оновчтой юм. Энэ асуудалд нийгмийн баялгийн төвлөрөл, баян ядуугийн ялгааны өсөлт, дундаж анги,

давхаргын бүрэлдэлтийн хурдцын удаашралт, орон нутагт нийгмийн бүтцийн хөгжлийн тэгш бус байдал зэрэг зүйлүүд хамаарч болох юм.

Нийгмийн тогтвортой байдлын үндэс болох “дунд анги” бүрэлдэх явц Монгол Улсад ихээхэн удаашралтай, баячууд ба үгээгүйгүйчүүд хоорондын ялгаа эрчимтэй өсөж байгаа нь нийгмийн бүтцийн хямрал гүнзгийрэх нэг шалтгаан болж байна. Ядуулаг хэсгийн давхаргад өнөө үед хамрагдаад байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа болон төрийн албан хаагчдын орлогыг нэмэгдүүлбэл дундчуудын бүлэгт багтаж болох талтай юм. Гэтэл тэднийг төрөөс дэмжих бодлого явцуу, өдөр хоногийг өнгөрөөсөн, аргацаасан байдалтай байна. Хэрвээ энэ бүлэгт багтаж байгаа хүн амын ядаж 25-30 хувь нь дундчуудын хэсэгт орох юм бол үнэхээр “Дунд анги” бүрэлдэж нийгмийн хямрал багасах үндэс бүрдэх бололцоо байгаа нь судалгаанаас харагдаж байгаа юм.

Монгол Улсын хүн амын давхаргын эрсдэлийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3.6

Хүн амын давхаргын эрсдэл

д/д	Ангилал	Төвшин	
		Босго үзүүлэлт	Бодит үзүүлэлт (2011 оны байдлаар)
1	Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ		
2	Хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн дотор ажилгүйчүүдийн эзлэх хувь	5-8	9
3	Бүх хүн ам доторх амьдралын доод түвшнээс доогуур амьдралтай хүмүүсийн эзлэх хувь	7	17
4	Амьдрал хамгийн түвшин хамгийн дээгүүр хүн амын 10 хувь, амьдрал түвшин хамгийн доогуур хүн амын 10 хувийн харьцаа	8	15

Манайд нийгмийн салбарын эрсдэлийн түвшнийг тогтооход өргөнөөр хэрэглэгддэг нийгмийн нөлөөллийн байдлын үнэлгээ (ННБҮ) бараг хийгдэхгүй шахам байна. Энэ үнэлгээг авч хэрэгжүүлэхээр бэлтгэж буй аливаа үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн нийгэмд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг үнэлэх үндсэн дээр тэдгээрийг хянах, удирдах үйл явцыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулдаг болно. Гадаадын олон судлаач “ННБҮ-

ний хамгийн гол зорилго нь биофизикийн болоод хүний орчныг илүү тогтвортой бөгөөд тэнцвэртэй байлгахад оршдог” гэснээс үзэхэд, жишээлбэл, наад зах нь “гэр бүлд ээлтэй” ажил эрхлэлтийн бодлого хэрэгжүүлэх нь хамгийн зөв шийдэл гэж үзэж байна. Гэр бүлийн гишүүдийг ажлаар хангах, “ажил-ар гэр”-ийн харьцаа, харилцааны тэнцвэр зэрэг асуудлуудыг ажил эрхлэлтийн төлөвлөгөөнд суулгаж өгөх нь нийгмийн салбарт үүсэж болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Нийгмийн янз бүрийн субъектэд нөлөөлж болох аливаа эрсдэлийн эх сурвалжийг амьдралын доод төвшинд орох (өлөн зэлмүүн, гэр оронгүй амьдрал), нийгмийн халамж, эрүүл мэндийн хамгаалалтаас гадуур байх (ямар ч тэтгэмж тусламжид хамрагдахгүй, халдварт өвчинд нэрвэгдэх, өвчлөх тохиолдолд эмнэлгийн тусламж авч чадахгүй байх) гэсэн хоёр томоохон бүлэгт хуваан үзэж болох юм. Эдгээр нь нийгмийн хөгжлийн төвшин, аюулгүй амьдрах нийгэм-эдийн засгийн тогтолцоо боловсронгуй бус байгаатай холбоотой байдаг. Ийм нөхцөл байдлаас үүдэн үүсэх эрсдэлийг л нийгэм-эдийн засгийн эрсдэл гэж нэрлэдэг болно. Эдгээр нь эцсийн дүндээ хүн амын дундаж наслалтыг богиносгох, онцгой нөхцөл байдал үүсэхэд нийгмийн хамгаалалтыг өргөн хүрээтэй зохион байгуулж, хэрэгжүүлж чадахгүйгээс болон аливаа өвчин, юуны өмнө халдварт өвчний улмаас амиа алдах зэргээр иргэн хүн манай нийгэмд амьд явах эрхтэй байдаг Үндсэн хуулийн заалт биелэгдэхгүй байхад хүргэдэг зүйлүүд юм.

Орон нутгийн нийгмийн аюулын төвшин нь түүний нутаг дэвсгэрийн аюулт үзэгдлийн тархалт, цаг үе, нийгмийн өөрийнх нь амьдралын үр дагавартай холбогддог онцлогтой. Жишээлбэл, байгаль, нийгмийн гарвальтай халдварт өвчний дэгдэлт, тархалт, террорист ажиллагаа үүсэх, явагдах, бослого үймээн дэгдэх, дайн байлдаанд өртөх гэх мэт

Монголын нийгмийг эрсдэлд оруулж болзошгүй өөр нэг хэсэг таагүй үзэгдэл бол авлига газар авах, эрүүгийн гэмт хэргийн тоо өсөх, төр, засгийн удирдах бүрэлдэхүүний мэдлэг, чадваргүй, хүнд сурталт байдал хавтгайрах зэрэг юм. Нийгмийн хувьслын явцад гарч ирсэн эдгээр үзэгдэл Монголын нийгмийн тогтвортой хөгжлийн ирээдүйд аюул учруулахаар хэмжээнд хүрээд байгаа нь судалгааны явцад хүчтэй ажиглагдсан болно. Үүний дотор олон учир

шалтгааны улмаас авлига бүх шатны төрийн байгууллага, олон нийтийг хамарсан шинж чанартай болж байгаа нь сэтгэл түгшээсэн асуудал болж байна.

Өнөөгийн Монголын нийгмийн гэмт хэргийн нөхцөл байдлын онцлогийг шинжилбэл, дараах төлөв байдал зонхилж буй бөгөөд нийгэмд бүхэлд нь эрсдэл учруулах ихээхэн магадлалтай болохыг харуулж байгаа юм. Тухайлбал:

- Гэмт хэргийн зохион байгуулалттай, мэргэшсэн байдал өсөж байгаа;
- Хүйтэн, халуун зэвсэг хэрэглэсэн гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа;
- Дээрэм, хулгай, авлигын үйлдлүүд, тэдгээрийн давтан үйлдэлт ихээхэн олширсон;
- Онцгой харгис, хэрцгий шинж чанартай гэмт хэрэг үйлдэгдэх явдал байнга тохиолдох болсон;
- Гэмт хэргүүдийн нийгэмд ноцтой аюул учруулахуйц хэмжээ нэмэгдэж байгаа явдал зэрэг юм.

Гэмт хэргийн улмаас нийгмийн хөгжилд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгааг дараах үзэгдлүүд нотлон харуулж байна. Үүнд:

- Улс төр – бизнес, төрийн алба – хувийн хэвшил, улс, нийгэм – хувийн хэвшлийн харилцаанд эрүүгийн шинж чанартай гэмт явдал нэвтрэх, нийгмийн амьдралын бүхий л салбарт гэмт хэрэг “өдөр тутмын”, хэвийн үзэгдэл болох, хууль эрх зүйг уландаа гишгэх үзэгдэл газар авах хандлага;
- Эрүүгийн шинж чанартай амьдралын хэв маяг, зан төлөв нийгмийн цогц үзэгдэл болох, энэ нь нийтийн ухамсарт шингэж хэвийн зүйл мэт ойлгогдож эхлэх;
- Хууль, хяналтын болон хууль сахиулах байгууллагад хүн амын дийлэнх хэсэг үл итгэх, аюулгүй байдлаа хангах зорилгоор өөрийн амь нас, эд хөрөнгөө хамгаалахын тулд иргэд өөрсдийгөө зэвсэглэж эхлэх, хувийн хамгаалалтын байгууллагад хандах, ингэснээр зэвсэглэсэн хувийн байгууллагуудын тоо, хүн амын гар дээр байгаа зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй галт зэвсгийн тоо нэмэгдэх;

- Хувь хүний материаллаг болон оюуны өмчийн халдашгүй дархан байдал алдагдах, нийгэмд хүчирхийлэл, хулгай дээрэм өсөх, түүнд иргэд, төрийн захиргааны байгууллага дасаж, үл хайхарсан сэтгэлгээ бий болох;
- Хувь хүний амьдралын үндсэн хэв маяг гажих, шударга, үнэнч байдал алдагдах, хөдөлмөрийн үнэ цэн буурах, өөрийнхөө хөдөлмөрөөр сайхан амьдрах, биеэ зөв авч явах хандлага багасах зэрэг болно.

Өнөөдөр тийм ч мэдрэгдэх төвшинд хүрээгүй боловч алс хэтдээ томоохон асуудал үүсгэх эх сурвалж болж болох Монголын нийгэмд шинээр гарч ирж буй өөр нэг аюул бол төрөл бүрийн шашин, түүнийг шүтэгчид хооронд үүсэж болзошгүй зөрчил сөргөлдөөн юм.

Үүнээс гадна XX зуунаас монголын нийгэмд дэлгэрч ирсэн архидалт, сүүлийн үед анхаарал татаж буй мансууруулах бодис хэрэглэх, янз бүрийн мөрийтэй тоглоом тоглохоос үүдэлтэй донтолт нийгмийн аюулт үзэгдлийн нэг болох шинж төлөвтэй байна.

Дээр дурдсан дүн шинжилгээ, баримтуудад дүгнэлт хийж үзэхэд, монголын нийгэмд аюул учруулж, эрсдэл дагуулж болзошгүй үзэгдлийн эх сурвалжид:


- нийгмийн бүлгүүдийн давхарга хоорондын эрс тэс ялгаа гүнзгийрэх, нийгэм дэх шударга бус байдал, хэлмэгдүүлэлт нэмэгдэх, хууль, журам, нийгмийн ёс суртахуун зөрчигчдийн тоо олшрох;
- авлига, эрүүгийн гэмт хэргийн өсөлт газар авах, төр, засаг, орон нутгийн засаг, захиргааны удирдах бүрэлдэхүүний мэдлэг, чадваргүй байдал түгээмэл болж төр бүхэлдээ сулрах, гадаадын хууль бус цагаачид олшрон нийгэмд таагүй нөлөөлж эхлэх, залуу үеийн хүмүүжилд эцэг, эх, сургууль, олон нийт, ажил эрхлэгч байгууллага, хүмүүсээс үзүүлэх нөлөө үгүй шахам болох;
- нийгмийн хэсэг бүлгүүдийн хооронд зөрчил, сөргөлдөөнөө шийдвэрлэхдээ гэмт хэргийн буюу зарим тохиолдолд террорист маягийн үйл ажиллагааг ашигладаг байдал үүсэх, олныг хамарсан үймээн самуун, эмх



замбараагүй байдал, бослого тэмцэл дэгдэх, олон төрлийн шашин, тэдгээрийг шүтэгчид хооронд үүсэх зөрчил, сөргөлдөөн нэмэгдэх;

- байгаль, нийгмийн гарвальтай халдварт өвчин (ДОХ, сүрьеэ, тахал, шувуу, гахайн ханиад) дэгдэх, тархах, архидалт, мансууралт, янз бүрийн мөрийтэй тоглоомоос үүдэлтэй донтолт олшрох, монгол хүний удмын сан булингартах, хүн ам зүйн бодлого, зохицуулалт алдагдах, төрөлт багасах, цаг бусаар нас барагсад олшрох зэрэг болно.

Нийгмийн аюулт үзэгдлийн ангиллыг дараах зурагт харуулав.



Зураг 3.1. Нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн ангилал

### 3.3.2. Нийгмийн салбарт эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйлс

Юуны өмнө нийгэм дэх авлига, шударга бус байдал, гэмт хэргийн өсөлт, төр засгаас тэдний эсрэг явуулж буй тэмцлийн үр дүн төдийлөн сайн биш байгаа нь Монголын нийгэмд анхаарал татсан асуудал болсон хэвээр байж нийгэм дэх эрсдэлийг нэмэгдүүлэх гол нэг нөхцөл, үзүүлэлт болсоор байгаа нь судалгаанаас харагдаж байгаа юм.

Нэгд. Төрийн бүх шатны удирдах бүрэлдэхүүний дунд түгээмэл болоод байгаа авлига, эрүүгийн шинж чанартай үйл ажиллагаа болон энэ бүрэлдэхүүнд хамаарах хүмүүсийн мэдээлэлтэй харьцах чадвар, ажлын дадлага туршлага, мэдлэг боловсрол нь нийгмийн хэрэгцээ шаардлагаас ихээхэн хоцрох болсон нь нийгэмд олныг хамарсан эрсдэл үүсэх нэг томоохон шалтгаан болж байна. Монголын нийгмийн хөгжлийн өнөө үед эдгээр үзэгдэл тогтвортой хөгжил болон үндэсний аюулгүй байдлын ирээдүйд шууд заналхийлэх хэмжээнд хүрээд байгаа тухай олон судлаачид бичих боллоо. Авлига нийтийг хамарсан хэвээр байгаа нь олон шалтгаанаас үүдэлтэй байна. Авлига нь хэд хэдэн хүрээнд, хэлбэр хэмжээ нь өөр өөр төвшинд явагдаж байна. Зах зээлийн нийгэм төлөвших эхэн үеэс шинээр бий болсон авлига хэмээх энэ хорт үзэгдлийн тоо, төрөл олширч, авах өгөх хэмжээ нь эрс ихсэж, дэлгэрч байгаа хүрээ нь шийдвэр гаргагч, зөвшөөрөл олгогч нараар төдийгүй дунд сургууль, цэцэрлэгийг хүртэл хамрах болсон байна. Уламжлалт гар цайлгах, гарын бэлэг өгөх зэрэг нь шинэ утга агуулгатай, авлигын хэлбэртэй болж, өгөх хэмжээ нь өсөж, нийгмийн доторх хамгийн өргөн хэсгийг хамрах болсоор байна.

Аж ахуйн нэгжүүд төрийн байгууллагатай хуйвалдан холбогдох, хувийн хэвшлийн байгууллагууд, хувиараа ажил хөдөлмөр эрхлэгсэд олон зүйл дээр төрийн болон орон нутгийн засаг захиргаанаас хараат хэвээр байгаа нь авлига дэлгэрэх, амь бөхтэй оршин тогтнох үндэс болсоор байна.

Хоёрт. Бизнес эрхлэгчдийн орлогын ихэнх нь далд эдийн засаг эрхлэгчдийн халаасанд орж байгаа бөгөөд энэ нь ДНБ-ний 35 хүртэлх хувьтай тэнцэж байгаа гэсэн судалгаа ч байна. Үүнийг үгүйсгэх аргагүй юм. Огт ажилгүй мөртөө хүнээс дутахгүй яваа, ядуулаг хэсгийн давхаргад хамаардаг боловч үйлдвэрлэл, үйлчилгээ амжилттай эрхэлж байгаа болон төрийн албан хаагчийн цалингаас өөр орлогогүй гэдэг боловч амьдралын дундаж түвшнээс дээгүүр амьдарч байгаа хүмүүс Монгол Улсад олон байна. Энэ нь далд эдийн засагтай шийдвэртэй тэмцэхгүй бол түүнд дасан зохицох, тэр ч байтугай дэмжин өөгшүүлэх явдал нийгэмд өсөж, эцсийн дүндээ нийгмийн гүнзгий хямралд хүргэж болзошгүй юм.

Монгол Улсад хуулийг өөрсдийнхөөрөө тайлбарлах, заалтуудыг нь өөртөө ашигтайгаар гуйвуулах, тэр ч байтугай үл тоомсорлох явдал иргэдийн дунд нэмэгдсээр байгаа нь цаашдаа нийгэмд учирч болох томоохон эрсдэлийн эх үүсвэр болж байгаа юм.

Засаг, захиргааны байгууллагууд хоорондын харилцаа, тэдгээрээс иргэд, ажил хөдөлмөр эрхлэгчдэд хандах хандлагад эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд илрэх болсон нь одоо хэнд ч нууц биш болжээ.

Удирдах засаглал эрүүгийн бизнестэй уусан нийлэх, төрийн албан хаагч, хүчний байгууллагын ажилтнууд авлигад өртөх нь цаашид ч өсөх хандлагатай байна. Үүнийг сүүлийн үед Авлигатай тэмцэх газраас шалгаж, прокурор, шүүхийн байгууллагад шилжүүлж буй олон хэрэг харуулж байна. Төрийн байгууллагуудын төлөөллийн хүмүүст өгөх авлигад хувийн хэвшил болон эрүүгийн гэмт хэргийн бүлгүүд ашгийнхаа тодорхой хувийг зориулдаг болсон нь олон баримтаар мөн нотлогдож байгаа юм. Энэ бүхнийг нэгтгэн дүгнэж үзэхэд Засаглал дахь авлигын эрүүгийн шинж чанар нь дор дурдсан хор хохирол учруулж болох нь тодорхой байна. Үүнд:

1. “Далд эдийн засаг”, “Далд хууль, эрх зүй” газар авч, төрийн үйл ажиллагааны ёс зүйн суурь ойлголтууд эвдэрч, үндэсний хөгжил дэвшлийн үзэл санаа утга учраа алдах;
2. Төрийн удирдлагын босоо шугамын зарчим алдагдаж, улс орныг үр ашигтай удирдах боломжгүй болж, элитүүд гэж өөрсдийгөө нэрлэдэг олигархууд хоорондын хуйвалдаан шийдвэр гаргах түвшний төрийн үйл ажиллагааны нэг гол хэлбэр болж хувирах;
3. Ард түмэн төр засгаасаа хөндийрч, төрдөө үл итгэх байдал хүчтэй болж “ард түмнийхээ төлөө биш төрийн эсрэг” хэмээх үзэл санаа нийгмийн сэтгэлгээний нэг үндэс болох;
4. Улс төрийн тогтворгүй байдал өсөн нэмэгдэж нийгмийн эмх замбараагүй байдлыг өдөөх;

5. Нийгмийн дотор баян, ядуугийн ялгаа улам бүр ихсэж, шударга ёс, тэгш байдал алдагдах;
6. Бизнесийн салбар, эрүүгийн ертөнц, засаг захиргаа хоорондоо уусан нэгдэж, эрүүгийн шинж чанарыг агуулсан олигарх дэглэм тогтон олон улсын нийгэмлэгүүд ба хөрөнгө оруулагчид Монгол Улсаас нүүрээ буруулах зэрэг болно.

Авлигын эсрэг авах арга хэмжээг боловсронгуй болгох ажиллагаа ойрын жилүүдэд идэвхжих хандлагатай байгаа нь сайн хэрэг юм. Гэвч энэ нь тийм ч хурдан үр дүнгээ өгөхгүй бололтой. Багагүй хөдөлмөр, хүчин чармайлт гаргасны дараа, түүний дотор авлигатай тэмцэх гүйцэтгэх засаглалын эрх үүрэг шинэчлэн тогтоогдож, ном журамдаа орсон тохиолдолд л авлигын эсрэг тэмцэл үр дүнтэй хэрэгжиж эхлэх бололтой байна. Шүүх, хууль хяналтын бүхий л тогтолцооны шинэчлэл түүний эд эсэд хүрч, тэднээс авлигатай хийх тэмцлийг шударга цогц хэлбэрт шилжүүлэхэд ч бас ихээхэн цаг хугацаа шаардагдах болж байна.

Энд тэмдэглэж хэлэх нэг зүйл бол иргэний нийгэм ойрын хэдэн жилд томоохон авлигачдыг илрүүлэх компани ажиллагаа явуулах хандлагатай байна. Энэ үйл явдал сонгуулийн болон өрсөлдөөний шинж чанартай хэдий боловч авлигыг бодитой устгаж чадна гэсэн нийгмийн сэтгэл зүйг бүрдүүлэх үндэс болох сайн талтай юм. Гэвч үүнээс үүдэн элитүүдийн дунд сөргөлдөөн, өөр хооронд барьцалдах байдал өсөх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргаа хоорондын харилцаа хурцдах, улс төрийн тогтворгүй байдал нэмэгдэх сөрөг үр дагавар бас гарч болох магадлалтай юм.

Ойрын жилүүдэд “далд эдийн засаг”, “далд хууль эрх зүй”, “далд улс төр” зэргийг илрүүлэн устгаж, ард олноос төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байгаа боловч цаашдаа энэ нь өргөжих, иргэдийн дэмжлэгийг авах төлөвтэй байгаа нь олон нийтийн дунд явуулсан судалгаануудаас харагдаж байгаа нь итгэл төрүүлж байна. Монголын нийгэм бүхэлдээ эдгээр хорт үзэгдлүүдийн эсрэг тэмцэлд нэгдсэн санаатайгаар оролцох идэвхтэй байгаа бөгөөд ингэхдээ энэ нь далд, амь бөхтэй үзэгдэл учир урт удаан хугацааны тэмцлийн үр дүнд л устгагдах болно гэдгийг мөн сайн ойлгох нь чухал байгаа юм.

Монголын нийгэмд учирч болзошгүй эрсдэл олон нийтийн оюун санааны хямралтай салшгүй холбоотой байгаа явдал бас ажиглагдаж байна. Монгол Улсын хүн амын аж амьдралын эрхэмлэх зүйл, гэгээн зорилго, зорилт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор оюун санааны хямралт байдалд орсон нь өнөө хэр дуусаагүй байна. Энэ хямрал, юуны түрүүнд хүмүүсийн дотоод ертөнцөд нийгэм-эдийн засгийн их өөрчлөлтүүдийн үр дагаврын нөлөө болон сүүлийн жилүүд дэх соёлын өв баялгийг хүртэх боломж буурсан зэргээс хамааралтай байлаа. Монгол Улсад оюун санаа, ёс суртахууны нөхцөл байдал хувьсамтгай байгаа нь уламжлалт буддын шашин, бөөгийн ёсон сэргэсэн, дэлхийн бусад шашны урсгал орж ирсэн, марксист ёс суртахууныг хурдан гээсэнтэй холбоотой байна. Оюун санааны хямрал цаашид үргэлжлэх нь олон тооны эрсдэлийг дагуулж болох аюултай хэмээн үзэж болохоор байна. Үүнд:

- Нийгмийн харилцаанд оюун санааны мухардмал байдал гүнзгийрвэл элдэв үүдэлтэй зөрчил сөргөлдөөний магадал өсөх;
- Ахмадууд ба залуусын үзэл бодлын ялгаанаас үүдэн зөрчил сөргөлдөөн үүсэж харилцан үл ойлголцох явдал газар авах;
- Сэтгэлгээний ядуурлын улмаас нийгмийн гутрангуй, идэвхгүй байдал нэмэгдэх;
- Хүмүүсийн оюуны соёл, боловсрол, мэдлэгийн төвшин ерөнхий хандлагаараа буурах, зааг ялгаа нь өсөн нэмэгдэх, улмаар бүх нийтийг хамарсан бүдүүлэг зан суртахуун, соёлгүй байдал нийгэмд ноёрхох;
- Нийгмийн болон оюун санааны шинийг сэтгэх чадвар саатаж, улс орны хөгжлийг хазаарлах түвшинд хүрэх зэрэг болно .

Дээрх эрсдэлүүд нь үндэсний эх оронч үзэл санаан дээр үндэслэсэн нийгмийн оюуны эрмэлзлийг бий болгох, улс орныхоо хөгжлийн төлөө гэсэн хамтын сэтгэлгээ бүрэлдэн бий болох, нийгмийн бүтээн байгуулах эрч хүчийг хүлээснээс чөлөөлөх явцыг удаашруулах зэрэг сөрөг талуудтай байна. Гэхдээ өнөө үед дээрх эрсдэлүүдийг амжилттай даван туулж, шинэ үзэл санаа, нийгмийн хөгжлийн шинэ стратегийн программ боловсруулах, оюуны амьдралын

хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох зэрэг үйл явцыг хурдацтай болгох таатай нөхцөл монголын нийгэмд бас хадгалагдсаар байгааг хэлэх нь зүйтэй юм.

Гэвч сүүлийн жилүүдэд манай нийгэмд газар аваад байгаа дээр дурдсан нийгэм, улс төрийн шинж чанартай элдэв сөрөг үзэгдлүүд нь оюун санааны амьдралыг либералчлах болон төрийн зүгээс соёл, урлаг, шинжлэх ухааны асуудлуудад тавих анхааралд хүчтэй сөрөг нөлөө үзүүлсээр байгаа бөгөөд энэ нь нийтэд чиглэсэн ухаалаг, энэрэнгүй соёл урлагийг төдийлөн дэмжихгүй байх, сэтгэхүйн зөв хэрэгцээний шаардлагад нийцэхээргүй болхи бүдүүлэг, мөнгөний хойноос хөөцөлдсөн урлаг, соёлын бүтээгдэхүүнийг бишрэн шүтэх явдлыг өөгшүүлэх зэрэг олиггүй байдлаар бас илэрч байгаа юм. Энэ бүхэн нь иргэний нийгмийн байгууллагууд, соёлт хүмүүсийн зүгээс гаргах хүчтэй шүүмжлэлтэй тулгарч зөрчил, сөргөлдөөнд ч хүргэж болзошгүй байна. Яваандаа оюуны амьдралын гэгээлэг хүрээнээс төр өөрөө шахагдах байдал ч гарч болох талтай юм. Энэ тохиолдолд төр алдаагаа ухаарч өөрийн байр сууриа оюуны амьдрал, соёл, урлагийн салбарт бататгах оролдлого хийх нь бас тодорхой юм.

Үүний зэрэгцээ чөлөөт нийгэм, эдийн засгийн зах зээлийн харилцаа гэх мэтийн хүрээнд барууны гэж нэрлэгддэг оюун санааны эрхэмлэх зүйлийн хүчтэй нэвтрэлт үүссээр байгааг анхаарах ёстой юм. Ер нь буддын шашин ба дорнодын соёл, гүн ухааны нөлөө суларч эхлэх хандлага үнэхээр байгаа бөгөөд барууны соёлыг бишрэн шүтэх үзэгдэл ихээхэн түгээмэл болсоор байгаа нь монголын нийгмийн бас нэг бодит зүйл юм. Энэ нь манай орны төрт ёс, соёл иргэншлийн уламжлалтай хүчтэй сөргөлдөөн үүсгэж стратегийн гэж хэлж болох нийгмийн эрсдэлийг үүсгэж болзошгүйг бид бас тооцож байх ёстой болж байна. Гэхдээ монголын нийгэм нь бусдын соёл, шашныг хүндэтгэж ирсэн олон зуун жилийн түүхэн уламжлалтай бөгөөд төр, засгаас ухаалаг бодлого хэрэгжүүлж чадах тохиолдолд ийм төрлийн эрсдэл, сорилтыг амжилттай туулж гарах, олон үндэстэн, соёл иргэншлийн үнэт зүйлсийг хослуулсан үндэсний оюун санааг шинээр бүрдүүлэн хөгжүүлэх чадавх монголын ард түмэнд бий гэдэг нь бас тодорхой юм.

### 3.3.3. Нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал

Дээр дурдсан Монголын нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй олон талт хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж үзэхэд нийгмийн салбарт дараах стратегийн эрсдэлүүд учрах магадал бодитой, өндөр байна. Үүнд:

- Нийгэм, эдийн засгийн хөгжил удаашрах, шударга бус байдал газар авах, ядуурал ихсэх зэрэг тохиолдолд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, Эх орноороо бахархах үзэл бүдгэрч бүхэлдээ гутранги, идэвхгүй сэтгэлгээ олны дунд ноёрхох;
- Хүн амын тодорхой хэсэг оюун санаа, эрүүл мэндийн доройтлын хэмжээнд хүрэхүйц ядууралд орох, боловсролын салбар хоцрогдолд нэрвэгдэх, иргэдээ эрүүлжүүлэх, гэгээрүүлэх замаар улс орны чанар, чансааг сайжруулах бодлогын хэрэгжилт удаашрах, тасалдах;
- Хүн амын аюулгүй байдлыг хангах бодлого доголдсоноос хуурамч, хадгалах хугацаа хэтэрсэн, хүний бие организмд хортой хүнс, эм тариа, хувцас, эд хэрэглэл гэх мэт зүйлүүд гаднаас орж ирэх, дотоодод үйлдвэрлэгдэх нь хяналтаас гарах, гадаад харилцаа өргөжиж хүн, мал, бараа бүтээгдэхүүний урсгал чөлөөтэй болох хэрээр элдэв халдварт өвчин тархах, үүний дотор ДОХ, нэн халдварт бусад өвчнөөр өвчлөгсдийн тоо өсөх;
- Улс орны хэмжээнд эрүүгийн нөхцөл байдал хяналтаас гарах, зохион байгуулалттай болон үндэстэн дамжсан гэмт хэргийн том бүлэглэлүүд бий болох, манай улсын нутаг дэвсгэрийг мансууруулах бодис, элдэв төрлийн зэвсэг, цөмийн түүхий эд, материал, хүн худалдаалахаар зөөвөрлөх, дамжуулах талбар болгох оролдлого гарах, тэдгээрийн хор уршиг нь улс орны улс төр, эдийн засгийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрэх.
- Монгол Улсын гадаад харилцаа өргөжих, нээлттэй болох хэрээр бусад орны амьдрах хэв маяг, эрхэмлэх үнэт зүйлсийн хүчтэй нэвтрэлт бий болох, үүнээс үүдэн үндэсний уламжлалт үнэт зүйлсийн үнэлэмжид эргэж буцалтгүй өөрчлөлт гарах;
- хүн төрөлхтний нийтлэг соёлыг дээдлэх, бусад шашныг хүндэтгэх үзэл болон монгол үндэстний төрөлх хэл, соёл, бурхны шашин, ёс заншил, удмын сан, угсаа гарвалиа хадгалан хамгаалах гэсэн эрмэлзлийн хооронд зөрчил, сөргөлдөөн үүсэх, энэ нь улс төржих замаар нийгэмд бухимдал үүсгэх зэрэг болно.

## **Дөрөвдүгээр бүлэг.**

### **ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС**

#### **4.1. Улс орны хөгжлийг удирдахад эрсдэлийг тооцох арга зүйн үндэс**

Төр улс, нийгэм, байгууллага, хувь хүний амьдралд янз бүрийн үүдэлтэй төрөл бүрийн аюул байнга заналхийлж байдаг нь түүхэн үзэгдэл бөгөөд тэдгээрийн учруулж болох хор уршиг, гай зовлон нь хүн төрөлхтнийг аюулаас хамгаалж, өөрсдийн тогтвортой хөгжлөө хангах зайлшгүй шаардлагыг бий болгодог билээ. Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад тохиолдож байсан ган гачиг, зуд, халдварт өвчин, газар хөдлөлт, үер, далайн хар шуурга, зэвсэгт халдлага довтолгоо, дайн байлдаан, терроризмын аюулууд тэдгээртэй болон хор уршигтай нь хийж ирсэн олон мянган жилийн тэмцэл үүний бодит гэрч юм. Энэ их өргөн далайц бүхий байгаль, нийгмийн онцгой аюулт үзэгдлүүдийн өмнө хүн төрөлхтөн байнга хүчин мөхсөдсөөр ирсэн боловч түүнээс учруулах хохирлыг багасгах арга замыг хайсаар, бас багагүй туршлага хуримтлуулсан юм.

Шинэ зууны эхэн болох бидний амьдарч байгаа өнөө үед дээрх аюулуудын эрсдэлийг таамаглах, үнэлэх, урьдчилан сэргийлэх, улмаар улс орны хөгжлийг удирдахад тэдгээрийн учруулж болох хор уршгийг тооцоход чиглэсэн системтэй мэдлэг хуримтлуулах, эдгээрийг удирдах онолын үндэслэл, арга зүйг боловсруулах, талаар улс орон бүхэн ихээхэн анхаарах болж эрсдэл судлал гэсэн шинжлэх ухааны бие даасан урсгал бий болох, түүнийг хөгжүүлэх асуудал улс орнуудын төрийн бодлогын түвшинд тавигдах хандлагатай байна.

Улс орны аюулгүй байдал, тогтвортой хөгжилд аюул занал учруулж болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглаж илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг нь тооцох, арилгах бодлого, үйл ажиллагааг төрийн удирдлагын түвшинд боловсруулан хэрэгжүүлэх ажлыг “эрсдэлийн удирдлага” гэж хураангуйлан нэрлэх болоод байгаа юм. Аливаа улс орон эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь дараах хоёр учир шалтгааны улмаас зайлшгүй тавигдаж байгаа болно. Нэгдүгээрт, өнөө үед хүн төрөлхтөнд учирч буй бүх нийтийг хамарсан шинж чанартай аюулын цар хүрээ, цаашдын хандлага нь улам бүр өсөн нэмэгдэж, үр дагавар нь тодорхой таамаглах аргагүй



болсоор байгааг хэн болгон ухамсарлан ойлгож эхэлсэнтэй холбоотой байна; Хоёрдугаарт, улс төр, нийгэм-эдийн засгийн хүрээнд үүссэн аюулт үзэгдлүүдийн хүрээ далайц, тэдгээрийн учруулж байгаа болон ирээдүйд учруулж болзошгүй хор хохирлын далайц нь эрчимтэй өсөн нэмэгдэж, нэрвэгдэгсдийн тоо хэдэн саяар тоологдох болж, дээр нь урьд өмнө тохиолдож байгаагүй цоо шинэ төрлийн аюул нүүрлэх болсон зэрэг юм.


Эрсдэлийг удирдах үйл ажиллагаа нь: эрсдэлийг урьдчилан харах; түүний магадлал, болзошгүй үр дагаврыг тодорхойлох; эрсдэлийн дүн шинжилгээ хийж хяналтыг зохион байгуулах; эрсдэлээс учруулах хохирлыг багасгах, түүнээс зайлсхийхэд чиглэсэн арга замыг тогтоох, үүний тулд шаардлагатай бодлого, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд чиглэдэг болно.

Эрсдэлийн удирдлага нь эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаж, түүний учруулж болзошгүй хор хохирлыг бууруулах, зайлсхийхэд шаардлагатай, чиглэл зорилго бүхий боломжит аргуудаас хамгийн оновчтойг нь сонгон авч, нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд, нөөц, цаг хугацааны хувьд хязгаарлагдмал нөхцөлд амжилттай хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэн удирдах үйл явц юм.

Эрсдэлийн удирдлагын зорилго, чиг үүрэг нь гадаад, дотоод дахь хүчин зүйлсийн нөлөөн дор байнга өөрчлөгдөж, тодотгогдож байдаг зүй тогтолтой байдаг.

Нийгмийн хөгжил түргэсэх, хэмжээ далайц нь ихсэх, зохион байгуулалт нь боловсронгуй болохын хэрээр эрсдэлийн тухай ойлголт тэлж, түүнийг шинжлэх ухааны үүднээс үнэлэх, дүгнэх асуудал улам бүр ээдрээ төвөгтэй болж, эрсдэлийн удирдлагын ач холбогдол өссөөр байна.

Эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт нь:



Зураг 4.1. Эрсдэлийг удирдах зохион байгуулалт

Зураг . -ээс харахад, эрсдэлийг удирдах үйл явц нь:

1. Үүсэж болох эрсдэлийг тандан илрүүлэх;
2. Бодитой учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, хянах;
3. Эрсдэлийг удирдах аргыг сонгох;
4. Сонгосон аргаа үр дүнтэй хэрэглэх;
5. Үр дүнг нь үнэлж дүгнэлт өгөх гэсэн хураангуйлсан дараалалтай байж болохоор байна.


Улс орны гадаад, дотоод нөхцөл байдлын өөрчлөлт янз бүрийн түвшинд илэрдэг нь улс төр, нийгэм-эдийн засгийн салбарын эрсдэлийг стратеги, тактикийн гэж ялгаатай төвшинд удирдахыг мөн шаарддаг болно. Аливаа эрсдэлийн төрөл, хэлбэр нэг бүрээр буюу тэдгээрт нийтлэгээр таарч нийцсэн удирдлагыг хэрэгжүүлэх нь эрсдэлийн удирдлагад тавигдах арга зүйн чухал шаардлага юм. Өөрөөр хэлбэл эрсдэлийн удирдлагын нэг хэлбэр, төвшин нь

нөгөөтэйгөө харилцан уялдаатай, хамааралтай байх ёстой юм. Жишээлбэл, Монгол Улс төр, нийгмийн ардчилал, эдийн засгийн чөлөөт зах зээлийн харилцаанд шилжих үед эдийн засгийн хэвшил, банк, санхүүгийн тогтолцоо, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харилцааны агуулга, аж ахуйг хөтлөхөд төр, засгийн гүйцэтгэх оролцоо зэрэгт системийн чанартай хувьсгалт гэж хэлж болох өөрчлөлтүүд гарсан явдал нь тухайн үеийн төр, засгийн удирдлагыг цаг хугацааны хувьд шахагдсан, далайц хэмжээний хувьд бага, стратегийн хувьд оновчтой бус боловч ч дайчин шуурхай, тактикийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хүргэж байсан юм.

Энэ нь тухайн үедээ нийгэмд багагүй эрсдэл учруулж, хор хохиролд хүргэж байсан хэдий ч нийгмийн хямрал, уналт улам бүр газар авахгүй байх, нөхцөл байдал өдрөөс өдөрт, сараас сард сайжрах бололцоог олгосон гэж манай орны төдийгүй гадаадын эрдэмтэд, судлаачид дүгнэдэг болно. Энэ туршлага нь тэр үеийн төр, засгийн удирдлага хэдийгээр өөрсдөө төдийлөн сайн ухаж ухаараагүй байж болох боловч эрсдэлийн удирдлагыг нийгэмд ардчиллыг хөгжүүлэх, чөлөөт зах зээлийн зарчимд эдийн засгийг шилжүүлэх, материалын болон оюуны өмчийг элдэв хязгаарлалтаас чөлөөлөх, тэдгээрийн хамгаалалтыг сайжруулахад чиглүүлж чадсан үр дүнтэй стратеги байсан юм.

Эцсийн дүндээ эрсдэлийн удирдлага нь өөрийн дотоод хүч боломж, сул талыг харгалзах, түүний дотор гадаад, дотоодоос учруулж болох аливаа аюул занал, таагүй нөхцөл байдлыг тооцоолох замаар улс орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн стратегийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зохистой чиглэлүүдийг зөвөөр сонгоход чиглэх учиртай болно.

## Үйл ажиллагааны гадаад нөхцөл, Хөгжил



Зураг 4.2. Эрсдэлийн удирдлагын механизм

Төр засгаас хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлага нь эцсийн дүндээ Монгол Улсын язгуур эрх ашгийг хамгаалахад чиглэх ёстой. Тухайлбал:

- Иргэдийнхээ амьдралын түвшнийг дээшлүүлэх;
- Улс орныхоо эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэх;
- Улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхыг хангах;
- Байгаль орчин, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлого нь улс орны тогтвортой хөгжлийг хангах хэрэгсэл болоход орчны нөлөөний тодорхойгүй, урьдчилан тааварлах боломжгүй байдал ихээхэн нөлөөлдөг. Тиймээс энэхүү урьдчилан тааварлах боломжгүй байдлын нөлөөг эрсдэлийн үнэлгээгээр дамжуулан гарч болох аюул, үүсэж болзошгүй нөлөөний магадлал хэлбэрээр тодорхойлж, түүнийгээ улс орны удирдлагыг урт удаан хугацаанд хэрэгжүүлэх арга барилд нэвтрүүлэх хэрэгсэл болгоход эрсдэлийн удирдлагын нэг мөн чанар

оршдог. Уламжлалт стратегийн удирдлагад эрсдэлийг тооцоолдоггүй байснаас, урьдчилан сэргийлэх, зайлсхийх арга замуудыг судалж тогтоодоггүй, урьдчилсан хамгаалалтыг бараг зохион байгуулдаггүй байжээ.

Тиймээс эрсдэлд өртөхийг байгаль, нийгмийн зүй тогтолт, хүчрэгдэшгүй үзэгдэл хэмээн үзэж, улмаар зөвхөн үр дагавар, хор холбогдлыг нь шуурхай арилгахад төрийн бодлогын гол анхаарлыг төвлөрүүлж ирсэн түүхтэй юм. Улсын хэмжээн дэх стратегийн эрсдэлийн байнгын удирдлага нь нийгэм-эдийн засгийн тогтолцооны бүрдэл хэсгүүдийн хөгжлийг жигд, тогтвортой, харилцан уялдаатай, байгаль, цаг уурын өөрчлөлтийн хандлагатай хамааралтай хангахдаа эрсдэлийг урьдчилан тооцоолж, хамгаалалтын үр өгөөж нь оновчтой байхад анхаарлаа төвлөрүүлдэг байна. Харин эрсдэлийн шуурхай удирдлагын үед гаднын нөлөөллийн талаарх мэдээллийг ашиглан тохиолдож буй үйл явцын үр дагаврыг багасгах, зөөлрүүлэхэд гол анхаарлаа чиглүүлдэг болно.

Улс оронд учирч болзошгүй эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь ерөнхий байдлаараа хоёр түвшинтэй байх нь Монгол Улсын хувьд тохиромжтой хэмээн төслийн баг үзэж байгаа юм. Үүнд: улсын хэмжээний; орон нутгийн хэмжээний гэж байх агаад тэдгээрт нийцсэн улс төрийн, хууль эрх зүйн, засаг захиргааны, эдийн засгийн механизм; эрсдэлийг бууруулахад чиглэсэн удирдлагын шийдвэрийг гаргах бэлтгэлийг хангах стратегийн удирдлагын зарчим, арга зүйн болон арга хандлага; урьдчилан сэргийлэх, үнэлгээ хийх арга хэрэгслүүд байх ёстой юм. Дээр дурдсан түвшин бүрд улсын болон орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргах бүрэн эрхээр хангагдсан удирдлагын субъектүүд бас байх учиртай болно. Энэ удирдлага нь улсын болон орон нутгийн амьдрал, төрийн засаг захиргааны бүтэц, зохион байгуулалт зэргээс хамаарч мөн тогтолцооны шинжтэй, хэд хэдэн дэд төвшинтэй байж болох талтай байна.

Ямар ч тохиолдолд, удирдлагын түвшин бүрд, өөрийн удирдах субъектийн онцлог, гаднын нөлөөний хэлбэр төрөл, шинж зэргээс хамаарч тохиолдож болзошгүй стратегийн эрсдэлийн жагсаалтыг гаргах, тэдгээрээс учруулж болзошгүй аюул заналыг үнэлэх, урьдчилан тооцоолох арга зүй, аргачлалыг тогтоох, стратегийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх хүч хэрэгслийг зохион байгуулж, бэлтгэх арга хэмжээнүүд хэрэгжиж байх ёстой болно. Улс оронд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэсэн

удирдлагын шийдвэр нь аль ч түвшнийх бай ялгаагүй, мэргэжлийн байгууллага, тусгайлсан комисс, шинжээчдийн зөвлөмж, үнэлгээний үр дүнд тулгуурлах бөгөөд урьдчилан боловсруулсан арга зүй, дүрэм журмын дагуу, харилцан хамаарал бүхий олон үүргийг хэрэгжүүлэх, тодорхой болон хослон нэгдсэн стратегийн шинж чанартай аюул заналыг үнэлж үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн тусгайлсан хөтөлбөрүүдийг боловсруулах нэг үндэслэл болох учиртай юм.

Ингэхдээ эрсдэлийг удирдах практик үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ улс төр, эдийн засаг, эрх зүй, захиргаа-зохион байгуулалтын тогтсон механизмуудыг ашиглах ёстой болно.

**Улс төрийн бодлогын хүрээнд** Монгол Улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах эрсдэлийн үнэлгээний онол, арга зүйн үндэс, зарчим, улс оронд учирч болох эрсдэлийг удирдах үзэл баримтлалыг боловсруулах бодлого, үйл ажиллагаа хамаарах бөгөөд Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Тэргүүний хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хариуцах бүрэн эрхэд хамаарах ёстой юм. Ялангуяа, эрсдэлийн үнэлгээний онол, арга зүйн үндсийг боловсруулах асуудлаар Монгол Улсын Шинжлэх Ухааны Академид чиглэл, үүрэг өгөх, захиалгат судалгаануудыг явуулах, тэдгээрийн үр дүнг ашиглах, стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн асуудлуудаар Засгийн Газарт зөвлөмж өгөх зэргээр ажиллах нь зүйтэй юм. Энд нэг зүйлийг зориуд тэмдэглэж хэлэхэд “Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” гэсэн нэртэй байж болох баримт бичгийн төслийг боловсруулах арга зүйн асуудал зүй ёсоор тавигдаж байна.

**Хууль эрх зүйн хүрээнд**, өнөөгийн байдлаар Монгол Улсын хууль эрх зүйн тогтолцоонд тусгагдаагүй, байраа эзлээгүй, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах механизм болж төлөвшөөгүй байгаа стратегийн эрсдэлийн удирдлагын асуудлыг боловсруулж оруулах асуудал чухлаар тавигдаж байна. Стратегийн эрсдэлд өртөх нь урьдаас мэдрэгдэж, мэдээллийн хэрэгслээр тарж, олон нийтийн санаа зовнилыг дуудаж эхэлсэн асуудлыг төр, засаг захиргааны аппарат мэдрэхгүй, мэдэрсэн ч хөтөлбөр, төлөвлөгөө, төсөв хөрөнгө нь тусгагдаагүй гэсэн шалтгаанаар эсвэл илүү хүч хэрэгсэл, зардал гаргахаас төвөгшөөсөн байдлаар үйл ажиллагаа явуулахгүй байж байгаад, аюулт үзэгдэл, гамшигт

нэрвэгдвэл стратегийн эрсдэлийн удирдлагын эс үйлдлийн хариуцлагыг хүлээх субъектийг тодорхой болгож ийм хариуцлага тооцох механизмыг бий болгох хэрэгтэй байгаа юм.

Мөн санаатай болон санамсаргүйгээр улс, нийгэм, байгаль орчин, экологид ихээхэн хэмжээний хохирол учруулж болзошгүй нөхцөл байдалд хяналт тавих механизмыг өргөтгөх, ард нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, үүргээ биелүүлээгүйн төлөөх болон зөрчил гаргагч нарт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг хуулийн заалтуудыг задлан өргөжүүлэх тодотгож дэлгэрүүлэх хэрэгцээ ч бас байгаа болно. Ган, зуд, гол мөрний үер, ой, хээрийн түймэр тохиолдох, уул уурхайн ашиглалтаас экологид үзүүлэх сөрөг нөлөө, хот суурин газрын агаарын бохирдолт, экологийн асуудал, ард түмний ядуурал зэрэг эрсдэл дагуулсан байгаль, нийгмийн үзэгдлийг урьдчилан харж чадаагүй, шуурхай арга хэмжээ авч зөөлрүүлэх асуудлыг шийдвэрлээгүйнхээ төлөө хүлээдэг хариуцлага хууль эрх зүйд тусгагдсан байх учиртай болж байна. Гамшиг зовлонд нэрвэгдсэн хойно нь ач буянаа төр засаг үзүүлээд байгаа юм шиг үйл явдлыг ямар нэг хэмжээгээр хязгаарласан ёс суртахуун, хуулийн заалт байхад ч буруугүй хэмээн төслийн баг үзэж байна.

Дээр дурдсан “Монгол Улсын төрөөс эрсдэлийн удирдлагын салбарт баримтлах бодлогын үндэс” гэсэн нэртэй байж болох баримт бичгийг боловсруулж Улсын Их Хурлаас батлан гаргах нь мөн хууль эрх зүйн хүрээнд эрсдэлийн удирдлагын зорилго, зорилтуудыг шийдвэрлэх асуудалд багтаж болох юм.

**Захиргаа–зохион байгуулалтын үйл ажиллагааны хүрээнд,** стратегийн эрсдэлийн удирдлага нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн учир түүнийг төлөөх хариуцлагыг Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөс шаардах түвшинд хүртэл ач холбогдлыг нь дээшлүүлэх хэрэгцээ шаардлага нэгэнт үүсэн бий болжээ. Энэ нь ҮАБЗ-ийн ажлын албыг энэ чиглэлээр хүчжүүлэх, үүргийн биелэлтэд тавих механизмыг бүрдүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм.

Эрсдэлийн удирдлагын ажиллах механизмыг өргөжүүлэх гүйцэтгэх засаглалын зохион байгуулалтын ажил ч үгүйлэгдэж байгаа болно. Улсын онцгой

комисс гэсэн “гал түймэр унтраах, зуд турханд өртөгсдөд тусламж үзүүлдэг” төдийгөөр ажлаа явуулдаг, Засгийн газрын бүтцийн бус түр зуурын байгууллага, түүнийг “даган баясах” үүргийг гол ажлаа болгосон Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах ажил ч захиргаа - зохион байгуулалтын хүрээний асуудал болон тавигдаж байна. Төрийн яам, агентлагуудаас хариуцсан асуудлын хүрээнд стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага, түүнийг тооцох механизм өнөөгийн захиргаа – зохион байгуулалтын тогтолцоонд үгүйлэгдсээр байна.

Эрсдэлийг удирдах төр, захиргааны хяналтын тогтолцоо мөр мөрөө хөөсөн байдалтай байгааг цэгцэлж, харилцан ажиллах, нэгдмэл үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтад оруулах ажлыг Засгийн газрын зүгээс зохион байгуулж, стратегийн эрсдэлийн удирдлагад оновчтой ашиглах механизмыг бүрдүүлэх нь нэн чухал байна. Үүний дотор экологийн, цаг уурын, мэргэжлийн, гаалийн болон хилийн хяналт гэх мэтийн үйл ажиллагааг зохицуулах, тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйлсийн өсөлт, бууралт, хувьсал өөрчлөлтийн талаар боловсруулж буй тэдний мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийх ажил манай оронд үндсэндээ алга байна.

Мэргэшсэн шинжээчдийн төрийн бус байгууллага, хамтлаг байгуулах, тэднээр төр өөрийн ачаанаас үүрүүлж, хяналт, үнэлгээний механизмыг улам бүр боловсронгуй болгох асуудал ч эрсдэлийн удирдлагын хүрээнд зохион байгуулагдаж хийгдэж, тодорхой үр дүнгээ өгч болох зүйл юм. Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь өнөө үеийн захиргаа – зохион байгуулалтын хүрээний эрсдэлийн удирдлагын чухал зорилт болж дэвшигдэн тавигдаж байна.

**Эдийн засгийн хүрээний** эрсдэлийн удирдлагын механизм нь шууд ба шууд бус гэсэн хоёр чиглэлтэй байдаг. Эдийн засгийн шууд зохицуулалт нь стратегийн эрсдэлийн удирдлагын ажил, арга хэмжээнд зориулсан тодорхой чиглэл зорилготой зүйл ангийг улсын төсөвт тусгайлан тусгаж төлөвлөснөөр илэрдэг. Бүр тодруулбал, стратегийн эрсдэлийг урьдчилан үнэлсний дагуу эрсдэлээс сэргийлэх, хамгаалах, хяналт тавих, үүссэн тохиолдолд үр дагаврыг багасгахад чиглэсэн ажилд зарцуулах хөрөнгө мөнгийг улс төсөвт зориуд суулгана гэсэн үг юм. Ингэхдээ, эрсдэлд өртсөн үед авч хэрэгжүүлэх ажил, арга



хэмжээний эн тэргүүний ач холбогдолтойд нь хөрөнгө, хүч хэрэгслийг төвлөрүүлэх, үргүй зардлыг аль болох багасгахад эрсдэлийн удирдлагын эдийн засгийн шууд зохицуулалт чиглэдэг байна.


Эдийн засгийн шууд бус зохицуулалтад, эрсдэлийг бууруулахад чиглэсэн зээл, татварын болон даатгалын механизмууд багтдаг. Стратегийн эрсдэлийг бууруулах, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгоход туслах чиглэлийн импортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн татварын хөнгөлөлтөөр, тийм бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэгч нарыг татварын бодлогоор, эрсдэлийг бууруулах, ажил арга хэмжээг дэмжихэд чиглэсэн нөөцөөр болон банк, санхүүгийн эрсдэлийн даатгалаар дамжин энэхүү шууд бус механизм үйлчилдэг. Даатгалын механизм нь улсын хэмжээний эрсдэлийн удирдлагад нэн чухал ач холбогдолтой болохыг “малын индексжүүлсэн даатгал”, манай өнөөгийн амьдралд үр дүнтэй дасан зохицож буйгаас харагдаж байгаа юм.

Дээр дурдсан, улс төр, хууль эрх зүй, захиргаа – зохион байгуулалтын болон эдийн засгийн хүрээний олон янзын, өргөн хүрээний бодлого, үйл ажиллагааг стратегийн эрсдэлийн удирдлагын арга, механизмаар зохицуулахын тулд удирдлагын босоо тогтолцоо, тэдгээрийн эрх үүргийн хуваарилалт, харилцан ажиллагаа, үйл ажиллагааны доороос дээш, дээрээс доош чиглэсэн урсгал бүрэлдэн бий болсон байх нь чухал юм. Ингэхдээ стратегийн эрсдэлийн удирдлагын дээрх механизмууд нь амьдрал, нөхцөл байдалтай уялдсан, уян хатан үйлчилгээтэй байх ёстой болно.

Ер нь Монголын нийгмийн нээлттэй, ардчилсан шинжийг илэрхийлэгч нэг хэсэг нь стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж буй үйл явц, энэ чиглэлээр дэлхийн хамтын нийгэмлэгтэй хамтран ажиллах чадвар байх болно. Улсын стратегийн эрсдэлийн удирдлага нь нийгэм – эдийн засгийн тогтолцооны хувьд болон удирдлагын үйл ажиллагааг төлөвшүүлэх, жигдрүүлэх замаар аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжигч байх нь ардчилал хөгжсөн орны нэг чухал шинж чанар байдаг нь үүнтэй мөн холбоотой юм.

#### **4.2. Эрсдэлийн үзүүлэлтэд тулгуурлан төрийн удирдлагыг хэрэгжүүлэх асуудал**

Монгол Улсын хэмжээнд улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санаа, техник технологийн гэх мэт амьдралын бүхий л хүрээнд стратегийн эрсдэлийн байдал, хандлагад тулгуурлан төрийн удирдлагын засаг захиргаа – зохион байгуулалтын удирдлагын механизмыг боловсруулахад ашиглаж болох арга зам, шалгуур үзүүлэлтүүдийг өмнөх бүлэгт дурдсан. Эдгээрт үндэслэн гүйцэтгэх засаглалын янз бүрийн төвшинд байж болох эрсдэлийн удирдлагын харилцан ажиллагааны ерөнхий бүдүүвчийг зургаар үзүүллээ.



Зураг 4.3. Гүйцэтгэх засаглалын эрсдэлийн удирдлагын харилцан ажиллагааны бүдүүвч

Дээрх бүдүүвч зургаас харахад, эрсдэлийн удирдлага нь хэд хэдэн төвшинтэй, харилцан хамааралтай байх ёстой нь харагдаж байна. Ингэхдээ төр, засаг захиргааны түвшинд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үндсэн гурван зарчим баримтлах ёстой болно. Нэгдүгээрт, улсын хэмжээний амьдралын асуудлыг эрсдэлтэй холбон авч үзэхдээ ангилалтай хандах (улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, техник, технологийн, байгаль, орчин, техногенийн гэх мэтээр) зарчмыг баримтлах; хоёрдугаарт, стратегийн эрсдэлийг улсын, төрийн яамд, агентлагуудын, орон нутгийн хэмжээнд шийдвэрлэж болох төвшнөөр үзүүлэлт, хэмжүүр тогтоох зарчмыг мөн баримтлах; гуравдугаарт, төвшин бүрд үндсэн салбаруудын хүрээний асуудал бүрээр (улс төрийн, эдийн засгийн, нийгэм, оюун санааны, техник, технологийн, байгаль, орчин, техногенийн гэх мэт) хэрэгжүүлэх цаг, хугацаа, хөрөнгө зардлаас хамаарч гурван бүлэгт (аюулгүй байдлыг байнга хангах, байнгын хяналт тавих, шуурхай шийдвэр гаргах гэсэн) хуваан үзэх зарчмыг баримтлах зэрэг болно. Удирдлагыг хэрэгжүүлэх үед энэ гурван бүлэг асуудал нь удирдлага ердийн, хэвийн байдлаар (ногоон гэрлээр) хэрэгжих;

удирдлагын хяналтад байнга байлгаж, шинжилгээ, үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг авч зохицуулан (шар гэрлээр) хэрэгжүүлж байх; эсвэл шуурхай арга хэмжээгээр (улаан гэрлээр) хэрэгжүүлэх гэсэн бэлэн байдлын зэрэглэлтэй байж болох юм.

Улс, нийгмийн амьдралын хүрээний эрсдэлийн удирдлагыг аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн босго үзүүлэлтүүдэд тулгуурлан хэд хэдэн арга замаар хэрэгжүүлж болно. Тийм арга замын нэгд, улс орны аюулгүй байдлын үзүүлэлт болон стратегийн эрсдэлийн үзүүлэлтийн үнэлгээг ашиглах арга орж болох юм. Үзүүлэлтүүдийн тоон утга болон чанарын үнэлгээнээс хамаарч удирдлагын зүгээс авах арга хэмжээ, хэрэгжүүлэх ажлын талаар тохирсон шийдвэрүүдийг гаргаж удирдлагыг хэрэгжүүлэх ёстой юм. Улсын хэмжээний стратегийн эрсдэлийн удирдлагын төвшин бүрээр улс, орон нутаг, хариуцлагын хүрээнээс хамаарч, холбогдох асуудлаарх үзүүлэлтүүдийн мэдээллийг байнгын цуглуулж, дүн шинжилгээ боловсруулалтыг хийж байх хэрэгтэй болно. Бид улсын хэмжээний стратегийн эрсдэлийг удирдах үүргийнхээ хүрээнд төрийн яам, агентлагуудаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц, тэдгээрийн үүргийн агуулгыг жишээ болгон дараах хүснэгтэд харуулав.

#### Хүснэгт 4.1

#### Улсын амьдралын хүрээний эрсдэлийг удирдах гүйцэтгэх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааны бүтцийн харилцаа

Гүйцэтгэх засаглалын байгууллагууд	Үндсэн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны хүрээ
Хууль зүйн яам	Хуулийн хүрээнд гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, чиглүүлэх улсын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ; Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах асуудлаарх улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Улс төрийн, нийгмийн;
Батлан хамгаалах яам	Эх орноо хамгаалах, батлан хамгаалах асуудлаар төр, олон нийтийн, орон нутгийн засаг захиргааны байгууллага болон аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх, зохицуулах асуудлаар улсын хэмжээний эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Улс төрийн;
Онцгой байдлын ерөнхий газар	Байгаль, техникийн болон нийгмийн шинжтэй онцгой үзэгдлийн үр дагавраас хүн амыг хамгаалах, улсын, төрийн бус болон хувийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг түүний хөнөөлөөс урьдчилан сэргийлэх ажил, үйл ажиллагаагаар чиглүүлэг өгөх чиглэлээрх улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Байгаль, техникийн болон нийгмийн;
Гадаад харилцаа,	Монгол Улсын гадаад улс орон, олон улсын байгууллагатай харилцах хүрээний улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг	Улс төрийн;

Эдийн засгийн хамтын ажиллагааны яам	хэрэгжүүлнэ;	
Сангийн яам	Улсын санхүү, зээл, мөнгөний бодлогыг боловсруулах, санхүүгийн хүрээний эрх зүй-удирдлагын хэм хэмжээг тогтоох, зохицуулах, татвар, гааль, даатгал, өр, зээлийн бодлого, зохицуулалтыг хийх, санхүү бүртгэлийн ажиллагаа, тайлан тооцоо гаргах, үнэт металл, чулуу олборлох, боловсруулах, үйлдвэрлэх ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих чиглэлээрх улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Эдийн засгийн;
Эдийн засгийн хөгжлийн яам	Эдийн засгийн хөгжил, эдийн засгийн гадаад харилцаа, худалдаа, гааль, улсын тоо бүртгэл, үнэ, монополийн эсрэг авах арга хэмжээ, улсын нөөц бүрдүүлэлт, гадаад, дотоодын үл хөдлөх хөрөнгө, тэдгээрийн байршил, жижиг бизнес эрхлэгчдийн асуудлаарх бодлого, эрх зүйн хэм хэмжээгээр улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Эдийн засгийн;
Эрүүл мэнд, спортын яам	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулах, эрх зүйн хэмжээ, стандартыг тогтоох чиглэлээрх стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Нийгмийн;
Барилга, хот байгуулалт, тээврийн яам	Барилга, хот байгуулалт, зам тээврийн асуудлаарх улсын бодлого, эрх зүйн хэм хэмжээний зохицуулалт, барилга, орон сууц, үйлчилгээний объект, авто болон төмөр зам байгуулалт, ашиглалт, улсын газрын зураг зүй, географийн объектын нэршлийн чиглэлээрх улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Эдийн засгийн, байгаль, техникийн;
Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яам	Мал аж ахуй, газар тариалан, хөнгөн болон хүнсний үйлдвэрийн асуудлаарх тогтвортой хөгжлийг хангах, нөхөн үйлдвэрлэлийг явуулах, байгаль, уур амьсгалын нөлөөд өртөгдөх, чиглэлээрх хууль, эрх зүйн зохицуулалт, нөөц бүрдүүлэлтийн улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Эдийн засгийн, байгаль, техникийн;
Эрдэс баялаг, эрчим хүчний яам	Эрдэс, байгалийн баялгийн олборлолт, ашиглалт, байгаль орчин болон экологийн нөлөө, түлш, эрчим хүчний үйлдвэрлэлт, ашиглалт, атомын цахилгаан станц байгуулалт г.м. асуудлаарх улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Эдийн засгийн, шинжлэх ухаан технологийн, байгаль, техникийн;
Боловсрол, шинжлэх ухааны яам	Боловсрол, шинжлэх ухаан, шинжлэх ухаан-техникийн, инновацын хөгжлийн асуудлаарх эрх зүйн хэм хэмжээг тогтоох, хөгжлийг хангах, өндөр технологийн, мэдлэг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн боловсруулах, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил, боловсрол олгох, мэргэшүүлэх, боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудын хөгжлийг хангах зэрэг асуудлаарх улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	шинжлэх ухаан технологийн, байгаль, нийгмийн, техногенийн;
Соёл, спорт, аялал жуулчлалын яам	Үндэсний соёл, урлагийг стратегийн эрсдэлээс хамгаалах улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Нийгмийн;
Мэдээлэл, холбооны	Холбоо, мэдээлэл, радио электроникийн хэрэгслийн асуудлаарх улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ;	Эдийн засгийн,

агентлаг		нийгмийн;
----------	--	-----------

Засгийн газар, яам, агентлагууд, орон нутгийн засаг захиргаа өөр өөрсдийн хариуцлагын төвшин дэх асуудлаар эрсдэл ямар зэрэглэлтэй байгаад байнга анхаарал тавьж, шинжилгээ, үнэлгээ хийж, “улаан гэрэл” асаж буй асуудлаар эрсдэл үүсэхээс зайлсхийх, магадлалыг багасгах, хор уршиг, үр дагаврын нөлөөг бууруулах шуурхай арга хэмжээ авч ажиллах ёстой юм. Хоёр ба түүнээс дээш асуудлаар “улаан гэрэл”-д орвол дээд төвшний удирдлагад асуудлыг тавьж, Засгийн газар, яам, агентлагуудын зүгээс тусламж дэмжлэг авах хэрэгтэй болно.

Өнөө үед улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлууд хөгжлийн даяаршлын үйл явцаас хамаарч хүрээ, далайц, хувьсал, өөрчлөлтийн хурд нь ихсэж буй нь эрсдэлийн удирдлагыг улам бүр ээдрээ төвөгтэй болгож байна. “Улаан гэрэл” ассан, хямралт байдал бий болсон эсэхийг шинжилж танин мэдэх, үнэлгээ өгөх асуудал нь шалгуур үзүүлэлтүүдийн сонголт, тэдгээрийн шалгуур босго утгыг тоон болон чанарын хэмжүүрийг оновчтой тогтоож чадсан эсэхээс ихээхэн хамаарах болж байна.

Бас тодорхой үр дагавартай, шууд танин мэдэх боломжгүй эрсдэлүүд ч байдаг. Энэ нь тусгайлсан боловсролтой, мэргэшсэн, нарийн мэргэжилтнүүдтэй, стратегийн эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийх чадвар өндөр байхыг шаарддаг. Тодруулж хэлбэл төрийн яамд, агентлагууд, орон нутгийн засаг захиргааны удирдлагын нэгжүүдэд өөрсдийн эрсдэлийн менежерүүд байх зайлшгүй шаардлагатайгаас гадна, асуудал хариуцсан мэргэжилтэн бүр өөрийн салбарын асуудлаар стратегийн эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийх чадвартай байх ёстой болж байгаа юм. Тэдний эрсдэлийн шинжилгээ, үнэлгээнд тулгуурласан дүгнэлт, санал, зөвлөмж нь зохих шатны дээд удирдлагын хүмүүс шийдвэр гаргах үндэслэл болох учир ихээхэн өндөр түвшинд хийгдэж байх ёстой нь ойлгомжтой зүйл юм. Хямралт байдлыг амжилттай даван гарах, удирдлагын үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулахгүй байх нь эрсдэлийг удирдах мэргэжилтнүүдийн мэргэшсэн байдлаас ихээхэн хамааралтай болно. Улсын стратегийн эрсдэлийн удирдлагыг дараах хоёр төвшинд хэрэгжүүлэх нь өнөөгийн хөгжлийн үед илүүтэй тохиромжтой байх болно хэмээн үзэж үзэж байна. Үүнд:

1. Улсын хэмжээний ажил, амьдралын салбаруудын хүрээн дэх эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа. Ийм удирдлагыг төрийн гүйцэтгэх засаглалын яам, агентлагууд өөр өөрсдийн хариуцах асуудлаар, тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн яам нийгмийн дотоод аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах; Тагнуулын ерөнхий газар олон улсын терроризмоос сэргийлэх, хамгаалах; Онцгой байдлын ерөнхий газар байгаль, техногенийн гаралтай болон галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх гэх мэт.
2. Улсын хэмжээнд эрсдэлийн удирдлагыг оновчтой явуулж, тогтвортой хөгжлийг хангах үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа. Ийм удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газраас явуулах бөгөөд тэдгээрийн шинжлэх ухааны үндэслэлийг Шинжлэх Ухааны Академийн болон салбарын хүрээлэнгүүд боловсруулж, судалгаа, шинжилгээний ажлаар дэмжиж өгөх ёстой болно.

Улсын хэмжээнд эрсдэлийн удирдлагаар, нийгэм - эдийн засгийн хөгжлийн үндсэн бүрдэл хэсгийн харилцан хамаарал, тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчны болон экологийн эрсдэлийн нөлөөний шинжилгээ, үнэлгээнд тулгуурлан тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалалтыг зохион байгуулах ажил, арга хэмжээг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд голлон анхаарах ёстойг энэхүү төслийн судалгаа харуулж байна. Хэрвээ, төрийн бодлогоор зохицуулагдах салбар хоорондын зохистой харьцаа, тэргүүлэх чиглэл, гадаад болон батлан хамгаалах, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн оновчтой бодлого алдагдвал эрсдэлийн удирдлагын үр ашиг төдийлөн өндөр бус байх нь бас тодорхой юм. Энэ нь манай орны хөгжлийн өнөөгийн шатанд эрсдэлийн удирдлагын хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдсээр байгааг нотолж байгаа хэрэг болно.

#### **4.3. Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны дүн шинжилгээ, үнэлгээний арга зүйн үндэс**

Төрийн удирдлагын үнэлгээ, шинжилгээний зарчмын гэж үзэж болох шинэ хэлбэрийн нэг бол эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ бөгөөд энэ нь улсын стратегийн удирдлагын тогтолцоонд эрсдэлийн удирдлага хэмээх зарчмын хэлбэр нэвтрэн орж ирснээр энэ үйл ажиллагааны цоо шинэ объект бий болсонтой холбоотой юм. Эрсдэлийн удирдлагын хяналт үнэлгээний объектын

ээдрээ түвэгтэй байдал, илэрхийлэгч үзүүлэлтүүдийн тогтолцоог боловсруулаагүй, тэдний шалгуур босго үзүүлэлтүүдийг тогтоогоогүй, асар их багтаамжтай, төрөл бүрийн утга бүхий, өөр өөр хэмжүүртэй, бас бүрэн төгс бус мэдээллийг боловсруулах шаардлагатай болоод байгаа зэрэг нь өндөр боловсрол бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэх хэрэгцээ шаардлага байгааг харуулахын зэрэгцээ шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэд энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг өргөн хүрээнд явуулах хэрэгтэйг харуулж байна.

Улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эрсдэлийн үзүүлэлтүүдийг ашиглахын тулд анхдагч өгөгдөхүүнүүдийг цуглуулах, илэрхийлэгч үзүүлэлтүүдийг шинжлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага тавигдаж байгаа юм. Эрсдэлийн үзүүлэлтэд үндэслэсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, төлөвшүүлэх нэг чухал хэсэг нь үнэлгээ, шинжилгээ (мониторинг)-ний тогтолцоо бөгөөд эрсдэлийн үнэлгээний илэрхийлэгч үзүүлэлт (индикатор) тус бүрийн шалгуур босго утгыг боловсруулж гүйцэтгэх засаглалын байгууллага, удирдлагад зөвлөмж болгон өгөх, дээрх утгаас жинхэнэ бодит байдал дээрх утга нь давсан, хэтэрсэн байгаа эсэхийг харьцуулах боломжийг олгох учиртай болно. Жинхэнэ утгаараа үнэлгээ шинжилгээ (мониторинг) нь үнэлгээний тогтоосон илэрхийлэгч үзүүлэлт (индикатор)-д байнга хяналт тавьж, нийтээр хүлээн зөвшөөрсөн арга зүйгээр тооцоо, шинжилгээг хийж, ашиг сонирхолд нь нийцэж буй объектуудад нөхцөл байдлын талаарх мэдээллийг байнга өгч, тэд өнөөгийн байдлаа зохицуулах, ирээдүйн хандлагаа төлөвлөх боломжийг олгоно.

Харин байгаль орчин, техногенийн шинжтэй онцгой нөхцөл байдлаас сэргийлэх, урьдчилан тооцоолох, нийгмийн тогтворгүй байдал, эрсдэлийн удирдлага, хямралт байдлаас сэргийлэх, урьдчилан тооцоолох хүрээний үнэлгээ шинжилгээ (мониторинг) нь арай өөр байх нь ойлгомжтой юм. Энэ нь дараах учир шалтгаантай холбоотой байна. Үүнд:

- Монгол Улс нь хөгжлийнхөө гараан дээр, ашиг орлого, алдагдал хүлээхийн аль алиных нь дэнэсэн дээр, боломж, алдааны аль алиныг үзэж болох нөхцөлд байгаа учраас нийгэм, эдийн засаг, экологи, хүн амын эрүүл мэнд, техник - технологи, нийгмийн сэтгэл зүйн байдлаар эрсдэлийн үнэлгээ шинжилгээ (мониторинг)-ний илэрхийлэгч үзүүлэлт (индикатор) нь өвөрмөц өөр, тэдгээрийн босго утга нь өөрийн онцлог утгатай байгаад;

- Улс орны амьдралын хүрээн дэх сүйрэлд хүргэх олон янзын хүчин зүйлийн түргэн, огцом хувьсамтгай байдал нь стратегийн шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай эрсдэлийн үнэлгээ шинжилгээ (мониторинг)-ний илэрхийлэгч үзүүлэлт (индикатор)-ийг сонгох онцлогийг бий болгоод зогсохгүй, шуурхай байдлыг хангах боломжийг бүрдүүлсэн байхад;
- Эрсдэлийн шинжлэх ухааны үнэлгээ (мониторинг) шинжилгээнд тулгуурласан шийдвэрийн цар хүрээ, үнэ цэн нь өнөө үед ердийн тогтвортой, хэвийн нөхцөлтэй харьцуулахад, нэлээд гүнзгий мэдээллийг шаардаад зогсохгүй, стратегийн ач холбогдол нь их байгаад;
- Улс оронд учирч болох эрсдэл, хямралын нөлөө нь ердийн амьдрал дахь байгаль, техникийн, нийгэм, эдийн засгийн хүрээн дэх онцгой байдлын улс орны хэтийн хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөнөөс илүү хурдтай өсөж, үнэлгээний ач холбогдол нь төдий хэмжээгээр нэмэгдэх хандлагатайд;
- Хямралт байдал, эрсдэлийн үнэлгээний алгоритм, онол, арга зүйн асуудал нь өнөө үед боловсруулалтынхаа шатанд явагдаж буй учир шууд аваад амьдралд нэвтрүүлэх, ашиглах боломжоор хязгаарлагдмал байгаад (энэ чиглэлийн мэргэжилтэн, судлаач, мэргэшсэн байгууллага бүрэлдэж бий болоогүй, төлөвшөөгүйд);
- Эрсдэлийн үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай статистик өгөгдөхүүн, мэдээлэл, тэдгээрийг боловсруулсан арга зүй нь шаардлага хангахгүй, нэлээд нь бий болоогүй, эргэлзээтэй, зайлшгүй магадлах шаардлагатай байгаа нь мэргэжилтнүүд авч ашиглах, зангилаа асуудлаар үнэлгээ дүгнэлт хийх боломжийг бүрдүүлээгүй байгаад;
- Монголын төр, нийгмийн байгуулал, эдийн засгийн хэвшилд хувьсгалын шинж чанартай их өөрчлөлтүүд явагдсан нь салбарын болон байгаль, нийгмийн шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын хуучирсан өгөгдөхүүн, мэдээлэл, онол, арга зүй удирдамжийг үгүйсгээд зогсохгүй, цоо шинэ прагматик бий болгох, төлөвшүүлэхийг шаардаж байгаа зэрэг болно;



Монгол Улсын эрсдэлийн удирдлагын шинжлэх ухааны үнэлгээ шинжилгээ (мониторинг)-ний тогтолцоо нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэх ёстой юм. Үүнд:

- Эх оронд тохиолдож болзошгүй аюул занал, эрсдэл, сорилтын аль алиныг сөрөн зогсох аргуудыг боловсруулж, үр дүнгээр нь стратегийн шийдвэр гаргах боломжит гарцуудыг байнга үнэлгээ хийж байх;
- Тэргүүлэх судлаачид, мэргэжилтнүүдийг нэгтгэж, шинжлэх ухааны суурь онол, тэдгээрийн аргуудыг ашиглан шинэ бөгөөд асар өргөн хүрээний нөхцөл байдлыг шинжлэх;
- Мэргэжилтнүүдэд ирэх мэдээллийн асар арвин урсгалыг нэгтгэн боловсруулалт хийх, итгэл үнэмшилтэй болгох, энэ үндсэн дээр урьдчилсан тооцоог гаргах;
- Суурь өгөгдөхүүний загварын мэдээллийн сан байгуулж, зарим нэн чухал шийдвэр гаргахад илүү бодит шинжлэх ухаанчаар ашиглах;
- Шинжээчдийн бүлгийн тогтолцоот ажиллагааг зохион байгуулж, тэдний арга зүй, аргачлал, урьдчилсан алгоритм, тэдгээрийн үнэн бодит чанарыг боловсронгуй болгож дээшлүүлэх;
- УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газрын аль нэгний эрх мэдэл доор байгуулж болох стратегийн эрсдэлийн үнэлгээ шинжилгээний байгууллагыг бий болгох, түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй, шаардлагатай мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх;
- Шинжлэх ухаан, мэдээллийн бүтцийн ажиллагаа нь улс орны удирдлагад стратегийн эрсдэлийн удирдлагаар зөвлөмж өгөх, үндэслэлтэй боломжит хөгжлийн загварыг боловсруулж өргөн барих;
- Улс орны шинжлэх ухааны чадавх, мэдээллийн шинэ технологийг ашиглаж байгаа мэдээллийг нэгтгэх тогтолцоог зохион байгуулах;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, шинжлэх ухааны үнэлгээ шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, төлөвшүүлэх ажлыг удирдан чиглүүлэх үүргийг хэрэгжүүлэхдээ Онцгой байдлын ерөнхий газар, Шинжлэх Ухааны Академийн чадавхыг ашиглах нь чухал болно. Сүүлийн он жилүүдийн байдлаас ажиглахад, төр, засгийн удирдлага, төрийн байгууллагууд гаднаас үзүүлж буй болон дотоодод үүсэж буй гэнэтийн тохиолдлуудад бэлэн бус байх, богино

хугацаанд, хязгаарлагдмал, бүрэн бус мэдээлэлд тулгуурлан, хуудуутай шийдвэр гаргах нь цөөнгүй байлаа. Үүнээс болж хүний амь нас, эд хөрөнгийн багагүй хохирлыг амсаж байв. Зүй нь шинжлэх ухааны үнэлгээ шинжилгээний тогтолцоог эртхэн бүрдүүлсэн байсан бол тэдгээрт зохих ёсны хариу үзүүлэх бэлтгэлтэй, хохирол, үр дагаврыг нэлээд хэмжээгээр багасгах боломж гарах байсан юм.

Энэ бүхэн нь шинжлэх ухаанч үнэлгээ шинжилгээний тогтолцоо нь эрсдэлийн үзүүлэлтийг ашиглан улс орныг удирдах тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болохыг харуулж байгаа юм. Шинжлэх ухааны үнэлгээ шинжилгээний тогтолцоо нь улс, нийгэм, хувь хүний аюулгүй байдлыг хангах, стратегийн эрсдэлд өртөх байдлыг багасгахад төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаатай уялдаж байх нь чухал юм. Улс орны нийгмийн амьдралын бүх хүрээнд янз бүрийн чиглэл, хүрээнд хийгдэх үнэлгээ шинжилгээ, удирдлага нь харилцан хамааралтай байх бөгөөд төрийн захиргааны төв болон нутгийн захиргаа, эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх, агуулгыг нь тодорхой болгохыг шаардаж байна.

Эрсдэлийн шинжлэх ухааны үнэлгээ шинжилгээний тогтолцоог бүрдүүлснээр дараах асуудлуудыг шийдвэрлэж болох юм. Тухайлбал:

- Улс орны тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээний үзүүлэлтүүд, статистик мэдээллийг боловсруулах;
- Улс, нийгэм, хувь хүний амьдралын үндсэн хүрээн дэх стратегийн эрсдэл, аюулгүй байдлыг хөгжлийн хандлагатай уялдуулан үзүүлэлт, шалгууруудыг үнэлэх;
- Улс, нийгэм, хувь хүний амьдралын янз бүрийн хүрээнд синергетикийн болзошгүй үйлчлэл, нөлөөг үнэлэх;
- Төр Засаг, яам, агентлаг болон орон нутгийн засаг захиргааны удирдлагад зөвлөмж бэлтгэж өгөх.

Шинжлэх ухааны үнэлгээ шинжилгээний тогтолцоог бүрдүүлэхийн тулд зохион байгуулалт, шинжлэх ухааны болон боловсон хүчний холбогдолтой олон асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй юм. Юуны түрүүнд, улсын удирдлагын зохион байгуулалтын бүтэц, шинжлэх ухааны болон судалгаа шинжилгээний бүтцийг

хөгжүүлж төлөвшүүлэх, эрсдэлийн үзүүлэлтүүдийг ашиглан шийдвэр гаргахад нэн шаардлагатай мэдээллийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, зөвлөмж бэлтгэх ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Үнэлгээ шинжилгээний тогтолцооны төсөл дэх нэн чухал бүрдэл хэсэгт стратегийн эрсдэлийн бүх үзүүлэлтийн төвшин, бүтцийг үндэслэлтэй тогтооход чиглэсэн шинжлэх ухааны судалгааны ажлыг гүйцэтгэх ажиллагаа багтана. Шинжлэх ухааны үнэлгээ шинжилгээний тогтолцоо нь Монголын Шинжлэх Ухааны Академи болон төрийн яамд, агентлагууд болон их сургуулиудын шинжлэх ухааны байгууллагуудын нөөцөд суурилж, дараах ажлыг гүйцэтгэж болох юм. Үүнд:

- Анхдагч өгөгдөхүүнүүдийн баазын хуваарилалт;
- Хямрал, сүйрлийг урьдчилан тооцоолох судалгаа, шинжилгээний ажлын үр дүн;
- Орчин үед Монгол Улсад үүсэж болзошгүй хямрал, тохиолдож болзошгүй сүйрлийн талаар газарзүйн байрлалын мэдлэгийн бааз (банк);
- Улс орны нийгэм-эдийн засгийн математик загварчлалын бааз;

Төгсгөлд нь тэмдэглэхэд шинжлэх ухаанч үнэлгээ шинжилгээний тогтолцоог бодитой бүрдүүлэх төлөвшүүлэх, үйл ажиллагааг жигдрүүлэхийн тулд юуны түрүүнд, эрсдэлийн удирдлага, эрсдэлийн шинжилгээ хийх боловсон хүчнээ бэлтгэх, давтан бэлтгэх хөтөлбөр, стандартыг гаргах шаардлага тавигдаж байна.

## ТӨГСГӨЛ

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсын стратегийн эрсдэлийг урьдчилан тооцоолох, таамаглах, шинжлэх, үнэлгээ өгөх үзүүлэлтүүдийг боловсруулах, тэдгээрийн хэмжүүрийг тогтоох онол, арга зүйг боловсруулахад чиглэсэн бөгөөд судлаач, суралцагч нарт асуудлыг ойлгомжтой байлгах үүднээс үнэлгээний арга зүйг тодруулж, үнэлгээ хийх загварыг тусгайлан тусгасан болно.

Улсын стратегийн эрсдэлийг үнэлэх онол, арга зүйг асуудлыг судалгааны ажлын хязгаарлалтын хүрээнд улс төрийн хүрээний, эдийн засгийн, нийгмийн, шинжлэх ухаан технологийн, экологийн эрсдэл гэсэн таван багц асуудлаар тус тусад нь авч үзсэн бөгөөд тэдгээрийн онол, арга зүй дэх онцлог, үзүүлэлтүүдийн ялгаа, хэмжүүрийн шинж чанарыг илэрхийлсэн юм. Энэ нь тухай тухайн асуудлаар төр, засгийн удирдлага, мэргэжилтэн, судлаачид, шинэ залуу боловсон хүчнүүд эрсдэлийн түвшнийг ойлгох, танин мэдэх, эрсдэлийн удирдлагыг оновчтой хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд практик ач холбогдолтой байх болно.

Судалгааны ажлын үр дүнгээр дараах дүгнэлтийг хийж болох юм.

1. Улсын стратегийн эрсдэлийн онолын боловсруулалтыг улам гүнзгийрүүлэх эхлэл үүгээр тавигдаж байгаа бөгөөд эрсдэл тус бүрийн зүй тогтол, үйлчилж буй байгаль, нийгмийн хууль, эрсдэлийг бууруулах, түүнээс сэргийлэх, хамгаалалтын чадавхыг дээшлүүлэх зарчим, хэрэгжүүлэх арга зам, механизмыг онол, арга зүйн хувьд цэгцтэй онол болгон хөгжүүлэхэд таатай боломжийг олгож байна.
2. Эрсдэлийн үнэлгээг тайланд тусгасан арга, аргачлалаар эхлүүлж, цаашид түүнийгээ улам боловсронгуй болгож, бодит байдалд улам бүр ойртуулах, дахин дахин тодотгож сайжруулах, улмаар стандарт арга зүйг боловсруулах боломжтой болж байна.
3. Улсын стратегийн эрсдэлийн онол, арга зүйг ашиглан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсүүдийн болон аймаг, орон нутгийн стратегийн асуудлаар эрсдэлийг үнэлж болох талтай болж байна. Үүний тулд

тогтолцоот шинж чанартай үзүүлэлтүүдийг оновчтой сонгох, хэмжүүрийг тогтоох шаардлагатай бөгөөд ингэхдээ тайланд тусгасан онол, арга зүйг удирдамжийг үндэс болгох нь хөдөлмөрийг хөнгөвчилсөн хэрэг болно.

4. Улс нийгмийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлс ихсэж буй өнөө цаг үед, эрсдэл учруулж болох зүйл, тохиолдол нэг бүрийг үнэлж, дүгнэж чадсанаар төлөвлөлтийн чанар чансааг дээшлүүлэх, эрсдэлийн удирдлагыг явуулах боломж шат шатны удирдлага, удирдлагын байгууллагад бий болно.
5. Нийгэм, эдийн засаг, оюун санааны хүрээнд даяаршил явагдаж, даяарших, дангааршихын зохистой харьцааг бүрэлдүүлэн төлөвшүүлэхэд стратегийн эрсдэлийн онол, арга зүйн удирдамж зүйрлэшгүй их ач холбогдолтой болж байна.

**“СТРАТЕГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САЛБАРТ ТӨРӨӨС  
БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС” БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ**

Суурь судалгааны төслийн үр дүн 2

# **“СТРАТЕГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС” БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ**

## **Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1.1. Олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт**

1.1.1. Стратегийн ач холбогдол бүхий чухал бүс нутаг, газар нутаг, тэнгис далайн сав нутгийн төлөөх дэлхийн том гүрнүүдийн өрсөлдөөн улам бүр цэрэг, стратегийн утга агуулгатай болж, дэлхий нийтийг бүхэлд нь хамран, хурцдах төлөвтэй байна.

1.1.2. Хүн төрөлхтний хөгжлийн төв буюу том гүрнүүдийн өрсөлдөөн аажмаар дорно зүгт шилжиж байна.

1.1.3. Олон улсын нөлөөллийн бүс нутгийн дахин хуваарилалтад Европ, Хойд Америкийн зэрэгцээ олон зуун сая, тэрбумаар тоологдох хүн амтай Хятад, Энэтхэг болон лалын гэгдэх ертөнц хүч түрэн орж ирж байна.

1.1.4. Том гүрнүүдийн өрсөлдөөний объектод цэрэг-стратегийн хувьд чухал болон эдийн засгийн чухал ач холбогдол бүхий район, бүс нутаг, далай тэнгисийн сав газрын зэрэгцээ байгалийн баялаг их хэмжээгээр төвлөрсөн болон нэгдмэл соёл иргэншилт үндэстэн ястан төвлөрөн суурьшсан газар нутаг бас хамаарах боллоо.

1.1.5. Цэрэг, стратегийн хувьд өндөр ач холбогдол бүхий тив дэлхий, бүс нутгийг өөрийн эзэмшилд буюу нөлөөндөө байлгах нь соёл иргэншлүүдийн нөлөөллийн өндөр статус, аюулгүй байдлын түвшин, эдийн засгийн хөгжлийн чадавхын илэрхийлэл болж байна.

1.1.6. Нөлөөллийн орон зайн төлөөх том гүрнүүдийн өрсөлдөөний хүч хэрэгсэл, арга хэлбэр хүн төрөлхтний амьдралын бүх салбарыг хамран өргөжиж, зөрчил, сөргөлдөөний гол талбар нь эдийн засаг, олон улсын худалдааны зах зээл, оюун санаа, соёл иргэншлийн үнэт зүйлсийн өрсөлдөөн болж хувирах талтай байгаа боловч үүнтэй зэрэгцэн цэрэг, зэвсгийн хүчээр асуудлыг шийдвэрлэх хандлага улам бүр газар авсаар байна.

1.1.7. Эцсийн дүндээ энэ зууны дунд гэхэд хүн төрөлхтөн соёл, иргэншлийн хуваарилалтын шинэ эринд амьдарч болзошгүй байна. Үүний дотор Хятад, Энэтхэгийн соёл иргэншил хүч түрэн гарч ирж, Европын соёл иргэншлийн нөлөө ихээхэн сулран, Хойд Америк танигдахын аргагүй өөрчлөгдөх магадлалтай байна. Гэхдээ дэлхий ертөнц илүү ёс суртахуунтай, байгаль орчинтойгоо зохицсон, ухаалаг болох төлөвтэй байна.

## **1.2. Олон улсын харилцаан дахь Монгол Улсын олон улсын ач холбогдол**

1.2.1. Сүүлийн жилүүдэд Монгол Улс том гүрнүүдийн ашиг сонирхлын өрсөлдөөний шинэ төв хэмээн нэрлэгдэх боллоо. Манай орны эргэн тойронд бий болсон олон улсын шинэ нөхцөл байдал нь ардчилал, эдийн засгийн зах зээлийн харилцааны замыг сонгосон 1990-ээд оноос бүрдэж эхэлсэн юм. Үүний гол учир шалтгаан нь Монгол орон Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашин, төр, нийгмийн байгууллын өөр хоорондоо ялгаа бүхий улс орнуудын зах нийлсэн заагт, Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд байдагт оршиж байна. Ер нь Евроазийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны стратегийн ач холбогдол бүхий чухал байршил нь эртнээс дэлхийн том гүрнүүдийн анхаарлын төвд байсаар ирсэн билээ.

1.2.2. Монгол Улс бага орон гэлтгүй олон улсын өрсөлдөөний талбарт идэвхтэй тоглогч болон хувирсныг хэн бүхэн хүлээн зөвшөөрөх боллоо. Энэ нь нэг талаасаа алт, уран, нүүрс, зэс, газрын ховор элементүүд, бусад ашигт малтмалын асар том ордыг ашиглахдаа гадаадынхантай хамтрах асуудлыг монголчууд харьцангуй сайн шийдвэрлэж чадаж байгаатай, нөгөө талаасаа, төр нийгмийн ардчилсан тогтолцоог амжилттай хэвшүүлж буй социализмын дараах Дорнын ганц орон гэдгээрээ олон улсад ихээхэн нэр хүнд хүлээх болсонтой шууд холбоотой байна.

1.2.3. Эрдэс баялгийн улам бүр нэмэгдэж буй хэрэгцээ, үүнийг дагасан үүнийн эрс өсөлт, эдгээртэй зэрэгцүүлэн эх орныхоо баялгийг ухаалгаар ашиглах, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн, иргэний ардчилсан нийгэм байгуулахын төлөө хийж буй Монголын төр засгийн болон нийт иргэдийн идэвхтэй тэмцэл манай орны олон улсын харилцаан дахь ач холбогдлыг ихээхэн нэмэгдүүлж байна.



1.2.4. Монгол Улсын энхийг эрхэмлэсэн олон тулгуурт гадаад бодлого, гуравдагч хөршийн үзэл баримтлал, цөмийн зэвсгээс ангид статус, Хойд Солонгостой харилцахдаа баримталж буй байр суурь зэрэг нь нь их гүрнүүдийн зүгээс Зүүн хойд Азийн тухайд болон манай орны талаар баримтлах бодлогодоо анхаарах зайлшгүй учир шалтгаан болж байна.

### **1.3. Монгол Улсын олон улсын ач холбогдлын давуу тал, чадавх**

1.3.1. Төрийн тусгаар тогтнол, газар нутаг, монгол үндэстэн, соёл иргэншлээ хэдэн зуун, мянган жилийн турш хадгалан хамгаалж ирсэн цэрэг-эх оронч өндөр сэтгэлгээ бүхий ард түмэнтэй;

1.3.2. Онгон тансгаараа хадгалагдан үлдсэн эрүүл байгаль орчин, газрын доор орших асар их эрдэс баялаг, сэргээгдэх эрчим хүчний барагдашгүй их нөөц бүхий уужим тал, малын бэлчээр, уул ус, ургамал жигдрэн зохицсон, хангай говь хосолсон өргөн уудам газар нутагтай;

1.3.3. Хүн амын тоо цөөн боловч чанар сайтай, төрөлх хэл, соёл, уламжлал зэрэг түүхэн мөн чанар, оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, өвөг дээдсээсээ уламжлан ирсэн үр, удам, төрөлх газар нутгаа хамгаалах өндөр сэтгэлгээтэй;

1.3.4. Түүхийн ямар ч нөхцөл байдалд үндэстний онцлох шинж чанараа хадгалах, дахин сэргээж ирсэн уламжлалтай;

1.3.5. Өөрийн орны давуу тал, уламжлалаа баяжуулан хөгжүүлэх, оюун санаа, соёл иргэншлийн өвөрмөц шинж чанараа бусдаар хүлээн зөвшөөрүүлэх гүн эрмэлзэлтэй;

1.3.6. Манай иргэдийн ёс суртахууны болон үйл хөдлөлийн загвараар илэрхийлэгдэх үндэсний соёл иргэншлийн дархлаатай;

1.3.7. Үндэсний соёл иргэншлийн дархлаагаа хадгалан хамгаалах төрийн хатуу чанд үзэл бодолд тулгуурласан аюулгүй байдлын салбарт төрөөс баримтлах бодлогын уг сурвалжтай. Энэ бодлогын язгуур үндсийг тодорхойлж хадгалан хамгаалах үндэстний удирдагчдын болон ухаантнуудын эрхэм чухал үүрэг байдаг.

#### **1.4. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын баталгаа.**

1.4.1. Монгол соёл иргэншил бусдад дарамтлагдаж, дайнд нэрвэгдэж, харийнханд сүйтгүүлэгдэж, элдэв бусад аюулд өртөж байсан боловч өөрсдийн уламжлалт үнэт зүйлс, амьдрах эрчим хүч, соёл иргэншлийн дархлаагаа хадгалж ирсэн дайчин уламжлалтай. Энэ дайчин уламжлалаа нэр төртэйгөөр үргэлжлүүлэх нь монгол үндэстэн оршин тогтнож, өөдлөн хөгжих, түүний үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байна.

#### **Хоёр. МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨР, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРТ УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ СОРИЛТ, АЮУЛ ЗАНАЛ.**

##### **2.1. Учирч болзошгүй эрсдэл.**

2.1.1. Олон улсын аюулгүй байдлыг хангах өнөөгийн механизмууд, юуны өмнө НҮБ, ЕАБХАБ зэргийн үүрэг, ач холбогдлыг бууруулах гэсэн зарим том гүрний эрмэлзэл хүчтэй нэмэгдэж байна;

2.1.2. Олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд бага орнуудыг аль болох оролцуулахгүй байх, тэднийг үл тоомсорлох хандлага газар авах боллоо;

2.1.3. Улс хоорондын харилцаанд цэрэг-улс төрийн эвсэл холбоодыг бэхжүүлэх, юуны өмнө НАТО-г дорно зүгт тэлэх, Орос, Хятадын цэрэг-стратегийн хамтын ажиллагааг холбоотны хэмжээ рүү ойртуулан гүнзгийрүүлэх эрмэлзэл ажиглагдаж байна;

2.1.4. Улс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр зэвсэгт хүчнээ ашиглах практик АНУ, Орос, Хятад, Турк гэх мэт орнууд болон НАТО-ийн тухайд хэвийн үзэгдэл болох төлөвтэй байна. Тэр ч байтугай үүнийгээ цэрэг-стратегийн номлолдоо тусгадаг болоод байна.

2.1.5. Тэргүүлэгч зарим гүрний технологийн хөгжлийн хэт тасархай байдал улам нэмэгдэж, шинэ үеийн зэвсэг, байлдааны техник бүтээх чадавх нь ихсэж байгаа нь зэвсэглэлийн чанараар өрсөлдөх шинэ үе шатыг авчирч, байлдааны ажиллагааны арга хэлбэрт эргэлтийн гэж хэлж болох өөрчлөлт оруулах

магадлалтай байна.

2.1.6. Олон улсын терроризм дэлхий нийтийн хэмжээний, олон талт шинж төрхтэй болж байгаа бөгөөд бүх улс орны аюулгүй байдалд ноцтой, нийтлэг аюул занал учруулах боллоо.

## **2.2. Үүсэж болзошгүй аюул заналын тухай төсөөлөл.**

2.2.1. Монгол Улсын эргэн тойронд буй болсон олон улсын шинэ нөхцөл байдал, үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж үзэхэд ойрын болон дунд хугацааны ирээдүйд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдал, төрийн байгуулалтад гаднаас цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул үндсэндээ байхгүй байна.

2.2.2. Манай улсын олон улсын нэр хүнд сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн, хөрш хоёр оронтойгоо элдэв маргаантай асуудлаа олон улсын эрх зүйн хүрээнд эцэслэн шийдвэрлэсэн, энэ хоёр улстай болон гуравдагч бусад хөрштэйгөө тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин хөгжиж байгаа нь ийм дүгнэлтэд хүргэж байна.

2.2.3. Үүний зэрэгцээ бүс нутгийн хүрээнд үүсэн Монгол Улс татагдан орж болох эсвэл өөр бусад гадаад хүчин зүйлээс үүдэн манай улсын дотоодод үүсэж болох дараах аюул занал бодитойгоор оршиж байна.

2.2.4. Бүс нутгийн олон улсын нөхцөл байдлаас үүдэн Монгол Улс татагдан орж болзошгүй аюул занал:

- Олон улсын терроризм улам бүр хүрээгээ тэлж Зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийг, түүний дотор Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамрах;

- Улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжлийг даган Ази тивд цэрэг-улс төрийн нөлөөллөө өргөжүүлэх энэ улсын эрмэлзлийг төрүүлэн үүний улмаас үүнтэй ижил төстэй ашиг сонирхол бүхий ОХУ болон АНУ-тай ноцтой, өргөн хүрээтэй зөрчилдөхөд хүргэх, үүнд нь Монгол Улс татагдан орох;

- Хоёр Солонгос, Хятад-Тайвань, Энэтхэг-Пакистан хоорондын эсрэг тэсрэг байр суурь, Курилийн арлуудын талаарх Орос-Японы маргаан зэрэг нь улс хоорондын харилцааны тодорхой нөхцөл байдалд зэвсэгт мөргөлдөөнд хүргэх. Энэ нь бүс нутгийг хамарсан шинжтэй болж өргөжин Монгол Улсыг ямар нэг хэлбэрээр хамрах;

- Ази, Номхон далайн бүс нутагт улам бүр өсөн нэмэгдэж буй НАТО-ийн цэрэг-улс төр, эдийн засгийн нөлөөг хязгаарлах зорилго бүхий Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн үйл ажиллагаа өргөжин үүний үр дагавраар АНУ, Барууны орнууд нэг талаас болон нөгөө талаас Орос, Хятадын хооронд цэрэг, зэвсгийн хүчийг тулгуур болгосон зөрчил, сөргөлдөөн үүсэх, үүнд Монгол Улс татагдан орох;

- 2008 онд тохиолдсонтой төсөөтэй нийтийг хамарсан эдийн засгийн хямрал Ази тив болон Зүүн Хойд Азид бий болж энэ нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах буюу зогсонги байдалд оруулах;

- Хөрш зэргэлдээ болон бусад оронд үүссэн хямралт байдлаас үүдсэн хяналтаас гарсан цагаачлал, жирийн болон зэвсэглэсэн дүрвэлтэд нэрвэгдэх зэрэг болно.

#### 2.2.5. Уламжлалт бус аюул занал:

2.2.5.1. Олон улсын ээдрээтэй нөхцөл, улс төрийн тогтворгүй байдал, үндэсний эдийн засгийн хямрал, нийгмийн хуваагдал, түүний дотор шашин хоорондын харилцааны зарим нэг зөрчил сөргөлдөөн зэрэг нь манай орны аюулгүй байдалд учрах гадаад, дотоод үүдэлтэй уламжлалт бус аюулын эх сурвалж болж байна.

2.2.5.2. Ойрын ирээдүйд гадаад, дотоод аливаа хүчин зүйлээс үүдэн дотоодын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй уламжлалт бус гэж хэлж болох дараах аюул занал үүсэж болзошгүй байна. Үүнд:

#### 2.2.5.3. Улс төрийн хүрээнд:

- Монгол Улсад стратегийн ашиг сонирхлоо хадгалах, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон эдийн засгийн бусад чухал салбарт давамгайл байдлаа бий болгох гэсэн том гүрнүүдийн зөрчил сөргөлдөөн болон тэдгээрийн манай улсын

тухайд явуулж буй тус тусын тодорхой чиглэл, зорилго бүхий бодлогын нөлөөлөл, үр дагавраас үүдэн Монгол Улсын төр засгийн бодлогод саад бэрхшээл үүсэх, аль нэг улс орон, улс төр-цэргийн эвсэл холбоо буюу үндэстэн дамжсан том корпорацуудаас улс төрийн хувьд ямар нэгэн байдлаар хараат байдалд орох;

- Олон улсын терроризм улам бүр газар авч байгаа болон манай улс терроризмын эсрэг барууны эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гаднын хүчний явуулгын улмаас энэ аюул ямар нэг хэлбэрээр Монгол Улсад орж ирэх;

- Монгол Улсын геополитик, цэрэг-стратегийн түшиц нутгийн ач холбогдол улам бүр өсөх болсонтой уялдаатайгаар гадаад орнуудын зүгээс манай орны эсрэг явуулах тагнуулын болон бусад үйл ажиллагаагаа нэмэгдэх, энэ нь чиглэл, зорилготой, нийгмийн тодорхой хэсэг бүлэг рүү чиглэсэн агуулгатай болох.

#### 2.2.5.4. Эдийн засгийн хүрээнд:

- Гадаадын хөрөнгө оруулалт, бусад улстай хийх худалдааг тэнцвэржүүлэх нэгдсэн бодлого алдагдах, үүнээс үүдэн улсын хөгжил удаашрах, зогсонги байдалд орох;

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлого, үйл ажиллагаанд алдаа, доголдол гарах, үүний улмаас эдийн засгийн салбарт тогтворгүй байдал үүсэх, мөнгөний бодлого, валютын зах зээлийн хямрал гарах, дампууралд орох, улмаар Монгол Улсын банк, санхүүгийн үйл ажиллагаанд итгэх гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн итгэл сулрах ;

- Сайтар тооцоогүй, эдийн засгийн өсөлтөөр баталгаажуулаагүй гаднын зээл тусламж нэмэгдэх, үнэт цаасны зах зээл өргөжих, үүнээс үүдэн төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэд өрөнд ихээр орох, улс орон валютын нөөцөө алдах, барьцаалуулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалт эмх замбараагүй байдалтай болох, түүнчлэн зээл, тусламжийг замаас нь завших явдал газар авснаас үүдэн гадаад орнууд, түүний дотор том гүрнүүд энэ төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээ зогсоох.

#### 2.2.5.5. Нийгмийн хүрээнд:

- Хуурамч, хадгалах хугацаа хэтэрсэн, хүний бие организмд хортой хүнс, эм тариа, хувцас, эд хэрэглэл гэх мэт зүйлүүд гаднаас ихээр орж ирэх, гадаад харилцаа өргөжиж хүн, мал, бараа бүтэгдэхүүний урсгал чөлөөтэй болох хэрээр элдэв халдварт өвчин тархах, үүний дотор ДОХ, шинэ вирусийн болон нэн халдварт бусад өвчнөөр өвчлөгсдийн тоо өсөх;

- Улс орны хэмжээнд, үндэстэн дамжсан гэмт хэргийн бүлэглэлүүд бий бол, эрүүгийн нөхцөл байдал хяналтаас гарах манай улсын нутаг дэвсгэрийг мансууруулах бодис, элдэв төрлийн зэвсэг, цөмийн түүхий эд, материал, хүн худалдаалахаар зөөвөрлөх, дамжуулах талбар болгох оролдлого гарах, тэдгээрийн хор уршиг нь улс орны улс төр, эдийн засгийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрэх;

- Харт тамхи, мансууруулах төрлийн бусад бодисын хэрэглээ, ялангуяа залуучуудын дунд хяналтаас гарах, ийм төрлийн бодисын тээвэрлэлт, түгээлт, сурталчилгаа, тараалт, худалдаа нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн хэлбэрт шилжих .

#### 2.2.5.6. Соёл иргэншлийн хүрээнд:

- Монгол Улсын гадаад харилцаа өргөжих, нээлттэй болох хэрээр бусад орны амьдрах хэв маяг, эрхэмлэх үнэт зүйлсийн хүчтэй нэвтрэлт гүнзгийрэх, үүнээс үүдэн үндэсний үнэт зүйлсийн үнэлэмжид эргэж буцалтгүй өөрчлөлт гарах, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлөх;

- хүн төрөлхтний нийтлэг соёлыг дээдлэх, бусад шашныг хүндэтгэх, зарим тохиолдолд албан ёсны бус гаднаас орж ирсэн шашны урсгалд автах үзэл болон монгол үндэстний төрөлх хэл, соёл, бурхны шашин, ёс заншил, удмын сан, угсаа гарвалиа хадгалан хамгаалах гэсэн эрмэлзлийн хооронд зөрчил, сөргөлдөөн үүсэх, энэ нь улс төржих замаар нийгэмд бухимдал үүсгэх.

#### 2.2.5.7. Байгал орчны хүрээнд:

- Дэлхийн цаг уурын дулаарал, өөрчлөлт болон бусад шалтгаанаас үүдэн байгалийн гамшигт үзэгдлүүд олшрох энэ нь улс орны эдийн засаг, нийгэмд дааж давшгүй хохирол учруулах;

- Хэт их гадаадын хөрөнгө оруулалт бүхий уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийг эрчимжүүлэх явцад байгалийн тэнцвэр алдагдах, ус, гол мөрөн, агаар мандал, хөрс бохирдох, ой сүйдэх, цөлжилт газар авах, бэлчээрийн талхдал, тариалангийн талбайн хомсдол ихсэх, эдгээрээс үүдэн хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариалангийн хөгжил зогсонги байдалд орох, өөр хоорондоо тэрсэлдэх;

- Манай орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах оролдлого гарах.

## **Гурав. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДСЭН АГУУЛГА, АЛСЫН ХАРАА, ЗОРИЛТ.**

### **3.1. Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлогын үндсэн агуулга:**

3.1.1. Г Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлогын үндсэн агуулга нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд оршино.

### **3.2. Алсын хараа, стратегийн зорилт, үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга зам.**

#### **3.2.1. Алсын хараа:**

Энхийг эрхэмлэсэн олон тулгуурт гадаад бодлогоо эрчимжүүлэн, Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцдог, олон улсын тавцанд геополитикийн өндөр нэр хүнд, өөрийн гэсэн байр суурь, дуу хоолойтой орны нэг болж, хүлээн зөвшөөрөгдөх, олон улсын шинэ нөхцөл байдал, үндэсний хөгжлийн онцлог, өнөөгийн шаардлага, хэтийн төлөвт нийцсэн эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах өөрийн гэсэн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд оршино” .

#### **3.2.2. Стратегийн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам:**

##### **3.2.2.1. Стратегийн 1 дүгээр зорилт**

Монгол Улсын эргэн тойронд бий болсон олон улсын шинэ нөхцөл байдал, олон улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, улс орны хөгжлийн шинэ чанар, хэтийн төлөв, ирээдүйн хандлагад нийцүүлэн Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлэх, энэ бодлогын эрх зүйн орчныг бий болгох.

*Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг манай орны эргэн тойронд бий болсон олон улсын нөхцөл байдал, үүнээс үүдэн улс орны дотоодод бий болсон нөхцөл байдалд нийцүүлэн шинэ утга агуулгаар баяжуулах, тодотгон шинэчлэх;

- “Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг боловсруулан УИХ-аар батлуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих үр дүнтэй механизмыг бий болгох.

- “Аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, төрийн бодлогын бусад баримт бичигт стратегийн эрсдэлээс үүдэл сэдэлтэй аюулаас урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах агуулга бүхий тодотгол хийх,

3.2.2.2. Стратегийн 2 дугаар зорилт

Шинээр бий болсон олон улсын нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, харилцан ашигтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлэх замаар эрсдэлийн аюулгүй байдлын олон улсын таатай орчныг бүрдүүлэх.

*Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*

- Энх тайвныг тогтоон барих, аливаа маргаантай асуудлыг эвийн аргаар шийдвэрлэхэд чиглэсэн улс хоорондын бүх талын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоог идэвхжүүлэх, ОХУ, БНХАУ-ын зэрэгцээ АНУ тэргүүтэй гуравдагч бусад улс орон, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаагаа өргөжүүлэх, өөрийн зарчимч байр суурь, дуу хоолойгоо



нэмэгдүүлэн Монгол Улсын олон улсын тавцанд эзлэх байр суурь, ач холбогдлыг өндөрсгөх;

- Хөрш орнууд, нөлөө бүхий гуравдагч бусад гүрний Монгол дахь геополитикийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, эдгээр гүрний гео стратегийн зөрчил, сөргөлдөөнөөс үүдэлтэй элдэв, аюул, сорилт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах утга агуулгаар гадаад, дотоод бодлогоо баяжуулах.

#### 3.2.2.4. Стратегийн 3 дугаар зорилт:

Шинээр бий болсон олон улсын нөхцөл байдалд нийцүүлэн ардчилал, сайн засаглалыг баталгаажуулах, монгол, соёл иргэншил, байгаль орчноо хадгалан хамгаалах, хүний эрх, иргэдээ хүчирхэгжүүлэх, амьдрах таатай орчин, эрх чөлөөгөөр хангах зэрэг улс орны давуу тал, чадавхыг дээд зэргээр ашиглахад чиглэсэн цэгцтэй бодлого хэрэгжүүлэн эрсдэлийн аюулгүй байдлын дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэх.

#### *Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*

- Ардчиллыг гүнзгийрүүлэх, сайн засаглалыг төрийн удирдлага, нийгмийн харилцаа, хууль эрх зүйн хүрээнд бүрэн хэвшүүлэх, бүх шатны сонгуулийн тогтолцооны шударга байдлыг баталгаажуулах, төрийн байгууллага, улс төрийн нам, иргэний байгууллага, нийт иргэдийн холбоог улс үндэстэн, газар шороо, төр засгаа дээдлэх төрт ёсны уламжлал, үндэсний эх оронч үзэлд тулгуурлан бэхжүүлж улс төрийн тогтвортой байдлыг хангах;

- Ядуурал, нийгмийн баялгийн шудрага бус хуваарилалт, авлига болон нийгмийн бусад сөрөг үзэгдэлтэй шийдвэртэй тэмцэх, эдийн засгийн, юуны өмнө уул уурхайн үйлдвэрлэлийн үр ашгийг ард түмэнд тэгш хүртээх, нийт иргэдийг ажлын байр, эдийн засгийн эрх чөлөө, бодитой орлого олох, боловсрол эзэмших, эрүүл энх амьдрах, хөдөлмөрлөх нөхцөл бололцоогоор бүрэн хангах үндсэн дээр хүн амын амьдралын түвшинг хурдтай дээшлүүлэх;

- Байгалийн гамшгийн хор уршгаас урьдчилан сэргийлэх, нэрвэгдэгсдэд туслалцаа үзүүлэх улс орны нэгдсэн тогтолцоог бий болгох, уул уурхайн чиглэлийн болон бусад хүнд үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэхдээ байгалийг сүйтгэхгүй, нөхөн сэргээдэг байхыг шаардсан эрх зүйн хатуу зохицуулалтыг бий

болгох, газрын ашиглалтыг үр дүнтэй болгох, түүний дотор бэлчээрийн болон тариалангийн газар ашиглалтыг эдийн засгийн аргаар зохицуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх.

#### 3.2.2.5. Хэрэгжүүлэх арга зам

##### *Улс төрийн салбарт*

- Өөрийн гэсэн үзэл бодолтой байх, шүтэх, эс шүтэх хүний эрх, эрх чөлөө, чөлөөт хэвлэлийг тууштай дэмжих, олонхын засаглалаас цөөнхийн эрх ашгийг хамгаалах механизмыг боловсронгуй болгож иргэний нийгмийг төлөвшүүлэн улс төрийн тогтвортой байдлыг хангах нь Монгол Улсын геополитикийн аюулгүй байдлыг хамгаалан бэхжүүлэх болно.

- Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох, ард иргэд сонгох сонгогдох эрхээ эдлэхдээ бүх төрлийн мэдээллээр хангагдах, өөрсдийн эрх ашгийг хамгаалж, илэрхийлж чадахуйц хүмүүсийг сонгох бололцоог олгосон тийм нөхцөл байдлыг бүрдүүлэх нь төр засгийн болон төрийн бус байгууллагууд, нийт иргэдийн чухал үүрэг болж байна.

- Цагдаа, тагнуул, шүүх, прокурор гэх мэт байгууллагуудыг хүний үндсэн эрхийг зөрчихгүйгээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах үйл ажиллагаанд суралцуулах, нөгөө талаас иргэдийг төрийн хууль ёсыг сахин биелүүлдэг, дээрх байгууллагуудын үйл ажиллагааг ойлгодог, дэмждэг нөхцөлийг бүрдүүлэх явдал ач холбогдолтой болж байна.

- Төр, засгийн байгууллагын үйл ажиллагааг цаашид ил тод байлгах нь төр, олон түмний холбоог бэхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, авилагтай тэмцэхэд олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзлийг тусгадаг болгоход тустай байх болно. Мөн иргэдийн шүтэх, эс шүтэх эрхийг бодитойгоор хангах асуудал хурцаар тавигдсаар байх төлөвтэй байна.

##### *Эдийн засгийн салбарт*

- Эдийн засгийн салбарын тогтвортой хөгжил нь геополитикийн аюулгүй байдлыг хангахад шийдвэрлэх үүрэгтэй болж байна. Хувийн хэвшил тэргүүлсэн, экспортын чиглэлтэй, нээлттэй эдийн засгийг хөгжүүлэх, Монгол Улсад ашигтай гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нь дэлхийн зах зээл дээр болж байгаа

өөрчлөлтөд түргэн дасах чадвартай эдийн засгийн бүтэц бий болгох бодлого, үйл ажиллагааны үндсэн агуулга юм. Энэ нь Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд голлох үүрэгтэйн зэрэгцээ геополитикийн аюулгүй байдлын гол баталгаа болох учиртай.

- Экспортыг дэмжих, энэ чиглэлийн гадаад дотоодын хувийн хэвшлийн үйлдвэрүүдтэй Засгийн газраас ажиллах арга барил, тухайлбал, экспортыг санхүүжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай болгох, бүтээгдэхүүний чанар, стандартын талаар сургалт явуулах хөтөлбөр гаргаж ажиллах шаардлага тавигдаж байна. Засгийн газар, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын хувийн хэвшлийн хамтын ажиллагааг албан ёсоор хэлбэршүүлж, үйл ажиллагааг нь сайжруулах нь чухал болно.

- Төрөөс хөгжлийн асуудалд хандахдаа бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг тулгуур болгож байгаа нь геополитикийн аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцэх юм. Мөн аль болох ажлын олон байр бий болгосон гадаад дотоодын компаниудыг төрөөс дэмжих асуудал чухал ач холбогдолтой юм. Энэ нь ядуурлыг бууруулахад бодитой нөлөө үзүүлэх болно.

- Банк, санхүүгийн салбарт олсон ололтыг бататгаж, цаашид энэ салбарт хувийн хэвшил, түүний дотор гадаадын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудад үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн тааламжтай нөхцөлийг хангах явдал чухал юм. Түүнчлэн Монгол Улсын экспортын гол нэрийн барааг дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс даатгуулах нь эдийн засгийн өрөөсгөл бүтэцтэй Монгол оронд төсвийн тогтвортой эх үүсвэртэй байхад нөлөө болох ач холбогдолтой байж болох талтай.

#### *Нийгмийн салбарт*

- Эрсдэлийн удирдлагын аюулгүй байдлын асуудлаар бүх нийтэд албан бус боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь Монголын нийгмийн хувьд үндэсний зөвшилцөл бий болгоход тустай байх болно.

- Ядууралтай тэмцэх, хүн амыг орлогоороо туйлшрахын эсрэг бүх талын арга хэмжээ авахыг Монгол Улсын геополитикийн ашиг сонирхол шаардаж байна. Ингэхдээ зах зээлийн жам ёсны хөгжлийг боомилж бас болохгүй юм.

- Гадаад орноос ирж оршин суугчид, цагаачдын амьдрах, ажиллах эрх зүйн орчныг тодорхой болгох, түүнчлэн гадаадад оршин суугч монгол иргэдэд төрийн зүгээс болон олон улсын байгууллагын тусламжтайгаар тал бүрийн туслалцаа үзүүлэх арга механизмд манай байгууллагууд суралцах ёстой болж байна.

- Гэр бүлийн үнэ цэнийг хамгаалан бэхжүүлэх, энэ талаар ажиллаж байгаа олон нийтийн болон хувийн байгууллагад бүх талаар дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал нийгмийг ёс суртахууны доройтол, ДОХ-ын аюулаас аврах үр дүнтэй алхам байх болно.

### *Байгаль орчны салбарт*

- Байгалийн гамшиг гэсэн ойлголтын эрх зүйн болон эдийн засаг, нийгмийн агуулгыг тодотгож, түүнд нэрвэгдэгсдэд туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгох, энэ талаар олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай өргөн хамтын ажиллагаа явуулах шаардлагатай болж байна.

- Монгол Улсад уул уурхайн чиглэлийн болон бусад хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ байгалийг сүйтгэхгүй, нөхөн сэргээдэг байх эрх зүйн хатуу зохицуулалтыг бий болгох асуудал тулгамдсан зорилт болж байна. Үүнээс гадна газрын ашиглалтыг үр дүнтэй болгох, түүний дотор бэлчээрийн болон тариалангийн газар ашиглалтыг эдийн засгийн аргаар зохицуулах явдал чухлаар тавигдаж эхэллээ.

### **Дөрөв. БУСАД**

4.1. Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

4.2. Эрсдэлийн удирдлагын салбарт төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаа нь олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт, Монгол Улсын геополитикийн давуу тал, чадавхтай уялдаатайгаар тодотгон шинэчлэгдэж байна.

**“МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”, “МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ  
БАРИМТЛАЛ”, “МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН  
ҮНДЭС”-Т-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ САНАЛ**

Суурь судалгааны төслийн үр дүн 3

Нэг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ"-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ

1. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад орчин, тулгамдаж байгаа сорилт, эрсдэл” гэсэн бүлэгт хоёрдугаар бүлэгт дараах заалтуудыг нэмэх:

### 1.1. Стратегийн эрсдэл.

1.1.1. Олон улсын аюулгүй байдлыг хангах өнөөгийн механизмууд, юуны өмнө НҮБ, ЕАБХАБ зэргийн үүрэг, ач холбогдлыг бууруулах гэсэн зарим том гүрний эрмэлзэл хүчтэй нэмэгдэж байна;

1.1.2. Олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд бага орнуудыг аль болох оролцуулахгүй байх, тэднийг үл тоомсорлох хандлага газар авах боллоо;

1.1.3. Улс хоорондын харилцаанд цэрэг-улс төрийн эвсэл холбоодыг бэхжүүлэх, юуны өмнө НАТО-г дорно зүгт тэлэх, Орос, Хятадын цэрэг-стратегийн хамтын ажиллагааг холбоотны хэмжээ рүү ойртуулан гүнзгийрүүлэх эрмэлзэл ажиглагдаж байна;

1.1.4. Улс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр зэвсэгт хүчнээ ашиглах практик АНУ, Орос, Хятад, Турк гэх мэт орнууд болон НАТО-ийн тухайд хэвийн үзэгдэл болох төлөвтэй байна. Тэр ч байтугай үүнийгээ цэрэг-стратегийн номлолдоо тусгадаг болоод байна.

1.1.5. Тэргүүлэгч зарим гүрний технологийн хөгжлийн хэт тасархай байдал улам нэмэгдэж, шинэ үеийн зэвсэг, байлдааны техник бүтээх чадавх нь ихсэж байгаа нь зэвсэглэлийн чанараар өрсөлдөх шинэ үе шатыг авчирч, байлдааны ажиллагааны арга хэлбэрт эргэлтийн гэж хэлж болох өөрчлөлт оруулах магадлалтай байна.

1.1.6. Олон улсын терроризм дэлхий нийтийн хэмжээний, олон талт шинж төрхтэй болж байгаа бөгөөд бүх улс орны аюулгүй байдалд ноцтой, нийтлэг аюул занал учруулах боллоо.

## **2. Стратегийн эрсдэлийн улмаас учирч болзошгүй аюул заналын тухай төсөөлөл.**

2.1.1. Монгол Улсын эргэн тойронд буй болсон олон улсын шинэ нөхцөл байдал, үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж үзэхэд ойрын болон дунд хугацааны ирээдүйд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдал, төрийн байгуулалтад гаднаас цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул үндсэндээ байхгүй байна.

2.1.2. Манай улсын олон улсын нэр хүнд сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн, хөрш хоёр оронтойгоо элдэв маргаантай асуудлаа олон улсын эрх зүйн хүрээнд эцэслэн шийдвэрлэсэн, энэ хоёр улстай болон гуравдагч бусад хөрштэйгөө тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин хөгжиж байгаа нь ийм дүгнэлтэд хүргэж байна.

2.1.3. Үүний зэрэгцээ бүс нутгийн хүрээнд үүсэн Монгол Улс татагдан орж болох эсвэл өөр бусад гадаад хүчин зүйлээс үүдэн манай улсын дотоодод үүсэж болох дараах аюул занал бодитойгоор оршиж байна.

### 2.1.4. Бүс нутгийн олон улсын нөхцөл байдлаас үүдэн Монгол Улсад учирч болзошгүй эрсдэл:

- Олон улсын терроризм улам бүр хүрээгээ тэлж Зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийг, түүний дотор Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамрах;

- Улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжлийг даган Ази тивд цэрэг-улс төрийн нөлөөллөө өргөжүүлэх энэ улсын эрмэлзлийг төрүүлэн үүний улмаас үүнтэй ижил төстэй ашиг сонирхол бүхий ОХУ болон АНУ-тай ноцтой, өргөн хүрээтэй зөрчилдөхөд хүргэх, үүнд нь Монгол Улс татагдан орох;

- Хоёр Солонгос, Хятад-Тайвань, Энэтхэг-Пакистан хоорондын эсрэг тэсрэг байр суурь, Курилийн арлуудын талаарх Орос-Японы маргаан зэрэг нь улс хоорондын харилцааны тодорхой нөхцөл байдалд зэвсэгт мөргөлдөөнд

хүргэх. Энэ нь бүс нутгийг хамарсан шинжтэй болж өргөжин Монгол Улсыг ямар нэг хэлбэрээр хамрах;

- Ази, Номхон далайн бүс нутагт улам бүр өсөн нэмэгдэж буй НАТО-ийн цэрэг-улс төр, эдийн засгийн нөлөөг хязгаарлах зорилго бүхий Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн үйл ажиллагаа өргөжин үүний үр дагавраар АНУ, Барууны орнууд нэг талаас болон нөгөө талаас Орос, Хятадын хооронд цэрэг, зэвсгийн хүчийг тулгуур болгосон зөрчил, сөргөлдөөн үүсэх, үүнд Монгол Улс татагдан орох;

- 2008 онд тохиолдсонтой төсөөтэй нийтийг хамарсан эдийн засгийн хямрал Ази тив болон Зүүн Хойд Азид бий болж энэ нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах буюу зогсонги байдалд оруулах;

- Хөрш зэргэлдээ болон бусад оронд үүссэн хямралт байдлаас үүдсэн хяналтаас гарсан цагаачлал, жирийн болон зэвсэглэсэн дүрвэлтэд нэрвэгдэх зэрэг болно.

#### 2.1.5. Уламжлалт бус аюул занал:

2.1.5.1. Олон улсын ээдрээтэй нөхцөл, улс төрийн тогтворгүй байдал, үндэсний эдийн засгийн хямрал, нийгмийн хуваагдал, түүний дотор шашин хоорондын харилцааны зарим нэг зөрчил сөргөлдөөн зэрэг нь манай орны аюулгүй байдалд учрах гадаад, дотоод үүдэлтэй уламжлалт бус аюулын эх сурвалж болж байна.

2.1.5.2. Ойрын ирээдүйд гадаад, дотоод аливаа хүчин зүйлээс үүдэн дотоодын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй уламжлалт бус гэж хэлж болох дараах аюул занал үүсэж болзошгүй байна. Үүнд:

#### 2.1.5.3. Улс төрийн хүрээнд:

- Монгол Улсад стратегийн ашиг сонирхлоо хадгалах, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон эдийн засгийн бусад чухал салбарт давамгайл байдлаа бий болгох гэсэн том гүрнүүдийн зөрчил сөргөлдөөн болон тэдгээрийн манай улсын тухайд явуулж буй тус тусын тодорхой чиглэл, зорилго бүхий гео стратегийн бодлогын нөлөөлөл, үр дагавраас үүдэн Монгол Улсын төр засгийн бодлогод саад бэрхшээл үүсэх, аль нэг улс орон, улс төр-цэргийн эвсэл холбоо буюу



үндэстэн дамжсан том корпорацуудаас улс төрийн хувьд ямар нэгэн байдлаар хараат байдалд орох;

- Олон улсын терроризм улам бүр газар авч байгаа болон манай улс терроризмын эсрэг барууны эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гаднын хүчний явуулгын улмаас энэ аюул ямар нэг хэлбэрээр Монгол Улсад орж ирэх;

- Монгол Улсын геополитик, цэрэг-стратегийн түшиц нутгийн ач холбогдол улам бүр өсөх болсонтой уялдаатайгаар гадаад орнуудын зүгээс манай орны эсрэг явуулах тагнуулын болон бусад үйл ажиллагаагаа нэмэгдэх, энэ нь чиглэл, зорилготой, нийгмийн тодорхой хэсэг бүлэг рүү чиглэсэн агуулгатай болох.

#### 2.1.5.4. Эдийн засгийн хүрээнд:

- Гадаадын хөрөнгө оруулалт, бусад улстай хийх худалдааг тэнцвэржүүлэх нэгдсэн бодлого алдагдах, үүнээс үүдэн улсын хөгжил удаашрах, зогсонги байдалд орох;

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлого, үйл ажиллагаанд алдаа, доголдол гарах, үүний улмаас эдийн засгийн салбарт тогтворгүй байдал үүсэх, мөнгөний бодлого, валютын зах зээлийн хямрал гарах, дампууралд орох, улмаар Монгол Улсын банк, санхүүгийн үйл ажиллагаанд итгэх гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн итгэл сулрах ;

- Сайтар тооцоогүй, эдийн засгийн өсөлтөөр баталгаажаагүй гаднын зээл тусламж нэмэгдэх, үнэт цаасны зах зээл өргөжих, үүнээс үүдэн төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэд өрөнд ихээр орох, улс орон валютын нөөцөө алдах, барьцаалуулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалт эмх замбараагүй байдалтай болох, түүнчлэн зээл, тусламжгүй замаас нь завших явдал газар авснаас үүдэн гадаад орнууд, түүний дотор том гүрнүүд энэ төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээ зогсоох.

#### 2.1.5.5. Нийгмийн хүрээнд:

- Хуурамч, хадгалах хугацаа хэтэрсэн, хүний бие организмд хортой хүнс, эм тариа, хувцас, эд хэрэглэл гэх мэт зүйлүүд гаднаас ихээр орж ирэх, гадаад харилцаа өргөжиж хүн, мал, бараа бүтэгдэхүүний урсгал чөлөөтэй болох хэрээр

элдэв халдварт өвчин тархах, үүний дотор ДОХ, шинэ вирусийн болон нэн халдварт бусад өвчнөөр өвчлөгсдийн тоо өсөх;

- Улс орны хэмжээнд, үндэстэн дамжсан гэмт хэргийн бүлэглэлүүд бий бол, эрүүгийн нөхцөл байдал хяналтаас гарах манай улсын нутаг дэвсгэрийг мансууруулах бодис, элдэв төрлийн зэвсэг, цөмийн түүхий эд, материал, хүн худалдаалахаар зөөвөрлөх, дамжуулах талбар болгох оролдлого гарах, тэдгээрийн хор уршиг нь улс орны улс төр, эдийн засгийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрэх;

- Харт тамхи, мансууруулах төрлийн бусад бодисын хэрэглээ, ялангуяа залуучуудын дунд хяналтаас гарах, ийм төрлийн бодисын тээвэрлэлт, түгээлт, сурталчилгаа, тараалт, худалдаа нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн хэлбэрт шилжих .

#### 2.1.5.6. Соёл иргэншлийн хүрээнд:

- Монгол Улсын гадаад харилцаа өргөжих, нээлттэй болох хэрээр бусад орны амьдрах хэв маяг, эрхэмлэх үнэт зүйлсийн хүчтэй нэвтрэлт гүнзгийрэх, үүнээс үүдэн үндэсний үнэт зүйлсийн үнэлэмжид эргэж буцалтгүй өөрчлөлт гарах, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлөх;

- хүн төрөлхтний нийтлэг соёлыг дээдлэх, бусад шашныг хүндэтгэх, зарим тохиолдолд албан ёсны бус гаднаас орж ирсэн шашны урсгалд автах үзэл болон монгол үндэстний төрөлх хэл, соёл, бурхны шашин, ёс заншил, удмын сан, угсаа гарвалиа хадгалан хамгаалах гэсэн эрмэлзлийн хооронд зөрчил, сөргөлдөөн үүсэх, энэ нь улс төржих замаар нийгэмд бухимдал үүсгэх.

#### 2.1.5.7. Байгал орчны хүрээнд:

- Дэлхийн цаг уурын дулаарал, өөрчлөлт болон бусад шалтгаанаас үүдэн байгалийн гамшигт үзэгдлүүд олшрох энэ нь улс орны эдийн засаг, нийгэмд дааж давшгүй хохирол учруулах;

- Хэт их гадаадын хөрөнгө оруулалт бүхий уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийг эрчимжүүлэх явцад байгалийн тэнцвэр алдагдах, ус, гол мөрөн, агаар мандал, хөрс бохирдох, ой сүйдэх, цөлжилт газар авах,

бэлчээрийн талхидал, тариалангийн талбайн хомсдол ихсэх, эдгээрээс үүдэн хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариалангийн хөгжил зогсонги байдалд орох, өөр хоорондоо тэрсэлдэх;

- Манай орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах оролдлого гарах.

**2. “Гурав Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гэсэн бүлгийн “3.1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал” гэсэн заалтыг дараах байдлаар өөрчилсүгэй.**

“Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдал зэргийг эрсдэлээс хамгаалах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн” .

**3. Гурав. Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гэсэн бүлэгт 3.1.5 дугаар зүйл болгон дараах заалтуудыг нэмсүгэй.**

3.1. Эрсдэлээс хамгаалах

3.2. Эрсдэлээс хамгаалах гэж Үндэсний язгуур ашиг сонирхлоо олон улсын аюулгүй байдлын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд найдвартай хадгалан хамгаалах, бусад орон, эвсэл холбоодтой найрсаг харилцаа хамтын ажиллагаатай байх болон гадаад ертөнцөд тодорхой хэмжээгээр нөлөө бүхий байр суурь эзлэх нөхцөл бололцоог олгосон, олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээний цогцыг хэлнэ;

3.3. Монгол Улсын эргэн тойронд бий болсон эрсдэлт шинэ нөхцөл байдал, олон улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, улс орны хөгжлийн шинж чанар, хэтийн төлөв, ирээдүйн хандлагад нийцүүлэн үндэсний аюулгүй байдлын бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох стратегийн эрсдэлийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлэх, энэ бодлогын эрх зүйн орчныг бий болгох;

3.4. Шинээр бий болсон эрсдэлт нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, олон

улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, харилцан ашигтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлэх замаар геополитикийн аюулгүй байдлын олон улсын таатай орчныг бүрдүүлэх;

3.5. Шинээр бий болсон эрсдэлт нөхцөл байдалд нийцүүлэн ардчилал, сайн засаглалыг баталгаажуулах, монгол, соёл иргэншил, байгаль орчноо хадгалан хамгаалах, хүний эрх, иргэдээ хүчирхэгжүүлэх, амьдрах таатай орчин, эрх чөлөөгөөр хангах зэрэг улс орны геополитикийн давуу тал, чадавхыг дээд зэргээр ашиглахад чиглэсэн цэгцтэй бодлого хэрэгжүүлэн үндэсний аюулгүй байдлын дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Хоёр.

**“МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-Д  
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ САНАЛ**

“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-д дараах зүйл, заалтыг нэмэх:

**НАЙМ. СТРАТЕГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САЛБАРТ БАРИМТЛАХ  
ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО**

28. Стратегийн удирдлагын салбарт баримтлах гадаад харилцааны бодлогын үндэс нь шинээр бий болсон олон улсын нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, харилцан ашигтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлэх замаар геополитикийн аюулгүй байдлын олон улсын таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

29. Стратегийн эрсдэлийн салбарт баримтлах гадаад харилцааны бодлогын үндсэн чиглэл:

29.1. Энх тайвныг тогтоон барих, аливаа маргаантай асуудлыг эвийн аргаар шийдвэрлэхэд чиглэсэн улс хоорондын бүх талын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоог идэвхжүүлэх, ОХУ, БНХАУ-ын зэрэгцээ АНУ тэргүүтэй гуравдагч бусад улс орон, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаагаа өргөжүүлэх, өөрийн зарчимч байр суурь, дуу хоолойгоо нэмэгдүүлэн Монгол Улсын олон улсын геополитикийн тавцанд эзлэх байр суурь, ач холбогдлыг өндөрсгөх;

29.2. Хөрш орнууд, нөлөө бүхий гуравдагч бусад гүрний Монгол дахь геополитикийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, эдгээр гүрний гео стратегийн зөрчил, сэргэлдөөнөөс үүдэлтэй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах утга агуулгаар гадаад, дотоод бодлогоо баяжуулах.

## Гурав.

### “МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ САНАЛ

“Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т дараах зүйл, заалтыг нэмэх:

Долоо. Батлан хамгаалах бодлогын стратегийн эрсдэлийн удирдлагын салбарт баримтлах чиглэл

7.1. Монгол Улс аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнийг улс хоорондын болон дотоодын маргаан бүхий асуудлуудыг шийдвэрлэх хэрэгсэл гэж үзэхгүй. Дэлхий дахинд болон бүс нутагт дайн, зэвсэгт мөргөлдөөн гаргуулахгүйн төлөө тэмцэл, зэвсэг хураах, ялангуяа цөмийн болон бусад үй олноор хөнөөх зэвсгийг бүрмөсөн хориглох, олон улсын терроризмтой тэмцэхэд чиглэсэн олон улсын бүх үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.

7.2. Улс орнуудын олон янзын эрх ашгийн зөрчил үе үе хурцдаж, заримдаа зэвсэгт мөргөлдөөнд хүргэн, зэвсэгт хүчнийг улс төрийн болон маргаантай бусад асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэрэглэх сэтгэлгээ хэвээр хадгалагдсаар байгаагийн гадна бүс нутгийн их гүрнүүдэд төрөл бүрийн зэр зэвсгийн асар их нөөц бүхий цэргийн хүчирхэг бүлэглэлүүд оршсоор, түүнчлэн Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрдэх эхлэл тавигдаагүй зэргээс үүдэн аливаа дайн, түрэмгийллийн бодит аюул бүрмөсөн арилаагүй байна гэж үзнэ.

7.3. Монгол Улсын төр, засгаас Эх орныхоо цэргийн аюулгүй байдлыг чухалчлан үзэж, үндэсний эрх ашгаа хамгаалахын тулд төрийн батлан хамгаалах бодлогоо оновчтой болгон бэхжүүлэх асуудлыг анхаарлын төвд байлгана.

7.4. Монгол Улс НҮБ-ын дүрмийн дагуу үндэсний аюулгүй байдлаа дангаараа буюу хамтын хүчээр батлан хамгаалах эрхээ эдэлнэ. Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг батлан хамгаалах, олон улсын энхийг сахиулах болон бусад үйл ажиллагаанд оролцох үүрэг бүхий өөрийгөө хамгаалах үндэсний Зэвсэгт хүчинтэй байна.

7.5. Өнөөгийн бий болоод байгаа нийтийг хамарсан уламжлалт бус аюул заналын нөхцөлд батлан хамгаалах асуудал улс гүрнүүдийн хил хязгаараар

зааглагдахгүй болж байгаатай холбогдон улс орны аюулгүй байдлыг улс орон бүрийн идэвхтэй оролцоотойгоор, тэр дотор зэвсэгт хүчнүүдийнхээ нэгдсэн чармайлтаар хангах явдал олон улсын харилцааны нэг шинэ хэлбэр болон хөгжиж үүнд Монгол Улсын Зэвсэгт хүчин идэвхтэй оролцоно.

7.6. Зэвсэгт хүчнийг үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ энхийг сахиулах, терроризмтой тэмцэх болон олон улсын бусад үйл ажиллагаанд оролцох, нийтийг хамарсан байгалийн гамшиг, технологийн осол, хүмүүнлэгийн сүйрэл зэрэг хямралт байдлын үед олон талт үүрэг гүйцэтгэх чадавх бүхий, өндөр мэргэшсэн болгон өөрчлөн зохион байгуулах болон орон нутгийн хамгаалалтыг жинхэнэ ёсоор нь бүрдүүлэн бий болгох асуудлыг шийдвэрлэх арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, үүнтэй уялдуулан Зэвсэгт хүчнийхээ үүрэг, зориулалт, бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, техник, үйл ажиллагааны стратеги, тактикийг өөрчлөх шаардлагыг бий болгож байна.